Ministry of Food, Agriculture
and Light Industry

Export Development
Project, World Bank

# МОНГОЛ УЛСЫН ХӨДӨӨ АЖ АХУЙН БАРАА, ТҮҮХИЙ ЭДИЙН БИРЖИЙН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ СУДАЛГААНЫ АЖИЛ

## Өнөөгийн байдал, тулгамдсан асуудал, цаашдын зорилт, стратеги төлөвлөгөө

Зөвлөх С.Тэгшжаргал

2021 оны 11 дүгээр сарын 22

# АГУУЛГА


Хүснэгт, график, диаграмм ... 3

Оршил ... 6

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. СУДАЛГААНЫ АЖЛЫН ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ ... 8

1.1. Үндэслэл ... 8

1.2. Зорилго, зорилт ... 10

1.3. Ажлын цар хүрээ, судалгааны аргачлал ... 10

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ХӨДӨӨ АЖ АХУЙН БИРЖИЙН БАРИМТ БИЧИГТ ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ ... 14

2.1. 2012 оны бирж байгуулах техник, эдийн үндэслэл ... 14

2.2. 2017 онд баталсан биржийн стратеги төлөвлөгөө ... 14

2.3. 2011-2020 онд батлагдсан биржийн хууль, дүрэм, журам ... 14

2.4. Дэд дүгнэлт ... 16

ГУРАВДУГААР БҮЛЭГ. САЛБАРЫН БОДЛОГО, ЭРХ ЗҮЙН ОРЧИН БОЛОН САЛБАРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ ... 17

3.1. Хөдөө аж ахуйн салбарын бодлого, эрх зүйн орчин ... 17

3.2. Хөдөө аж ахуйн салбарын төлөв байдал ... 19

3.3. Хөдөө аж ахуйн салбарын бараа, түүхий эд бэлтгэлийн тогтолцооны хөгжлийн төлөв байдал ... 26

3.4. Дэд дүгнэлт ... 33

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ОЛОН УЛСЫН БАРААНЫ БИРЖИЙН ТУРШЛАГА, ТҮҮНИЙ СУРГАЛЖ БА БОЛОМЖ ... 34

4.1. Барааны бирж, түүний амжилттай ажиллах урьдчилсан нөхцөл ... 34

4.2. Олон улсын барааны биржийн хөгжил, туршлага, харьцуулалт ... 43

4.3. Олон барааны биржийн туршлагаас монгол улсад нэвтрүүлэх боломж ... 48

4.4. Дэд дүгнэлт ... 53

ТАВДУГААР БҮЛЭГ. НӨХЦӨЛ БАЙДЛЫН ШИНЖИЛГЭЭ ... 55

5.1. Хөдөө аж ахуйн биржийн өнөөгийн байдал, тулгамдсан асуудал ... 55

5.2. Зах зээлийн шинжилгээ ... 68

5.3. TOWS шинжилгээ ... 86

5.4. PESTLE шинжилгээ ... 88

5.5. GAP шинжилгээ ........ 88
5.6. Дэд дүгнэлт ........ 94
ЗУРГАДУГААР БҮЛЭГ. БИРЖИЙГ ХӨГЖҮҮЛЭХ СТРАТЕГИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ТӨЛӨВЛӨЛТ ........ 95
6.1. Стратегийн зорилго, зорилтууд, стратегийн үе шат ........ 95
6.2. Бизнесийн үйл ажиллагааг сайжруулах боломж ба эрсдлүүд ........ 102
6.3. Биржийн стратеги төлөвлөгөө ........ 114
6.4. Биржийн эрсдлийн төлөвлөгөө ........ 133
6.5. Биржийн удирдлага, бүтэц зохион байгуулалт, ажилчдын ажил үүрэг ........ 134
6.6. Дэд дүгнэлт ........ 140
ДҮГНЭЛТ, САНАЛ, ЗӨВЛӨМЖ ........ 142
Дүгнэлт ........ 142
НОМ ЗҮЙ ........ 144

# Хүснэгт, график, диаграмм

**Хүснэгтийн жагсаалт:**

Хүснэгт 1. Хөдөө аж ахуйн биржийн хуульд оруулсан өөрчлөлт

Хүснэгт 2. Биржийн дүрэм, журам

Хүснэгт 3. Бүс, аймгаар МАА болон ГТ-ын үйлдвэрлэлд эзлэх хувь, %

Хүснэгт 4. Малчин өрхийн болон малчдын тоо

Хүснэгт 5.  Малчин өрхийн болон малчдын тоо, бүсээр, эзлэх хувь

Хүснэгт 6. Малтай өрхийн тоо, малын бүлэглэлээр

Хүснэгт 7. Тариалан эрхэлж байгаа аж ахуйн нэгж болон өрхийн тоо

Хүснэгт 8. ХАА-н хоршоодын тоо, гишүүдийн тоо ба хувь нийлүүлсэн хөрөнгө

Хүснэгт 9. Хоршоодын гишүүд, тэдгээрийн санхүүгийн оролцоо

Хүснэгт 10. Голлох хөдөө аж ахуйн түүхий эдийн нөөцийн байршил

Хүснэгт 11.  Улаанбаатар хотоос алслагдсан байдал

Хүснэгт 12. Бэлтгэлийн тогтолцооны өөрчлөлт

Хүснэгт 13: Биржийн зөөлөн болон хатуу дэд бүтэц

Хүснэгт 14. Зах зээл, бирж болон брокерийн түвшин дэх зохицуулалт

Хүснэгт 15. Биржийн эрсдлүүд

Хүснэгт 16	Олон улсын биржийн харьцуулалт

Хүснэгт 17	ХААБ-ийгн бусад орны биржтэй харьцуулсан байдал

Хүснэгт 18. Бирж байгуулагдах урьдчилсан нөхцөл

Хүснэгт 19. Хөдөө аж ахуйн биржийн арилжааны өнөөгийн байдал

Хүснэгт 21. Хууль, журмын хэрэгжилт

Хүснэгт 22. Биржээр арилжаалсан ноолуур, мянган тонн

Хүснэгт 23. Биржээр арилжаалсан хонины ноос, мянган тонн

Хүснэгт 24. Хураамж, шимтгэл

Хүснэгт 25. 2021 оны эхний хагас жилийн ХААБ-ийн орлого

Хүснэгт 26. Ноолуурын нөөцийн байршил

Хүснэгт 27. Ноолуурын өрсөлдөх чадварын байдал

Хүснэгт 17. Ноолуурын салбарт хийсэн СВОТ шинжилгээ

Хүснэгт 28. Ноолуурын бэлтгэлийн хэмжээ, бүс, аймаг, сумдаар

Хүснэгт 29. Махны үйлдвэрлэл, нядалгааны жингээр

Хүснэгт 30. Махны нөөцийн байршил

Хүснэгт 31. Махны нөөц, үйлдвэрлэл, хэрэглээ ба экспорт, мянган тонн

Хүснэгт 32. Махны салбарт хийсэн СВОТ шинжилгээ

Хүснэгт 33. Махны бэлтгэлийн хэмжээ, мянган тонн, 2020 оноор

Хүснэгт 34. Махны бэлтгэлийн хэмжээ, бүс, аймаг, сумдаар

Хүснэгт 35. Ноосны нөөцийн байршил

Хүснэгт 36. Хонины ноосны нөөц, үйлдвэрлэл ба экспорт

Хүснэгт 37. Ноосны салбарт хийсэн СВОТ шинжилгээ

Хүснэгт 38. Хонины ноосны бэлтгэлийн хэмжээ, мянган тонн, 2020 оноор

Хүснэгт 39. Хонины ноосны бэлтгэлийн хэмжээ, бүс, аймаг, сумдаар

Хүснэгт 40. Арьс ширний нөөц

Хүснэгт 41. Арьс, ширний нөөцийн байршил, сая ширхэг

Хүснэгт 42. Бүс нутгууд дахь арьс ширэн түүхий эдийн бэлтгэл /түүхий эд тус бүрээр/

Хүснэгт 43.Үйлдвэрт тушаасан арьс ширний тоо хэмжээ, мян.ширхэг

Хүснэгт 44. Арьс ширний нөөц, үйлдвэрлэл, хэрэглээ ба экспорт, сая ширхэг

Хүснэгт 45. Арьс, ширний салбарт хийсэн СВОТ шинжилгээ

Хүснэгт 46. Бэлтгэсэн арьс, ширний тоо хэмжээ, сая ширхэг, 2019 оноор

Хүснэгт 47. Арьс ширний бэлтгэлийн хэмжээ, бүс, аймаг, сумдаар

Хүснэгт 48. Бэлтгэсэн сүүний үйлдвэрлэл, сая литр

Хүснэгт 49. Сүүний нийлүүлэлтийн нөөцийн байршил

Хүснэгт 50. Махны нөөц, үйлдвэрлэл, хэрэглээ ба экспорт, сая литр

Хүснэгт 51. СВОТ шинжилгээ

Хүснэгт 52. Сүүний нийлүүлэлтийн хэмжээ, сая литр, бүс, тэргүүлэх аймгаар 2020 он

Хүснэгт 53. Сүүний бэлтгэлийн хэмжээ, бүс, аймаг, сумдаар

Хүснэгт 54. Биржийн үйл ажиллагааны дотоод болон гадаад орчинд хийсэн СВОТ шинжилгээ

Хүснэгт 55. Биржийн гадаад орчны өөрчлөлтөд хийсэн PESTLE шинжилгээ

Хүснэгт 56. GAP шинжилгээ

Хүснэгт 57. Стратегийн төлөвлөгөө боловсруулах хүрээнд хийгдсэн нөхцөл байдлын шинжилгээний дүгнэлт

Хүснэгт 58. Стратеги төлөвлөгөөний зорилго, зорилтууд

Хүснэгт 59. Биржийн үйл ажиллагааны зарчим

Хүснэгт 60. Биржийн эко-системийн бүрэлдэхүүн

Хүснэгт 61. Алсын хараа, Эрхэм зорилго, зарчим

Хүснэгт 62. Хэрэгжүүлэх үе шат, хүрэх үр дүн

Хүснэгт 63. Хэрэгжүүлэх стратегийн зорилго, зорилтууд, түүний хүрэх үр дүн

Хүснэгт 64. Стратегийн үйл ажиллагааны төлөвлөгөө

Хүснэгт 65: Биржийн эрсдлийн төлөвлөгөө

Хүснэгт 66. Хөдөө аж ахуйн биржийн бүтэц, зохион байгуулалт, чиг үүргийн талаарх санал

**Диаграммын жагсаалт:**

Диаграмм 1. Биржийн стратеги төлөвлөгөө боловсруулах арга зүйн схем
Диаграмм 2: Салбарын бодлогын уялдаа
Диаграмм 3. Түүхий эдийн бэлтгэлийн тогтолцоонд тулгарсан асуудал
Диаграмм 4. Бирж байгуулах оролдлогууд
Диаграмм 5. Бирж байгуулснаар гарах хүлээлт
Диаграмм 6. Хөдөө биржийн тогтолцоо
Диаграмм 7. Ханган нийлүүлэлтийн тогтолцоо
Диаграмм 9. Биржийн бүтэц /одоогийн/
Диаграмм 10. Бирж байгуулагдахаас өмнөх бэлтгэн, нийлүүлэлтийн процесс
Диаграмм 11. Биржийн худалдааны процесс
Диаграмм 12. Махны бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоо
Диаграмм 13: Стратегийн зорилтын үе шат, хэрэгжүүлэх хугацаа
Диаграмм 14. Биржийн бүтэц, зохион байгуулалтын шинэчлэх санал
Диаграмм 15. Биржийн дэд, бүтэц, эко-системийн ерөнхий бүдүүвч
Диаграмм 16. Хөдөө аж ахуйг биржийн тогтолцоо

**Графикийн жагсаалт:**

График 1, МАА-н үйлдвэрлэл ба малын тоо толгой
График 2. ХАА-н үйлдвэрлэлийн ДНБ-д эзлэх хувь, бүсээр
График 3. Малын тоо толгой төрлөөр ба малын бүтэц, хувиар
График 4.Арилжаанд оролцсон брокерын тоо
График 5.Арилжааны бүртгэлийн дүн, тэрбум.төг
График 6. Биржээр арилжаалсан ноолуурын нийт арилжааны дүн, тэрбум.төг
График 7. Биржээр арилжааны ноолуурын үнэ, тоо хэмжээний уялдаа
График 8. Биржээр арилжаалсан ноосны дүн, тэрбум.төг
График 9. Биржээр арилжааны хонины ноосны үнэ, тоо хэмжээний уялдаа
График 10. Ямааны тоо толгой, ноолуурын хэмжээ
График 11. Хонины тоо болон ноосны хэмжээ

# Оршил

Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам, Дэлхийн банкны Экспортыг дэмжих төслийн нэгж, Монгол хөдөө аж ахуйн бирж, Монголын Ноос, ноолуурын холбоо, Монгол Хоршоодын нэгдсэн холбоо, Хөдөө аж ахуйн хоршоодын холбооны төлөөлөгчдөд хамтран ажиллаж, дэмжиж ажилласан талархал илэрхийлж байна.

Энэхүү судалгааг хийхэд хамтарч, дэмжиж ажилласан Дэлхийн банкны Экспортыг дэмжих төслийн нэгж, Хөдөө аж ахуйн биржийн удирдага, хамт олон дахин талархлаа илэрхийлж байна. Дэлхийн банкны Экспортыг дэмжих төслийн захиалгын дагуу "Хөдөө аж ахуйн бараа, түүхий эдийн бирж"-ийн стратеги төлөвлөгөө боловсруулах судалгааны ажлыг хийлээ.

Судалгааны зорилго нь Хөдөө аж ахуйн бараа, түүхий эдийн экспортыг хөгжүүлэхэд чиглэсэн Хөдөө аж ахуй бараа, түүхий эд биржийн өнөөгийн байдал, цаашдын төлөвт дүн шинжилгээ хийж, тулгамдсан асуудлыг тодорхойлж (gap analysis), түүний үндсэн дээр ХААБ-ийг хөгжүүлэх стратеги төлөвлөгөө боловсруулахад чиглэсэн.

Хөдөө аж ахуйн салбар нь эдийн засгийн гол тулгуур салбарын нэг бөгөөд төрөс дэмжих, зохион байгуулалтын худалдааны хэлбэрт оруулах шаардлагатай салбар юм. Хөдөө аж ахуйн салбар нь 2020 оны байдлаар ДНБ-ний 12.2 хувь, экспортын орлогын мөн 12.0 орчим хувь, хөдөлмөр эрхлэлтийн 23.2 хувь, улсын төсвийн зардлын 3.1 хувийг эзэлж байгаа нь уг салбарын эдийн засагт томоохон оруулах хувь нэмэр оруулж байгааг харуулж байна. Гэсэн хэдий хөдөө аж ахуйн салбарт зарим хүндрэл, сорилтууд, сайжруулах шаардлага тулгарсан хэвээр байна. Үүнд:

- Сүүлийн жилүүдэд улсын хэмжээгээр хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний ДНБ-д эзлэх хувь хэмжээ буурсаар байна. Тухайлбал, 2000 онд 19.6 хувьтай байснаа 2020 онд 12.2 хувь болж буурсан. Харин аймаг, орон нутгийн эдийн засагт хөдөө аж ахуйн салбар томоохон үүрэгтэй хэвээр байгааг дурдах нь зүйтэй юм.
- Хөдөө аж ахуйн салбарт ажиллагсдын тоо, мөн нийт экспортод эзлэх хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний экспортын хэмжээ буурсаар байна. Хөдөө аж ахуйн экспортод түүхий болон хагас боловсруулсан бараа, түүхий эд зонхилж байна.
- Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл өссөн хэдий ч хэрхэн хаана яаж борлуулах асуудал тулгамдсан гол асуудал болоод байна.

2011 онд Хөдөө аж ахуйн биржийн тухай хууль батлагдаж, хөдөө аж ахуйн бирж байгуулагдах үндэс тавигдсан. 2013-2020 онд хөдөө аж ахуйн бирж нь 1339 удаагийн кросс арилжаагаар нийт 4.2 их наяд төгрөгийн бүтээгдэхүүн арилжаа бүртгэгдсэн байгаа нь мөн хугацаанд ДНБ-ний 1.9 хувь, Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн 15.3 хувьтай тэнцэж байна. Гэсэн хэдий ч хөдөө аж ахуйн биржийн өнөөгийн үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр биржийн үйл ажиллагаа боловсронгуй болгох, шинэчлэх шаардлагатай тулгарч байна.

Судалгааны хүрээнд эхний шатанд хөдөө аж ахуйн гол нэр төрлийн бараа, түүхий эдийн зах зээл (ноос, ноолуур, арьс, шир, мах, сүү, сүүн бүтээгдэхүүн)-ийн талаарх судалгаа хийж, зах зээлийн боломжийг тодорхойлсон. Хөдөө аж ахуйн биржийн өнөөгийн байдалд нөхцөл байдал (SWOT, PESTLE болон Gap analysis)-ын дүн шинжилгээ хийлээ. Зах зээлийн судалгаа болон нөхцөл байдлын шинжилгээнд суурилан одоогийн болон

цаашдын зорилтын хоорондох зөрүүг тогтоож, шалтгааныг тодруулж, бодит нөхцөлд хэрэгжүүлэх боломж байгаа эсэх, тулгарч болох эрсдлүүдийн талаар судалсан.

Дараах ерөнхий дүгнэлтэд хүрээд байна. Үүнд:

- Хөдөө аж ахуйн бараа, түүхий эдийн биржийн бэлтгэл ажлыг сайтар хангаж чадаагүй үйл ажиллагаагаа эхлүүлжээ.
- Хөдөө аж ахуйн биржийн үйл ажиллагааг хянан зохицуулах үүрэг бүхий Биржийн Зохицуулах Зөвлөл нь хуулийн дагуу үүрэг, үйл ажиллагаагаа бүрэн хэрэгжүүлж чадаагүй байна.
- Орон нутагт хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийг бэлтгэх, ангилах, ялгах, баталгаажуулах агуулахын аж ахуй хөгжөөгүй байна. Энэхүү агуулахын аж ахуйн нь биржийн арилжааны байнгын гишүүн оролцогч (брокер) болон байнгын бус гишүүн оролцогч (хоршоо)-ны итгэмжлэгдсэн агуулах байх бөгөөд агуулах нь биржээс итгэмжлэгдсэн тээвэр ложистик болон лабораторитой холбогдон арилжааны системд оролцох ёстой бөгөөд эдгээр ажлууд орхигдсон байна.
- Биржийн арилжаа нээлттэй, ил тод явагдахгүй байна.
- Биржийн оролцогчдыг татах, итгэлцэл, мэдээлэл, санхүүгийн урсгалыг олон улсын биржийн жишгээр бүрдүүлээгүй байна.
- Улсын төсвөөс биржид шаардлагатай хөрөнгө оруулалт, дэмжлэгийг хангалттай хэмжээнд оруулаагүй байна.
- Хөдөө аж ахуйн биржийн хуулийн хэрэгжилт хангалтгүй, биржийн хуулийг бүрэн ашиглаж чадаагүй байна.

# НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. СУДАЛГААНЫ АЖЛЫН ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ

## 1.1. Үндэслэл

Хөдөө аж ахуйн салбар нь эдийн засгийн гол тулгуур салбарын нэг юм. Хөдөө аж ахуйн салбар нь 2020 оны байдлаар ДНБ-ний 12.2 хувь, экспортын орлогын мөн 12.0 орчим хувь, хөдөлмөр эрхлэлтийн 23.2 хувь, улсын төсвийн зардлын 3.1 хувийг эзэлж байгаа нь уг салбарын эдийн засагт томоохон оруулах хувь нэмэр оруулж байгааг харуулж байна. Мөн хөдөө аж ахуй нь санхүүгийн хямралтай үеүдэд ч гэсэн эдийн засгийн хүндрэлээс даван гарах тэргүүлэх салбар юм. Тухайлбал, 2009 онд эдийн засгийн бодит өсөлт -1.3 хувьтай байхад хөдөө аж ахуйн салбарын өсөлт 3.6 хувь, 2020 онд эдийн засгийн бодит өсөлт -4.9 хувийн уналттай байхад хөдөө аж ахуйн салбарт 5.8 хувийн өсөлттэй гарсан нь томоохон жишээ болж байна. Гэсэн хэдий хөдөө аж ахуйн салбарт зарим хүндрэл, сорилтууд, сайжруулах шаардлага тулгарсан хэвээр байна. Үүнд:

- Сүүлийн жилүүдэд улсын хэмжээгээр хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний ДНБ-д эзлэх хувь хэмжээ буурсаар байна. Тухайлбал, 2000 онд 19.6 хувьтай байснаа 2020 онд 12.2 хувь болж буурсан. Харин аймаг, орон нутгийн эдийн засагт хөдөө аж ахуйн салбар томоохон үүрэгтэй хэвээр байгааг дурдах нь зүйтэй юм.
- Хөдөө аж ахуйн салбарт ажиллагсдын тоо, мөн нийт экспортод эзлэх хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний экспортын хэмжээ буурсаар байна. Хөдөө аж ахуйн экспортод түүхий болон хагас боловсруулсан бараа, түүхий эд зонхилж байна.
- Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл өссөн хэдий ч хэрхэн хаана яаж борлуулах асуудал тулгамдсан гол асуудал болоод байна.

2011 онд Хөдөө аж ахуйн биржийн тухай хууль батлагдаж, хөдөө аж ахуйн бирж байгуулагдах үндэс тавигдсан. 2013-2020 онд хөдөө аж ахуйн бирж нь 1339 удаагийн кросс арилжаагаар нийт 4.2 их наяд төгрөгийн бүтээгдэхүүн арилжаа бүртгэгдсэн байгаа нь мөн хугацаанд ДНБ-ний 1.9 хувь, Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн 15.3 хувьтай тэнцэж байна.

Гэсэн хэдий ч хөдөө аж ахуйн биржийн өнөөгийн үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр биржийн үйл ажиллагаа боловсронгуй болгох, шинэчлэх шаардлагатай тулгарч байна. Үүнд:

| Үзүүлэлт: | Одоогийн нөхцөл байдалд: |
|---|---|
| Бүтээгдэхүүний чанар | Малчид, тариаланчид, хоршоодын дийлэнх нь түүхий эдийг бэлтгэхдээ үндэсний стандартын дагуу анхан шатны тордолт хийхгүйгээр завсрын худалдаачдад шууд арилжиж байгаа нь түүхий эдийн чанар буурахад нөлөөлж, улмаар түүхий эдийн бэлтгэлийн тогтолцоо алдагдсан байгааг харуулж байна. Иймд үндэсний стандартад нийцсэн чанартай бараа, түүхий эдийг малчид, тариаланчид болон хоршоодын оролцоотойгоор бэлтгэн, баталгаажуулж, биржийн арилжаагаар дамжуулан хэрэглэгчдэд хүргэх нь чухал байна. |
| Баталгаат нийлүүлэлтийн тогтолцоо | Дархан болон Ховд аймаг, Эмээлтэд арьс, ширний аж үйлдвэрийн парк шинээр байгуулагдаж байгаа бөгөөд эдгээр паркуудад нийт 11.0 сая ширхэг арьс, шир болон түүхий эдээр |

| | |
|---|---|
| | хангах хэрэгцээ гарч байна. Дотоодын үйлдвэрүүдийг чанартай түүхий эдээр тогтвортой хангахын тулд биржийн арилжааны системийг ашиглан түүхий эдэд анхан шатны тордолт хийж, бэлтгэн нийлүүлэх баталгаат тогтолцоо үгүйлэгдэж байна. |
| Биржээс үзүүлэх үйлчилгээний төрөл | Мэдээллийн үйлчилгээ: Биржийн арилжаа болон арилжааны зах зээлд оролцогчдыг биржийн арилжаатай холбоотой зах зээлийн бодит мэдээ, мэдээллээр хангах мэдээллийн урсгал хангалтгүй байна. Үйлдвэрлэгчдийн түүхий эд бэлтгэл, анхан шатны тордолт, тээврийн үйл ажиллагааг хөнгөвчлөх цогц үйлчилгээ үзүүлж чадахгүй байна. |
| Арилжаа | Хөдөө аж ахуйн бирж нь ил тод, нээлттэй, бие даасан зарчимд үндэслэн зах зээлийн шударга өрсөлдөөний нөхцлөөр арижаа хийж, олон оролцогчдын татах бөгөөд энэ нөхцөл хангагдсан арилжаа хийгдэж чадахгүй байгаа нь судалгааны үр дүнгээс харагдсан. Зөвхөн борлуулагч, худалдан авагч хоёр талын гэрээнд үндэслэн кросс арилжаа хийж байна. Энэ нь арилжаа олон нийтэд ил тод биш, мөн биржийн арилжаанд оролцогчдод нээлттэй бус байх шалтгаан болж байна. Мөн Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийг судлан, эрэлт хэрэгцээ өндөр байгаа түүхий эдийг арилжаалах нь зүйтэй байна. |

Энэхүү судалгааг хийхийн тулд дараах асуултуудад хариулт өгөх шаардлагатай байна. Үүнд:

- Хөдөө аж ахуйн биржийн үйл ажиллагааг боловсронгуй болгох, шинэчлэх шаардлага байна уу?
- Хэрэв боловсронгуй болгож, шинэчлэх шаардлагатай гэвэл бирж юу хийх хэрэгтэй вэ?
- Сонгодог утгаар нь биржийн үйл ажиллагаа явуулахад ямар хүндрэлүүд гарч байгаа, түүнийг хэрхэн шийдвэрлэж болох уу?
- Биржийн стратеги зорилт юу вэ? Энэхүү зорилтод хүрэхийн тулд боломж болон эрсдэл юу байна уу, хэрхэн төлөвлөх үү? Ямар хугацаанд одоогийн нөөцийг хэрхэн үр ашигтай ашиглаж хүрч болох уу?
- Малчид, тариаланчдын орлогыг нэмэгдүүлэхэд хоршоогоор дамжуулан тэдний үүрэг, оролцоог хэрхэн нэмэгдүүлж болох, нөгөө талдаа үйлдвэрүүдийг түүхий эдээр хэрхэн тогтвортой хангаж болох, гадаад худалдаачдыг түүхий эд бэлтгэлийн тогтолцоонд оролцуулахгүй байх боломж байна уу?
- Ирээдүйн гэрээний арилжаа буюу форвард, фьючерсийн арилжааг нэвтрүүлэхэд ямар асуудлууд тулгарч байна уу, хэрхэн шийдвэрлэх үү? зэрэг болно.

Иймд биржийн бүтээгдэхүүний арилжааны үйл ажиллагааг ил тод, үр ашигтай байлгах, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний чанар, үнэлэмжийг сайжруулах, баталгаажуулах замаар биржийн нэр хүнд, итгэлцлийг өсгөх, биржийн зах зээлийг хөгжүүлэх шаардлагатай байна. Дээрх үндэслэлээр хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний биржийг үйл ажиллагааг сайжруулах, хөгжүүлэх стратеги төлөвлөгөө боловсруулах үндэслэл болж байна.

## 1.2. Зорилго, зорилт

Ноос, ноолуур, арьс, шир, мах, сүү, сүүн бүтээгдэхүүний дотоодын зах зээлийн багтаамж, боломж, орон зайг тодорхойлж, хөдөө аж ахуйн биржийн өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж, биржийн үйл ажиллагааг цаашид ямар үе шаттайгаар хэрхэн сайжруулах, шинэчлэх шаардлагатай байгаа талаар дүн шинжилгээ хийсний үндсэн дээр хөдөө аж ахуйн биржийг хөгжүүлэх стратеги төлөвлөгөө боловсруулахаар зорилоо.

Үүний тулд дараах зорилтуудыг дэвшүүлсэн.

**Зорилт 1**. Мал аж ахуйн гол нэр төрлийн бүтээгдэхүүн болох ноос, ноолуур, арьс, шир, мах, сүүн бүтээгдэхүүний зах зээлийн судалгааг хийх;

**Зорилт 2.** Хөдөө аж ахуйн биржийн өнөөгийн байдалд хийсэн нөхцөл байдлын шинжилгээ, зах зээлийн боломж, олон улсын сайн туршлага зэрэгт тулгуурлан хөдөө аж ахуйн биржийн үйл ажиллагааг сайжруулах, шинэчлэх боломж байгаа талаар тодорхойлох.

**Зорилт 3**. Хөдөө аж ахуйн биржийн өнөөгийн байдал, цаашдын хандлагын талаар нарийвчлан судалж, тулгамдаж байгаа асуудал бүрийн шалтгаан, эрсдлүүдийг илрүүлж, шийдвэрлэх боломжийн талаар санал, зөвлөмж гаргах.

**Зорилт 4**. Нөхцөл байдлын шинжилгээнд суурилан стратегиийн төлөвлөгөөний зорилго, зорилтуудыг тодорхойлох.

**Зорилт 5**. Хөдөө аж ахуйн биржийн стратеги төлөвлөгөө боловсруулах. Үүний тулд стратеги төлөвлөгөө нь дараах хүрээг хамарсан байна. Үүнд:

1) Биржийн хөгжлийн стратегийн чиглэлийг тодорхойлох;
2) Биржийн үйл ажиллагаа, бизнесийн боломжийг тодорхойлох;
3) Биржийн эрсдлийн үнэлгээ болон эрсдлийг бууруулах төлөвлөгөө боловсруулах;
4) Биржийн хууль, эрх зүйн орчинд хийх сайжруулалт;
5) Биржийн платформд үнэлгээ хийх, санал боловсруулах;
6) Төсөвтэй уялдсан биржийн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах;
7) Биржийн тохиромжтой байгууллагын бүтэц зохион байгуулалтын талаар санал дэвшүүлэх, ингэхдээ ажлын байрын тодорхойлолттой уялдуулна.
8) Биржийн санхүүгийн прогноз хийнэ.

## 1.3. Ажлын цар хүрээ, судалгааны аргачлал

Судалгааны хүрээнд дараах хүрээг хамруулан хөдөө аж ахуйн биржийн өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийсэн болно. Үүнд:

1) Биржийн бүтэц зохион байгуулалтын судалгаа (гишүүнчлэл, менежмент г.м);
2) Бүтээгдэхүүн ба үйлчилгээний судалгаа (бүтээгдэхүүн, үйлчилгээ, арилжаа, маржин шаардлага, төлбөр хураамж гэх мэт);
3) Хууль, эрх зүйн орчны шинжилгээ (Хууль, дүрэм, журмын хэрэгжилт, хяналт, гишүүнчлэлийн гүйцэтгэлийн хяналт, арилжаа болон арилжааны зах зээлд оролцогчдын төлөв байдал, хандлага);
4) Хүний нөөцийн судалгаа
5) Бизнес процессийн судалгаа (бэлтгэл, нийлүүлэлтийн тогтолцоо, биржийн арилжааны зах зээлд оролцогчид, агуулах, төлбөр тооцоо г.м)
6) Биржийн капиталын судалгаа (тоног төхөөрөмж, хатуу болон зөөлөн дэд бүтэц, программ хангамж г.м)

Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зах зээлд оролцогчдын дараах төлөөлөлтэй уулзалт зохион байгуулсан. Үүнд:

- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам;
- Хөдөө аж ахуйн бирж;
- Ноос, ноолуурын холбоо;
- Бэлчээр ашиглалтын нэгдсэн холбоо;
- Монголын Хоршоологчдын нэгдсэн холбоо зэрэг болно.

Хөдөө аж ахуйн бирж, биржийн арилжааны зах зээлд оролцогч байгууллагуудаас авсан статистик тоо мэдээлэл болон тайлан, ижил төстэй судалгааны ажлын тайлан материал цуглуулж, дүн шинжилгээ шинжилгээ дүгнэлт боловсруулсан. Эдгээр ажлыг дараах бүлгүүдэд хувааж авч үзэж байна:

1. Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн салбарт баримтлах бодлого, хөтөлбөр, хэрэгжилтийн тайлан.
2. Хөдөө аж ахуйн биржийн 2012 онд боловсруулагдсан техник, эдийн засгийн үндэслэл, 2017 онд баталж, хэрэгжүүлж байгаа 2017-2021 онд хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөө, түүний хэрэгжилт
3. Хөдөө аж ахуйн биржийн тайлан, мэдээлэл
4. Мэдээ, статистик тоо баримт.
5. Биржийн зах зээлийн арилжаанд оролцогч байгууллагуудаас авсан мэдээ, мэдээлэл
6. Үйл ажиллагаа нь өргөжин тэлж байгаа хөгжиж буй орнуудын хөдөө аж ахуйн биржийн үйл ажиллагаатай холбоотой судалгааны тайлангууд хамрагдна.

Биржийн стратеги төлөвлөгөө боловсруулах хэрэгцээ шаардлага, стратегийн зорилтыг тодорхойлохын тулд зах зээлийн болон нөхцөл байдал (swot, pestle, gap шинжилгээ, зах зээлийн шинжилгээ) шинжилгээ хийлээ.

Стратегийн хэрэгцээ шаардлагад тулгуурлан биржийн хөгжлийн стратеги төлөвлөгөө боловсруулсан. PESTLE шинжилгээний хүрээнд Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн салбарт баримтлах бодлого, хөтөлбөр, арга хэмжээ, хууль эрх зүйн орчин, мөн Монгол Улсын макро эдийн засгийн орчин, техник технологи болон нийгмийн хандлагад гарч байгаа өөрчлөлт, хандлагуудын талаар тусгаж, эдгээр өөрчлөлт, хөдөлгөөн нь нь хөдөө аж ахуйн биржийн үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлж байгаа, ямар эрсдлүүд тулгарч байгаа зэргийг судлахад чиглэсэн.

SWOT шинжилгээний хүрээнд биржийн давуу, сул, боломж болон аюулын талаар судалж, хөдөө аж ахуйн түүхий эд бэлтгэн нийлүүлэлт, биржийн арилжааны болон арилжааны зах зээлийн тогтолцоо, биржийн бүтэц, зохион байгуулалт, арилжаа, биржээс үзүүлж байгаа үйлчилгээ, биржээр арилжих бараа, бүтээгдэхүүн, биржийн хүний нөөц, маркетинг, менежментийн бодлого, биржид ашиглаж байгаа тоног төхөөрөмж, дэд бүтэц, платформын ашиглалт, арилжаанд болон арилжааны зах зээл оролцогчдын оролцооны байдлыг хамруулан авч үзсэн.

**Диаграмм 1.** Биржийн стратеги төлөвлөгөө боловсруулах арга зүйн схем




Стратеги төвлөгөөний зорилгын хувилбарыг сонгохдоо дараах судалгаа хийсний үндсэн дээр тодорхойлогдоно. Үүнд:

- SWOT шинжилгээ: Энэхүү шинжилгээний хувьд биржийн дотоод болон гадаад орчны талаар шинжилгээ хийж, биржийн дотоод орчны давуу ба сул байдал, гадаад орчноос нөлөөлж байгаа боломж ба аюулын талаар үнэлсэн.
- PESTLE шинжилгээ: Энэ шинжилгээний макро гадаад орчны шинжилгээ бөгөөд төрийн бодлого, хууль эрх зүйн орчин, эдийн засаг, нийгэм, техник технологийн хөгжил, өөрчлөлттэй уялдуулан биржийн үйл ажиллагааг хэрхэн хөгжүүлэх талаар тодруулан харуулахад чиглэсэн.
- Зах зээлийн шинжилгээ: Гол нэр төрлийн мал аж ахуйн гаралтай түүхий эд болох ноос, ноолуур, арьс, шир, мах, сүүн бүтээгдэхүүний нөөц, үйлдвэрлэл, бэлтгэлийн тогтолцоо, малчид, хоршоодын оролцооны талаар судалж, зах зээлийн боломж, потенциалыг тодорхойлоход чиглэсэн судалгаа юм.
- GAP шинжилгээ: Зах зээлийн боломж, биржийн үйл ажиллагаан дахь өнөөгийн нөхцөл байдлын шинжилгээнд тулгуурлан стратеги төлөвлөгөөний зорилгыг тодорхойлох бөгөөд тэрхүү зорилгод хүрэхийн тулд ямар зорилтууд тавигдах, тэрхүү зорилго, зорилтод хүрэхийн тулд өнөөгийн биржийн үйл ажиллагаанд ямар ямар асуудлууд тулгарч байгаа, тэдгээр асуудал, эрсдлүүдийг хэрхэн давж гарах боломжтой талаар gap шинжилгээ хийгдсэн.
- Эдгээр шинжилгээг цогцоор нь үнэлж, дүгнэн бодитоор хэрэгжих боломжтой урт, дунд болон богино хугацааны стратеги төлөвлөгөөний сонголтыг хийсэн.
- Энэхүү сонголтоос биржийн үйл ажиллагааг боловсронгуй болгож шинэчилснээр боломжууд болон тулгарч болох эрсдлүүдийн талаар судалж, эрсдлийн төлөвлөгөө, стратеги төлөвлөгөөний дизайныг боловсруулсан.
- Стратеги төлөвлөгөө боловсруулахын зэрэгцээ энэхүү стратеги төлөвлөгөөг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд биржийн бүтэц, зохион байгуулалт, санхүүгийн төсөөлөл, тооцоолол, бүтээгдэхүүн, биржийн арилжааны төрөл, биржийн үйл ажиллагаатай холбоотой тооцоо, судалгаа хийсэн.

**Мэдээллийн эх үүсвэрийн тухайд:**

Хөдөө аж ахуйн бараа, түүхий эдийн биржийн хөгжлийн үе шат, үйл ажиллагааны болон арилжааны төрөл, тэдгээрийн онцлог, бүтэц зохион байгуулалт, арилжааны механизм, хууль, эрх зүйн зохицуулалт, биржийн зах зээлд үзүүлэх нөлөө, гүйцэтгэх үүргийн талаар ХААБ-ийн болон олон улсын биржүүдийн цахим тоон мэдээлэл, мөн чиглэлээр өмнө хийгдсэн судалгааны ажлын тайлан зэргийг цуглуулсан. Энэхүү судалгааны ажлын зорилгоор цуглуулсан мэдээллийн голлох эх сурвалжийг дараах байдлаар ангилж байна. Үүнд:

1) Хууль тогтоомж, дүрэм журмын мэдээлэл:
   - Хуулийн цахим мэдээллийн сан - http://www.legalinfo.mn: Тус цахим хуудаснаас Монгол Улсын хууль тогтоомж, Засгийн газрын тогтоол, Сайдын тушаал болон холбогдох дүрэм, журмуудыг авсан .
   - ХААБиржийн тухай хууль, үйл ажиллагааны журам: Биржийн тухай хууль, үйл ажиллагааны журмыг авсан болно
2) Тоон мэдээллийн сан:
   - Үндэсний статистикийн хорооны мэдээллийн сан - htpp://www.1212.mn: Монгол Улсын нийгэм, эдийн засаг, ажиллах хүчний болон ХАА-н салбарын үзүүлэлтүүдийн тоон мэдээллийг энэ цахим хуудаснаас авсан болно. Түүнчлэн ҮСХ-ноос гаргасан статистикийн жилийн эмхэтгэл, судалгааны ажлын тайлан;
   - Монгол Улстай холбоотой бусад статистик мэдээллийн сан: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Мэргэжлийн холбоод болон бусад байгууллагуудаас мэдээлэл;
   - Олон улсын статистик мэдээллийн сан: UNCTAD, Дэлхийн Банк, ОУВС, сонгогдсон орнуудын хөдөө аж ахуйн бирж зэрэг олон улсын байгууллагын албан ёсны цахим хуудас;
3) Биржийн арилжааны зах зээлд оролцогч байгууллагуудын төлөөлөлтэй уулзалт зохион байгуулсны үндсэн дээр судалгааны ажил хийгдсэн.

Энэхүү судалгааг хийснээр дараах үр дүн гарахаар хүлээгдэж байна. Үүнд:

- Ирээдүйн гэрээний арилжаа хийх нөхцлийг бүрдүүлэх;
- Биржийн арилжаанд оролцогчдын тоог нэмэгдүүлэх;
- Биржээр чанартай, баталгаатай бараа, түүхий эд арилжаалах баталгаажуулалтын тогтолцоог бүрдүүлэх;
- Биржийн арилжаа болон биржийн арилжааны зах зээлд оролцогчдын мэдлэг чадварыг тогтмол сайжруулах нөхцлийг бүрдүүлэх;
- Биржийн мэдээллийн урсгал, маркетингийн бодлогыг оновчтой төлөвлөх;
- Биржийн үйл ажиллагаанд тулгарч болох эрсдлүүдийг тооцоолон эрдслийн төлөвлөгөө боловсруулах
- Төсөвтэй үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах;
- Биржийн үйл ажиллагааг шинэчлэж байгаатай уялдуулан зохистой удирдлага зохион байгуулалтын бүтцийг танилцуулна. Судалгааны ажил нь 6 бүлгээс бүрдсэн.

# ХОЁРДУГААР БҮЛЭГ. ХӨДӨӨ АЖ АХУЙН БИРЖИЙН БАРИМТ БИЧИГТ ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

## 2.1. 2012 оны бирж байгуулах техник, эдийн үндэслэл

2012 онд боловсруулсан Хөдөө аж ахуйн бирж байгуулах техник, эдийн засгийн үндэслэлд дүн шинжилгээ хийлээ. Энэхүү техник, эдийн засгийн үндэслэл нь 3 бүлэг, 19 дэд сэдвийн хүрээнд боловсруулагдсан бөгөөд Хөдөө аж ахуйн биржийн үйл ажиллагааг эхлүүлэх, хэвийн явуулахад чиглэсэн бодлогын баримт бичиг болсон байна. Эхний бүлэгт төсөл боловсруулах арга зүй, аргачлал, хоёрдугаар бүлэгт зах зээлийн судалгаа, гуравдугаар бүлэгт зах зээлийн судалгаанд суурилан боловсруулагдсан төслийн үзүүлэлтүүдийн талаар дурдсан байна. Зах зээлийн судалгааны хүрээнд мал аж ахуй, газар тариалангийн салбарт баримтлаж байгаа төрийн оролцоо, бодлого, хөтөлбөр арга хэмжээний талаар тусгаж, мөн биржээр арилжаалах боломжтой бараа, түүхий эдийн жагсаалт гаргаж, барааны чанар, гарал үүслийн баталгаа гаргах, хэрэгжүүлэх тогтолцооны талаар судалжээ. Биржээр арилжаалах бүтээгдэхүүн, түүний чанарын тогтолцоотой уялдуулан биржийн эрх зүйн орчин, түүний хүрээнд зохион байгуулагдах биржийн статус, бүтэц, зохион байгуулалт, хүний нөөц, маркетинг болон менежментийн төлөвлөлт, биржийн арилжаанд оролцогчид, биржид тулгарч болох эрсдлүүд, санхүүгийн төлөвлөлт, үр ашиг болон хэрэгжүүлэх үе шатын талаар судалсан байна.

## 2.2. 2017 онд баталсан биржийн стратеги төлөвлөгөө

Судалгааны хүрээнд 2017 онд боловсруулж, баталсан “Хөдөө аж ахуйн биржийн 2017-2020 онд хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөө”-нд дүн шинжилгээ хийсэн. Хөдөө аж ахуйн бирж нь байгуулагдсан цагаас хойш 5 жилийн дараа буюу 2017 онд Хөдөө аж ахуйн биржийн 2017-2020 онд стратеги төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлсэн байна. Агуулгын хувьд стратеги төлөвлөгөө нь гадаад, дотоод орчны шинжилгээ хийж, зорилтод зах зээл болон үүсмэл зах зээлийн арилжааны талаар дэлгэрэнгүй тусгаж, үүнтэй уялдуулан бизнес төлөвлөгөө боловсруулжээ. Энэхүү стратеги төлөвлөгөөний зорилго, зорилт нь ложистикийн төв байгуулах, биржийн дэд бүтцийг сайжруулах замаар биржийн бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулах, биржийн арилжаанд оролцогчдын тоо, оролцоог нэмэгдүүлэх, компанийн засаглал болон зах зээлийн хөрвөх чадварыг сайжруулахад чиглэжээ.

## 2.3. 2011-2020 онд батлагдсан биржийн хууль, дүрэм, журам

Хөдөө аж ахуйн бараа, түүхий эд бэлтгэлийг хуулийг 2011 онд баталсан. Өнгөрсөн хугацаанд энэхүү хуульд 2013-2018 онуудад 5 удаагийн өөрчлөлт оруулжээ.

**Хүснэгт 1.** Хөдөө аж ахуйн биржийн хуульд оруулсан өөрчлөлт

| Өөрчлөлт оруулсан огноо | Хуучин заалт | Өөрчлөгдсөн заалт |
|---|---|---|
| **2013.5.24** | Хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-т:<br>Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24, 25 дугаар зүйл гэснийг ...<br><br>Хуулийн 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсэгт:<br>Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20.4 болон ... гэснийг | Үнэт цаасны зах зээлийн тухай 42, 44, 45 дугаар зүйлд гэж,<br><br>Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4 дүгээр бүлэгт гэж |

| | | |
|---|---|---|
| **2015.11.10** | Хуулийн 8 дугаар зүйлийн 8.8 дах хэсэгт:<br>Зохицуулах Зөвлөл нь ажлын албатай байна гэснийг | Хүчингүй болгосон |
| **2015.12.04** | Хуулийн 16 дугаар зүйл:<br>16.1-т Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль тогтоомж зөрчсөн гэм буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүйгээр бол эрх бүхий байцаагч зөрчлийн байдлыг харгалзан хариуцлага хүлээлгэх гэснийг | Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль эсхүл Зөрчлийн хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ гэж |
| **2017.12.21** | Хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т:<br>.... чанарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага гэснийг | .... тохирлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага гэж |
| **2018.11.15** | Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2-т:<br><br>Биржээр арилжих хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эд гэж биржээр арилжих барааны жагсаалтад орсон, гарал үүсэл, чанарын гэрчилгээтэй, биржийн гэрээний стандартыг хангасан бараа, түүхий эдийг гэснийг<br><br>11.1.2-т:<br><br>Стандартын /бэлтгэх, хадгалах, тээвэрлэх, баглаа боодлын/ дагуу бэлтгэн сумын мал эмнэлэг, үржлийн тасагт бүртгүүлж, мэргэжлийн хяналтын байцаагчийг дүгнэлт гаргуулсан бараа, түүхий эд арилжих гэснийг | Биржээр арилжих хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эд гэж биржээр арилжих барааны жагсаалтад орсон, гарал үүсэл, чанарын болон мал эмнэлэгийн, лабораторийн гэрчилгээтэй, биржийн гэрээний стандартыг хангасан бараа, түүхий эдийг гэж<br><br>Стандартын /бэлтгэх, хадгалах, тээвэрлэх, баглаа боодлын/ дагуу бэлтгэн сум, дүүргийн хөдөө аж ахуйн мэдээллийн санд бүртгүүлж, мал эмнэлэгийн болон лабораторийн магадлан шинжилгээний гэрчилгээ авсан бараа, түүхий эдийг арилжих гэж |

Эдгээр хуулийн өөрчлөлтөөр хууль зөрчсөн биржийн оролцогчдод хүлээлгэх хариуцлага нэмэгдсэн, биржээр арилжих бүтээгдэхүүнийг мэдээллийн санд бүртгүүлэх, биржийн Зохицуулах зөвлөлийн ажлыг албыг татан буулгасан зэрэг өөрчлөлтүүд орсон байна. Суманд мэргэжлийн хяналтын байцаагч ажилладагүй бөгөөд малын гаралтай бараа, түүхий эдийн бэлтгэлд сумын мал эмнэлэг болон биржийн итгэмжлэгдсэн лабораторийн магадлан шинжилгээгээр бараа, түүхий эдийг биржээр арилжихаар зохицуулсан. 2013-2021 оны хугацаанд нийт 20 орчим дүрэм, журам батлагдсан байна. 2013 онд Арилжааны танхимын дотоод журам, Бараа, түүхий эд коджуулах журам боловсруулж баталжээ. 2015 онд Биржийн үйл ажиллагааны ерөнхий журам, ХААБ-ийн бус гишүүнд тавигдах шалгуур үзүүлэлт зэргийг, харин 2016 онд Арилжааны журам, Хяналтын журам, Гишүүнчлэлийн журам зэрэг гол журмуудыг баталж, хэрэгжүүлж байна. Бусад журмуудыг 2020-2021 онуудад баталжээ.

**Хүснэгт 2.** Биржийн дүрэм, журам

| Журам | Огноо | Хариуцсан алба |
|---|---|---|
| - Арилжааны журам | 2016.04 | Арилжааны алба |
| - Арилжааны танхимын дотоод журам | 2013.11.05 | |
| - ХААБ-ээр арилжих бараа, түүхий эдийн тодорхойлолт олгож журам | 2021.4.12 | |
| - Хяналтын журам | 2016.4.6 | Бинзес хөгжүүлэлтийн алба |
| - Биржийн хяналтын журам | төслийн шатанд | |

| | | |
|---|---|---|
| - Биржийн эрсдлийн удирдлагын журам | төслийн шатанд | |
| - Биржийн дүрэм | 2020.10.08 | Захиргааны алба |
| - Биржийн үйл ажиллагааны ерөнхий журам | 2015.6.25 | |
| - Бараа, түүхий эд коджуулах журам | 2013.3.7 | |
| - Биржийн ажилтны ёс зүйн дүрэм | 2020.12.14 | |
| - Хөдөлмөрийн дотоод журам | 2020.11.05 | |
| - Гишүүнчлэлийн журам | 2016.4.6 | Төлбөр тооцоо, клирингийн алба |
| - Төлбөр тооцооны журам | 2017.2.8 | |
| - ХААБ-ийн бус гишүүнд тавигдах шалгуур үзүүлэлт | 2015.1.20 | |
| - Гишүүнчлэлийн журам | Шинэчлэн боловсруулж байна. Төслийн шатанд явж байна. | |
| - Төлбөр тооцооны журам | | |
| - ХААБ-ийн бус гишүүнд тавигдах шалгуур үзүүлэлт | | |
| - Итгэмжлэлийн журам | 2021.1.7 | Ложистикийн алба |
| - Агуулахад тавигдах итгэмжлэлийн шалгуур үзүүлэлт (мах, махан бүтээгдэхүүн, тосны ургамал, хүнсний буудай, арьс шир, ...) | 2021.1.7 | |
| - Тээвэрлэгчид тавих итгэмжлэлийн шалгуур үзүүлэлт | 2021.1.7 | |
| - Сорилтын лабораторит тавих итгэмжлэлийн шалгуур үзүүлэлт | 2021.1.7 | |

## 2.4. Дэд дүгнэлт

Хөдөө аж ахуйн биржийг байгуулах техник, эдийн засгийн үндэслэлд суурилан стратеги төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх ажил хийгдээгүй, тус ТЭЗЗ-д тусгагдсан зорилго, зорилтын дагуу ажлууд хийгдээгүй байна. Энэ нь тус ТЭЗҮ-тэй уялдуулан стратеги төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлээгүйтэй холбоотой байна.

2017 онд боловсруулсан Биржийн стратеги төлөвлөгөө нь амбицтой зорилго дэвшүүлсэн хэдий ч зорилгоо бүрэн хэрэгжүүлж чадаагүй. Стратегийн төлөвлөгөөний хүрээнд Төв аймгийн Аргалант суманд ложистикийн төвийг барьсан, block-chain-д суурилсан арилжааны платформыг бий болгосон байна.

Өнгөрсөн хугацаанд Хөдөө аж ахуйн биржийн хууль нь сайтар судалж, боловсруулагдсан, хэрэгжих боломжтой хууль юм. Энэ талаар судалгаанд оролцсон хүмүүстэй уулзахад дийлэнх нь сайн хууль гэж үзэж байна. Харин тус хуулийн хүчин чадлыг бүрэн ашиглаж чадаагүй, хуулийн хэрэгжилт хангалтгүй байна. Хөдөө аж ахуйн биржийн хуулийг бүрэн ашигласан бол татаас, урамшуулал, төрийн худалдан авалт, лаборатори, хоршоо, Биржийн зохицуулах зөвлөл, төрийн оролцоотой холбоотой олон ажлууд хийгдэх боломжтой юм. Энэхүү хуультай уялдуулан биржийн дүрэм, журмыг боловсруулах ажлууд 2013-2021 онд хийгдсэн. Уг нь биржийн бэлтгэл ажлыг хангах хүрээнд биржийн үйл ажиллагаа эхлэхээс өмнө эдгээр дүрэм, журам боловсруулагдаж, олон талын төлөөллийн оролцоотойгоор батлагдсан байх учиртай юм. Гэвч 2013 онд биржийн үйл ажиллагаа эхэлсэн хэдий ч дийлэнх журмууд боловсруулагдаагүй байсан. Мөн биржээр арилжаалах бүтээгдэхүүний шимтгэлийн хэмжээг олон удаа өөрчилсөн нь биржид итгэх итгэлийг сулруулахад нөлөөлсөн гол хүчин зүйлийн нэг байна. Ер нь биржийг байгуулах бэлтгэл ажил хангалтгүй хэрэгжсэн байна. Ялангуяа биржийн үйл ажиллагааг олон нийтэд зөв ойлгуулах, хүртээмжтэй мэдээллийн үйлчилгээгээр хангах, биржийн арилжаанд хоршоодыг идэвхтэй оролцуулах зэрэг ажлууд хангалтгүй хэрэгжсэнтэй холбоотой байна.

# ГУРАВДУГААР БҮЛЭГ. САЛБАРЫН БОДЛОГО, ЭРХ ЗҮЙН ОРЧИН БОЛОН САЛБАРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ

## 3.1. Хөдөө аж ахуйн салбарын бодлого, эрх зүйн орчин

Хөдөө аж ахуйн бирж байгуулах эрх зүйн үндэслэл нь 2008-2010 онд Улсын Их Хурлаас баталсан бодлого, хөтөлбөрт тодорхой тусгагдсан байна. Тухайлбал:

- Монгол Улсын Их Хурлын 2008 оны 12 тоот тогтоолоор “Мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого”, мөн 2009 оны 39 тоот тогтоолоор “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-ыг баталсан. Эдгээр бодлогын баримт бичигт мал аж ахуйн түүхий эд, бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуйн нөхцлийг сайжруулж, гарал үүслийг тодорхой болгох, мэдээллийн цогц санг бүрдүүлэх, малчдын орлогыг нэмэгдүүлэх зорилгоор мал аж ахуйн түүхий эд, бүтээгдэхүүний биржийн худалдаа явуулах тогтолцоог бий болгохоор тусгасан.
- Хөдөө аж ахуйн бирж байгуулах асуудал Улсын Их Хурлын 2008 оны 35 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, 2010 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Мал” үндэсний хөтөлбөрт туссан. Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.8 дахь заалтал Хөдөөгийн иргэд бэлтгэсэн түүхий эд, бүтээгдэхүүний хэрэглэгчид шууд худалдаалах боломж бүрдүүлсэн мэдээллийн технологид суурилсан биржийн сүлжээ байгуулах, мөн “Монгол Мал” хөтөлбөрийн 3.5.1 дэх заалтад Мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэлийн стандартыг боловсронгуй болгох, бүтээгдэхүүний чанарын хяналт, баталгаажуулалтын оновчтой тогтолцоог бүрдүүлэх зэрэг арга хэмжээг авах замаар түүхий эд бэлтгэлийн системийг боловсронгуй болгох гэж, мөн 3.5.3.7 дахь заалтад малчид, үйлдвэр эрхлэгчдийн шууд харилцааг дэмжих, биржийн сүлжээ бий болгохоор төрийн бодлогод тусгасан байна.

Эдгээр бодлого, хөтөлбөрийн баримт бичигт заасны дагуу Монгол Улсын Их хурлаас 2011 оны 6 дугаар сарын 2-ны өдөр “”Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай” хууль батлагдсан. Уг хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор Засгийн газрын 2011 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн 235 тоот тогтоолоор “Хөдөө аж ахуйн бирж байгуулах” тухай тогтоол гарч, бэлтгэл ажлыг хангах үүргийг Хүнс, хөдөө аж ахуйн яаманд үүрэг, чиглэл өгсөн байна. Уг тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор 2011 оны 8 дугаар сард Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаман дээр “Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн бирж байгуулах бэлтгэл ажлыг хангах” үүрэгтэй төслийн нэгж байгуулагдсан. 2013 оны 2 дугаар сард Төрийн өмчийн хорооноос Хөдөө аж ахуйн бирж ХХК-ийг байгуулж, Төлөөлөн удирдах зөвлөл болон Гүйцэтгэх захирлыг томилсноор биржийн үйл ажиллагаа эхэлсэн.

Хөдөө аж ахуйн бирж байгуулагдсны дараагаар биржийн үйл ажиллагааг сайжруулах, төрийн бодлоготой уялдуулах зорилготой Улсын Их Хурлаас тогтоол баталсан байна. Тухайлбал:

- 2015 онд Улсын Их Хурлаас шинэчлэн баталсан “”Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн салбарт баримтлах бодлого”-ын 6.2.7-д мал, амьтан, ургалам, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний стандартыг шинэчлэх, тэдгээрийг хөдөө аж ахуйн биржээр арилжаалах тогтолцоонд шилжих гэж,
- Улсын Их Хурлын 2016 оны 45 тоот тогтоолоор баталсан Засгийн газрын 2016-2020

оны үйл ажиллагааны хөтөлбөрт мал аж ахуйн түүхий эд, бүтээгдэхүүнийг бэлтгэх, зах зээлд нийлүүлэх зорилго бүхий хөдөө аж ахуйн биржээр арилжих бараа, түүхий эдийн нэр төрөл, тоог нэмэгдүүлэх, үйл ажиллаагааг нь боловсронгуй болгох, эрчимжүүлэхээр гэж,

- УИХ-аас 2020 онд баталсан "Алсын хараа 2050" урт хугацааны үндэсний хөгжлийн бодлогын Тогтвортой хөдөө аж ахуйн бодлогын хүрээнд I шат буюу 2021-2030 онд Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн нөөц ашиглалт, эдийн засгийн эргэлтийг эрчимжүүлэх, тооноос чанар, бүтээмжид шилжих зорилтын хүрээнд хүн амын хүнсний хангамж хүрээмжийг тогтворжуулах, үйлдвэрүүдийг чанартай түүхий эдээр хангах, II шат буюу 2031-2040 онд хөдөө аж ахуйн түүхий эд, бүтээгдэхүүнд чанарын үнэлэмж бий болж, биржийн арилжааны системийг бэхжүүлэх, үйлдвэрүүдийн хүчин чадал ашиглалтыг сайжруулж, өргөтгөхөөр гэсэн зорилт, арга хэмжээнүүд тусгагдсан байна.

Мал аж ахуйн, газар тариалангийн салбарт нийт 10 гаруй хууль хэрэгжиж байна. Эдгээр хуулиудаас хөдөө аж ахуйн биржтэй холбоотой гол хуулиудад Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль, Малын генетикийн нөөцийн тухай хууль, Газар тариалангийн тухай зэрэг хуулиуд байна. Биржийн арилжаа болон арилжааны зах зээлд оролцогчидтой холбоотой хуулиудад Иргэний хууль, Компанийн хууль, Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хоршооны шинэчилсэн хууль зэрэг байна. Улсын Их Хурлаас Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг баталж, уг хөтөлбөрийн дагуу жил бүр Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг баталж байна. Энэхүү үндсэн чиглэлд дараах хөтөлбөрүүдэд тусгасан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж байна. Үүнд:

- Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр;
- Алсын хараа 2050 хөгжлийн хөтөлбөр;
- Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030;
- Төрөөс малчдын талаар баримтлах бодлого;
- Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого;
- Малчид, үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих арга хэмжээний тухай;
- Монгол Мал хөтөлбөр;
- Ноолуур хөтөлбөр;
- Ноос, арьс шир, мах, сүүний аян зэрэг олон хөтөлбөрүүдийг тусган хэрэгжүүлж байна.

Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам нь батлагдсан Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан арга хэмжээг төсөвтэй уялдуулах зорилгоор Улсын төсвийн тухай хуулийн төсөлд жил бүр санхүүжилт тусгаж, УИХ-аар батлуулж байна. Аливаа орны барааны бирж нь төрийн томоохон бодлоготой уялдуулан хөгжүүлж ирсэн байна.

Ихэнх орнууд нь аж үйлдвэрийн бодлого, гадаад худалдааны бодлоготой уялдуулан хөдөө аж ахуйн биржийг хөгжүүлж байна. Манай улсын хувьд хөдөө аж ахуйн бирж нь яг аль хуультай нийцүүлэн хөгжүүлж байгаа нь тодорхойгүй байна. Харин 2020 онд Алсын хараа 2050 хөтөлбөрт, Цахим хөдөө аж ахуй хөтөлбөртэй уялдуулан хэрэгжүүлэх боломжтой байна.

**Диаграмм 2:** Салбарын бодлогын уялдаа




Хүнс, хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн яамнаас Цахим Монгол хөтөлбөртэй уялдуулан салбарын бодлогыг хэрэгжүүлэх талаар багагүй ажлууд хийгдэж байна. Хөдөө аж ахуйн биржийн хуулийн хэрэгжилтийг эдгээр хууль, УИХ-ын болон Засгийн газрын тогтоол, салбарын бодлого, хөтөлбөрүүдтэй хэрхэн уялдуулан Хөдөө аж ахуйн биржийн үйл ажиллагааг боловсронгуй болгох нь нэн шаардлагатай байна.

## 3.2. Хөдөө аж ахуйн салбарын төлөв байдал

Монгол Улсын эдийн засагт хөдөө аж ахуйн салбар томоохон үүрэг гүйцэтгэсээр ирсэн. Монгол улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцоонoос зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжээд 30 жил болж байна. Зах зээлийн эдийн засгийн шилжилтийн эхэн үед мал аж ахуй болон газар тариалангийн салбарыг хувьчилж, малчид болон тариаланчид өөрийн өмчтэй болсон.



**А/. Хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл:** Монгол улсад хөдөө аж ахуй, ялангуяа мал аж ахуйн салбар нь өнөөг хүртэл хүн амын амьжиргааны томоохон эх үүсвэр болж, эдийн засаг, нийгэмд томоохон үүрэг гүйцэтгэсээр ирсэн. 2000 оны байдлаар монгол орон 30 гаран сая толгой малтай, 354.0 тэрбум төгрөгийн хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байсантай харьцуулахад 2020 онд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 5.7 их наяд төгрөгт хүрч, жилд дундажаар 14.7 хувийн өсөлттэй гарчээ.

Энэхүү өсөлтөд малын тоо толгой жилд дундажаар 4.1 хувийн өсөлттэйгөөр 67.1 сая толгойд хүрсэн нь голлон нөлөөлжээ. 2010-2020 оныг 2000-2010 онтой харьцуулахад мал аж ахуйн салбарын бүтээгдэхүүний үйлдвэрлэл 4 гаруй дахинаар, газар тариалангийн салбарын бүтээгдэхүүний үйлдвэрлэл 3 гаруй дахинаар тус тус өсжээ.

Хөдөө аж ахуйн салбарт нөлөөлдөг гол хүчин зүйлийн нэг нь байгаль, цаг уурын өөрчлөлт юм. 2000 оны эхээр монголд ган, зуд болж хөдөө аж ахуй, ялангуяа мал аж ахуйн үйлдвэрлэл буурч байсан ч цаг агаарын таатай байдлын нөлөөгөөр 2005-2020 онд ихээхэн өссөн байна. Цаг агаарын нөлөөлөл бага бол эдийн засгийн таатай, хүндрэлтэй аль ч нөхцөлд салбарт өсөлт гарч, хүн амын хэрэгцээг хангасаар байна.

**График 2.** ХАА-н үйлдвэрлэлийн ДНБ-д эзлэх хувь, бүсээр




Улсын дүнгээр, ХАА-н бүтээгдэхүүний үйлдвэрлэл ДНБ-ийн 12.3 хувь байгаа ч хөдөө, орон нутгийн эдийн засагт хөдөө аж ахуй салбар чухал үүрэгтэй хэвээр байна. Графикаас харахад Зүүн бүсэд хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэлийн эзлэх хувь буурсан ч бусад бүсүүдэд өсөлттэй байна. Бүсийн ДНБ-ийн 32 - 47 хувийг хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл эзэлж байна.

Мал аж ахуйн салбарын нөөцийн байршил нь Хангай, Баруун болон Төвийн бүс зонхилж байгаа ч төвлөрсөн зах зээл, үйлдвэрүүдээс байршил хол байна. Газар тариалангийн салбарын үйлдвэрлэлийн дийлэнх нь Төв, Сэлэнгэ, Булган аймагт хамаарч байна.

Малын тоо толгойг малын төрлөөр авч үзвэл:

**График 3.** Малын тоо толгой төрлөөр ба малын бүтэц, хувиар



Нийт малын 45 хувийг хонь, 41 хувийг ямаа, 7 хувийг үхэр, 6 хувийг адуу болон 1 хувийг тэмээ эзэлж байна. Өнгөрсөн 20 жилийн хугацаанд малын тоо өссөн боловч малын бүтцэд ихээхэн өөрчлөлт гарсан нь харагдаж байна. Тухайлбал, 2000 онд нийт малын 80 хувийг бог, үүний дотор хонь 46 хувь, ямаа 34 хувийг эзэлж байсан бол 2020 онд нийт малын 86 хувийг бог эзэлж, ямааны тоо толгой өсч, нийт малын 41 хувийг эзлэх болжээ. Малчид амьжиргаагаа дээшлүүлэх зорилгоор зах зээлд борлуулалт сайтай малын гаралтай түүхий эдийг түлхүү үйлдвэрлэх болсон нь малын бүтцэд өөрчлөлт гарах нэг үндэслэл болжээ. Тухайлбал, ямааны тоо 2000 онд 10.3 сая толгой байснаа 2020 онд 27.7 саяд хүрч бараг 3 дахин өсчээ. Хөдөө ахуйн салбарын нийт бүтээгдэхүүний 84 хувийг мал ах ахуй, 16 хувийг газар тариалангийн салбарт үйлдвэрлэсэн байна. Газар тариалангийн салбарын хувьд Төвийн бүс 50.1 хувь, үүний дотор Төв аймаг 25.2 хувь, Сэлэнгэ 20.2 хувийг эзэлж тэргүүлж байна. Хангайн бүсийн хувьд ГТ-ийн үйлдвэрлэлийн 8.2 хувийг Хөвсгөл, 5.4 хувийг Булган, Баруун бүсэд Ховд 5.5 хувь, Увс 3.9 хувийг эзэлж удаалжээ. МАА-н үйлдвэрлэлийн 34.6 хувийг Хангайн, 25.3 хувийг Төвийн, 20.8 хувийг Баруун, 18.0 хувийг Зүүн бүс эзэлж, малын гаралтай бараа, түүхий эд үйлдвэрлэж бэлтгэн эдийн засагт томоохон үүрэг гүйцэтгэж байна.

**Хүснэгт 3.** Бүс, аймгаар МАА болон ГТ-ын үйлдвэрлэлд эзлэх хувь, %

| Аймаг | Мал аж ахуй | | | Газар тариалан | | |
|---|---|---|---|---|---|---|
| | 2010 | 2020 | %, 2020/2010 | 2010 | 2020 | 2020/2010, % |
| *Нийт* | **100** | **100** | | **100** | **100** | |
| ***Баруун бүс*** | **20.8** | **20.8** | **99.7** | **11.4** | **14.0** | **122.7** |
| *Баян-Өлгий* | 4.2 | 3.9 | 92.0 | 2.5 | 2.8 | 112.2 |
| *Говь-Алтай* | 2.8 | 4.1 | 145.4 | 0.8 | 0.5 | 69.8 |
| *Завхан* | 4.5 | 5.2 | 116.3 | 1.1 | 1.3 | 114.4 |
| *Увс* | 4.4 | 4.2 | 94.4 | 2.4 | 3.9 | 162.7 |
| *Ховд* | 4.9 | 3.4 | 69.6 | 4.6 | 5.5 | 118.7 |
| ***Хангайн бүс*** | **34.7** | **34.6** | **99.6** | **19.4** | **21.5** | **111.2** |
| *Архангай* | 6.6 | 8.8 | 132.4 | 3.2 | 2.9 | 91.6 |
| *Баянхонгор* | 5.5 | 5.8 | 105.7 | 0.8 | 0.7 | 86.7 |
| *Булган* | 7.8 | 4.8 | 61.3 | 6.6 | 5.4 | 82.6 |
| *Орхон* | 1.0 | 0.3 | 31.7 | 1.9 | 1.5 | 78.6 |
| *Өвөрхангай* | 3.8 | 7.1 | 183.9 | 1.7 | 2.7 | 164.0 |
| *Хөвсгөл* | 9.9 | 7.8 | 78.7 | 5.2 | 8.2 | 158.6 |
| ***Төвийн бүс*** | **27.7** | **25.3** | **91.4** | **55.2** | **50.1** | **90.7** |
| *Говьсүмбэр* | 0.5 | 0.6 | 120.7 | 0.1 | 0.1 | 102.6 |
| *Дархан-Уул* | 1.6 | 1.0 | 63.6 | 6.0 | 2.9 | 49.1 |
| *Дорноговь* | 3.9 | 3.5 | 88.9 | 0.1 | 0.3 | 261.4 |
| *Дундговь* | 3.9 | 6.0 | 152.5 | 0.2 | 0.8 | 410.7 |
| *Өмнөговь* | 3.4 | 3.9 | 114.6 | 0.3 | 0.5 | 148.0 |
| *Сэлэнгэ* | 5.5 | 3.2 | 58.6 | 28.1 | 20.2 | 72.0 |
| *Төв* | 8.8 | 7.0 | 80.0 | 20.3 | 25.2 | 124.0 |
| ***Зүүн бүс*** | **14.5** | **18.0** | **123.9** | **6.3** | **10.0** | **159.6** |
| *Дорнод* | 3.8 | 5.0 | 130.8 | 1.4 | 3.5 | 249.7 |
| *Сүхбаатар* | 4.8 | 5.7 | 117.5 | 0.5 | 2.0 | 391.6 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| *Хэнтий* | 5.9 | 7.3 | 124.6 | 4.4 | 4.5 | 104.2 |
| ***Улаанбаатар*** | **2.2** | **1.3** | **59.4** | **7.8** | **4.4** | **56.5** |

Эх сурвалж: ҮСХороо, 2020

**В/. Хөдөө аж ахуйн салбарын оролцогчид:**

**Малчид:** Монгол улсад 2020 оны байдлаар нийт 242.0 мянган малтай өрхтэй байгаагаас 74.8 хувь буюу 181.1 мянга нь малчин өрх эзэлж байна. Нийт 181.1 мянган малчин өрхийн 298.8 мянган малчид мал аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн үйлдвэрлэж, бэлтгэж зах зээлийн харилцаанд оролцож байна. Өнгөрсөн 8 жилийн хугацаанд малчин өрхийн тоо жилд дундажаар 2.7 хувиар өссөн ч малчдын тоонд дорвитой өөрчлөлт гараагүй байна.

**Хүснэгт 4.** Малчин өрхийн болон малчдын тоо

| | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2017 | 2018 | 2019 | 2020 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Малтай өрх, мянга** | 207.8 | 209.9 | 213.4 | 216.7 | 223.8 | 229.0 | 230.9 | 233.3 | 242.0 |
| **Малчин өрх, мян** | 146.1 | 145.3 | 149.7 | 153.1 | 160.7 | 169.7 | 169.7 | 171.6 | 181.1 |
| **Малчдын тоо, мян** | 289.6 | 285.7 | 293.6 | 297.8 | 311.4 | 303.6 | 288.7 | 285.5 | 298.8 |
| **Малчин өрхийн нийт малтай өрхөд эзлэх хувь** | 70.3 | 69.2 | 70.2 | 70.6 | 71.8 | 74.1 | 73.5 | 73.6 | 74.8 |

Эх сурвалж: ҮСХороо, 2020

Хангай бүсэд 73.6 мянган малчин өрхийн 124.4 мянган малчид амьдарч мал аж ахуй эрхэлж байгаа нь улсын нийт малчдын 41.6 хувь, малчин өрхийн 40.6 хувийг тус тус эзэлж байна. Баруун бүс удаалж, нийт малчдын 24.7 хувь, малчин өрхийн 24.1 хувийг эзэлж байна.

**Хүснэгт 5.** Малчин өрхийн болон малчдын тоо, бүсээр, эзлэх хувь

| | Малчдын тоо | Бүсийн эзлэх хувь | Малчин өрхийн тоо | Бүсийн эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| **Нийт** | 298.8 | 100.0 | 181.1 | 100.0 |
| **Баруун бүс** | 73.7 | 24.7 | 43.7 | 24.1 |
| **Хангайн бүс** | 124.4 | 41.6 | 73.6 | 40.6 |
| **Төвийн бүс** | 60.7 | 20.3 | 38.5 | 21.3 |
| **Зүүн бүс** | 36.3 | 12.2 | 22.4 | 12.4 |
| **Улаанбаатар** | 3.8 | 1.3 | 2.9 | 1.6 |

Эх сурвалж: ҮСХороо, 2020

2012 оны байдлаар 207.8 мянган малтай өрх байснаас 72 хувь нь 51-ээс дээш малтай өрхүүд эзэлж байсан бол 2020 онд 79 хувь болж өссөн. Энэхүү өсөлтөд 100-аас дээш, ялангуяа 200 мал, түүнээс дээш малтай өрхүүд нэмэгдэж, харин 100-аас доош малтай өрхүүд буурсантай холбоотой байна. Өнгөрсөн 8 жилийн хугацаанд 100-500 малтай өрхийн тоо 20 хувиар, 500-999 малтай өрхийн тоо 2.1 дахин, 1000 дээш малтай өрхийн тоо 2.8 дахин өссөн үзүүлэлттэй байна. Нийт малтай өрхийн 83 хувийг 500 хүртэлх малтай өрхүүд эзэлж байна. Ялангуяа 63 орчим хувийг 100-1000 хүртэлх малтай, 50

орчим хувийг 100-500 малтай өрхүүд эзэлж байгаа нь статистик тоон мэдээллээс харагдаж байна.

**Хүснэгт 6.** Малтай өрхийн тоо, малын бүлэглэлээр

| | 2012 | 2020 | 2012 | 2020 |
|---|---|---|---|---|
| **Бүгд** | 207818 | 242024 | 100% | 100% |
| **51-100 малтай** | 32902 | 32411 | 16% | 13% |
| **101-200 малтай** | 48474 | 51185 | 23% | 21% |
| **201-500 малтай** | 50468 | 67958 | 24% | 28% |
| **501-999 малтай** | 14276 | 30327 | 7% | 13% |
| **1000-1499 малтай** | 3046 | 8454 | 1% | 3% |
| **2001-ээс дээш малтай** | 199 | 549 | 0% | 0% |
| **50 дээш малтай өрхийн эзлэх хувь** | | | 72% | 79% |

Эх сурвалж: ҮСХороо, 2020

**Тариаланчид:** 2020 оны байдлаар 16.3 мянган өрх, 1.5 мянган аж ахуй нэгжүүд газар тариалангийн үйлдвэрлэл явуулж байна. Газар тариалангийн үйлдэрлэл эрхэлж буй аж ахуйн нэгжийн тоо жилд дундажаар 1.7 хувиар өсөж 2014 онд 1.35 мянга байснаа 2020 онд 1.49 мянгад хүрээд байна. Харин газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэх өрхийн тоо жил бүр буурч, тухайлбал 2014 онд 20.45 мянган өрх байснаа жилд дундажаар 3.7 хувиар буурч 16.29 мянган өрх болсон байна. Энэ нь газар тариалангийн салбарын үйлдвэрлэл санхүүжилт их шаарддаг, орчин үеийн шинэ тоног төхөөрөмжүүд ихээхэн нэвтэрсэн, өрсөлдөөн ихтэй зэрэг шалтгаантай байна.

**Хүснэгт 7.** Тариалан эрхэлж байгаа аж ахуйн нэгж болон өрхийн тоо

| | 2014 | 2015 | 2016 | 2017 | 2018 | 2019 | 2020 |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Аж ахуйн нэгж** | 1352 | 1395 | 1414 | 1447 | 1422 | 1401 | 1498 |
| **Өрхийн тоо** | 20459 | 18440 | 17145 | 15985 | 15862 | 14728 | 16292 |

Эх сурвалж: ҮСХороо, 2020

Газар тариалан эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүдийн 51.9 хувь нь Төвийн бүсэд, 20.9 хувь нь Хангайн бүсэд, 14.6 хувь нь Баруун бүсэд, 8.7 хувь нь Зүүн бүсэд, үүний дотор 22.5 хувь нь Төв аймагт, 21.5 хувь нь Сэлэнгэ аймагт, 6.8 хувь нь Булган аймагт, 6.3 хувь нь Увс аймагт, 5.5 хувь нь Өвөрхангай аймагт тус тус үйлдвэрлэл явуулж тэргүүлж байна.

**Хоршоод:** Монгол улсад 2020 оны байдлаар 4.5 мянган хоршоо улсын бүртгэлд бүртгэлтэй байгаагаас 28.9 хувь буюу 1.3 мянган хоршоо нь хөдөө аж ахуйн салбарт хамааралтай байна. Стастикийн тоо баримтаар авч үзвэл, 2013-2020 онуудад дундажаар 7.8 тэрбум төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй, 31.8 мянган гишүүнтэй нийт 1275 хоршоо байгаа дүнтэй байна. Хөдөө аж ахуйн хоршоод нь нийт хоршоодын 30.7 хувь, нийт хоршооны гишүүдийн 18.1 хувь, хоршоонд хувь оруулсан нийт хөрөнгийн 20.0 хувийг тус тус эзэлж байна. Энэ утгаараа хөдөө аж ахуйн хоршоо нь хорооны хөгжилд хувь нэмэр оруулж байна. Хөдөө аж ахуйн хоршооны гишүүн бүрд ногдох хувь нийлүүлсэн хөрөнгө нь ойролцоогоор 247.1 мянган төгрөг, нэг хоршоонд ногдох хувь нийлүүлсэн хөрөнгө нь 31.2 сая төгрөг байхаар тооцоолол гарч байна.

**Хүснэгт 8.** ХАА-н хоршоодын тоо, гишүүдийн тоо ба хувь нийлүүлсэн хөрөнгө

| Тоо | салбар | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2017 | 2018 | 2019 | 2020 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Гишүүд, мянган хүн** | Нийт | 112.4 | 134.0 | 142.0 | 197.1 | 209.2 | 223.3 | 235.0 | 234.6 |
| | ХАА-н хоршоо | 27.2 | 31.4 | 29.8 | 32.2 | 32.6 | 34.1 | 34.4 | 33.1 |
| **Хоршоо, мянга** | Нийт | 3.2 | 3.9 | 4.1 | 4.2 | 4.4 | 4.5 | 4.6 | 4.5 |
| | ХАА-н хоршоо | 1.1 | 1.3 | 1.3 | 1.3 | 1.3 | 1.3 | 1.3 | 1.3 |
| **Хувь нийлүүлсэн хөрөнгө, тэрбум.төг** | Нийт | 36.3 | 30.0 | 31.6 | 37.7 | 41.1 | 43.3 | 48.1 | 49.5 |
| | ХАА-н хоршоо | 8.7 | 6.6 | 6.5 | 7.8 | 8.1 | 8.3 | 8.6 | 8.1 |

Эх сурвалж: ҮСХороо, 2020

**Хүснэгт 9.** Хоршоодын гишүүд, тэдгээрийн санхүүгийн оролцоо

| # | Сум | Хоршооны нэр | Гишүүдийн тоо | Сумын нийт малчин өрхөд эзлэх хувь | Гишүүдийн нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, төг | Хоршооны нийт хөрөнгийн хэмжээ, төг |
|---|---|---|---|---|---|---|
| **1** | Өндөр-Улаан | Малчин түмний буян | 300 | 26.6 | 2,000,000 | 2,800,000 |
| **2** | Тариат | Хоргын мишээл | 1090 | 100.0 | 4,000,000 | 12,250,000 |
| **3** | Их-Тамир | Тамир таван эрдэнэ | 300 | 2.9 | 3,000,000 | 3,000,000 |
| **4** | Чулуут | Буга зүрх | 183 | 25.5 | 5,000,000 | 15,000,000 |
| **5** | Халиун | Эвт залаа | 126 | 23.6 | 4,500,000 | 20,000,000 |
| **6** | Эрдэнэ | Бялхам-Баялаг Арвижих | 60 | 16.4 | 1,800,000 | 1,800,000 |
| **7** | Богд | Орог Нуурын Хишиг | 48 | 7.2 | 17,000,000 | 49,000,000 |
| **8** | Жинст | Түйн Хишиг | 50 | 10.3 | 9,096,000 | 48,800,000 |
| **9** | Баацагаан | Цнхир Хайрхан | 49 | 6.6 | 5,900,000 | 58,700,000 |
| **10** | Бөмбөгөр | Өгөөж баян Өлзийт гол | 56 | 7.6 | 7,000,000 | 77,400,000 |
| **11** | Шинэжинст | Цармын Цагаан Сувд | 60 | 12.2 | 7,200,000 | 61,000,000 |
| **Нийт дүн** | | | **2322** | **29.2** | **66,496,000** | **349,850,00** |

Эх сурвалж: Бэлчээр ашиглалтын нэгдсэн холбооны тайлан, 2019

Бэлчээр ашиглалтын нэгдсэн холбооны судалгаагаар Архангай, Говь-Алтай, Баянхонгор аймгийн 11 сумын хоршоодын гишүүдийн тоо, сумын нийт малчдад эзлэх хоршоодын гишүүдийн эзлэх хувь хэмжээ, гишүүдийн хувь нийлүүлсэн хөрөнгө болон хоршоодын хувь нийлүүлсэн нийт хөрөнгийн талаар шинжилсэн байна. Хоршоод нь дундажаар 50 - 300 гишүүнтэй, нийт малчдын 29.2 хувийг хамруулж чадсан байна. Хоршооны дундаж хувь нийлүүлсэн нийт хөрөнгө нь 32.5 сая төгрөг байна.

**С/. Нөөцийн байршил ба зах зээлээс алслагдсан байдал:** Аймгуудын ДНБ-нд хөдөө аж ахуйн салбар томоохон үүрэгтэй байна. Харин сүргийн бүтэц, мал сүргийн байршилтаас хамаарч аймаг, бүсүүдийн мал аж ахуй, газар тариалангийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл харилцан адилгүй байна. Мал аж ахуйн түүхий эд бүтээгдэхүүний нөөцийг тооцохдоо сүүлийн таван жилийн дундаж малын тоог аймаг сум бүрээр тооцсон ба нэг малаас ашиглах мал аж ахуйн гаралтай түүхий эдийн нормативыг үндэслэн тооцов.

**Хүснэгт 10.** Голлох хөдөө аж ахуйн түүхий эдийн нөөцийн байршил

| **Үзүүлэлт** | | **Хэмжих нэгж** | **Бүсүүд** | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Баруун | Хангай | Төв | Зүүн | УБ | Дүн |
| **Хүн ам** | Тоо | мян.хүн | 415.1 | 604.2 | 515.9 | 225.1 | 1597.3 | 3357.6 |
| | Хувь | % | 12.4% | 18.0% | 15.4% | 6.7% | 47.6% | 100.0% |
| **Малчин өрх** | Тоо | мян.өрх | 43.7 | 73.6 | 38.5 | 22.4 | 2.9 | 181.1 |
| | Хувь | % | 24.1% | 40.7% | 21.3% | 12.4% | 1.6% | 100.0% |
| **Мал** | Тоо | сая.тол | 15.8 | 22.7 | 16.69 | 11.3 | 0.47 | 67.1 |
| | Хувь | % | 23.6% | 33.9% | 24.9% | 16.9% | 0.7% | 100.0% |
| **Мах** | Тоо | мян.тн | 115.4 | 208.9 | 116.6 | 95.4 | 8.8 | 545.0 |
| | Хувь | % | 21.2% | 38.3% | 21.4% | 17.5% | 1.6% | 100.0% |
| **Ноос** | Тоо | мян.тн | 8.6 | 11.7 | 7.7 | 5.5 | 0.2 | 33.6 |
| | Хувь | % | 25.5% | 34.9% | 22.8% | 16.4% | 0.6% | 100.0% |
| **Ноолуур** | Тоо | тонн | 3.108 | 3.706 | 2.856 | 1.2143 | 0.04 | 10.9 |
| | Хувь | % | 28.5% | 33.9% | 26.1% | 11.1% | 0.4% | 100.0% |
| **Арьс, шир** | Тоо | ширхэг | 6154.7 | 10970.6 | 5674.2 | 4165.5 | 154.1 | 27119.0 |
| | Хувь | % | 22.7% | 40.5% | 20.9% | 15.4% | 0.6% | 100.0% |
| **Сүү** | Тоо | тонн | 235.3 | 376.0 | 242.1 | 195.1 | 25.9 | 1074.3 |
| | Хувь | % | 21.9% | 35.0% | 22.5% | 18.2% | 2.4% | 100.0% |
| **Буудай** | Тоо | тонн | 26383.0 | 71675.0 | 239087.8 | 39861.0 | 5.0 | 377011.8 |
| | Хувь | % | 7.0% | 19.0% | 63.4% | 10.6% | 0.0% | 100.0% |

Эх сурвалж: ҮСХороо, 2020

Энэ байдлаар бүтээгдэхүүний үйлдвэрлэл нь хэрэглэгчдээсээ алс зайдуу оршиж байгааг илтгэж байна. ХАА-н бүтээгдэхүүн түүхий эдийг хотын хүн амд болон боловсруулах үйлдвэрүүдэд хүргэхэд газар зүйн байршлын бэрхшээл ихтэй байна. Хүн ам, боловсруулах үйлдвэр, ХАА-н бүтээгдэхүүн, түүхий эдийн нөөцийн байршлийг Улаанбаатараас 450 км дотрохи, 451-800 км 801 цааших км –т оршиж байгаа гэсэн гурван бүс хүрээгээр аймаг, сумдаар авч үзлээ. Хүснэгт 11 –ээс үзэхэд Улаанбаатар болон төв бүсд хүн амын 63.0 хувь оршиж байхад Хангайн бүсэд 18.0 хувь, Баруун болон Зүүн бүст 19.0 хувь оршиж байна. Малын тооны хувьд 33.9 хувь нь Хангайн, 23.6 хувь нь Баруун, 24.9 хувь нь Төвийн, үлсэн хувь нь Зүүн бүсэд байгаа бөгөөд нийт малын 58 орчим хувь нь Хангай, Баруун бүсүүдэд байна. Баруун болон Хангай бүс нь мал аж ахуйн түүхий эдийн гол нөөцийг бүрдүүлж байна. Тухайлбал, махны 60 орчим хувь, ноосны 60.5 хувь, ноолуурын 62.4 хувь, арьс ширний 63.2 хувь, сүүний 57.0 орчим хувийг бүрдүүлж байна.

**Хүснэгт 11.** Улаанбаатар хотоос алслагдсан байдал

| **Үзүүлэлт** | | **Хэмжих нэгж** | **Бүсүүд** | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | 450 км дото | 451-800 км | 801-1700 км | Дүн |
| **Хүн ам** | Тоо | мян.хүн | 1880.3 | 705.1 | 772.2 | 3357.6 |
| | Хувь | % | 56.0% | 21.0% | 23.0% | 100.0% |
| **Боловсруулах үйлдвэр** | Тоо | ширхэг | | | | |
| | Хувь | % | 84.0 | 8.5 | 7.5 | |
| **Малчин өрх** | Тоо | мян.өрх | 99.6 | 39.8 | 41.6 | 181.1 |
| | Хувь | % | 55.0% | 22.0% | 23.0% | 100.0% |
| **Мал** | Тоо | мян.толгой | 18108.5 | 28168.8 | 20791.2 | 67068.5 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | Хувь | % | 27.0% | 42.0% | 31.0% | 100.0% |
| **Мах** | Тоо | мян.тн | 144.4 | 218.0 | 180.9 | 545.0 |
| | Хувь | % | 26.5% | 40.0% | 33.2% | 100.0% |
| **Ноос** | Тоо | мян.тн | 8.9 | 13.4 | 11.2 | 33.6 |
| | Хувь | % | 26.5% | 40.0% | 33.2% | 100.0% |
| **Ноолуур** | Тоо | тонн | 2.9 | 4.4 | 3.6 | 10.9 |
| | Хувь | % | 26.5% | 40.0% | 33.2% | 100.0% |
| **Арьс, шир** | Тоо | ширхэг | 7186.5 | 10847.6 | 9003.5 | 27119.0 |
| | Хувь | % | 26.5% | 40.0% | 33.2% | 100.0% |
| **Сүү** | Тоо | тонн | 284.7 | 429.7 | 356.7 | 1074.3 |
| | Хувь | % | 26.5% | 40.0% | 33.2% | 100.0% |
| **Буудай** | Тоо | тонн | 283.9 | 39.6 | 53.5 | 377.0 |
| | Хувь | % | 75.3% | 10.5% | 14.2% | 100.0% |

Эх сурвалж: ҮСХороо, 2020

Хүснэгт 13-аас үзэхэд Улаанбаатараас алслагдах 450 км-ийн доторх хүрээнд улсын нийт хүн амын 56 хувь, боловсруулах үйлдвэрийн 84 хувь, мал аж ахуйн бүтээгдэхүүний 26.5 хувь, газар тариалангийн бүтээгдэхүүний 75.3 хувь оршиж байна. Мөн малчин өрхийн 55.0 хувь амьдарч байна. Алслагдаж 450-800 км-ын дотор хүм амын 21 хувь, малын 42 хувь, боловсруулах үйлдвэрийн 8.5 хувь, МАА-н бүтээгдэхүүний 40 хувь, газар тариалангийн бүтээгдэхүүний 10.5 хувь нь байна. 801 км-ээс цааших нутагт хүн амын 23 хувь, малын 31 хувь, боловсруулах үйлдвэрийн 7.5 хувь, МАА-н бүтээгдэхүүний 33,2 хувь, газар тариалангийн бүтээгдэхүүний 14.2 хувийг эзэлж байна. Дээр дурьдсан гурван хүрээний харьцуулалтаас үзэхэд ХАА-н бүтээгдэхүүний гол хэрэглэгчид хүн ам, боловсруулах үйлдвэр Улаанбаатар, Дархан,Эрдэнэтэд болон эдгээр хотуудын ойрын хүрээнд оршиж байхад МАА-н бүтээгдэхүүн түүний эдийн гол нөөц Улаанбаатараас 451 км-ээс цааш 73.5 хувь оршиж байна. Харин газар тариалангийн салбарын үйлдвэрлэлийн 75.3 хувь нь 450.0 км дотроо, ялангуяа Төв, Сэлэнгэ, Булган, Өвөрхангай аймгуудад дийлэх нь байрлаж байна. Үүнээс харахад үйлдвэрлэгч, хэрэглэгч хоёрыг уулзуулахад ихээхэн бэрхшээлтэй нь тодорхой байна.

Энэ бэрхшээлийн багасгахад орон нутагт хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн тогтолцоог үр дүнтэй зохион байгуулах нь чухал болоод байна.

## 3.3. Хөдөө аж ахуйн салбарын бараа, түүхий эд бэлтгэлийн тогтолцооны хөгжлийн төлөв байдал

Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг сайжруулах, экспортыг нэмэгдүүлэх эдийн засгийн суурь нь бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоог сайжруулах явдал юм. Энэхүү хөдөө аж ахуйн бэлтгэл, нийлүүлэлтийн тогтцолцоог боловсронгуй болгоход анхан шатны тордолт хийх замаар хөдөө аж ахуйн бараа, түүхий эдийн чанар, стандартын шаардлагыг хангаж, нэгдсэн зохион байгуулалтаар арилжаалдаг биржийн сүлжээ ихээхэн чухал үүрэгтэй байдаг. Биржийн гол үүрэг нь түүхий эд бэлтгэлийн үйл ажиллагааг хөнгөвчилөх, хэлцлийн зардал болон эрсдлийг бууруулах, арилжаанд оролцогчдын бизнесийн итгэлцлэлийг бий болгох, спот болон ирээдүйн гэрээний арилжаа хийх нөхцлийг бүрдүүлэх явдал байдаг.

Зах зээлийн эдийн засагт шилжснээр хөдөө аж ахуй бараа, түүхий эд бэлтгэлийн тогтолцоонд ихээхэн өөрчлөлтүүд гарсан. Үүнд:

**А/. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний бэлтгэл нийлүүлэлтийн хүрээнд гарсан өөрчлөлт:** Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцооны үед мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг зохион байгуулалттайгаар борлуулах бололцоог олгох, тээвэрлэлтийг зохион байгуулахад худалдаа бэлтгэлийн байгууллагууд, үүний дотор хоршоод гол үүрэг гүйцэтгэж ирсэн. Худалдаа бэлтгэлийн байгууллагууд нь хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийг улсын төлөвлөгөөний комисоос гаргасан төлөвлөгөөний дагуу худалдан авч, эх орны хөнгөн үйлдвэрүүдэд нийлүүлж, мөн экспортын хэрэгцээг хангаж байсан. Өмч хувьчлалын үр дүнд малчид, тариаланчид өөрийн гэсэн өмч хөрөнгөтэй болж, малын тоо нэмэгдсэн, газар тариалангийн үйлдвэрлэл өссөн хэдий ч түүхий эдийн чанар буурсан, мөн малчид, тариаланчид түүхий эдээ хаана, яаж борлуулж өрхийн орлогоо хэрхэн нэмэгдүүлэх борлуулалтын тогтсон сүлжээ байхгүй болсон. Эдийн засгийн тогтолцооны шилжилтийн явцад бүх аймаг, сумдыг хамарсан худалдаа, түүхий эд бэлтгэлийн систем, агентийн бааз суурь үгүй болж, хэрэглэгчид болон дотоодын үйлдвэрлэгчдийн хооронд “хоосон орон зай” үүсч, энэ орон зайд дундын зуучлалын систем үүссэн. Энэхүү “орон зай”-г дотоод, гадаадын /хятадын голдуу/ мэргэжлийн бус худалдаачид эзэлж, хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийг бэлтгэх үндэсний стандартын дагуу бэлтгэл ажил хийгдэхгүй байгаагаас үүдэн барааны чанар, эрүүл ахуйн байдал, түүхий эд бэлтгэлийн стандарт хангагдахгүй болсон байна. Хүснэгт 3-т Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн үеийн хөдөө аж ахуйн бараа, түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоог өнөөгийн байдалтай харилцуулан үзүүлэв. Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засагтай харьцуулахад өнөөдрийн байдлаар зах зээлийн эдийн засгийн харилцаанд тохирсон хөдөө аж ахуйн бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоог бүрдүүлж чадаагүй байна. Уг нь хөдөө аж ахуйн бирж чухал үүрэгтэй оролцох учиртай юм. 2011 онд Хөдөө аж ахуйн бирж байгуулагдсанаар хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийг арилжих нөхцөл бүрдсэн ч малчид, тариаланчид шууд оролцох боломж байхгүй, түүхий эдийн чанар муудсан, түүхий эд бэлтгэлийн ажил хийгдэхгүй зэрэг сөрөг үзэгдлүүд хэвээр байна.

**Хүснэгт 12. Бэлтгэлийн тогтолцооны өөрчлөлт**

| Үзүүлэлтүүд | Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засаг | Зах зээлийн эдийн засаг |
|---|---|---|
| **Өмч** | Төрийн өмч | Хувийн өмч |
| **Малчид** | 300 гаруй хоршоо, түүний 180.0 мянган малчин өрхийн 421.4 мянган малчид | 298.0 мянган мал бүхий өрх, үүнээс 181 мянган малчин өрх |
| **Тариаланчид** | 1.3 мянган хоршоо, түүгий 60 гаруй мянган тариаланч өрх | 16.3 мянган тариаланч өрх, 1.5 мянган тариалан эрхлэдэг аж ахуйн нэгж |
| **Бэлтгэлийн ажил** | Бэлтгэлийн байгууллага, хоршооны хяналтад дор бэлтгэлийн ажил хийгддэг | Бэлтгэлийн ажил орхигдсон |
| **Оролцогчид** | Нийлүүлэгч:<br>- САА болон ХАА нэгдэл<br>Хэрэглэгч:<br>- Улсын үйлдвэр<br>- Экспортын бааз<br>Зохион байгуулагч:<br>- Худалдаа бэлтгэлийн бааз | Нийлүүлэгч:<br>- Малчид, тариаланчид<br>Хэрэглэгч:<br>- Дотоодын үйлдвэрлэгчид<br>- Гадаадын хэрэглэгчид<br>Зуучлагчид:<br>- Брокер, хоршоо |
| **Зохицуулалтын хэлбэр** | Төрөөс тогтоосон төлөвлөгөө болон журмын дагуу ангилан бэлтгэх, тээвэрлэх, нийлүүлэх ажлууд хийгддэг. | Бараа, түүхий эдийн эрэлт, нийлүүлэлтээр үнэ зохицуулагдах бөгөөд бирж нь хууль, дүрэм, журмыг ягштал баримтладаг зохицуулалттай, мэргэжлийн байгууллага. Арилжаа нь гэрээгээр зохицуулагддаг, итгэлцлэлд суурилсан бизнесийн үйл ажиллагаа юм. |

**B/. Боловсруулах үйлдвэрлэлийн хүрээний өөрчлөлт.** Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцооны үед хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн, түүхий эдийг боловсруулах үйл ажилагаагааг мөн төрийн өмчийн том хэмжээний үйлдвэрүүд эрхэлж байв. Зах зээлд шилжсэнээр эдгээр том үйлвэрүүдийн дийлэнх нь зогсонги байдалд орсон бөгөөд үүний голлох шалтгаан нь эргэлтийн хөрөнгийн дутагдлаас түүхий эдээ авч чадахгүй байгаа, техник, технологи хоцрогдсон, чанартай түүхий эдээр тасралтгүй хангагдах бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоо байхгүйтэй холбоотой байсан. Сүүлийн жилүүдэд төрийн оролцоо, дэмжлэгтэйгээр үндэсний үйлдвэрүүд техник технологийн шинэчлэлт хийж, шаардлагатай түүхий эдийн эргэлтийн хөрөнгийн дэмжлэг авч байна. Мөн бирж байгуулагдсанаар бэлтгэн нийлүүлэлтийн байдалд нааштай өөрчлөлтүүд гарсан хэдий ч анхан шатны тордолт, ангилан ялгалт хийгдээгүй, хаягдал ихтэй түүхий эдээр хангагдаж байна. Мөн гадаадын худалдан авагчид болон дотоодын ченжүүдийн тогтолцоо өнөөг хүртэл биржийн гадуурх арилжаанд идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна. Үйлдвэрүүд ченжүүдтэй өрсөлдөж түүхий эдээ худалдан авч байна.

**C/. Үнийн зохицуулалтын өөрчлөлт**. Өмнөх тогтолцооны үед бүтээгдэхүүний үнийг төрөөс хатуу тогтоодог байсан. Зах зээлийн шилжилтийн үед хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн, түүхий эдийн үнэ зах зээлийн зарчим, бүтээгдэхүүний эрэлт, нийлүүлэлтийн хууль, зүй тогтол төлөвшин хөгжих хандлагатай болсон. Хөдөө аж ахуйн бирж нь арилжаа хийж, үнэ тогтоох ажлыг хийж байгаа хэдий ч зах зээлийн бодит үнийг бүрдүүлж чадахгүй байна.

**D/. Борлуулалтын сувагт гарсан өөрчлөлт.** Зах зээлийн нөхцөлд тохирсон бараа борлуулалт, түүхий эд бэлтгэлийн зохистой тогтолцооны суваг төлөвшиж бүрдээгүй байгаа нь маркетингийн тулгамдсан асуудлын нэг болж байсан.

Хөдөө аж ахуйн бирж байгуулагдсанаар менежмент, маркетингийн оновчтой борлуулалтын сувгийг бий болгоход дараахи өвөрмөц онцлогийг зайлшгүй харгалзан үзэх шаардлагатай гэж үзнэ.

- Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн, түүхий эдийн нийлүүлэлт нь улирлын шинж чанартай, нөөц нь хязгаарлагдмал байна.
- Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн, түүхий эдийг малчид, тариаланчид нь төвлөрсөн зах зээл, үйлдвэрүүдээс алс хол таруу байршилтай тул бүтээгдэхүүн, түүхий эдийг цуглуулж борлуулахад нэлээд бэрхшээлтэй, зардал өндөр хэвээр байна.
- Хөдөө орон нутагт зам харилцаа, холбоо, мэдээллийн дэд бүтэц сүүлийн жилүүдэд хурдацтай хөгжсөн нь маркетингийн оновчтой суваг бүрдүүлэхэд эерэг нөлөөлөл үзүүлэхээр байна. Хэдийгээр дэд бүтэц хөгжиж, зам, холбоо харилцаа хөгжиж байгаа ч биржийн хэлцлийн зардлыг бууруулахад чухал үүрэгтэй байдаг.
- Монгол улсын хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний дотоод зах зээлийн багтаамж бага, хөрш зэргэлдээ хоёр том гүрний зах зээлийн нөлөөлөл хүчтэй байна.
- Ченжийн тогтолцоо өнөөг хүртэл ихээхэн нөлөөтэй ажиллаж байна. Энэхүү албан бус секторыг биржийн арилжааны тогтолцоотой уялдуулах шаардлагатай байна.

Эдгээр онцлог байдлаас шалтгаалж хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн, түүхий эдийн борлуулалтын сувагт малчид, тариаланчид болон үйлдвэрүүдийг холбоход хэд хэдэн суваг голлох үүрэгтэй оролцож байна.

- **Ченж**: Борлуулалтын сувагт “ченж” гэж нэрлэгдэх завсарын худалдаачид чухал үүрэг гүйцэтгэсээр байна. Тухайлбал, дотоод зах зээлд борлуулагдаж буй түүхий арьс ширний 78,5 хувь нь завсрын наймаачдын гараар дамждгийг судлаач С.Хандсүрэн /2001/ онд тогтоожээ. Мөн Мерси Кор олон улсын байгууллагын судалгаа болон Ноос, ноолуурын холбооны хийсэн судалгааны тайлангуудад мал аж ахуйн бараа, түүхий эдийн 80 гаруй

хувь нь хот болон аймгийн захууд, сумын төв дэх завсрын наймаачдаар, 20 орчим хувь нь үндэсний үйлдвэрүүдийн төлөөлөгчдөөр дамжин арилжаалдаг байна. Завсрын наймаачид өөрсдийн болон гадаадын худалдаачдын хөрөнгөөр түүхий эд бэлтгэн нийлүүлж байгаа бөгөөд түүхий эдийн бэлтгэл, анхан шатны тордолт шаардахгүйгээр авч байна.

- **Хоршоо**: Хөдөө аж ахуйн чиглэлийн хоршоо ихэнх сумдад идэвхитэй үйл ажиллагаа явуулж байгаа боловч менежмент болон маркетингийн бодлого, эргэлтийн хөрөнгө, санхүүгийн боломж сул хэвээр байна.
- **Үйлдвэрийн төлөөлөгчид**: Боловсруулах үйлдвэрүүд орон нутаг дахь өөрсдийн төлөөлөгчөөр дамжуулан түүхий эдээ олж авч байна. Сүүлийн жилүүдэд төрөөс хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн (ноос, ноолуур, арьс, шир, мах, сүү, улаан буудай) -үүдэд татаас олгож байгаа бөгөөд үйлдвэрт тушаасан тохиолдолд малчид, тариаланчдад татаас олгож байна. Энэ нь үйлдвэрүүдийн түүхий эдийн нөөц бүрдэхэд ихээхэн дэмлэг болж байна.
- **Өөрсдөө шууд нийлүүлэх**: Томоохон хот суурьн газарт ойр байршилтай малчид, тариаланчид түүхий эдийн төрөлжсөн зах, боловсруулах үйлдвэрүүдэд түүхий эд, бүтээгдэхүүнээ өөрспөө авчирч шууд борлуулж байна.
- **Хөдөө аж ахуйн бирж**: Хөдөө аж ахуйн биржийн арилжааны байнгын оролцогчид нь брокерууд, байнгын бус оролцогч болох хоршоод хамаарч байна. Биржийн арилжаанд оролцох оролцогчдын оролцоо сул байна.

Хөдөө аж ахуйн бирж байгуулах асуудал нь олон жилийн төрийн бодлогын үр дүн бий болсон.

Диаграмм 3. Түүхий эдийн бэлтгэлийн тогтолцоонд тулгарсан асуудал




***Шилжилтийн эдийн засгийн үед бий болсон эерэг өөрчлөлтүүд:***

1. Өмч хувьчлалын үр дүнд малчид, тариаланчид өөрийн өмч, хөрөнгөтэй болсон.
2. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл өссөн.

***Шилжилтийн эдийн засгийн үед бий болсон бэлтгэн нийлүүлэлтийн өөрчлөлтүүд:***

1. Зохион байгуулалттай худалдааны систем задран унасан
2. Хоосон орон зайнд ченжийн тогтолцоо үүссэн

Үүссэн сөрөг үр дагавар:

1. Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн бэлтгэлийн стандартын хэрэгжилт үгүй болж, чанар буурсан;
2. Зах зээлийн шударга өрсөлдөөний зарчим үйлчлэхгүй болж, малчдын хувьд түүхий эд, бүтээгдэхүүнээ зохион байгуулалттайгаар борлуулах тогтсон сүлжээ байхгүй болсон;
3. Малчид, тариаланчдын орлогын эх үүсвэр тодорхойгүй болсон;
4. Үндэсний үйлдвэрүүд шаардлагатай түүхий эдийн нөөцөөр дутагдсан;
5. Гадаадын худалдаачдын нөлөө хүчирхэгжиж, гадаадын хөрөнгөөр монголын ченжүүд стандартын дагуу бэлтгэхгүйгээр түүхий эд, бүтээгдэхүүнийг худалдан авч, түүхийгээр нь экспортлож байна;
6. Товчоор илэрхийлбэл, Монгол Улс нь нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, экспортлох боломжоо алдаж байна.

Төрөөс хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт баримтлах бодлого, хөтөлбөрүүдэд хүн амыг аюулгүй хүнсээр болон дотоодын үйлдвэрүүдийг чанартай түүхий эдээр хангах, малчдын орлогыг нэмэгдүүлэх зэрэг зорилтууд дэвшүүлсэн.

Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл өссөн хэдий ч зохион байгуулалттай худалдааны систем задран унасан. Энэ хоосон орон зайд түүхий эд цуглуулдаг дундын зуучлалын систем буюу ченжийн тогтолцоо үүссэн. Үүний үр дүнд хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн бэлтгэлийн стандарт үгүй болж, чанар буурсан, зах зээлийн шударга өрсөлдөөний зарчим үйлчлэхгүй болж, малчдын хувьд түүхий эд, бүтээгдэхүүнээ зохион байгуулалттайгаар борлуулах тогтсон сүлжээ байхгүй болж, түүхий эдийн чанар муудсан зэрэг асуудлууд үүссэн.

Эдгээр асуудлын нэг нь малчид, тариаланчдын орлогын эх үүсвэр тодорхойгүй болсон, мөн үйлдвэрүүд шаардлагатай түүхий эдийн нөөцөөр дутагдсан зэрэг асуудлууд тулгарсан. Мөн түүнчилэн гадаадын худалдаачдын нөлөө хүчирхэгжиж, гадаадын хөрөнгөөр монголын ченжүүд стандартын дагуу бэлтгэхгүйгээр түүхий эд, бүтээгдэхүүнийг худалдан авч, түүхийгээр нь экспортлож байна. Товчоор илэрхийлбэл, Монгол Улс нь нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, экспортлох боломжоо алдаж байна. Монголын нөхцөлд, дундын зуучлагчид бараа, түүхий эдийн худалдан авах болон худалдах үнийг тогтоож байна.

Диаграмм 4. Бирж байгуулах оролдлогууд




1990 оноос хойш өнөөг хүртэл хөдөө аж ахуйн барааны бирж байгуулах оролдлогуудыг төрөөс хийж байсан. Тухайлбал:

1990-1995 Монгол улсад зах зээлийн эдийн засгийн эхэн үед, тухайлбал 1990 онд Эрдэнэт бирж, 1992 онд төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцооны үед байсан худалдаа бэлтгэлийн байгууллагуудын өмч хөрөнгө, боловсон хүчний сууринд тулгуурлан Хөдөө аж ахуйн бирж байгуулсан боловч амжилттай ажиллаж чадаагүй байна.

| | |
|---|---|
| 2000 оны эхэн үед | Үйлдвэр худалдааны яамнаас НҮБ-ийн төслийн хүрээнд Баянхонгор, Хэнтий зэрэг аймгуудад ноолуурын хэд хэдэн удаагийн дуудлага худалдаа туршиж явуулж байсан. |
| 2001-2010 | Үе үеийн төрийн сонгуулийн үеэр малчид, тариаланчид хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн бүтээгдэхүүнийг борлуулах тогтолцоог бий болгох шаардлагыг тавьж ирсэн. Засгийн газрын 2001 оны 219 дүгээр тогтоолоор “Бөөний худалдааны сүлжээ” хөтөлбөрийг баталж, хэрэгжүүлсэн. Энэхүү хөтөлбөрийн зорилго нь хүн амыг чанартай хүнс, өргөн хэрэглээний бараагаар, үйлдвэрлэлийн түүхий эдээр тасралтгүй хангах, бараа, түүхий эдийн бэлтгэл, нийлүүлэлтийн зохистой тогтолцоог бий болгох, бараа, түүхий эдийн хадгалалт, тээвэрлэлтийн оновчтой тогтолцоог бий болгох замаар зах зээлийн бодит үнийн түвшинг бүрдүүлж хот, хөдөөгийн хоорондох үнийн зөрүүг багасгахад чиглэсэн. Уг хөтөлбөр 2001-2010 оны хугацаанд хүнс, өргөн хэрэглээний барааны хангамжийн хувьд амжилттай ажилласан боловч түүхий эдийн бэлтгэл, нийлүүлэлтийн тогтолцоог сайжруулахад амжилттай ажиллаж чадаагүй байна. 2007-2011 оны хугацаанд Улсын Их Хурал, Засгийн газар, Хүнс, хөдөө аж ахуйн яамны түвшинд ажлын хэсэг байгуулагдаж, хөдөө аж ахуйн бирж байгуулах хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх, гадаадын туршлага судлах ажлууд хийгдсэн байна. |
| 2011-2020 | Улсын Их Хурлаас 2011 онд Хөдөө аж ахуйн бараа, түүхий эдийн биржийн хууль батлагдснаар хөдөө аж ахуйн түүхий эдийн бэлтгэл, нийлүүлэлтийн тогтолцоонд өөрчлөлт, шинэчлэлт бий болох нөхцлийг бүрдүүлсэн. |

Диаграмм 5. Бирж байгуулснаар гарах хүлээлт




Эдгээр асуудлыг шийдвэрлэх тулд Монголын Засгийн газар малчид, тариалагчид болон үйлдвэрүүдийн хоорондох худалдааг дэмжсэн хөдөө аж ахуйн биржийг байгуулахаар зорьсон. Хөдөө аж ахуйн бирж байгуулагдсанаар хөдөө аж ахуйн түүхий эд, бүтээгдэхүүний зах зээлийн бодит үнэ бүрдэх, малчдын орлого тогтворжих, бараа, түүхий эдийн чанар, стандарт сайжирах, үйлдвэрүүдийг чанартай түүхий эдээр хангах,

агуулах, тээвэр, лаборатори, даатгал, банк санхүүгийн зохион байгуулалттай биржийн хатуу болон зөөлөн дэд бүтэц бий болох зэрэг таатай боломжууд бий болдог.

Бирж нь биржээс баталсан дүрэм, журмын хүрээнд малчид, тариаланчид болон үйлдэрүүд биет болон бүтээгдэхүүнд суурилсан гэрээний арилжаа хийдэг зохион байгуулалттай худалдааны газар юм. Бирж байгуулах өөр нэг шалтгаан бол төвлөрсөн газар худалдаа хийхийг хүсч байгаа малчид, тариаланчид болон үйлдвэрүүдийг төвлөрүүлэх явдал юм. Хөдөө аж ахуйн бирж нь бараа, түүхий эдийн ангилалт, тээвэрлэлт болон агуулахын үйлчилгээтэй холбоотой зардлыг бууруулах, зах зээлийн үнэ, тоо хэмжээний талаарх бодит мэдээ, мэдээллээр хангах зэрэг боломжийг олгодог.

Нийгэм, эдийн засгийн шаардлага болон төрийн бодлогын зорилтыг хангах хүрээнд хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн тогтолцоог сайжруулах зорилгоор Хөдөө аж ахуйн биржийг 2011 онд байгуулагдах эрх зүйн орчин бүрдэж, 2013 онд байгуулагдаж, 8 жил үйл ажиллагаа явуулж байна. Бирж байгуулагдснаар үйлдвэр, малчид, тариаланчид, хоршоод болон бусад төрийн, төрийн бус байгууллага, биржийн арилжаанд оролцогчдын хувьд хамтын ажиллагаа, арилжаа, түүхий эдийн чанар болон хангамж сайжирч зах зээлийн бодит үнэ бүрдсэн биржийн сүлжээ бий болно гэсэн хүлээлт өндөртэй байсан хэдий ч хөдөө аж ахуйн бирж нь дээрх хүлээлтэд хүрч ажиллаж чадаагүй байна.

Биржээс дээр дурдсан чанартай үйлчилгээ үзүүлэх, форвартын арилжааг нэвтрүүлэх замаар олон оролцогчдыг татаагүй, ялангуяа хоршоодыг хамруулж чадаагүй, хөдөө аж ахуйн биржийн хуулийг хангалтгүй хэрэгжүүлсэн учраас өнөөг хүртэл ченжийн тогтолцоо хэвээр ажиллаж байна.

## 3.4. Дэд дүгнэлт

Хөдөө аж ахуйн салбар нь 2005-2020 онд жилд дундажаар 6.0 хувийн бодит эдийн засгийн өсөлттэй байна. Энэ нь дэлхийн түвшинтэй харьцуулахад өндөр үзүүлэлт юм. Тухайлбал 2000-2020 оны дундаж ДНБ-ийн өсөлт 6.7 хувь байсан бол хөдөө аж ахуйд 6.9 хувьтай байсан. Хөдөө аж ахуйн салбарын бүтээгдэхүүн, үйлдвэрлэл 2011 оноос нэмэгдсэн хэдий ч тулгарч байгаа зарим хүндрэлүүд байсаар байна.

- **Хөдөө аж ахуйн экспортын өсөлт удааширалтай хэвээр байна**: Хөдөө аж ахуйн экспортын нийт экспортод эзлэх хувийн жин 2000 онд 20 хувь байснаа 2020 онд 12 хувь хүртэл буурчээ.
- **Цаг агаарын өөрчлөлт:** Хөдөө аж ахуйн салбарт байгаль, цаг уурын нөхцөл байдал шууд нөлөөлдөг гол хүчин зүйлийн нэг бөгөөд 2000 оны эхээр монголд ган, зуд болж хөдөө аж ахуй, ялангуяа мал аж ахуйн үйлдвэрлэл буурсан.
- **Салбарын ажил эрхлэлтийн эзлэх хувийн жин буурч байна:** 2000 оны эхэн үед нийт ажил эрхлэлтийн 50 орчим хувийг хөдөө аж ахуйн салбар эзэлж байснаа 2020 оны байдлаар 25.3 хувь хүртэл буурсан байна. Хөдөөнөөс хот руу нүүх шилжилт хөдөлгөөн, бусад салбарын үйлдвэрлэлийн идэвхжил, хотжилт, орчин үеийн технологийн нэвтрэлт зэрэг олон хүчин зүйлсийн нөлөөллөөр буурах хандлагатай байна.
- **Малчид, тариаланчид түүхий эдээ борлуулах нэгдсэн сүлжээ байхгүй байна:** Нэг малчин, тариаланчид ногдох орлого мөн хугацаанд өссөн байна. Газар тариалангийн салбарын хувьд төвийн бүсийн Төв, Сэлэнгэ аймгуудад тариалан эрхлэлт зонхилон хийж байна. Гэвч малчид, тариаланчид түүхий эдээ хадгалах агуулах байхгүй, түүхий эдийн чанарт хяналт тавих тогтолцоо байхгүй учраас стандартын дагуу түүхий эдээ бэлтгэхгүйгээр дундын зуучлалын худалдаачдад хямд үнээр борлуулж байна.
- **Төвлсөрсөн зах зээлээс хөдөө аж ахуйн нөөцийн байршил алслагдсан.**
- **Түүхий эдийн чанар буурсан:** Малын тоо өсч, малчдын орлого нэмэгдсэн хэдий ч түүхий эдийн чанар буурсан, малын бүтцэд өөрчлөлт гарсан.
- **Хоршооны оролцоо сул байна:** Хоршоодын менежмент, хүний нөөц, санхүүгийн боломж сул, жинхэнэ малчдын хоршоог дахин үнэлж, биржийн үйл ажиллагаатай уялдуулах шаардлагатай байна.
- **Биржийн үйл ажиллагааны хэрэгжилтийг эрчимжүүлэх шаардлагатай байна.** Хөдөө аж ахуйн бирж нь төрөөс дэвшүүлсэн зорилтыг хангах, хүлээгдэж буй үр дүнг хангахад бүхий л нөөцөө төвлөрүүлэн ашиглах нь зүйтэй байна.

Хөдөө аж ахуйн салбарын бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоог сайжруулах замаар үйлдвэрүүдийг чанартай түүхий эдээр тогтвортой хангах, малчдын орлогыг нэмэгдүүлэх, хөнгөн үйлдвэрлэлийн салбарын үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлж, ажлын байрыг шинээр бий болгох салбарын бодлогыг хэрэгжүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

# ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ОЛОН УЛСЫН БАРААНЫ БИРЖИЙН ТУРШЛАГА, ТҮҮНИЙ СУРГАЛЖ БА БОЛОМЖ

## 4.1. Барааны бирж, түүний амжилттай ажиллах урьдчилсан нөхцөл

**Барааны биржийн ойлголт, тодорхойлолт:** Бирж гэдэг үгийг англи хэлэнд "exchange" , орос хэлэнд "биржа", латин хэлэнд "borsa" зэргээр хэлдэг бөгөөд монгол хэлнээ "бирж" гэж нэрлэж байна. Бараа, бүтээгдэхүүний биржийг англи хэлэнд "commodity exchange", орос хэлэнд "товарная биржа" гэж нэрлэдэг. Мөн бараа, бүтээгдэхүүний бирж, бараа товарын бирж, барааны бирж гэж нэрлэж байна. Зарим тохиолдолд биржийг "commodity market" буюу "terminal market" гэж нэрлэдэг байна. Хөдөө аж ахуйн гаралтай бараа, бүтээгдэхүүнд буудай, үр тариа, ноос, ноолуур, мах, махан бүтээгдэхүүн, элсэн чихэр, кофе, какао зэрэг бүтээгдэхүүн багтдаг.

Барааны биржийн талаар олон төрлийн тодорхойлолтууд байдаг. Үүнд:

- Олон улсад барааны биржийн талаар нэгдсэн тодорхойлолтыг НҮБ-аас тодорхойлсон байдаг. Тус тодорхойлолтоор "Бараа, түүхий эдийн бирж гэдэг нь биржээс тогтоосон дүрэм, журмын үндсэн дээр олон худалдан авагч, худалдаалагчид олноороо оролцож бараа бүтээгдэхүүнтэй холбоотой гэрээг арилжаалдаг зах зээл юм". (UNCTAD-ийн хөгжил, 2009).
- Бирж нь томоохон зах зээл (түүхий эдийн нөөцөд ойрхон)-ийн дэргэд байрлалтай бараа, түүхий эд худалдагч болон худалдан авагчдын хоорондын арилжааг нэг цэгт төвлөрүүлэн зохион байгуулдаг мэргэшсэн худалдааны байгууллага юм.
- Барааны бирж гэж тогтсон дүрэм, журмын хүрээнд бараа, бүтээгдэхүүнийг худалдах болон худалдан авах үйл ажиллагаа явуулдаг, олон тооны худалдагч болон худалдан авагч нарийг уулзуулдаг, зохион байгууллалттай үйл ажиллагаа явуулдаг байгууллагыг хэлнэ.
- Бараа, бүтээгдэхүүний биржийг хязгаарлагдмал утгаар нь авч үзвэл худалдаа, арилжааны гэрээ хэлцэл төвлөрч явагддаг төв гэж хэлдэг. Өргөн утгаар нь олон улс, бүс нутаг болон тухайн орны хэмжээнд хийж буй арилжаа наймаа, хэлцэлийн бүртгэл хийдэг төв юм. Бирж нь бэлэн бүтээгдэхүүний арилжаа хийхээс гадна хугацаат болон фьючер гэрээний арилжааг зохион байгуулдаг газар юм.
- Монгол улсын хувьд хөдөө аж ахуйн бирж гэж хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн арилжааг тогтсон журмын дагуу зориулалтын байранд, эсхүл цахим сүлжээгээр дамжуулан арилжаа хийдэг газар гэж тодорхойлдог.

Барааны бирж нь **бараа болон санхүүгийн зах зээлийн хосолсон хэлбэр** гэж ойлгох нь зүйтэй. Хөдөө аж ахуйн биржийн гол үүрэгт арилжаа, бараа, түүхий эдийн чанарын баталгаажуулалт, зах зээлийн үнийн бодит мэдээлэл, найдвартай, аюулгүй хадгалалт, хамгаалалт, тээвэр ложистикийн асуудал багтдаг. Тогтолцооны хувьд **агуулахын аж ахуйн** үйл ажиллагаанд суурилан бараа, түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлтийн үйл ажиллагаа явагддаг бөгөөд агуулын аж ахуйд түүхий эдийн анхан шатны тордолт хийх, дээж авах, жинлэх, ангилах, хүлээн авах, цахим болон танхимийн арилжаа хийх, төлбөр тооцоо, клирингийн үйл ажиллагаа болон мэдээлэл солилцоо явуулах, чанарт асуудал гарсан тохиолдолд биржийн дотоод арбитр ажиллах зэрэг үйл ажиллагаа явагддаг.

Зөөлөн дэд бүтэцэд дүрэм, журам, арилжааны болон мэдээлийн IT сүлжээ, платформ зэрэг орно. Хатуу дэд бүтцэд агуулахын аж ахуйн, биржийн барилга зэрэг багтана.

**Хүснэгт 13:** Биржийн зөөлөн болон хатуу дэд бүтэц

| Систем | Дэд бүтэц | Дүрэм, журам | Оролцогч |
|---|---|---|---|
| Үйл ажиллагаа:<br>- Агуулахын үйл ажиллагаа<br>- Дээж авах<br>- Жинлэх<br>- Ангилах<br>- Хүлээн авах<br>- Төлбөр тооцоо хийх<br>- Мэдээлэл<br>- Арбитр | Биржийн хувьд:<br>- Агуулахын аж ахуйн<br>- IT систем<br>- Барилга байгууламж<br>- Нийтийн мэдээллийн сан | - Эрхзүйн орчин<br>- Арбитрийн ажиллагаа<br>- Гишүүнчлэл<br>- Брокер<br>- Мэргэжлийн холбоо<br>- Удирдлага | - Биржийн орон тооны ажилагсад<br>- Биржийн Удирдах Зөвлөл<br>- Арилжааны гишүүд<br>- Хэрэглэгчид |

Нөгөөтэйгүүр бирж нь зөвхөн бараа, бүтээгдэхүүний арилжаа явуулахаас гадна үйлдвэрлэгч, хэрэглэгчдийг үйлдвэрлэл, хэрэглээ, санхүү, зах зээлийн бодит мэдээллийн урсгалаар хангаж, холбож өгдөг худалдааны өвөрмөц хэлбэр юм.

**Диаграмм 6.** Хөдөө биржийн тогтолцоо




**Барааны урсгал** гэдэгт агуулахын аж ахуйд бараа хүлээн авч, ангилалт, ялгалт, баталгаажуулалт хийж арилжаанд оруулах, хүргэлт хийх бүхий л үйл ажиллагааны процесс багтана. **Санхүүгийн урсгал** гэдэгт бараа, түүхий эдийн чанарын баталгаажуулалт, арилжааны мэдээлэлд тулгуурлан клиринг, төлбөр тооцоотой холбоотой, мөн төрийн худалдан авалт, татаастай холбоотой мэдээллийн урсгалыг агуулна. **Мэдээллийн урсгал** гэдэгт биржийн бэлтгэн нийлүүлэлт, арилжаа, төлбөр тооцоо, гишүүд болон оролцогчдод зориулсан өдөр тутмын шаардлагатай, цаг үеийн шинжтэй бүхий л мэдээллийг агуулсан ойлголт юм.

Бирж нь зохион байгууллаттай зах зээлийн хэлбэр бөгөөд түүний зорилго нь худалдаа арилжаанд оролцогч бүх этгээд, хувь хүмүүст **ил тод, нээлттэй, шударга байх зарчим** болон чөлөөт үнийн тогтолцоонд тулгуурлан үйлдвэрлэгч, хэрэглэгчийн үнэн зөв, бодит мэдээ, мэдээллээр хангаж, бүх оролцогчдод адил тэгш, шударга ажиллах боломжоор хангах, биржийн арилжааны зах зээлийн тогтолцоонд гарах хэлцлийн зардлыг бууруулах үүрэгтэйгээр ажиллахад чиглэж ажилладаг.

Бараа, түүхий эдийн худалдааг нэг цэгт төвлөрүүлснээр арилжаанд оролцогчдын цаг хугацаа болон зардлыг хэмнэх, хэрэгцээт бараа, бүтээгдэхүүнээр тасралтгүй хангах нөхцөл бүрддэг. Олон улсын биржүүд нь нийгэм, эдийн засгийн шаардлагаар үүсэн

байгуулагдаж, үйлдвэрлэгч, хэрэглэгч, банк, санхүүгийн байгууллага болон төрийн байгууллагуудыг үйл ажиллагааг холбосон томоохон үүргийг гүйцэтгэж байна. Бирж нь зөвхөн бараа, бүтээгдэхүүний арилжаа хийдэг гэж ойлгож болохгүй. Өөрөөр хэлбэл барааны урсгалаас гадна үйлдвэрлэгч болон хэрэглэгчдийг холбосон мөнгө- санхүү, зах зээлийн бодит мэдээллийн урсгалаар холбогддог. Спот арилжаа хийж байгаа тохиолдолд зөвхөн бараа, бүтээгдэхүүний арилжаа идэвхтэй явагдаж, харин форвард болон фьючерсийн арилжааг нэвтрүүлснээр санхүүгийн зах зээлтэй холбогдож, оролцогчдын тоо, барааны чанарт ахьц гардаг.

Олон улсад үйл ажиллагаа явуулж байгаа бараа, түүхий эдийн биржүүд нь биржийн бүх оролцогчдод нээлттэй, ил тод, шударга байх зэрэг нийтлэг зарчимд тулгуурлан ажилладаг. Биржийн баримтлах зарчим нь оролцогчдод ил тодоор үйлчлэх, зах зээлийн чөлөөт үнийн тогтолцоонд тулгуурлан оролцогчдыг шудрагаар өрсөлдөх боломжийг бүрдүүлэхэд чиглэдэг. Бирж нь өөрийн үйл ажиллагааг бие даан зохицуулах үүднээс хэнээс ч хараат бус байхаар эрх зүйн орчингоор хангагдсан, нийгмийн эрх ашгийг эрхэмлэх үүднээс ашгийн бус зорилгоор аж ахуйн үйл ажиллагаа явуулж байна.

Олон улсад үйл ажиллагаа явуулж байгаа барааны бирж амжилттай ажиллахын тулд дараах нийтлэг үүргийг гүйцэтгэдэг байна. Үүнд:

1. Биржээр арилжих барааны үнийг зарлах, хаах;
2. Зах зээлийн ил тод байдлыг хангах;
3. Үнийн эрсдлийг удирдах;
4. Тогтолцооны зардлыг бууруулах;
5. Санхүү, хөрөнгө оруулалт, зээл авах боломжоор хангах;
6. Оролцогчдыг татаж, тэдний эрх ашгийг хамгаалах.

Биржээр арилжих барааны үнийг зарлах, хаах хүрээнд: Биржийн гол үүргийн нэг нь биржээр арилжаалах бараа, бүтээгдэхүүний үнийг нээх, хаах үйл ажиллагаа явуулдаг. Биржийн дуудлага худалдааны хэлбэрийг ашиглан оролцогчид худалдах, худалдан авах үнээ санал болгож, арилжаанд оролцсоноор бирж дээр бодит үнэ бүрдэх нөхцөл бүрддэг. Биржээр арилжаалсан бүтээгдэхүүний үнэ биржийн гадуурх арилжаа болон хэлцэлд жишиг үнэ болдог.

Зах зээлийн ил тод байдлыг хангах хүрээнд: Бирж дээр ил тод байдлыг бий болгох, үйл ажиллагааг хөнгөвчлөх зорилгоор биржээр арилжаалдаг бүтээгдэхүүнийг ангилах, ялгах, багцлах, тээвэрлэх, агуулах зэрэг үйл ажиллагаа мэргэжлийн төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудаар дамжуулан гүйцэтгэдэг байна. Биржийн бүртгэлтэй гишүүд хэлэлцээр хийдэг бөгөөд гэрээний нөхцөлүүд нь стандартчлагдсан албан шаардлагын шинж чанартай байдаг. Худалдан авах ба зарах захиалгыг олон нийтийн дуудлага худалдаагаар явуулах ба эндээс гарсан үнийг бичин авч тэр дор нь нийтэд зарласнаар зах зээлийн ил тод байдлыг хангадаг. Ил тод байдлыг хангахын тулд мэдээллийн сүлжээ чухал үүрэгтэй. Мэдээллийн сүлжээ гэдэгт биржийн барааны зах зээлийн эрэлт, нийлүүлэлт, үнэ болон чанартай холбоотой мэдээллийн урсгал багтдаг. Мэдээллийн сүлжээ нь өдөр, цаг бүрээр шинэчлэгдсэн бодит мэдээллээр хангагдана. Энэ нь биржийн оролцогчдын хувьд бизнесийн үйл ажиллагааны аливаа зардлуудыг хэмнэсэн үр ашигтай нөхцөл болно.

Үнийн эрсдлийг удирдах хүрээнд: Арилжааны явцад зарим оролцогчид хожоотой байдаг бол бусад нь алдагдал болон эрсдэл хүлээдэг. Гарч болох эрсдлээс сэргийлэх нэр арга бол фьючесрийн гэрээний хэлбэрийг арилжаанд нэвтрүүлж болно. Гэрээний арилжааны хэлбэрээр биржийн худалдаа явагдаж байгаа тохиолдолд биржийн

оролцогчдод бүтээгдэхүүний чанар, хугацаа, хүргэлт, төлбөр тооцоо болон аюулгүй байдалтай холбоотой хариуцлагыг өндөржүүлж өгдөг.

Тогтолцооны зардлыг бууруулах хүрээнд: Биржийн үүргийг эрх, үүргийн ойлголтоос “transaction cost” буюу үйл ажиллагааны зардал гэдэг ойлголт гарч ирдэг. Зардал гаргахгүй бизнесийн үйл ажиллагаа явуулах боломж хомс юм. Арилжаанд аль болох бага зардалтайгаар оролцох нь эдийн засгийн хувьд ач холбогдолтой. Үйлдвэрлэгч нь биржээр дамжуулан бараа, бүтээгдэхүүнийг худалдан авалт хийдэг системийг “pull system” буюу худалдан авалтын систем гэж нэрлэдэг. Энэ системийг зуучлагчтай буюу зуучлагчгүй гэж ангилдаг. Зуучлагчтэй арилжааны системийг зохион байгуулалттай албан сектор дахь арилжааны хэлбэр нь бирж бөгөөд зохион байгуулалтгүй албан бус сектор дахь арилжааны хэлбэр нь ченжийн арилжаа гэж ангилдаг байна.

Диаграмм 7. Ханган нийлүүлэлтийн тогтолцоо




Бараа, бүтээгдэхүүнийг арилжаалах, үйлдвэрлэгч хэрэглэгчтэй хамтран ажиллахыг хүсч байгаа аж ахуйн нэгж болон худалдан авагч нь хэн болохыг мэдэх, анхны үнээр санал болгох, худалдан авах, үнийг буулгахад хүргэж болох хэлцэлийг зохион санал болгох, ярих хэлэлцээ хийхээр уулзах зэрэг шаардлага тулгардаг. Бирж буюу төвлөрсөн зохион байгуулалттай худалдааны газар байхгүй тохиолдолд зах зээлийн мэдээ, мэдээлэл олж авах, түүхий эдийн ангилах, анхан шатны тордолт хийх, багцлах, агуулах, тээвэрлэх, арилжаалахтай холбоотой маш их өндөртэй зардал гардаг. Зохион байгуулалтгүй арилжаа хийж байгаа үед арилжаа хийснээр ихээхэн хэмжээний зардал гарахын зэрэгцээ хугацаа алдах, томилолтоор удаа дараа явах, бизнесийн ажилд аз турших, алдагдал хүлээх зэрэг сөрөг үзэгдлүүд бий болдог. Хүмүүсийн хооронд хийдэг эмх замбараагүй арилжааг зохион байгуулалтад “бирж” гэсэн байгууллагын бүтцийг байгуулж, дэвшилтэд техник технологийн тусламжтайгаар бизнесийн зардлыг бууруулдаг олон улсын туршлага харуулж байна. Бирж байгуулагдах эхний шатанд үйл ажиллагааны зардлыг бууруулахын тулд үйлдвэрлэгчид хэрэглэгчдийг хооронд нь уулзуулах, биенээ олоход дэмжлэг үзүүлэх зорилготой бэлэн бүтээгдэхүүний бирж “Spot exchange” зах зээлийг байгуулж эхэлсэн туршлага ихээхэн байдаг байна.

Санхүү, хөрөнгө оруулалт, зээл авах боломжоор хангах хүрээнд: Бараа, бүтээгдэхүүний биржийн үйл ажиллагааны давуу талуудын дэлгэрэнгүй анализ хийхдээ биржийн тогтолцоонд шинэлэг арга хэлбэр нэвтрүүлэх, үйл ажиллагааг шинэ түвшинд гаргах боломжийг үргэлж эрэлхийлж байх шаардлагатай байдаг. Санхүү, хөрөнгө оруулалт, зээлээр хангах системийг бий болгох нөхцөл нь агуулахын аж ахуй байдаг. Банк хөдөө аж ахуйн салбарт зээл өгч эрсдэл хүлээхээс болгоомжилж зээл өгөх сонирхолгүй байгаа нөхцөлд агуулахын аж ахуйгаас баталгаажуулж, олгосон агуулахын болон чанарын сертификат нь малчид, тариаланчид, хоршоодын хувьд зээл авах боломжтой арга хэрэгсэл болдог. Бүтээгдэхүүнээ биржээр арилжаалахаар гэрээлсэн тохиолдолд банкнаас зээл олгодог.

Оролцогчдыг татаж, тэдний эрх ашгийг хамгаалах хүрээнд: Биржийн оролцогчдын эрх ашгийг хамгаалах, биржийн оролцогчдыг татах таатай орчинг бүрдүүлж, үйлчилгээ сайн үзүүснээр оролцогчдын биржид итгэх итгэлцэл нэмэгддэг.

Бирж нь ил тод, нээлттэй, шударга байх зарчимд тулгуурлан биржийн үүргийг гүйцэтгэхийн тулд нэгдүгээрт барааны бирж байгуулах, хөгжүүлэх урьдчилсан нөхцлийг хангах, хоёрдугаарт бараа, бүтээгдэхүүний зах зээлийг хөгжүүлэх, гуравдугаарт биржийн тогтолцооны дэд бүтцийг бий болгох, дөрөвдүгээрт бараа, бүтээгдэхүүний биржийн эко-системийг бүрдүүлэхэд голлон ажиллах шаардлагатай байна. Үүнд:

1. <u>Барааны бирж байгуулах, хөгжүүлэх урьдчилсан нөхцлийг хангах хүрээнд</u> барааны биржийн эрх зүйн орчинг бий болгох, макро эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан санхүү, хөрөнгө оруулалтын таатай орчинг бүрдүүлэхэд анхааран ажиллах шаардлагатай байдаг.
2. <u>Бараа, бүтээгдэхүүний зах зээлийг хөгжүүлэх хүрээнд</u> зах зээлийн боломжийг тодорхойлж, судлах бөгөөд бараа, түүхий эдийн худалдан авагч, худалдаалагчдийн тоо, оролцоо, бүтээгдэхүүний хөрвөх чадвар, мөн биржээр арилжаалах бүтээгдэхүүн нь агуулахад нөөцлөх боломжтой эсэх, улирлын үнийн хэлбэлзэлтэй эсэх болон санхүүгийн үйлчилгээний талаар судладаг байна.
3. <u>Биржийн тогтолцооны дэд бүтцийг бий болгох хүрээнд</u> хөдөө аж ахуйн бараа, түүхий эдийн ангилалт, ялгалт хийх бэлтгэлийн стандартыг сайжруулах, мэдээллийн системийг бий болгох, биет дэд бүтцийг хөгжүүлэх зэрэг ажлуудыг хийх хэрэгтэй байдаг.
4. <u>Бүтээгдэхүүний биржийн эко-системийг бүрдүүлэх хүрээнд</u> агуулахын аж ахуйг хөгжүүлэхийн зэрэгцээ банк, санхүү, даатгал, төлбөр тооцоо, маргаан, арилжааны платформ болон биржийн бүтэц, зохион байгуулалтыг хөгжүүлэх ажлууд хийгддэг байна.

Дэлхийн олон улс орнуудад барааны биржүүд хөгжлийн явцад нь дараах нөхцөл, шаардлагыг хангахад анхаарсаар ирсэн байна. Үүнд:

1. Арилжааны бүх оролцогчдод нээлттэй, ил тод, хариуцлагатай, бүх нийтээр даган мөрдөхөөр сайн боловсруулагдсан хууль эрх зүйн орчинтой байх;
2. Бүтээгдэхүүний чанар, зах зээлийн эрэлт хэрэгцээ, нийлүүлэлтэй уялдсан уян хатан үнийн тогтолцоо бүрдүүлсэн арилжаа явагддаг байх;
3. Хангалттай хэмжээний бүтээгдэхүүний эрэлт хэрэгцээтэй байх, түүнийг хангах, хүрэлцээт нөөц, үйлдвэрлэл, нийлүүлэлттэй байх;
4. Бүтээгдэхүүний нэр төрөл, стандартыг тодорхой заагдсан байх;
5. Орчин үеийн шаардлага стандартыг хангасан агуулах, санхүүгийн байгууллага, лаборатори болон тээвэр логистикийн сүлжээтэй байх;
6. Арилжаанд оролцогчид үнэн зөв, шуурхай мэдээлэл авах, арилжаа хийх боломжоор хангагдсан техник, технологи, програмчлалын сүлжээтэй байх;
7. Арилжаанд оролцогч брокерууд болон оролцогчид үнэнч шударга, ёс зүйтэй, өргөн мэдлэгтэй, мэргэшсэн чадварлаг байх;
8. Шинэ дэвшилтэт технологийг биржийн үйл ажиллагаанд нэвтрүүлсэн байх зэрэг болно.

Мөн түүнчлэн урт хугацаанд тогтвортой үйл ажиллагаа явуулж, итгэлцлийн тогтолцоо бий болгоход онцгойлон анхаарч, дараах үйл ажиллагаа явуулдаг.

- Тухайн улс орны нийтлэг эрх ашгийн хүрээнд бирж нь ашгийн бус зорилгоор үйл ажиллагаа явуулах;

- Улс төрөөс үл хамааралтай, бие даасан, өөрөө өөрийгөө зохицуулах үүрэгтэйгээр зах зээлийн зарчимд тулгуурлан ажиллах;
- Биржийн арилжаанд оролцогчдын үүрэг, хариуцлагыг өндөржүүлэх, мэргэжлийн худалдаачдыг арилжаанд өргөнөөр оролцуулах;
- Төрийн бодлоготой уялдуулан биржийн эрх зүйн орчинг бүрдүүлж, арилжаанд оролцогчдод ил тод, нээлттэй байх боломжоор хангах;
- Барааны чанар, стандартыг тогтоох, барааны чанарт баталгаа олгох;
- Биржийн оролцогчдын мэдлэг чадварыг тогтмол сайжруулах, мэргэшүүлэх;
- Үйлдвэрлэлийн томоохон бүс нутаг, төвийг түшиглэн биржийн салбар, нэгж, агуулахын аж ахуй, тээвэр ложистик, банк санхүү, даатгалын нэгжийг байгуулах;
- Биржийн худалдагч болон худалдан авагчид нь бие биенээ хурдан олоход туслах;
- Биржийн арилжаанд оролцогчдын хувьд биржийн мэдээ, мэдээлэл, гэрээ хэлцэлээ үндэслэн бизнесээ төлөвлөх, хэрэгцээ шаардлагаа бодитоор тооцоолох, бизнесээ өргөтгөх боломжоор хангах;
- Гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдад хөдөө аж ахуйн салбарт хөрөнгө оруулах боломж бүрдүүлэх;
- Үйлдвэрлэгч болон хэрэглэгчдэд зах зээлийн үнээр арилжаа хийх боломжийг бүрдүүлэх, үнийн эрсдлийг удирдах замаар биржийн оролцогчдын орлогыг тогтворжуулах, бараа, бүтээгдэхүүний чанар, стандартыг сайжруулах зэрэг болно.

Бүтээгдэхүүний үнэ, оролцогчид, тэдгээрийг холбож буй гэрээ нь нэгдмэл байдал, итгэлцлийг бий болгож байдаг.

1-рт: Бараа таваар нь **чанар тоо** хэмжээний хувьд зохих **стандартын дагуу бэлтгэгдсэн** байх ёстой. Олон улсад биржийн агуулахад хүлээн авсан хөдөө аж ахуйн бараа, түүхий эдэд зэрэглэл, ангилалт, ялгалт хийж, чанарын баталгааны гэрчилгээ олгох бөгөөд лабораторын шинжилгээнд үндэслэгдсэн хувийн хэвшлийн болон төрийн мэргэжлийн чанарын баталгаа олгогч, магадлан шинжээч, байцаагч нар олгож байна. Ангилалт, зэрэглэл нь үнэн зөв, зах зээл дээр хүлээн зөвшөөрөгдсөн байх ёстой .

2-рт: Бирж нь нийтийн дунд арилжих саналаа **ил тод бага зардлаар** дэлгэн харуулахад чиглэсэн үнэ хаялцах дуудлага худалдааны арилжааны механизмаар явагдана. Цахим хэлбэрээр ч мөн явагдаж болно .

3-рт: **Дүрмийг** баталгаатай даган мөрдөхийн тулд гишүүнчлэл дээр үндэслэгдсэн арилжаа хийдэг байна. Энэ тохиолдолд гишүүнчлэл нь дүрэм журам болон зохих стандартыг дагаж мөрдөх чадвар дээр үндэслэгдэнэ. Гишүүд нь үүнийг чанд сахин мөрдөх ёстой ба тэдэнд дараах шаардлага тавигдана. Үүнд:

- Арилжааны явцыг чадах бүхнээрээ дэмжих урамшуулах;
- Бизнесийн ёс суртахуун нэгдмэл байдлын өндөр хэм хэмжээг баримтлах;
- Арилжааны ёс зүйтэй ашиг сонирхолыг чухалчлах;
- Биржээс баталсан хууль, дүрэм, журам, актуудыг даган мөрдөх;
- Ашгаа нэмэгдүүлэх шинэ арга барил, менежментийг судалж, хэрэгжүүлэх;

4-рт: **Дүрэм,** журам нь ихэвчлэн гишүүдийнхээ хувьд заавал мөрдөх зүйл ба ингэснээр стандартын гэрээг зохих ёсоор хийнэ. Ингэснээр биржийн гэрээний арилжааг хөгжүүлэх, 2 талын ойлголцлыг баталгаажуулах ач холбогдолтой.

Засгийн газар биржийн үйл ажиллагааг дэмжих ажиллах нь хөгжиж буй орны хувьд ихээхэн чухал байдаг. Засгийн газрын үүрэг роль хоёр хэсгээс бүрдэнэ:

- Энэ нь зах зээлээс ашиг олохын тулд заль мэх гаргах, булхай, луйвар хийх зэрэг үйлдлийг таслан зогсоож тухайн үйлдэл гаргасан тохиолдолд арга хэмжээ авах

зэргээр нийтэд нь хянаж ажиллахаас гадна гэрээнүүдийн хамгаалалт/ аюулгүй байдлыг хангана.
- Шаардлагатай хууль эрхзүйн орчинг бүрдүүлэх ба зарим тодорхой нөхцөл байдалд дэд бүтэц, эко-системийг бий болгох, бодит зохицуулалтыг хийх асуудалд анхаарч ажиллах шаардлагатай байдаг. /агуулах, лаборатори, банк, санхүү, даатгал, тээвэр, харилцаа холбоо, мэдээллийн сүлжээ гэх мэт/.

Бусад улс орнуудад Олон улсын биржүүд, байгууллагуудтай нягт хамтран ажиллаж байна. Олон Улсын Аюулгүй Байдлын Комиссын аюулгүй байдлыг зохицуулах зорилго ба зарчмын дагуу (IOSCO) зохицуулалт нь гурван хэсгээс бүрдэнэ. Үүнд:
- зах зээлийн нэгдлийг хангахын тулд энэхүү дүрэм журмыг шудрага, үр ашигтай, ил тод байдалд хэрэгжүүлэх;
- үр ашигтай менежментийн хэлбэрээр санхүүгийн нэгдлийг хангах/дэмжих;
- хөрөнгө оруулагчдыг хамгаалах, ялангуяа арилжаанд оролцогчдын шудрага бус, хариуцлагагүй үйлдлээс хамгаалах. Иймийн тулд баталгаатай түүхий эд бэлтгэлийн системийг бүрдүүлэх нь биржийн томоохон зорилтын нэг болдог.

Хүснэгт 14. Зах зээл, бирж болон брокерийн түвшин дэх зохицуулалт

| | **Зах зээлийн түвшний зохицуулалт** | **Биржийн түвшний зохицуулалт** | **Зуучлагчийн түвшний зохицуулалт** |
|---|---|---|---|
| **Зах зээлийн нэгдлийн хангах хүрээнд** | -Биржийг бүртгэж лиценз олгох<br>-Шинэ гэрээнүүдийг батлах журам<br>- Хууран мэхлэх, луйвар хийх, өрсөлдөгчддөө шудрага бусаар хандах зэрэг буруу үйлдэлтэй тэмцэж, хяналт тавих<br>- Бирж, зах зээл дээр ажилладаг том худалдаачдын талаарх мэдээлэл өгөх<br>-Аудит хийх /биржийн бүх оролцогчдод<br>-гадаадын түншүүдтэй мэдээлэл солилцох | -арилжааны бүх үйл ажиллагаанд аудит хийх;<br>-зах зээлийн бүх оролцогчдод бодит мэдээлэл түгээх;<br>-зах зээлийн дамчдад “дамыг хэтрүүлэхгүй” байх хязгаар тогтоох;<br>-Бараа нийлүүлэхэд хууран мэхлэх, луйвар хийххийн эсрэг хатуу хяналт тавих:<br>-Арилжааны үйл ажиллагааг хянах аудио видео хяналтууд<br>-Агуулах, лаборатори, хадгалалтын байр савыг шалгаж мониторинг хийх<br>-Нууцлалын чанартай материалын хадгалалт, хамгаалалтыг өндөр түвшинд хийх<br>-Биржээр арилжих бараа, түүхий эдийг кодлох, хадгалалт, хамгаалалтыг хийх. | - Зах зээлийн зуучлагчдын ёс зүйн байдалыг хангах<br>-Захиалагчийн захиалгыг зөрчихийн эсрэг хамгаалах<br>- зуучлагчид өөрсдийн ашиг сонирхлыг үйлчлүүлэгчийн ашиг сонирхлоос дээгүүр тавьхийг хориглох, заалт оруулах |
| **Санхүүгийн нэгдэл** | - Клиринг тооцооны төвийг тоногжуулах шаардлага<br>- Зуучлагчийн санхүүгийн тайлангийн шаардлагууд<br>- Тогтсон нягтлан бодох бүртгэлийн стандартуудыг зах зээлд ашиглах шаардлагууд | - Шинээр суудал авахад эхлэлтийн ашиг<br>- Зах зээлээс-зах зээлд суурилсан өдөр тутмын тооцоогоорхи ашгийн хэлбэлзлийг тооцох<br>- Хүргэлийн үеийн эсвэл үнийн хэлбэлзэлтэй үеийн тусгай ашиг<br>- Клирингийг гишүүдэд байх ёстой хөрөнгийн доод хэмжээ ба хөрөнгөд суурилсан суудлын тооны хязгаар тогтоох | 1. Оролцогчдод тавих ёстой хөрөнгийн доод хэмжээ ба хөрөнгөд суурилсан суудлын тооны хязгаарыг тогтоох |
| **Хөрөнгө оруулагчийн аюулгүй байдал** | Доорхи нөхцлийг хангах эрх зүйн орчинг бүрдүүлэх:<br>- гэрээг байгуулах, оролцогч талуудын үүрэг хариуцлагыг хуулийн | - Тодорхойл ил тод байх, хуулиар зохицуулагдсан биржийн үйл ажиллагаа, ялангуяа хүргэлтийн үйл ажиллагаатай байх | 2. Зах зээлийн зуучлагчдад чанарын стандарт, зөвшөөрөл олгох системийг бий болгох |

| | | | |
|---|---|---|---|
| | хүрээнд тодорхой байх нөхцлийг бүрдүүлэх,<br>- гүйлгээ хийх, клиринг хийх, хүргэлт хийх үйл ажиллагаанд оролцогч талуудын хууль зүйл харилцааг тодорхойлох<br>- Бирж дэх бүх оролцогч талуудын эрх тэгш, шударга байдлыг хангах<br>- Биржийн зохицуулалтыг ерөнхийд нь бүрдүүлэх | - Гишүүдийн маргааныг шийдвэрлэх арбитрын механизмтай байх<br>- Үүрэг хариуцлагын зөрчил гаргасан гишүүдэд зориулсан шийтгэлийн системтэй байх | 3. Зуучлалын маркетингийн практикийг удирдан зохицуулах (зар сурталчилгааны стандарт, үйлчлүүлэгийг татах арга гэх мэт)<br>4. Үйлчлүүлэгчийн сан хөмрөгийг брокероос тусгаарлах<br>5. Брокерүүдэд шаардлага өндрөөр тавих |

Бирж нь оролцогчдыг хэрэгцээт мэдээллээр хангах үйл ажиллагаа явуулснаар арилжаанд оролцогчдыг татах, үнийн болон мэдээллийн тэгш бус байдлыг арилгах, биржийн оролцогчдын тоог ихэсгэх, тэдний ашиг, орлогыг нэмэгдүүлэх зэрэг боломжийг олгодог. Фьючерийн үнийг мэдэж байгаа тохиолдолд дараа жилүүдийн хөдөө аж ахуйн гаралтай бараа, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээ, орлогыг урьдчилан төлөвлөх боломжийг бүрдүүлж өгдөг. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл нь байгаль цаг уурын нөхцөл байдлаас бага хамааралтай, зах зээлийн эрэлт, хэрэгцээнээс шууд хамааран өөрчлөгддөг онцлогтой. Бирж нь нэгдүгээрт, биржийн оролцогчид арилжааны харилцаа тогтооход илүү хялбар хоёрдугаарт, биржийн оролцогчдод зах зээл олоход тусалдаг гуравдугаарт, үнэ ил тод байх бөгөөд үр ашигтай наймаа хийх бололцоог олгодог эцэст нь, бирж дээр орчин үеийн шаардлагыг хангасан агуулахын аж ахуй, мэдээллийн сүлжээ, тоног төхөөрөмжөөр хангагдаж, цахим худалдааг хийх боломжтой байхаар тоноглогдсон байдаг.

Бараа, бүтээлдэхүүний бирж дээр спот арилжаанаас гадна стандарт хэлбэрийн гэрээнүүдийн (фьючерс болон опцион гэрээнүүд)-ийн тусламжтайгаар арилжаа явагддаг. Үүнд:

**Спот арилжаа “Spot contract”:** Биржээс тогтоосон стандарт, техникийн нөхцлийн үндсэн дээр арилжаа хийгддэг. Биржийн арилжаагаар ихэвчлэн чанарын стандартыг хангасан барааг арилжаалдаг. Бэлэн бараа, бүтээгдэхүүний арилжаа хийж байгаа тохиолдолд дараах байдлаар арилжаа хийдэг. Үүнд:

- ✓ Стандарт, чанарын шаардлагын дагуу хариуцлагатай арилжаа хийдэг.
- ✓ Харилцан итгэлцэл тогтсон байдаг учраас бараагаа урьдчилан үзэх, харах, шалгах шаардлагагүй болно;
- ✓ Барааны дээж, загвартай танилцсаны үндсэн дээр арилжаа хийх;
- ✓ Барааг урьдчилан үзсэний үндсэн дээр арилжаа хийх;

Бэлэн бараа, бүтээгдэхүүний арилжаа хийж байгаа үед дараах нөхцлийг үеийн барааг биет бүтээгдэхүүнд хамруулан авч үздэг байна. Үүнд:

- ✓ бараа биржийн “итгэмжлэгдсэн агуулах”-д хадгалагдаж байх;
- ✓ Үйлдвэрлэгч эсвэл худалдагчийн агуулахад хадгалагдаж байх;
- ✓ Бараа биржийн хаягаар замд явж байгаа;

Биржийн арилжаанд оролцож, бэлэн бүтээгдэхүүний арилжаа хийх үед худалдагч Тал нь биржийн зөвшөөрөл олгосон “итгэмжлэгдсэн агуулах”-д бэлэн бараагаа арилжаа эхлэхээс тодорхой хугацааны өмнө хүлээлгэн өгч, тус агуулахаас барааны чанар, тоо хэмжээний батламжийг авч, арилжааны өмнө брокерийн пүүст өгсөн байх шаардлагатай.

**Форвард болон фьвчерсийн арилжаа:** Бэлэн бараа, бүтээгдэхүүнээр арилжаа хийж, тогтсон бизнесийн харилцагчтай болсны дараагаар харилцан итгэлцэл үүсдэг. Энэ үед форвард гэрээ хийх нөхцөл бүрддэг. Форвард гэрээ хэлцэл хийх тохиолдолд дараах байдлаар арилжаа хийдэг. Үүнд:

- ✓ Харилцагчийн тогтоосон стандартыг үндэслэн арилжаа хийх;
- ✓ Өмнөх саруудад эсвэл тухайн жилүүдэд нийлүүлж байсан бараа, бүтээгдэхүүний тодорхойлолт, худалдан авсан хэмжээ, хэрэгцээг үндэслэн арилжаа хийх;
- ✓ Биржийн баталгааг үндэслэн арилжаа хийх;

Форвард, фьючесрийн арилжаа хийж байгаа үед гэрээнд заасан тоо хэмжээ, чанар стандартыг хангасан бараа, бүтээгдэхүүнийг гэрээгээр тохирсон хугацаанд багтаан биржийн итгэмжлэгдсэн агуулахад нийлүүлнэ. Биржийн агуулах барааг шалгаж хүлээж, авсны дараагаар баталгаат гэрчилгээг худалдагчид олгоно. Худалдагч уг баталгааг өөрийн брокерийн пүүст хугацаанд нь өгч арилжаанд оруулдаг.

Биржийн арилжаанд оролцож форвард болон фьючесрийн арилжаа хийх үед худалдагч, худалдан авагч Талууд төлбөрийн бүрэн чадвартай байх, гэрээгээр хүлээсэн үүргээ харилцан биелүүлэх баталгаа болгож, тодорхой хэмжээний дэнчин төлбөр тавина. Хэрэв Форвард, фьючесрийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй буюу хагас дутуу биелүүлсэн тохиолдолд эрсдлийг үүрэх чадвартай байх шаардлагатай. Агуулахад бараа, бүтээгдэхүүнээ байршуулж байгаа бол дэнчин бага байх бөгөөд агуулахад бараа, бүтээгдэхүүн нь байршаагүй, харин өмнөх саруудын худалдан авалтын хэмжээ, гэрээг үндсэн арилжаа хийж байгаа бол дэнчингийн хэмжээ өндөр байна. Бирж дээр худалдан авагч бараа, бүтээгдэхүүний бэлэн хэлбэрээр бус тухайн бараа, бүтээгдэхүүнийг эзэмших эрхтэй опционы гэрээ хэлбэрээр худалдаж авна. Опцион гэрээнд барааг худалдан авагчдад хүргэж өгөх хугацаа, барааны стандарт шаардлага, тухайн барааг худалдан авахаар тохиролцсон үнэ тодорхой тусгадаг.

Аливаа биржийн арилжаанд барааны чанар ихээхэн чухал. Биржээс баталсан бэлтгэлийн стандартын дагуу бэлтгэхэд биржээс итгэмжлэгдсэн агуулах мөн гол үүрэгтэй байдаг. Биржийн агуулахыг дараах хувилбартайгаар байгуулж болдог. Үүнд:

**(1)** Нэг бирж, нэг агуулах, нэг ангилан ялгах төв
**(2)** Нэг бирж, хэд хэдэн агуулах/ангилах төвүүд
**(3)** Нэг бирж, салбар биржүүд, агуулахууд/ ангилах төвүүд

Эрсдэлгүй бизнес гэж байдаггүй. Хөдөө аж ахуйн бирж нь хууль, дүрэм, журмын хүрээнд мэргэшсэн арилжаалагчдын хооронд арилжаа хийдэг хэдий ч дараах нийтлэг эрсдлүүд гардаг. Үүнд:

Хүснэгт 15. Биржийн эрсдлүүд

| Эрсдлийн төрөл | Эрсдлийн тухай тайлбар |
|---|---|
| **Гүйцэтгэл** | Бирж эсвэл гуравдагч тал нь биржийн гишүүдийн өмнө дараах үүрэг гүйцэтгэнэ.<br>▪ Агуулах үйлчилгээ үзүүлэх<br>▪ Ангилан ялгалтыг зохион байгуулах<br>▪ Худалдаа, арилжаа зохион байгуулах<br>▪ Төлбөр тооцоо, хэлэлцээрийг зохион байгуулах |
| **Гэрээ** | Гишүүд нь биржийн өмнө хариуцлага хүлээнэ. Биржийн арилжааны гэрээний заалтыг талууд зөрчиж, эрсдэл гарсан тохиолдолд биржийн арбитрын хороо ажиллаж эхлэн асуудлыг шийдвэрлэдэг. |

| | |
|---|---|
| **Сууръ** | Сууръ эрсдэл нь бүтээгдэхүүний чанар, гэрээний үзүүлэлтүүд, нийлүүлэлтийн байршил болон хугацаанаас хамаардаг |
| **Үнийн** | Үнийн эрсдэлд хэджинг, манифуляци болон спекуляци зэрэг ойлголтууд хамаарна. Бирж дээр гэрээний тоглогчид ашиг олох зорилгоор хэджинг, манифуляци болон спекуляцитай холбоотой төрөл бүрийн үйл ажиллагаа явуулж, тоглолт хийж, үнэ ханшны зөрүүг бий болгох бөгөөд мөн үнийн өөрчлөлттэй холбоотой эрсдлүүдийг үүсгэдэг. |
| **Үйлдвэрлэлийн** | Байгалийн гэнэтийн өөрчлөлт болон ган, зуд эсвэл үйлдвэрлэлийн осол зэргээс шалтгаалан төлөвлөсөн хугацаанд эрдсийн бүтээгдэхүүнээ гэрээний дагуу нийлүүлж чадахгүй болсонтой холбоотой эрсдлүүдийг хамааруулж үздэг. |
| **Засгийн газрын оролцооны** | Засгийн газар нь биржийн үйл ажиллагаанд хязгаарлагдмал байдлаар оролцох нь зүйтэй байдаг олон улсын туршлагууд байна. Хөгжиж байгаа улс орнуудын хувьд Засгийн газар нь биржийн эрхзүйн орчинг бүрдүүлэх, дэд бүтцийг сайжруулах, биржийн арилжаанд гишүүн хэлбэрээр оролцож, арилжааг эрчимжүүлэх зэргээр оролцож болдог. Харин биржийн үйл ажиллагаанд нөлөөлөх замаар зах зээлийн үнэд өөрчлөлт оруулах, биржийн удирдлагын эрх мэдлийн төлөө улс төрийн үйл ажиллагаа явуулах, биржийг улс төрийн үйл ажиллагаанд татан оруулах зэргээр Засгийн газрын оролцоо оролцохыг хориглодог. Хэрэв энэ мэтээр оролцсон бол биржид томоохон эрсдэлүүд тулгарч, дампуурахад хүрдэг. |

## 4.2. Олон улсын барааны биржийн хөгжил, туршлага, харьцуулалт

Хүснэгт 16 Олон улсын биржийн харьцуулалт

| *Үзүүлэлт* | *Беларусийн универсал бараазы бирж* | *Женжоугийн барааны бирж* | *Этиопийн барааны бирж* | *Энэтхэгийн multi-commodity exchange* |
|---|---|---|---|---|
| *Улс* | *Бүгд Найрамдах Беларусь Улс (БНБУ)* | *Бүгд Найрамдах Хятад Ард Улс (БНХАУ* | *Бүгд Найрамдах Ардчилсан Этиоп улс* | *Бүгд найрамдах энэтхэг улс* |
| *Англи нэр* | Belarusian Universal Commodity Exchange | Zhengzhou Commodity exchange | Ethopian Commodity Exchange | India Multi-Commodity exchange |
| *Товчилсон нэр* | BUCE | ZCE | ECX | MCX |
| *Байгуулагдсан огноо* | 2003он | 1990 он | 2008 он | 2003 он |
| *Биржийн зарчим* | - Ил тод, нээлттэй байдлыг бүрдүүлэх<br>- Итгэлцлийн системийг бүрдүүлэх<br>- Арилжаанд оролцогчдын эрх ашгийг баталгаажуулах<br>- Зөвхөн биржээр арилжаалсан бүтээгдэхүүн экспортлох | - Нээлттэй, шударга, ил тод байх | - Нээлттэй, ил тод, найдвартай арилжааны болон агуулахын үйлчилгээ үзүүлэх<br>- Зах зээлийн нэгдмэл байдал, зах зээлийн үр ашиг, ил тод байдлыг хангах, эрсдлийг удирдах<br>- Худалдагч, худалдан авагчдын хооронд нейтрал байр сууръ баримталж арилжаа явуулах | - Нейтрал, аюулгүй, ил тод байх зарчмаар арилжаа зохион байгуулах |
| *Зорилго* | - Чөлөөт үнэ болон өрсөлдөөнд суурилсан ил тод худалдааны механизмыг бүрдүүлэх<br>- Бизнесийн түншийг олоход туслах<br>- Беларусийн бүтээгдэхүүний экспортыг дэмжих, | - Хятадад анхдагч фьючерсийн бирж бөгөөд дэлхийн тэргүүлэх 10 биржийн нэг гэсэн байр сууриа бататгах<br>- Орчин үеийн техник, технологийг нэвтрүүлэх замаар цахим арилжааны систем, хүргэлт, клиринг тооцоо, мэдээлэл, | - Дэлхийн хамгийн сүүлийн үеийн бирж бөгөөд энэ байр сууриа бататгаж, Африк тивийн тэргүүлэх бирж болох<br>- Эрхэм зорилго нь дэвшилтэд техник, технологи, инновацийг | - Биржийн талаарх зөв ойлголтыг нийгэмд, оролцогчдод хүргэх<br>- Үнийн өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг бууруулах,<br>- Зах зээлд оролцогчдыг нейтрал, ил топ, |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | борлуулалтын зах зээлийг төрөлжүүлэх<br>- Стратегийн бүтээгдэхүүний бодит үнийг бүрдүүлэх<br>- Биржийн болон арилжааны талаарх мэдээллийг цуглуулах, дүн шинжилгээ хийх, түгээх<br>- Биржээр арилжих жагсаалтад оруулах бүтээгдэхүүний нэр төрлийг өргөтгөх, шинэ арга хэрэгслүүдийг нэвтрүүлэх<br>- Биржийн гишүүдийн харилцан үр ашигтай байх нөхцлийг бүрдүүлэх | үйлчилгээ зэргийг цахим хэлбэрээр хүргэдэг орчин үеийн фьючерсийн бирж байгуулах<br>- Электрон худалдаа, мэдээлэл дамжуулах, санхүүгийн үйлчилгээ, зөвлөх үйлчилгээг иж бүрэн цогц хэлбэрээр нэгдсэн зохион байгуулалттайгаар дэлхийн зах зээлд нэвтрүүлэх<br>- Барааны үүсмэл хэрэгслүүдийн тухай хуулийн үндсэн дээр зах зээл дээр бүртгэлтэй барааны фьючерс,нэн шаардлагатай түүхий эдийн зах зээлийг бий болгож, үйл ажиллагаа явуулах | нэвтрүүлэх замаар орчин үеийн үр ашигтай, ил тод, нээлттэй, найдвартай зах зээлийн платформ болон агуулахын аж ахуйн үйлчилгээгээр хангах | аюулгүй оролцох нөхцлөөр хангах<br>- Төрийн байгууллага, гишүүдийн оролцоотойг хангаж барааны чанар, худалдааны дүрмийг тасралтгүй шинэчлэх<br>- Биржийн арилжаан дахь ёс суртахуунгүй оролцоог халах, биржийн эко-системийн хөгжилд хөрөнгө оруулах |
| **Үүсгэн байгуулагч** | - БНБУ-ын Худалдааны яам<br>- Худалдаа, үйлдвэрлэлийн "Белресурсы" нийгэмлэг<br>- Экспорт, импортын даатгалын "Белэксимгарант" компани<br>- Нээлттэй хувь хувьцаат нийгэмлэг "Беларусбанк" | - БНХАУ-ын төрийн зөвлөлийн шийдвэрээр байгуулсан анхны фьючерсийн бирж | - Засгийн газар үүсгэн байгуулагч бөгөөд Худалдааны яам, Хөдөө аж ахуйн яамны хамтарсан удирдлага дор үйл ажиллагаа явуулдаг | - Энэтхэгийн Засгийн газар |
| **Өмчийн статус** | Нээлттэй хувь нийлүүлсэн хувьцаат компани, төрийн өмчит | Төрийн өмч | - Төр, олон улсын байгууллага, хувийн хэвшлийн оролцоотойгоор байгуулагдсан | - Төрийн өмч, Сангийн яам нь өмчлөгч байдаг |
| **Төрийн оролцооны үүрэг** | Төрийн өмчлөл, зохицуулалт | Хятадын үнэт цаасны зохицуулах хороо(China Securities Regulatory Commission) болон Хятадын фьючерсийн арилжааны дүрмийн хяналтад дор үйл ажиллагаа явуулдаг. Бүртгэл, хяналт, арилжаа, клиринг тооцооны чиглэлээр биржийн үйл ажиллагааг хянадаг. | Төрийн нэгдсэн хяналтыг Биржийн удирдах зөвлөл зохион байгуулж, хэрэгжүүлдэг | Энэтхэгийн Үнэт цаасны биржийн зөвлөлийн удирдлага, хяналтад дор үйл ажиллагаа явуулдаг цахим хэлбэрээр үүсмэл гэрээ арилжаалдаг төрийн өмчит анхны бирж |
| **Гишүүнчлэл** | Биржийн гишүүнээр элсэх боломжтой биржийн арилжаанд оролцогчид:<br>- 1 жилээс доошгүй хугацаанд бирж дээр идэвхитэй ажилласан оролцогч болон/эсвэл брокер<br>- бүртгэлийн сүүлийн 1 хуанлийн жилд дүрмийн зөрчил гаргаагүй<br>- биржийн хороо эсвэл биржийн хувь эзэмшигчийг дэмжсэн албан тоот<br>- гишүүний трейдерүүдын биржээс тогтоосон мэргэжлийн түвшин, мэдлэгийн түвшинг | Тодорхой хөрөнгийн хэмжээтэй, төлөөлөгчийн газартай субьектууд гишүүнээр элсэх эрхтэй. Хөрөнгө оруулагчид нь цахим арилжаагаар дамжуулан арилжаанд оролцох боломжтой. | Бирж нь 4 төрлийн гишүүнчлэлтэй.<br>- Худалдааны байнгын<br>- Худалдааны зуучлагчийн<br>- Худалдааны түр зуурын<br>- Зуучлагчийн түр зуурын<br><br>Суудал худалдан авч эсвэл жилээр түрээслэх замаар арилжаанд оролцоно. Биржээс брокерт шаардлага тавьдаг. | Бирж нь дараах төрлийн гишүүнчлэлтэй<br>- Төлбөр, арилжааны эрхтэй<br>- Арилжааны эрхтэй<br>- Төлбөр тооцооны эрхтэй |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | хангаж буйг баталсан шалгалтын комиссын дүгнэлт<br>- санхүүгийн байдалд тавигдах шаардлагыг хангах | | | |
| **Үйл ажиллагааны үндсэн чиглэл** | - Бөөний худалдааг боловсронгуй болгох<br>- Гадаад худалдааг санхүүжүүлэх<br>- Төрийн зохицуулалтыг хэрэгжүүлэх<br>- Биржийн дуудлага худалдаа зохион байгуулах<br>- Биржээр арилжаалсан хэлцлийг бүртгэх<br>- Бараа, түүхий эдийн чанарын хяналтыг хийх<br>- Эрэлт, нийлүүлэлтийн судалгаа хийх, биржээр арилжих барааны нэр төрлийг нэмэгдүүлэх | - Биржийн үйл ажиллагааг олон улсад сурталчилах,<br>- Гадаадын болон дотоодын худалдан авагч, үйлдвэрлэгчдийг холбох<br>- Олон улсын биржийн байгууллагуудад гишүүнчлэлээр элсэх<br>- Фьючерсийн болон опцион арилжаа зохион байгуулах<br>- Биржийн оролцогчдод мэдээллийн чанартай үйлчилгээ үзүүлэх.<br>- Биржээр арилжих бүтээгдэхүүнд чанарын баталгаа гаргах<br>- Цахим хэлбэрээр арилжаа зохион байгуулах | - Төвлөрсөн арилжаа хийх<br>- Агуулахын аж ахуйн үйл ажиллагаа явуулах<br>- Клиринг төлбөр тооцооны үйл ажиллагаа явуулах<br>- Зах зээлийн нэгдсэн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх<br>- Цахим арилжаа зохион байгуулах<br>- Мэдээллийн болон барааны чанарын аюулгүй, баталгаат байдлыг хангах<br>- Арбитрын үйлчилгээ үзүүлэх<br>- Гадаадын худалдан авагчдыг олж өгөхөд туслалцаа үзүүлэх | - Хөдөө аж ахуйн болон газрын тосны бүтээгдэхүүний фьючерсийн болон мөнгө, алтны опционы гэрээний арилжаа хийдэг<br>- Биржээс итгэмжлэгдсэн агуулахын үйлчилгээ үзүүлж, биржийн цахим платформоор дамжуулан арилжаанд оролцуулах<br>- Сургалт, мэдээ, мэдээллээр хангах |
| **Арилжааны төрөл, хэлбэр** | - Танхимын дуудлага худалдаа: Бүх дуудлага худалдаа төвд болон бүсүүдэд нэгэн зэрэг төлөвсөн календарын дагуу явагддаг.<br>- Цахим дуудлага худалдаа: Аж үйлдвэрийн болон өргөн хэрэглээний барааны дуудлага худалдаа зөвхөн интернэтээр явагддаг. | - Ихэвчлэн цахим хэлбэрээр арилжаа явуулах<br>- Фьючерсийн болон опционы арилжаа зохион байгуулах | - Танхимын болон цахим арилжаа явуулах<br>- Мөн календарын хугацааны дагуу арилжаа явагддаг<br>- Биржийн агуулахын арилжаагаар зээлийн үйлчилгээ үзүүлэх нөхцлийг бүрдүүлдэг | - Дийлэнх арилжаа нь цахим хэлбэрээр явагдаж байна |
| **Арилжаалах бүтээгдэхүүн** | - Металл бүтээгдэхүүн:<br>- Модон бүтээгдэхүүн:<br>- ХААн бүтээгдэхүүн:<br>- Аж үйлдвэрийн болон өргөн хэрэглээний бараа:<br>- Фьючесрийн гэрээ | - Хөдөө аж ахуйн нэгж, барилгын материал, эрчим хүч, уул уурхайн бүтээгдэхүүний спот арилжааны гэрээ<br>- Фьючесрийн болон опционы гэрээ | - Хөдөө аж ахуйн гол нэр төрлийн бүтээгдэхүүн | - Хөдөө аж ахуй болон уул уурхайн төрөл бүрийн бүтээгдэхүүн<br>- Фьючерсийн арилжааны гэрээ |
| **Үйлчилгээ** | - Биржийн арилжаа хийхэд оролцогчдыг зах зээлийн мэдээ, мэдээллээр хангах<br>- Брокерийн үйлчилгээ үзүүлэх<br>- Цахим арилжаа зохион байгуулах<br>- Үнэ төлбөргүй гишүүдэд программ хангамж суурилуулах<br>- Сургалт зохион байгуулах | - Мэдээ, мэдээллээр хангах<br>- Сургалт зохион байгуулах<br>- Төлбөр тооцоо, клирингийн үйлчилгээ<br>- Брокерийн үйлчилгээ<br>- Барааны чанарт хяналт тавих, эрдслийн тооцоолол хийх, маржин шаардах<br>- Цахим арилжаа явуулах | - Танхимийн болон цахим арилжаа зохион байгуулах<br>- Агуулахын аж ахуйн үйлчилгээ үзүүлэх, бараа, түүхий эдийг ангилан ялгах, баталгаажуулалт олгох<br>- Клиринг төлбөр тооцооны үйл ажиллагаа явуулах<br>- Зах зээлийн нэгдсэн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх<br>- Сургалт зохион байгуулах<br>- Зах зээлийн судалгаа хийж, бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх | - Арилжаа<br>- Мэдээллийн үйлчилгээ<br>- Агуулахын аж ахуйн үйлчилгээ<br>- Төлбөр тооцоо, клирингийн үйлчилгээ<br>- Сургалт |
| **Арилжаанд оролцох шаардлага** | - Дуудлага худалдаанд оролцоход магадлан итгэмжлэл эсвэл | Зөвхөн тодорхой шаардлага хангасан оролцогчид | - Зөвхөн брокерууд арилжаанд оролцоно | - Шаардлага хангасан арилжаанд оролцох гишүүдэд нээлттэй |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | арилжааны брокер оролцоно<br>- Аж үйлдвэрийн болон өргөн хэрэглээний барааг худалдан авах тохиолдолд магадлан итгэмжлэл шаардахгүй боловч заавал цахим бүртгэлд орсон байна. | (туршлага, хөрөнгийн түвшин) | - Санхүүгийн шаардлага хангасан гишүүд брокерын суудал худалдан авах эсвэл түрээслэх замаар арилжаанд оролцоно | - Брокерууд зөвхөн арилжаанд оролцоно |
| **Биржийн дэд бүтэц** | - 5 хотод салбартай | - Гадаад, дотоодод 4 хотод салбартай, дотоодод 27 мужид үйл ажиллагаа явуулдаг | - Агуулахын аж ахуйн үйлчилгээ<br>- Клирингийн төвлөрсөн төв<br>- Мэдээллийн нэгдсэн төв<br>- Арбитрын хороо<br>- Арилжааны нэгдсэн төв<br>- Биржийн оролцогчдын холбоо | - Агуулахын аж ахуйн үйлчилгээ<br>- Төвлөрсөн клиринг, төлбөр тооцооны үйлчилгээ |
| **Хамтын ажиллагаа** | - ОХУ, БНХАУ, Эспони, Унгар, Герман, Япон, Казакстан, Польш, Латви, Литви, Израйл зэрэг 64 орны 25000 гишүүн | - АНУ, Япон, Сингапурын биржүүдтэй хамтран ажилладаг | - Европын холбоо<br>- Африкын биржүүдийн холбооны биржүүдтэй хамтран ажилладаг | - ОУ-ын үнэт цаасны хорооны гишүүн<br>- Хятад, АНУ, Европын холбооны биржтэй хамтардаг |
| **Дүрмийн сан** | - 98 хувь нь төрийн өмчит<br>- 2 хувь нь хувьцаа эзэмшигчид | - 100 хувь төрийн өмчит | - Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаатай | - Төрийн өмч |

Хүснэгт 17 ХААБ-ийгн бусад орны биржтэй харьцуулсан байдал

| ***Үзүүлэлт*** | ***Бусад орны барааны бирж*** | ***Монголын ХААБ*** |
|---|---|---|
| ***Биржийн зарчим*** | Бусад орны барааны биржүүд нийтлэг дараах зарчимтай байна. Үүнд:<br>- Арилжаанд оролцогчдод нээлттэй, ил тод, шударга, нейтрал байх;<br>- Найдвартай арилжааны болон агуулахын үйлчилгээ үзүүлэх;<br>- Зах зээлийн нэгдмэл байдал, зах зээлийн үр ашиг, ил тод байдлыг хангах, эрсдлийг удирдах;<br>- Орчин үеийн инноваци, шинэ технологийг нэвтрүүлэх. | Монголын ХААБ-ийн хуульд нээлттэй, ил тод, бие даасан байх зарчим баримтлана гэж тодорхой тусгасан бөгөөд хуулийн хэрэгжилтийг хэрэгжүүлэх нь шаардлагатай байна. Үүнээс гадна орчин үеийн техник, технологи, дэвшилтэд шинэ санаачилга, төрийн бодлогын уялдааг хангаан ажиллах чиглэлээр зарчмаа өргөтгөн шинэчлэх нь зүйтэй юм. . |
| ***Зорилго*** | Бусад орны биржүүд тодорхой байр сууриа бататгах, дараагийн байр сууриа руу хүрэхэд орчин үеийн дэвшилтэд техник, технологи, инновацийг нэвтрүүлж, тодорхой үйлчилгээ үзүүлэх замаар хүрнэ гэж тодорхойлж байна. | ХААБ-ийн зорилго нь нэлээдгүй ерөнхий, хэрэгжүүлэхэд хугацаа, санхүүжилт их шаардлагатай, улсын хэмжээний ажлыг хамруулсан, хэмжих боломжгүй байдлаар томьёологдсон байна. Биржийн өөрийнх нь зорилго нь байгууллагын зорилго учраас байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн зорилго байх нь зүйтэй болов уу. |
| **Үүсгэн байгуулагч** | Судалсан ихэнх биржүүдийг Засгийн газар байгуулсан. Этиопын барааны биржийн хувьд Засгийн газар, Олон улсын байгууллага, хувийн хэвшлийн хамтарсан хөрөнгө оруулалтаар хийж гүйцэтгэсэн байна. Зарим улс орнуудад хамтарсан яамны удирдлага дор биржийг үүсгэн байгуулж, хамтран хэрэгжүүлж байгаа тохиолдол байна. | ХААБ-ийн үүсгэн байгуулагч нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам. Одоогоор 5 тэрбум төгрөгийн үнэ цэнэтэй хувьтай эзэмшдэг. Энэхүү хувьцааны тодорхой хувийг эргэлтэд оруулах, хувийн хэвшил, мэргэжлийн холбоодын төлөөлөлд хувьцаа хэлбэрээр хуваарилах, тэдгээрийн хамтын ажиллагаа, хяналтыг нэмэгдүүлэх чиглэлээр тодорхой санаачилга гаргах нь зөв болов уу. |
| **Өмчийн статус** | Хятад, Энэтхэг, Беларуссын биржүүд нь төрийн өмчийн оролцоотой, Этиопын бирж нь төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаатайгаар | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Төрийн өмчийн хорооны удирдлага дор бодлого зохицуулалт хийж байна. |

| | | |
|---|---|---|
| | байгуулагдсан. | |
| **Төрийн оролцооны үүрэг** | Бусад орнуудад төрийн хяналтыг Биржийн Удирдах Зөвлөл, Санхүү, үнэт цаасны хяналтын хороо хэрэгжүүлдэг. | Төрийн хяналтын хэлбэр нь бусад орныхтой адилхан юм. ХААБ-ийн хувьд Биржийн Зохицуулах Зөвлөл, Санхүүгийн зохицуулах хорооны хяналтад дор үйл ажиллагаа явуулж байна. Биржийн зохицуулах зөвлөл нь илүү мэргэжлийн бодлогын нэгдмэл байдлыг хангахад ажиллах нь зөв юм. |
| **Гишүүнчлэл** | Хөгжиж байгаа орны ихэнх биржүүд хязгаарлагдмал оролцогчид буюу мэргэжлийн брокеруудыг оролцуулж байна. Бусад оролцогчид нь брокерийн компаниар дамжуулан арилжаанд оролцдог. Брокерууд нь худалдааны эрхтэй, төлбөр тооцооны эрхтэй, худалдаа болон төлбөр тооцооны эрхтэй гэж ангилдаг байна. | ХААБ-ийн оролцогчид брокер болон хоршоод хамаардаг. Брокерын тоо цөөн, хоршоодын оролцоо байхгүй байна. Оролцогчдын тоо нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах шаардлагатай болж байна. Санхүүгийн зохцуулах хорооноос тавих санхүүгийн шаардлагыг бууруулах чиглэлээр хамтран ажиллах нь зөв боловуу. |
| **Үйл ажиллагааны үндсэн чиглэл** | Хөгжиж буй ихэнх орнуудад сүүлийн жилүүдэд агуулахын аж ахуй хөгжиж байна. Биржийн нэг хэсэг болох агуулахын аж ахуй, Клиринг, төлбөр тооцооны төв, Цахим арилжааны төв, Мэдээллийн нэгдсэн төв, Арбитрын болон худалдан авагчдын зуучлалын төвийн үйлчилгээ үзүүлэх замаар биржийн оролцогчдын үйл ажиллагааг идэвхжүүлж байна. Эдгээр төвүүд нь сургалт, судалгаа, мэдээ, мэдээллийн цогц үйлчилгээ үзүүлж, маркетинг, менежментийн оновчтой бодлого баримтлан оролцогчдыг татах, барааны чанарт баталгаа өгч, үйлчилгээ үзүүлж байна. | ХААБ нь агуулах, лаборатори, тээврийн аж ахуй нэгжүүдэд итгэмжлэл олгож байгаа хэдий ч үйлчилгээ хийгдэхгүй байна. Мөн сургалт, мэдээ, мэдээллээр оролцогчдыг бүрэн хангаж ажиллахгүй байна. Эдгээр үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг нь биржид байгаа хэдий ч өргөн цар хүрээтэй, цогц үйлчилгээ үзүүлэхгүй байгаа учраас цаашид анхаар ажиллах нь зүйтэй юм. Хоршоонд суурилсан агуулахын аж ахуйг хөгжүүлж, түүхий эдийн бэлтгэгч бэлтгэн оролцох, мэргэшсэн чанарын баталгаажуулалтын нэгжийг хувийн хэвшилд тулгуурлан хоршоотой уялдуулан шинээр байгуулах, итгэмжлэх, хамтран ажиллах нь зөв болов уу. |
| **Арилжааны төрөл, хэлбэр** | Хятад, Энэтхэгийн биржүүд фьючеср, Этиоп, Беларуссийн биржүүд нь спот арилжааг танхимын болон цахим хэлбэрийг ашиглан голлон хийж байна. Ихэнх биржүүд агуулахын аж ахуйд суурилан чанарын шаардлага хангасан бараа, түүхий эдийг арилжааны төлөвлөгдсөн хуваарийн дагуу арилжаанд оруулж байна. Агуулахын аж ахуйг хөгжүүлснээр оролцогчдын тоо нэмэгдэх, биржид итгэх итгэх сэргэх, оролцогчид зээлийн үйлчилгээнд хамрагдах боломжууд бий болдог. Үүний тулд итгэмжлэгдсэн банк, даатгалын үйлчилгээ ихээхэн чухал үүрэгтэй байна. | ХААБ нь голлон спот арилжаа хийж байна. Цаашид форвард, фьючерсийн арилжааг үе шаттайгаар нэвтрүүлэх, эдгээр арилжааг нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хангах шаардлагатай юм. Гол нөхцлийг нэг нь хоршоонд суурилсан агуулахын аж ахуйг хөгжүүлэх явдал юм. Арилжаанд оролцох хүсэлтэй, оролцож байгаа бүх хүмүүст хуваарийн дагуу мэдээ, мэдээллээр жигд хангаж, танхимийн болон цахим хэлбэрээр нээлттэй, ил тод байхаар дуудлага худалдааг зохион байгуулж, зах зээлийн эрэлт, нийлүүлэлт болон чанарын үнэлэмжид суурилсан бодит үнэ бүрдүүлж ажиллах шаардлагатай байна. |
| **Арилжаалах бүтээгдэхүүн** | Ихэнх биржүүд олон төрлийн бүтээгдэхүүн арилжаалж байна. Бараа, бүтээгдэхүүнээс гадна гэрээ, индекс арилжаалж байна. Гэрээ болон индекс арилжаалахад олон оролцогчдыг татах нь чухал юм. Үүний цаана барааны эрх нэгээс нөгөөд шилжих бөгөөд гэрээний үнийн өөрчлөлтөөс ашиг хайгчид идэвхтэй оролцож байна. Этиопын биржийн хувьд хөдөө аж ахуйн цөөн төрлийн бүтээгдэхүүнээр төрөлжин ажиллаж байна. Энэтхэгийн бирж нь граммаар алт, мөнгөний жижиг гэрээ арилжаалж, олон оролцогчдыг татаж, үйлчилгээ үзүүлж байна. | Монголын хувьд ХААБ нь цөөн тооны бараа, түүхий эд арилжаалж байна. Тухайлбал, энэтхэгийн биржийн адилаар бага хэмжээтэй, ангилсан, тордолт хийсэн багцалсан ноолуурыг жижиг аж ахуйн нэгжүүд, иргэдийг оролцуулан арилжаалах боломж байгаа юм. Этиопын биржийн адилаар мөшгих тогтоотой уялдсан агуулахын аж ахуйгаар дамжуулан анхан шатны тордолт хийж, багцалж, чанарын баталгаа өгч, арилжаанд оруулах нь зөв байна. Үндэсний стандартын дагуу түүхий эдийн ангилалт, ялгалт, анхан шатны тордолтыг хийдэг түүхий эд мэргэжлийн хүмүүс, тоног төхөөрөмжийг тусламжтайгаар ажилбарыг гүйцэтгэх нь илүү үр өгөөжтэй байгаа нь судалгаанаас харагдаж байна. |
| **Үйлчилгээ** | Бусад орны биржүүд хэрэглэгчдийг оролцоог хангахын тулд биржийн үйл ажиллагаа, арилжаа, чанарын баталгаажуулалт, зах зээлийн үнэ, | ХААБ-ийн хувьд сургалт, судалгаа, мэдээ, мэдээллээр хангах үйлчилгээ үзүүлж байгаа хэдий ч олон нийтийн мэдээллийн хэрэгслэлээр |

| | | |
|---|---|---|
| | хүргэлт, төлбөр тооцоо, шимтгэлтэй холбоотой бүхий мэдээ, мэдээллээр гадаад, дотоодын бүх хүмүүсийг жигд хангах үйлчилгээ үзүүлж байна. Мөн үндэсний болон олон улсын томоохон хэвлэл, мэдээллийн хэрэгслэлээр мэдээллээ хүргэдэг. Биржүүд нв олон төрлийн үйлчилгээгээр хангаж, тухайлбал брокерийн үйлчилгээ, агуулахын үйлчилгээ (анхан шатны тордолт, лаборатори, агуулахын сертификат, банк, даатгалын үйлчилгээ), мэдээ, мэдээлэл, сургалтын үйлчилгээ үзүүлж байна. | өргөн цар хүрээтэй явуулахгүй байна. Агуулахын үйлчилгээ үзүүлж чадахгүй байна. Биржийн оролцогчид үйлчилгээ сул гэж үздэг. Иймд үйлчилгээний нэр төрөл, чанарыг сайжруулах хэрэгтэй байна. |
| **Арилжаанд оролцох шаардлага** | Олон тооны оролцогчдыг татахын тулд санхүүгийн өндөр шаардлага тавиад байдаггүй. Зөвхөн брокерууд оролцож байгаа учраас брокерууд нь санхүүгийн шаардлагаа тавьж, арилжаанд оролцогчдод зуучлалын үйлчилгээ үзүүлдэг. Брокерын суудлын тоо хязгаарлагдмал учраас суудал өмчлөх, түрээслэх хэлбэрээр брокерууд суудлын эрх авдаг. Чанартай түүхий эдийг арилжаанд оруулдаг. Чанарын баталгаажуулалтыг Этиоп улсад хувийн хэвшлийн чанар баталгаажуулалтын нэгж гүйцэтгэж байна. | Санхүүгийн зохицуулах хорооноос брокерт өндөр шаардлага тавьдаг. Энэ нь олон тооны брокерууд оролцох боломжийг хязгаарладаг. Хоршоодын хувьд санхүүгийн шаардлага байхгүй, харин агуулахтай байх нь давуу тал болно. Брокер болон хоршоод нь малчид, тариаланчдад өндөр шаардлага тавьж болохгүй. Харин түүхий эд бэлтгэлтэй холбоотой зардал гарах бөгөөд эдгээр зардлыг боломжит бага нөхцлөөр хоршоо өөрөө эсвэл малчид хариуцан бэлтгэн нийлүүлэгчдээр бэлтгүүлэх нь зөв юм. Бодит нөхцөл байдалд малчид, мал бүхий итгэд бэлтгэлийн өндөр зардал гаргаж, түүхий эдээ бэлтгэж байна. Нэг үгээр хэлбэр бэлтгэлийн зах зээл орон нутагт аль хэдийнээ хөгжөөд эхэлсэн. |
| **Биржийн дэд бүтэц** | Биржийн бүтэц, зохион байгуулалтын хувьд бэлтгэл, нийлүүлэлт, чанарын баталгаажуулалт, мэдээлэл, төлбөр тооцоо, клирингтэй холбоотой цогц дэд бүтэц, эко-системийг хөгжүүлж байна. Этиопын биржийн хувьд оролцогчдын нэгдмэл байдлыг хангахын тулд Биржийн оролцогчдын нгэгдсэн холбоог байгуулж, Биржийн Удирдах зөвлөлийн дэргэд үйл ажиллагаа явуулдаг. Биржийн эко-системд агуулахын аж ахуй, мэдээллийн нэгдсэн төв, арилжааны нэгдсэн төв, мөшгих мэдээллийн систем, мэдээллийн аюулгүй байдлын төв, арбитрын хороо багтаж байна. Агуулахын аж ахуй гэдэгт агуулах, банк, даатгал, лабораторитой мэргэжлийн чанарын баталгаажуулалтын нэгж, тээврийн аж ахуйг хамааруулж ойлгож байна. | Монгол улсад биржийн дэд бүтэц, эко-систем хөгжөөгүй байна. Иймд хоршоонд суурилсан агуулахын аж ахуйг хөгжүүлж, орон нутгийн банк, даатгалын үйлчилгээ, мэргэжлийн түүхий эд бэлтгэгч, хувийн хэвшлийн явуулын чанар баталгаажуулалтын нэгжийн хамтын оролцоотойгоор дэд бүтцийг бий болгох нь илүү хурдан, илүү үр дүнтэй байж болох юм. |
| **Хамтын ажиллагаа** | Ихэнх биржүүд гадаад, дотоод хамтын ажиллагаа, төсөл, хөтөлбөрүүдийг их явуулдаг байна. Дээрх биржүүд нь олон улсын бирж холбоо болон Үнэт цаасны хороонд гишүүнээр элссэн байна. Хятад, Энэтхэгийн биржүүд олон улсын томоохон биржтэй хамтран ажиллах санамж байгуулж, ажиллаж байна. Тухайбал АНУ, ЕХ болон бусад орны биржүүдтэй хамтарч байна. | 2017 онд Хятадын Бохайн биржтэй хамтран ажиллах санамж байгуулсан. Олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах ажил идэвхжиж байна. |

## 4.3. Олон барааны биржийн туршлагаас монгол улсад нэвтрүүлэх боломж

**Биржийн амжилттай ажиллах урьдчилсан нөхцлийг хангах хүрээнд:** Барааны бирж нь бараа, мэдээлэл, санхүүгийн урсгалын нийлбэр цогц юм. Хятад, Энэтхэг зэрэг орнуудын барааны биржээр олон төрлийн бүтээгдэхүүний спот, форвард болон фьючерсийн арилжаа хийж, бараа, санхүү, мэдээллийн урсгалыг холбосон биржийн үйл ажиллагаа явуулж байна. Харин Этиопийн бирж нь спот арилжаа голлон арилжаалж байна. Бирж нь дараах нөхцлийг хангасан байх шаардлагатай байдаг. Үүнд:

Хүснэгт 18. Бирж байгуулагдах урьдчилсан нөхцөл

| | |
|---|---|
| **Зах зээлийн ил тод, нэгдмэл байдлыг хангах** | Зах зээлийн ил тод байдлыг хангах; |
| | Тогтолцооны зардлыг бууруулахад анхаарах |
| | Засгийн газраас биржийн дэд бүтэц, эко-системийг бүрдүүлэх, хууль эрх зүйн таатай орчинг бүрдүүлэх, төрийн бодлогын уялдаа холбоог хангахад дэмжлэг болж ажиллах |
| **Дэд бүтэц, эко системийг бүрдүүлэх** | Орчин үеийн шаардлага стандартыг хангасан агуулах, санхүүгийн байгууллага, лаборатори болон тээвэр логистикийн сүлжээтэй байх; |
| | Үйлдвэрлэлийн томоохон бүс нутаг, төвийг түшиглэн биржийн салбар, нэгж, агуулахын аж ахуй, тээвэр ложистик, банк санхүү, даатгалын нэгжийг байгуулах |
| **Үр ашигтай арилжаа явуулах** | Биржийн худалдагч болон худалдан авагчид нь бие биенээ хурдан олоход туслах |
| | Биржийн үнэ нь зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн хуулийн дагуу арилжаанд оролцогчдын хооронд ил тод, нээлттэй нөхцлөөр тохиролцсон хэлэлцээрийн үр дүнд бүрдүүлэх |
| **Эрх зүйн орчинг бүрдүүлэх** | Биржийн оролцогчдын эрх ашгийг хамгаалах, соёлтой, ёс зүйтэй, шударга худалдаа хийх эрх зүйн орчин, нөхцлийг бүрдүүлэх; |
| | Хуулийн хэрэгжилтийг чанд мөрдүүлэх, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих |
| | Биржийн арилжаанд оролцогчдын үүрэг, хариуцлагыг өндөржүүлэх, хуульд заасан мэргэжлийн худалдаачдыг арилжаанд өргөнөөр оролцуулах |
| **Биржийн нэр хүнд, итгэлцлийг бий болгох** | Биржид итгэх итгэлцлийн тогтолцоог бүтээгдэхүүний чанарын баталгааг хангах, чанартай үйлчилгээ үзүүлэх замаар бүрдүүлэх; |
| | Барааны чанар, стандартыг тогтоох, барааны чанарт баталгаа олгох |
| **Үйлчилгээ, бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх** | Олон төрлийн чанартай үйлчилгээ үзүүлж, биржийн оролцогчдын мэдлэг чадварыг тогтмол сайжруулах, мэргэшүүлэх |
| | Хангалттай хэмжээний нөөцтэй, агуулахад хадгалах боломжтой, нэг төрлөөр багцалж болох бүтээгдэхүүнээр хангах |
| | Биржид хөрөнгө оруулах нөхцлийг бүрдүүлэх, мөн биржийн оролцогчид зээл авах боломжоор хангах |

Зарим улс орнуудад бирж нь өөрийн үйл ажиллагааг бие даан зохицуулах үүднээс хэнээс ч хараат бус байхаар эрх зүйн орчингоор хангагдсан, нийгмийн эрх ашгийг эрхэмлэх үүднээс ашгийн бус зорилгоор аж ахуйн үйл ажиллагаа явуулдаг. Манай орны ХААБ нь ашгийн төлөө үйл ажиллагаа явуулах байгууллага бөгөөд ийм төрлийн биржүүд олон улсад байдаг. Гэхдээ ашгийн бус байж, нийтийн эрх ашгийн төлөө ажиллах боломжтой юм.

**Зорилго, зорилт, зарчим, чиг үүргийг тодорхой болгох хүрээнд:** Дэлхийн ихэнх орнууд нээлттэй, ил тод, шударга байх зарчим баримталж байгаа нь манай нөхцөл байдалтай адилхан байна. Беларуссийн бирж нь ил тод, нээлттэй, зах зээлийн бодит үнийг тогтооход биржийн зорилго чиглэсэн бөгөөд зорилгодоо хүрэхийн тулд шинэ нэр төрлийн бүтээгдэхүүнийг судалж, танилцуулж, нэвтрүүлэх, экспортыг дэмжсэн борлуулалтын зах зээлд төвлөрөх, бизнесийн түншийг олж өгөх арга хэрэгслийг өргөн ашиглаж байна. Хятадын барааны биржүүд нь фьючерсийн арилжаагаа бататгах, орчин үеийн дэвшилтэд техник, техниологийг нэвтрүүлэх, олон улсын томоохон биржийн нэг болох зэрэг томоохон зорилтуудыг дэвшүүлдэг. Энэтхэгийн барааны биржийн хувьд биржийн арилжаан дахь ёс зүйтэй арилжаа, ил тод нээлттэй байдлаар явуулахад чиглэж байна. Этиопын барааны бирж нь дэлхийн хамгийн сүүлийн үеийн бирж гэсэн байр сууриа бататгах, Африк тивийн тэргүүлэх бирж болох алсын харааны бодлоготой. Үүний тулд дэвшилтэд техник, технологи, инновацийг нэвтрүүлэх замаар орчин үеийн үр ашигтай, ил тод, нээлттэй, найдвартай зах зээлийн платформ болон агуулахын аж ахуйн үйлчилгээгээр хангана гэж эрхэм зорилгоо тодорхойлсон байна. Биржийн зорилго нь тогтолцооны болон байгууллагын нөөц боломжийг сайтар тооцоолсоны үндсэн дээр нөөц, боломжийг хэрхэн үр ашигтай ашиглаж, үр дүнд хүрэх талаар тодорхой тусгасан байна. Биржийн ажиллах үндсэн үүрэг нь урьдчилж бэлтгэн ангилж, зэрэглэсэн бараа, бүтээгдэхүүнийг арилжаанд оруулах явдал байдаг. Ингэхдээ арилжаалах бүтээгдэхүүний чанарын ангилал нь бүтээгдэхүүнийг худалдан авагч, худалдагчаас аль алинаас хараат бус найдвартай этгээд /хувийн хэвшлийн хариуцлаг хүлээх чадвартай мэргэжлийн байгууллага/-ээр хийгдсэн гэдэг итгэл үнэмшил төрүүлэхүйц байх нь хамгийн чухал бөгөөд энэ үүрэг/үйлчилгээг биржээс итгэмжлэл авсан чанарын баталгаажуулалтын нэгж гүйцэтгэдэг байна. ХААБ-ийн зорилго нь ерөнхий, мөн хэмжигдэх боломжгүй байна. Иймд биржийн зорилгыг дахин томьёолох хэрэгтэй байна.

**Биржийн бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэх хүрээнд:** Биржийн дотоод удирдлага зохион байгуулалтын тогтолцоо ямар хэлбэртэй байх нь ихээхэн чухал үүрэгтэй байдаг. Япон улсын ТОСОМ биржийн дотоод удирдлагын тогтолцоо бол харьцангуй сайн бүтэцтэй биржийн тоонд багтдаг. Хувьцаа эзэмшичдийн бүх нийтийн хурал нь биржийн хамгийн дээд удирдлага бөгөөд нийтийн хурлын дэргэд аудиторуудын зөвлөл байдаг. Биржийн захирлуудын Зөвлөл нь хувьцаа эзэмшигчдын нийтийн хурлын шийдвэрээр байгуулагдаж, захирлуудын Зөвлөлөөс биржийн гүйцэтгэх захирлыг томилдог. Захирлуудын зөвлөл нь дэргэдээ зөвлөх баг ажиллуулж болно. Энэхүү зөвлөх баг нь зах зээлийн хороо, санхүүгийн хороо, хүргэлтийн хороо, бүтээгдэхүүний төрөл бүрээр хороо байгуулагдаж ажилладаг. Гүйцэтгэх захирал нь өөрийн алба, хэлтэстэй байна. Биржийн өдөр тутмын үйл ажиллагааг хянах үүрэг бүхий үйл ажиллагааг аудиторууд гүйцэтгэдэг байна. БНХАУ-ын Тяньжин, Шанхай болон Зенжоугийн биржүүд нь адилхан дотоод бүтэц зохион байгуулалттай байдаг. Биржийн зорилгодоо хүрэхийн тулд нөөц боломжийг зөв хуваарилж, үр дүнтэй удирдахад хялбар, уян хатан, хөрвөх чадвартай бүтэц, зохион байгуулалттай байна. Биржийн үйл ажиллагааны төлөвлөлт, зохион байгуулалт, хяналтын бүхий л процесс нь хоорондоо

уялдаа холбоотой, тасралтгүй шинж чанартай байдаг байна. Хөдөө аж ахуйн биржийн хувьд төлөвлөлт болон хяналтын процесс сул байна. Ялангуяа орчин үеийн техник, технологийг нэвтрүүлэх, төрийн бодлогын уялдааг хангах, хуулийн хэрэгжилтийг ягштал хэрэгжүүлэх зэрэг ажлууд, биржийн арилжаанд оролцогчдын үйл ажиллагаанд хяналт тавих, тайлагнах, хариуцлага тооцох систем тааруу ажиллаж байна. Иймд биржийн бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэх нь зүйтэй байна.

**Арилжааны төрөл, хэлбэрийг сайжруулах хүрээнд:** Этиопийн барааны бирж нь танхимийн нээлттэй дуудлага худалдааны хэлбэрийг ашиглан спот арилжаа голлон хийж байна. Беларуссийн бирж нь цахим арилжаагаар дамжуулан спот, форвард арилжаа хийж байна. Хятад, Энэтхэгийн барааны биржүүд нь цахим арилжааг ашиглан фьючесрийн арилжаанд төвлөрөн ажиллаж байна. Манай биржийн хувьд нээлттэй дуудлага худалдааны хэлбэрийг ашиглан цахим арилжаа явуулах нь тохиромжтой хэлбэр байж болох юм.

**Бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх хүрээнд:** Этиоп, Беларуссийн бирж нь голдуу экспортод чиглэсэн бараа, түүхий эд арилжаалдаг бол Хятад, Энэтхэгийн биржүүд нь голлон импорт, дотоодын зах зээлд чиглэсэн бараа, бүтээгдэхүүн арилжаалж байна. Монгол орны хувьд экспортод чиглэсэн бараа, түүхий эдийг худалдан авагч орнуудын хэрэгцээ, чанарын шаардлагыг хангасан байдлаар бэлтгэн арилжаалах нь зүйтэй болов уу. Үйлчилгээний хувьд бэлтгэн нийлүүлэлт, банк санхүү, төлбөр тооцоо болон брокерийн үйлчилгээ, сургалт, судалгаа, мэдээ, мэдээлэл, маркетинг, даатгалын цогц үйлчилгээ үзүүлэх шаардлагатай байна. Биржээр арилжаалах бараа бүтээгдэхүүнд чанарын баталгаажуулалт хийгддэг. Агуулахад барааг хүлээн авч, орчин үеийн мэдрэгчтэй тоног төхөөрөмжөөр шалгаж, дээш авч, баталгаажуулан ангилалт, чанарын зэрэглэлийг тогтоодог. Үүнийг чанарын баталгаажуулалтын шинжээчид эсвэл хувийн хэвшлийн чанарын баталгаажуулалтын нэгж гүйцэтгэдэг. Тэдний ашиглаж буй лаборатори нь тусгай зөвшөөрөлтэй, биржээс тогтоосон тодорхой журам, зохицуулалтыг мөрддөг бөгөөд баталгаатай, найдвартай, мэргэжлийн байх нь ихээхэн чухал байдаг байна. Олон оронд чанарын баталгаажуулалтын нэгж болон шинжээч нар нь олон улсын хянан баталгаажуулалтын компаниудын ажиллагсад байдаг бөгөөд хариуцлагын баталгаа, даатгалтай байдаг байна. Хариуцлага алдвал санхүүгийн чадвартай байх шаардлагатай юм.

**Оролцогчдын тоог нэмэгдүүлэх хүрээнд:** Олон улсын барааны биржүүдийн хувьд олон тооны худалдан авагч, худалдаалагчидтай байдаг бөгөөд танхимын арилжаанаас илүүгээр цахим арилжаа явуулдаг. Спот арилжаа хийж байгаа тохиолдолд хяналтыг сайжруулахын тулд худалдан авагч, худалдаалагчдаас үнийн саналыг авч, арилжаанд оруулах зөвшөөрөлтэй тодорхой тооны брокеруудтай байдаг байна. Барааны биржийн арилжаанд мэдээлэл сайтай, томоохон үйлдвэрлэгч, хэрэгчид голлон оролцдог учраас биржийн арилжаанд жижиг оролцогчдыг өргөнөөр хамруулах нь аливаа хөгжиж буй орнуудад нийтлэг асуудал байдаг. Барааны биржийн арилжаанд ямар шаардлага хангасан хичнээн хэмжээний бүтээгдэхүүнийг ямар үнээр арилжаалж байгаа тухай зах зээлийн мэдээ, мэдээллээр хангагдах байдал нь жижиг оролцогчдын хувьд ихээхэн хомс байдаг. Мөн түүнчилэн хаана, хэн, ямар үнээр бараа, түүхий эдийг бэлтгэж, хаана нийлүүлж байгаа, түүхий эд бэлтгэхэд ямар хэмжээний зардал гарах, барааны чанар хэн хяналт тавих, баталгаажуулах тухай мэдээ, мэдээллээр биржийн оролцогчдыг жигд хангаж чадаж байна уу гэдэгт асуудал гардаг. Тухайн орны жижиг тариаланчид, үйлдвэрлэгчид нь өөрсдийн зардлаар түүхий эдээ бэлтгэн төвлөрсөн арилжааны газарт хүргэж, худалдаалахад ихээхэн хэмжээний зардал гарч, мөн янз

бүрийн үнээр арилжаалдаг. Харин тэдгээр жижиг тариаланчид, үйлдвэрлэгчид хөдөлмөр, хөрөнгө, бүтээгдэхүүнээрээ хоршиж, гарч болох аливаа зардлаа дундаа хуваалцаж, арилжаанд оролцсоноор зардал буурах, нөгөө талдаа тогтсон үнээр борлуулах боломжтой болдог. Мөн бараа, түүхий эдээ хадгалах агуулах байхгүй учраас хямдаар зарж борлуулахад хүргэдэг гол хүчин зүйлийн нэг байдаг. Ийм учраас жижиг оролцогчдыг хоршоо хэлбэрээр нэгтгэх, хоршоогоор дамжуулан мэдээ, мэдээллийг тогтмол хүргэх замаар биржийн оролцогчдыг татах боломжтой байдаг. Мөн хөгжиж байгаа орнуудын дийлэнх барааны биржүүд нь хязгаарлагдмал тооны брокеруудтай, тэдгээр брокеруудаар дамжуулан оролцогчдыг татан оролцуулдаг. Олон улсын туршлагаас харахад бирж нь байгууллагын хувьд худалдах, худалдан авалтын хэлцэл хийхгүй. Хэлцлүүдийг биржүүдийн брокер, гишүүдийн тусламжтайгаар хийж, харин гишүүн бус оролцогчид зөвхөн биржийн гишүүн брокеруудаар дамжуулан хэлцэл байгуулдаг учраас брокерийн үйлчилгээг сайжруулах, хоршоодын оролцоог идэвхжүүлэх шаардлагатай байна. иймд арилжаанд оролцох эрхтэй брокер болон хоршоод чухал үүрэгтэй төдийгүй брокерийн пүүс, хоршоод нь оролцогчдыг гишүүнчлэлд идэвхтэй хамруулах үйлчилгээ явуулдаг гэдгийг ойлгуулах, мэргэшүүлэх нь зүйтэй байна.

**Дэд бүтэц, эко-систем, агуулахын аж ахуйг хөгжүүлэх хүрээнд:** Хөгжиж байгаа улс орнуудад спот арилжааны бирж зонхилдог бөгөөд арилжаанд оролцож байгаа гадаад, дотоодын иргэд нь биржийн барааны тоо хэмжээ, чанарын баталгаажуулалтын асуудалд онцгой анхаарал хандуулдаг. Үйлдвэрийн нөөцөд ойрхон биржийн салбар, нэгжийг байгуулж, агуулахын аж ахуйг бий болгож, үйлдвэрлэгчдэд дөхөж ажилладаг байна. Бирж дээр зуучлалын үүрэг гүйцэтгэх брокерийн компани нь төвлөрсөн болон нөөцөд ойрхон орон нутагт байрлана. Бирж нь агуулах, мэдээллийн сүлжээ, бүтээгдэхүүний сорилын лабораторитой, бие даан үйл ажиллагаа явуулах дүрэмтэй байгууллага байна. Агуулахын аж ахуй нь биржийн хамгийн чухал бүрэлдэхүүн хэсэг байдаг. Эдгээр итгэмжлэгдсэн тээвэр зуучийн байгууллага, агуулахын аж ахуй, лаборатори болон төлбөр тооцооны төвүүд нь олон улсын стандартыг баримтлаж, дэвшилтэд тоног төхөөрөмжөөр хангагдсан байвал илүү их ач холбогдолтой байдаг байна. Дэлхийн ихэнх орнууд агуулахын аж ахуйг хөгжүүлэх, агуулахын аж ахуйгаас олгож байгаа чанарын болон агуулахын сертификатад тулгуурлан банк, санхүү, зээлийн үйлчилгээнд хамрагдах боломж бүрддэг байна. Агуулахын аж ахуйн нь агуулахад байгаа бараанд суурилсан санхүүжилт авах нөхцлийг бүрдүүлдэг. Энэ нь баталгаат агуулахад хадгалуулсан бүтээгдэхүүнээрээ барьцаалж зээл авах боломжийг олгодог. Улирлын нөхцөл байдал, эрэлт, нийлүүлэлтээс хамааран үнэ унах үед малчид, тариаланчдын хувьд зээл авах шаардлага тулгардаг байна. Агуулахын эрхлэгчийг эрх бүхий этгээд хянан баталгаажуулдаг. Зарим орнуудад банкны тогтолцоотой хамтран ажиллах, түүгээр хүлээн зөвшөөрөгдсөн байх шаардлагатай байдаг тул агуулахын аж ахуй нь биржийн бүрэлдэхүүн биш, харин бие даасан аж ахуй байдаг байна. Үндэсний стандартын дагуу түүхий эдэд анхан шатны тордолт хийж, ангилан ялгаж, чанарын баталгаажуулалт хийж, агуулсанаар биржийн арилжаанд оролцогчдын олон төрлийн үйл ажиллагааг хөнгөвчилж, зардлыг бууруулах боломжтой болдог. Бусад орнуудад агуулахын бүртгэлийн тогтолцоо нь биржээс гадуур байгууллагад хамаардаг боловч агуулахын бүртгэлийг уялдуулан ажилладаг тохиолдол байдаг байна.

**Арилжааны шимтгэлийг бууруулах хүрээнд:** Эпиопын биржийн арилжааны шимтгэл 0.06 хувь, Беларуссийн барааны бирж нь 0.2 хувьтай байдаг. Биржийн арилжаа, үйлчилгээний шимтгэл хураамж бага байх нь оролцогчдыг татах нэг төрөл юм. Биржээр арилжаалах бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээ, мөн арилжаанд оролцогчдын тоог нэмэгдүүлэх замаар үе шаттайгаар биржийн шимтгэлийг бууруулдаг байна. мөн

биржийн арилжааны шимтгэл, төлбөр тооцоо, хураамжийн хэмжээ урт хугацаанд тогтвортой хэвээр байдаг байна. Иймд

**Төрийн хяналт, хамтын ажиллагааг сайжруулах хүрээнд:** Хөдөө аж ахуйн бирж нь төрийн өмчит бирж учраас биржийн үйл ажиллагаа амжилттай явж байгаа эсэх, хэрэв амжилтгүй ажиллаж байгаа бол шалтгаан нь юу болох, ямар эрсдлүүд болон тулгамдаж байгаа асуудал байгаа талаар Засгийн газраас хяналт тавин ажиллах нь чухал юм. Биржийн үйл ажиллагаанд төрийн хяналт тавих субьект нь биржийн зохицуулах зөвлөл байдаг. Дэлхийн ихэнх биржүүд олон улсын биржүүдийн холбоо, үнэт цаасны хороо болон бусад томоохон биржүүдтэй хамтран ажиллах санамж бичиг, гэрээ байгуулж, түүний хүрээнд биржийн чадавхийг сайжруулах чиглэлээр хамтран ажилладаг байна. Этиопын хөрөнгийн биржийн газар нь төрийн зохицуулалт, хяналтын үүргийг гүйцэтгэдэг байгууллага юм. Манайхаар биржийн Зохицуулах зөвлөлтэй адилхан. Энэ газар биржийн зохион байгуулалт, мөрдвөл зохих дүрэм, журмыг батална. Гол чиг үүрэгт инновацыг дэмжих, шударга өрсөлдөөнийг хангах, зах зээлийн мэдээлэл авах, санхүүгийн нэгдмэл байдлыг хангах, үнийн эрсдэл, залилан мэхлэх, системийн шинжтэй аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажилладаг юм. Биржийн удирдах зөвлөлийн дэргэд Үндэсний биржийн оролцогчдын холбоо ажилладаг бөгөөд энэ байгууллага нь шударга байдал, мэргэжлийн ур чадвар, биржид оролцдог бүх тоглогчдын туршлага дадлын стандартыг хангуулах зорилгоор байгуулагдсан. Иймд Монголын нөхцөл Биржийн зохицуулах зөвлөлийн үйл ажиллагаа хуулийн хүрээнд дахин явуулах, зохицуулах зөвлөлийн дэргэд Үндэсний биржийн оролцогчдын холбоо буюу оролцогчдын дээвэр холбоог байгуулах нь зөв болов уу.

## 4.4. Дэд дүгнэлт

Эрдэс баялгийн экспортын чиглэлтэй Беларусийн Универсал барааны бирж, Хятадын Бохайн бирж, харин голдуу импорт рүү чиглэлтэй биржид Хятадын Ченжоугийн биржүүдийн хооронд маш их ялгаа байна.

Беларусь улсын биржийн хувь нийлүүлэгчид бүгд төрийн, төрийн өмчит субьектууд байна. Зөвхөн Беларусийн бирж дээр арилжаалагдсан бараа бараа бүтээгдэхүүн экспортонд гарах эрхтэй, гаалийн хороо нь сар бүр биржийн гол хувь нийлүүлэгч болох тус улсын худалдааны яаманд экспортонд гарсан барааны мэдээ хүргүүлж байх журамтай.

Женжоугийн бирж нь үйл ажиллагааны гол чиглэл нь БНХАУ-ын боловсруулах үйлдвэрийн түүхий эдийн нийлүүлэлтийг хангах, олон улсын хөрөнгө оруулалтын нөөц эзэмшигчидтэй холбох, БНХАУ-ын олборлолтын технологи, хүчин чадлыг олон улсын зах зээлд нэвтрэхэд дэмжих, дотоодын бүтээгдэхүүний хувиарлалтыг оновчтой болгох, мөн дотоодын ашигт малтмал ашиглах зөвшөөрлүүдийг худалдааны эрх зүйн зохицуулалт муутай байдлыг сайжруулах, захиргааны шаардлагуудын дагуу зах зээлийн хөшүүргээр дотоодын олборлох үйлдвэрлэлийг удирдан нэгтгэхэд энэхүү бирж нь туслалцаа үзүүлдэг байна.

"Бараа бүтээгдэхүүний биржийн тухай" 1992 оны маш ерөнхий заалтуудтай хуулийг үндэслэл болгон ашиглаагүй ирж, 100% төрийн өмчит биржийг Беларусийн биржийг Сайд нарын Зөвлөлийн тогтоолоор 2003 онд байгуулж 2009 онд барааны биржийн тухай хуультай болжээ.

Олон улсын сайн туршлага болон судалгааны зарим үр дүнд суурилан дараах арга хэмжээ авах нь зүйтэй байна.

1. Олон тооны оролцогчдыг татахын тулд ангилах, ялгах, хадаглах, тээвэрлэх ажиллагааг хөнгөвчлөх
2. Форвард арилжааг нэвтрүүлэх
3. Цаг үеийн мэдээллээр шуурхай хангах
4. Хязгаарлагдмал оролцоотойгоор Засгийн газрыг оролцуулах;
5. Хууль эрх зүйн орчин нь эдийн засгийн хөгжилтэй уялдуулан уян хатан хэлбэртэй байх;
6. Биржийн арилжаа, тооцооны аюулгүй байдлыг бий болгох;
7. Зохион байгуулалт сайтай дотоодын бүтээгдэхүүнийг гадаадын зах зээлд экспортлох аж ахуйн нэгжүүдийг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлэх;
8. Цахим хэлбэрийг ашиглан дуудлага худалдааг зохион байгуулах;
9. Биржийн оролцогчдыг сургалтад хамруулах;
10. Чадварлаг боловсон хүчинг бэлтгэх;
11. Бэлтгэн нийлүүлэгчдийг дэмжих;
12. Олон улсын байгууллагын дэмжлэг авах, олон улсын биржийн холбоонд нэгдэх.

# ТАВДУГААР БҮЛЭГ. НӨХЦӨЛ БАЙДЛЫН ШИНЖИЛГЭЭ

## 5.1. Хөдөө аж ахуйн биржийн өнөөгийн байдал, тулгамдсан асуудал

### А/. Хөдөө аж ахуйн биржийн үндсэн зорилго, чиг үүрэг

Хөгжиж буй орнуудын бараа, түүхий эдийн биржүүд нь өөр өөрийн онцлогтой, зорилго болон чиг үүрэгтэй байдаг. Хөгжиж буй орнуудын ихэнх түүхий эдийн биржүүд түүхий эдийн зах зээлд зохион байгуулалттай худалдааг хөгжүүлэхийн тулд олон арга хэрэгслийг ашигладаг. Зарим судалгаа, тайланд дурдсанаар улс орон бүр өөрийн орны онцлог эсвэл барааны онцлогтой тохирсон хөдөө аж ахуйн бараа, түүхий эдийн биржийг байгуулах нь зүйтэй гэж үздэг байна.

Ерөнхийдөө биржийн гол зорилго нь үнийн ил тод байдлыг хангаж, оролцогчдыг зах зээлийн үр ашигтай мэдээ, мэдээллээр хангах, олон оролцогчдыг татах замаар биржийн арилжааг нээлттэй, ил тод шударга явуулж, зах зээлийн бодит үнийг тогтоох, улмаар тогтолцооны хэлцлийн зардлыг бууруулах зорилготой. Үүний тулд чанар стандарт, агуулах, лабораторийн үйлчилгээгээр хангаж, малчид урьдчилж ирэх жилийн бараа, түүхий эдээ өнөөдрийн ханшаар арилжаалдаг форвард болон фьючерсийн гэрээний арилжааг нэвтрүүлэх арга хэмжээ авдаг.

Монгол Улсын Засгийн газрын 2013 онд “Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийг үүсгэн байгуулж, Төлөөлөн Зохицуулах Зөвлөл болон Гүйцэтгэх удирдлагыг томилж, биржийн үйл ажиллагаа эхэлсэн. Хөдөө аж ахуйн биржийн үүсгэн байгуулагч нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам бөгөөд төрийн өмчийн 100 хувийн оролцоотой төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани, мөн ашгийн төлөө ажиллах зорилготой байна.

Хөдөө аж ахуйн бирж нь Төрийн өмчийн хороо болон Санхүүгийн зохицуулах хорооны хяналтад дор үйл ажиллагаа явуулж, хөдөө аж ахуйн биржийн хууль, биржээс баталсан дүрэм, журам, стандартыг чанд мөрдүүлж, олон тооны худалдагч, худалдан авагчдыг нэг дор уулзуулж, цахим болон танхимын арилжааны хэлбэрээр спот болон форвард, фьючерс, опционы гэрээний арилжааг зохион байгуулдаг төрийн зохицуулалттай арилжааны газар юм. Биржийн зорилго нь хөдөө аж ахуйн биржийн хуульд тусгагдаагүй харин дүрэмд заасан байна

Биржийн дүрэмд зааснаар “Биржийн зорилго нь олон улсын стандартад нийцсэн хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлтийн нэгдсэн тогтолцоог бий болгох, бараа, түүхий эдийн арилжааг тогтсон журмын дагуу зориулалтын байранд зохион байгуулах” гэж тодорхойлсон байна. Зорилго нь арилжаа зохион байгуулах, бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоог бий болгохоор зорьсон хэдий ч өнөөг хүртэл зорилгодоо хүрч чадаагүй хэвээр байна. Тухайлбал, үнийг ил тод, нээлттэй байдлаар тогтоодогүй, бирж дээр арилжаалагдах бараа, түүхий эдийг бэлтгэлийн стандартын дагуу ангилан ялгах зэрэг ажил хийгддэгүй, хоршоо биржийн арилжаанд оролцох эрхтэй боловч оролцоог хангаж чадахгүй байгаа зэрэг асуудлууд байсаар байна. Зорилго нь олон улсын барааны биржийн жишигтэй нийцсэн, харин цахим хөдөө аж ахуйн бодлого, инноваци зэрэгтэй уялдуулан шинээр тодорхойлох нь зөв болов уу.

Биржийн хуульд биржийн чиг үүргийн талаар тодорхой тусгасан хэдий ч олон улсын биржийн чиг үүрэгт нийцүүлж, ангилах нь зүйтэй байна. Диаграмм 3-т олон улсын барааны биржийн чиг үүргийг тусгаж, монгол орны хөдөө аж ахуйн биржийн чиг үүргийг уялдуулсан.

Ил тод, нээлттэй, шударга арилжаа явуулах хүрээнд биржийн арилжааг зохион байгуулах, оролцогчдын сургах, зах зээлийн бодит үнээр жигд хүртээмжтэй хангах, биржийн брокер, хоршоодын идэвхтэй оролцоог хангах, барааны чанар, тоо хэмжээг баталгаажуулах, арилжааны үнийн хэлбэлзлийг хянах, форвард болон фьючерсийн арилжаа явуулах нөхцлийг бүрдүүлэх, хэрэгжүүлэх зэрэг ажлуудыг шингээж, чиглэж ажиллах нь зүйтэй юм. Үүнд арилжааны алба нь чухал үүрэгтэй оролцоно.

Диаграмм 8: Олон улсын биржийн чиг үүрэг




Зах зээлийн бодит үнэ бүрдүүлэх чиглэлийн хүрээнд зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн талаар судалгаа хийх, биржээр арилжих боломжтой барааны жагсаалтыг батлах, биржтэй холбоотой худалдааны маржин, арилжааны шимтгэл, төлбөр, хураамж, суудлын төлбөр хураамжийг тогтоох, оролцогчдыг бүртгэх, арилжааны зөвшөөрөл олгох зэрэг ажлуудыг багтааж, биржийн бизнес хөгжлийн алба болон төлбөр тооцоо, бүртгэлийн алба хамтран ажиллах шаардлагатай болно. Оролцогчдын идэвхтэй оролцоог хангах, тэдгээр чанартай, хүртээмжтэй төрөл бүрийн үйлчилгээг үзүүлэх чиг үүргийн хүрээнд стандартын шаардлага хангасан агуулах, тээвэр, лабораторт итгэмжлэл олгох, биржээр арилжаалсан бараа, түүхий эдийг экспортох бол тодорхойлолт өгөх, баталгаат чанар, тоо хэмжээгээр хангах зэрэг ажлуудыг бүх газрууд, ялангуяа ложистик бүтээгдэхүүний чанарын баталгаажуулалтын алба голлон гүйцэтгэх хэрэгтэй юм. Үүнээс гадна биржийн дэд бүтэц, эко-системийг хангах, биржийн хууль, дүрэм, журам, стандартыг ягштал мөрдүүлэхэд биржийн хяналтын алба, мэдээлэл технологийн алба, мөн биржийн захиргаа удирдлагын алба чухал үүрэгтэй оролцох ёстой байдаг. Одоогоор биржийн бие даасан хяналтын болон технологийн алба байхгүй байна.

Хөдөө аж ахуйн бараа, түүхий эдийн биржийн хуулийг бүрэн ашиглаж чадахгүй, хэрэгжилт хангалтгүй байна. Өнгөрсөн хугацаанд энэ хуульд таван удаа нэмэлт өөрчлөлт оруулсан. Хугацаа хоцорсон ч гэсэн биржийн үйл ажиллагаатай холбоотой 20 орчим дүрэм, журмыг биржээс баталж, хэрэгжүүлж байна. Бирж байгуулагдсанаас хойш төрөөс хүнс, хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэх олон бодлогууд шинэчлэгдэн батлагдсан. Эдгээр төрөөс хөдөө аж ахуйн салбар баримтлах бодлого болон биржийн хуультай уялдуулан биржийн дүрэм, журам, эрх зүйн орчныг сайжруулах шаардлагатай байна. Бирж нь биржийн үйл ажиллагаанд нийцсэн бирж дээр арилжаалагдаж буй бараа бүтээгдэхүүний стандарт, зэрэглэлийг батлаагүй байна. Түүнчлэн, бирж нь хоршоодыг татах, зохицуулах зөвлөлийг ажиллуулах, түүхий эдийн чанар, стандартыг баталгаажуулах, форвард арилжааг нэвтрүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж чадахгүй байна. Бирж нь ашгийн төлөө үйл ажиллагаа явуулахаар дүрэмд заасан. Төрийн өмчийн оролцоотой ихэнх биржүүд ашгийн бус байдаг. Чанарт тохирсон үнэ арилжаалах гол

үүрэгтэй хэдий ч энэ зорилт хэрэгжихгүй байна. Биржийн хуулиар чанар сайжирна гэсэн үзэл баримтлалтай боловч хууль хангалтгүй хэрэгжсэн, чанар муудаж, чанарыг зөнд нь хаясан байна.

### В/. Биржийн бүтэц, зохион байгуулалт, хүний нөөц

Аливаа биржийн бүтэц, зохион байгуулалт нь хувьцаа эзэмшигчид, бараа, түүхий эдийн нэр төрөл, байршил, зах зээлийн нөхцөл байдал өөрчлөгддөгтэй холбоотойгоор мөн өөрчлөгдөн шинэчлэгдэж явдаг. Монголын хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн бирж нь яам, төрийн байгууллагуудын төлөөллийг оролцуулсан хувьцаа эзэмшигчдийн оролцоо бага, оролцогчдын идэвх сул бүтэцтэй байна. Өөрөөр хэлбэл, цөөхөн тооны хувьцаа эзэмшигчтэй байна.

Диаграмм 9. Биржийн бүтэц /одоогийн/




Ерөнхийдөө биржийн хувьцаа эзэмшигчдийн тоог нэмэгдүүлж, дээрээс доошоо удирдлагын шийдвэр гарах бус харин доороосоо дээшээ гэсэн удирдлагын шийдвэр гаргалттай байхаар биржийн бүтэц, зохион байгуулалтыг өөрчилснөөр биржийн удирдлагын оновчтой шийдвэр гаргахад илүү үр дүнтэй байдаг. Бирж нь үйл ажиллагаагаа, бүтэц, зохион байгуулалтаа дэмжсэн техник, технологийн дэвшлийг нэвтрүүлэх, төрийн цахим бодлогыг хөгжүүлэх, дэд бүтцийг хөгжүүлэх, агуулахтай болох зэрэг ажил хийхгүй байгаа нь биржийн хөрөнгө оруулалт, санхүү, технологи, мэргэжлийн боловсон хүчний нөөц дутагдалтай байгаатай холбоотой. Засгийн

газраас таван тэр бум төгрөг төлөвлөж нэг тэрбум төгрөг хөрөнгө оруулалт хийсэн. Үүнээс гадна бирж нь орчин үеийн дэвшилтэд шинэ техник, технологийг нэвтрүүлэх, дүрэм журмыг уян хатан байдлаар шинэчлэн батлах, олон оролцогчдыг татах зэрэг уян хатан, мэдрэмжтэй бодлого хэрэгцүүлдэг байх шаардлагатай байна.

Биржийн Зохицуулах Зөвлөлийг Засгийн газар байгуулж, зөвлөлийн дүрэм, үйл ажиллагааны журмыг Засгийн газар баталж, 2013 оноос эхлэн Биржийн Зохицуулах зөвлөл, зөвлөлийн ажлын албыг байгуулан ажилласан боловч 2016 онд үйл ажиллагаа нь зогссон байна. Зөвлөл нь чухал үүрэгтэй бөгөөд тайлангаа Засгийн газарт шууд тайлагнадаг байгууллага юм. Зөвлөлийн гол үүрэг нь төрийн бодлого болон хуулийн хэрэгжилтийг хангах, цаг үеийн тулгамдсан асуудлыг шуурхай шийдвэрлэх, биржийн үйл ажиллагаанд оролцогч төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод, арилжаанд оролцогчдын үйл ажиллаагааг уялдуулах, үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх, биржийн үйл ажиллагааг зохицуулах, биржийн бодлогыг тодорхойлох, дүрэм, журам, стандартыг батлах бөгөөд эдгээр ажлууд 2017 оноос хойш орхигдсон байна.

2017 онд төрийн захиргааны байгууллагуудын төлөөллөөс бүрдсэн биржийн удирдах зөвлөлийг Хүнс, хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн яамнаас байгуулсан бөгөөд өнгөрсөн хугацаанд 2-3 удаа л уулзалт зохион байгуулсан байна. Биржээр арилжих бараа, түүхий эдийн гарал үүсэл, чанарыг баталгаажуулах, биржийн хуулийн хэрэгжилтийг хангуулах үүрэгтэй байгууллагын үйл ажиллагаа зогссоноор биржийн хуулийн хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих чиг үүрэг суларсан. Биржийн арилжаанд оролцогч төрийн хяналтын байгууллагууд, төрийн болон хувийн хэвшлийн үйлчилгээний байгууллагууд, төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоо, хоршоод, малчид, тариаланчид, үйлдвэрүүд, брокеруудын үйл ажиллаагааг уян хатан байдлаар зохицуулах, тэдгээрийн үүрэг, оролцоог тодорхой болгох, идэвхжүүлэхэд зохион байгуулалт, менежментийн арга хэмжээ авч хэрэгжүүлэх, агуулах, тээвэр, лабораторийн уялдааг хангах нь чухал байдаг. Мөн биржийн биржийн дэд бүтцийг бий болгоход төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг сайжруулах томоохон асуудал тулгарсан. Эдгээр шийдвэрлэх чухал үүрэгтэй байгууллага бол зохицуулах зөвлөл юм.

Биржийн үйл ажиллагааг оновчтой удирдах, шийдвэр гаргах процессийг сайжруулах зорилгоор биржийн удирдах зөвлөлд мэргэжлийн холбоо, хоршоо, үйлдвэр, брокер, төрийн байгууллагын төлөөллийг түлхүү оролцуулах шаардлагатай байна. Бирж нь хөрөнгө оруулалт, технологи, мэргэжлийн хүний нөөц дутагдалтай хэвээр байна. Яам нь мөшгих систем, татварын цахим бүртгэл болон урамшуулал татаастай холбоотой бодлогыг боловсруулж, хэрэгжүүлж байгаа бөгөөд эдгээр бодлоготой уялдуулан биржийн арилжааны үйл ажиллагааг боловсронгуй болгох хэрэгтэй байна.

Санхүүгийн зохицуулах хорооноос арилжааны төлбөр, шаардлага өндөр байна гэсэн гомдол байна. Зөвхөн засварын худалдаачид нь Санхүүгийн зохицуулах хорооноос тавьсан энэ шаардлагыг хангаж байна.

2013-2020 онуудад хөдөө аж ахуйн биржийн бүтэц, зохион байгуулалт 4 удаа өөрчлөгдсөн. Бирж нь 2013 онд Захиргаа, Худалдаа, Төлбөр тооцоо, Гишүүнчлэл, Логистик, Бараа, Мэдээлэл, Хяналт гэсэн 7 хэлтсийн нийт 35 ажилтантайгаар ажиллаж эхэлсэн. Бүтэц өөрчлөгдөхөд хэлтсийн тоо буурч, менежер, ажилчдын тоо нэмэгдсэн байна. Ажиллагсдын тоо нэмэгдэхээр үйлчилгээний тоо, чанар, хүртээмж нэмэгдэж, биржээс үзүүлж буй үйлчилгээ сайжирах ёстой. Гэвч бодит нөхцөл байдалд үйлчилгээ муу байна. Бирж нь 2021 онд захирал, 2 дэд захирал, 5 хэлтсийн нийт 43 ажилтантай үйл ажиллагаа явуулж байна. Мэдээллийн технологи, дотоод хяналт, хяналт хариуцсан хэлтэс гэж байхгүй байна. Мөн хүний нөөцийн тогтвортой бодлогыг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

## C/. Хөдөө аж ахуйн биржийн тогтолцоо, арилжаа, арилжаанд оролцогчид, бүтээгдэхүүн, үйлчилгээ

**Түүхий эд бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоо:** Хөдөө аж ахуйн бараа, түүхий эдийн бирж байгуулагдахаас өмнө түүхий эд бэлтгэл, нийлүүлэлтийн тогтолцоо зохицуулалтгүй, бэлтгэлийн стандартыг мөрдөхгүй, түүхий эдийн чанарын стандарт алдагдсан байдалтай байсан, одоо ч хэвээрээ байна.

**Диаграмм 10.** Бирж байгуулагдахаас өмнөх бэлтгэн, нийлүүлэлтийн процесс




**Бэлтгэл:** Бэлтгэлийн процесс байхгүй, түүхий эдийн бэлтгэл хийхгүйгээр шууд арилжиж байгаа нь түүхий эд чанар, бэлтгэлийн стандартад нөлөөлж байна.

**Нийлүүлэлт:** Нийлүүлэлтийн эмх цэгцгүй, хяналт сул, дотоодын үйлдвэрүүд өрсөлдөж түүхий эдээ авдаг.

Судалгаагаар жилд бэлтгэсэн нийт түүхий эдийн 20 хувь нь малчдын хоршоогоор, 80 хувь нь дундын зуучлагчдаар дамжин борлуулагдаж байна. Үйлдвэрүүдийн хувьд Хөгжлийн банк, Арилжааны банк болон бусад эх үүсвэрээс түүхий эдийн бэлтгэлд зориулсан эргэлтийн хөрөнгийн зээл авч, бэлтгэл, чанарын шаардлага тавьж малчид, хоршоодоос түүхий эдийг худалдан авч байна. Малчдын хувьд бэлтгэл, чанарын шаардлага тавихгүй, харьцангуй өндөр үнээр шууд худалдан авч байгаа дотоодын завсрын худалдаачид болон гадаадын худалдан авагчдад нийлүүлж байна. Худалдааны энэ тогтолцооны үр дүнд түүхий эдийн нийлүүлэлт нэмэгдсэн хэдий ч түүний чанар ихээхэн муудсан байна. Малчдын дийлэнх нь гэрийн хотоны гаднаасаа ноолуур, бусад түүхий эдээ дундын зуучлагч нарт шууд арилжаалж байна.

**Диаграмм 11. Биржийн худалдааны процесс**



Монгол Улсад 2011 онд Хөдөө аж ахуйн бараа, түүхий эдийн тухай хууль батлагдсанаар Хөдөө аж ахуйн бирж байгуулагдах үндэс тавигдсан. Хөдөө аж ахуйн бирж нь биржээс тогтоосон бэлтгэлийн стандарт, гарал үүсэл, чанарын шаардлага хангасан хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн арилжааг нээлттэй, ил тодоор зохион байгуулах зорилгоор байгуулагдсан. Биржээр арилжаалсан бараа, түүхий эдийн дийлэнх нь ноолуур эзэлж байна. Биржээр арилжаалах ноолуурын хувьд ХААБ-ээс чанарын тодорхой шаардлага тавьж байгаа хэдий ч түүхий эд бэлтгэл, ялангуяа анхан шатны бэлтгэл, тордолтын ажилд хяналт тавьж чадахгүй байна. Ноолуурын түүхий эд бэлтгэл, нийлүүлэлтийн процессын зэрэгцээгээр чанар, баталгаа, аюулгүй байдлын хяналтын урсгал, мэдээллийн урсгал, барааны урсгал, мөнгөний урсгал явагддаг. Хөдөө аж ахуйн бирж байгуулагдахаас өмнө малчдын хотоноос үйлдвэрлэгч хүртэл 4-5 шат дамжлагатай байдаг байсан бол бирж байгуулагдсанаар энэхүү шат дамжлагыг бууруулах, малчин хоршоогоор дамжин шууд арилжаалдаг байх тогтолцоог бүрдүүлэхэд чиглэн ажиллаж байгаа ч дорвитой үр дүн гарахгүй байна. Үүнд орон нутагт агуулахын аж ахуй, чанарын баталгаажуулалтын лаборатори, даатгал, банк, тээврийн цогц үйлчилгээ үзүүлдэг дэд бүтэц, экосистем байхгүйтэй холбоотой байна.

**Арилжаанд оролцогчид:** Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас бараа, түүхий эдийг кодлох журам болон биржээр арилжаалагдах бараа, түүхий эдийн жагсаалтыг баталсан. Хөдөө аж ахуйн бирж нь брокер, хоршоо гэсэн арилжааны хоёр оролцогчтой байна. Анхан шатны бэлтгэлийн тордолт, ангилалт, ялгалт хийсэн чанартай түүхий эдийг бэлтгэн брокер болон хоршоод нь биржийн арилжаанд оруулах үүрэгтэй. Хөдөө аж ахуйн бараа, түүхий эдийн биржийн тухай хуулиар биржийн арилжаанд оролцогчийг байнгын буюу брокер, байнгын бус буюу хоршоо гэж ангилсан. Биржийн брокер нь үндэсний эсвэл үндэсний хөрөнгө оруулалт давамгайлсан хуулийн этгээд байхаар зохицуулалт хийгдсэн. Биржийн брокер нь биржид суудлын эрх авч, Санхүүгийн зохицуулах хорооноос арилжааны тусгай зөвшөөрөл авч оролцдог. Харин хоршоо нь биржээс зөвшөөрөл авч, нэг удаагийн төлбөр өгч оролцдог. Санхүүгийн зохицуулах хорооноос тавьсан мэргэжлийн болон санхүүгийн шаардлагыг хангах аж ахуйн нэгж, хоршоод байгаагүй, харин тухайн үеийн ченжүүд энэ шаардлага, нөхцлийг хангаж, брокерийн үйл ажиллагаа явуулж байна.

Бирж байгуулагдахаас өмнө ченжүүд нь гадаадын худалдаачдын мөнгөөр хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийг худалдан авч, хууль бусаар экспортлодог байсан бол одоо албажиж, биржээс шаардсан төлбөр, хураамжийг төлж, экспортлодог болсон байна. Энэ хугацаанд түүхий эд бэлтгэлийн тогтолцоонд өөрчлөлт гараагүй, мөн биржийн тухай хууль болон төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого, хөтөлбөрт тусгагдсан зорилго хангагдаагүй хэвээр байна. 2012 оны байдлаар Хөдөө аж ахуйн биржид бүртгэлтэй нийт 36 байнгын гишүүн оролцогч буюу брокеруудтай байсан. Эдгээр брокеруудын 16 нь Улаанбаатар, бусад нь орон нутгийн брокерууд байсан. Гэхдээ Сэлэнгэ, Архангай, Сүхбаатар, Дорноговь, Говьсүмбэр, Орхон аймгуудад бүртгэлтэй брокерын компани байгаагүй хэдий ч ихэнх аймгуудад брокерын пүүсүүдтэй байсан. 2013-2021 оны хугацаанд биржтэй гэрээ хийсэн 20 тооны брокерууд байгаагаас 6 брокерийг пүүсүүд нь идэвхтэй арилжаа хийсээр иржээ. Үүнд Ханбүргэд Хэнтий, Хаан Тэлмэн, Цэц-Инвест, Алтаншагай импекс, Бадархундага Оргил, Роял Кашимер зэрэг брокерууд болно. Эдгээр 6 брокерийн 4 нь Улаанбаатар хотод, 2 нь Завхан, Хэнтий аймагт үйл ажиллагаа явуулж байна. Харин биржийн бус гишүүн болох хоршоодын хувьд 2018 онд 3, 2019 оны хувьд 2 хоршоо биржтэй гэрээ байгуулж, биржээс зөвшөөрөл авч арилжаанд оролцож байжээ. Хоршооны оролцоо сул байна.

**График 4.**Арилжаанд оролцсон брокерын тоо




Хэрэв гадаадын иргэн, хуулийн этгээд биржийн арилжаанд оролцохдоо биржийн байнгын гишүүн оролцогчоор дамжиж оролцдог. Харин биржийн байнгын бус гишүүн буюу хоршоодын оролцоо ихээхэн чухал байна. Хоршоод нь арилжаанд оролцох хүсэлтийг гаргаж, ХААБ -ээс зөвшөөрөл авсаны үндсэн дээр арилжаанд оролцох боломжтой.

Өнгөрсөн жилүүдэд хоршоодын хувьд биржийн арилжаанд оролцох хүсэлт удаа дараалан гаргаж байсан ч оролцож чадахгүй байна. Хоршоодын нэгдсэн холбоо болон хоршоодын төлөөлөлтэй уулзахад хоршоод бэлтгэсэн бараа, түүхий эдээ биржээр арилжих оролдлого олон удаа хийж байсан ч дундаас нь брокерууд оролцож, түүхий эдийг нь шууд худалдан авдаг байжээ. Биржийн арилжаанд хоршоо болон брокерууд арилжаанд ил тод, тэгш, шударга оролцох зохицуулалттай хэдий ч хуулийн хэрэгжилт хангагдахгүй байна. Хөдөө орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа брокер болон хоршооны биржийн арилжаанд оролцох идэвхтэй оролцоо маш сул байна. Хоршоодын хувьд бүх аймаг, сумдад тодорхой хэмжээгээр малчид, малчдын бүлгэмийг хамруулсан гишүүдтэйгээр хөдөө аж ахуйн бараа, түүхий эд арилжаалж байгаа ч биржийн арилжаанд идэвхтэй оролцож чадахгүй байна.

**Биржийн арилжааны хэлбэр, төрөл:** Биржийн арилжааг танхимийн болон цахим хэлбэрээр зохион байгуулж байна. Хөдөө орон нутгийн малчид, тариаланчид нь биржээс зөвшөөрөл авсан хоршооны цахим сүлжээгээр дамжуулан биржийн арилжаанд шууд оролцох боломжтой хэдий ч цөөн тооны брокерууд хөдөө, орон нутгийн малчид, иргэд, хоршоодын түүхий эдийг худалдан авч, арилжаа хийсэн гэж бүртгүүлэн гадаадын худалдаачид болон дотоодын үйлдвэрүүдэд нийлүүлж байна.

Биржийн арилжааны журмын дагуу захиалгын төрлийг зах зээлийн, нөхцөлт, кросс болон зах зээл үүсгэгч гэж ангилж байна. Кросс захиалга гэдэг нь биржийн арилжаанд оролцогч талууд урьдаас хэлэлцэн тохиролцсон арилжааг хэлнэ. Кросс захиалгаар хийгдэх хэлцлийн үнийг арилжааны системийн бүртгэлээр орлуулах боловч үнэ тогтооход оруулахгүй, зөвхөн арилжааны мэдээнд оруулах журмын дагуу арилжаа хийгдэж байна. Хэдийгээр арилжааны журамд кросс захиалгын нөхцөлтэй спот арилжаа хийхээр зохицуулсан байгаа ч энэ нь биржийн хууль, дүрэм, журамд заасан нээлттэй арилжаа хийх гэсэн заалтыг зөрчиж байна. Мөн биржийн арилжаанд оролцохыг хүсч байгаа оролцогчдод нээлттэй, ил тод байж чадахгүй, мөн бодит үнэ бүрдүүлэх нөхцөл хангагдахгүй, зөвхөн арилжааг бүртгэж байна. Энэ нь биржийн нэр хүндийг унагах, биржид итгэл итгэл сулрах нөхцлийг бүрдүүлж байна.

**Хүснэгт 19.** Хөдөө аж ахуйн биржийн арилжааны өнөөгийн байдал

| # | Нөхцөл байдал |
|---|---|
| **Арилжааны төрөл** | 2013-2020 оны хугацаанд 1339 удаагийн арилжаа бүртгэгдсэн бөгөөд дийлэнх нь кросс захиалгын нөхцөлтэй спот арилжаа хийгдсэн байна. |
| **Арилжааны хэлбэр** | Цахим болон танхимийн арилжаа хийж байна. Зах зээлд оролцогчдын тоо болон бүтээгдэхүүний төрөл цөөн байна. |

Арилжааг зохион байгуулахад арилжаа хөтлөгч, хяналтын мэргэжилтэн, арилжааны албаны мэргэжилтэн, технологийн мэргэжилтэн болон биржийн арилжаанд оролцогчид биржийн арилжааны журамд заасан дэг, журмын дагуу оролцож байна. Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуульд нь дараах арилжааны төрлүүдтэй байхаар тусгасан. Үүнд:

**Хүснэгт 20.** Арилжааны төрөл

| | Арилжааны төрөл | Тодорхойлолт |
|---|---|---|
| 1 | Шууд арилжих буюу спот арилжаа | Бараа, түүхий эдийг тогтоосон үнээр шууд, биет байдлаар нийлүүлэх гэрээ |
| 2 | Хугацаат гэрээ буюу форвард арилжаа | Бараа, түүхий эдийг тогтоосон хугацаанд, тохиролцсон нөхцөлөөр, биет байдлаар ирээдүйд нийлүүлэх болон төлбөр гүйцэтгэх хугацаат гэрээ |
| 3 | Нэг загварын гэрээ буюу фьючерсийн арилжаа | Бараа, түүхий эдийг тогтоосон хугацаанд, тохиролцсон үнээр, ирээдүйд нийлүүлэх стандарт нөхцөл бүхий нэг загварын гэрээ |
| 4 | Ирээдүйн худалдах, худалдан авах гэрээ буюу опционы арилжаа | Ирээдүйд бараа, түүхий эдийг худалдах, худалдан авахаар тохиролцох, худалдагчийн үүргийн гэрээ |

Биржийн арилжааны дийлэнх нь бэлэн бүтээгдэхүүний буюу спот хийгдэж байна. Биржээр арилжих бүр төрлийн гэрээнд чанар, тоо хэмжээ, үнэ болон хүргэлт гэсэн 4 зүйл заавал тусгаж оруулдаг бөгөөд эдгээрийн биелэлтийг хангах нь хамгийн чухал байдаг. Бэлэн бараа бүтээгдэхүүний арилжаа хийж байгаа тохиолдолд дараах нөхцөлөөр арилжаа хийдэг. Үүнд:

**Хүснэгт 21.** Хууль, журмын хэрэгжилт

| Үзүүлэлт | Хууль, журамд зааснаар | Одоогийн хэрэгжилтийн байдал |
|---|---|---|
| **Чанар** | Биржээр арилжих эдгээр барааг брокер болон хоршоо нь үндэсний стандартын дагуу анхан шатны тордолт хийж, сумын хөдөө аж ахуйн тасгийн мэдээллийн санд бүртгүүлж, мал эмнэлгийн болон лабораторийн магадлан шинжилгээний гэрчилгээ олгож, баталгаажуулснаар биржээр арилжаалах | Биржээр арилжих бараанд чанарын хяналт хийгдэхгүй байна. Зөвхөн сумын мал эмнэлэг, үржлийн газрын мэргэжилтэн тодорхойлолт өгч байна. Энэ нь малын эрүүл мэнд талаасаа тодорхойлж байгаа болохоос түүхий эдийн ангилалт, ялгалт, чанарын талаар баталгаа болж чадахгүй байна. |
| **Тоо хэмжээ** | Брокер болон хоршооны агуулахад барааг хүлээн авч жинлэж, тоо хэмжээг баталгаажуулах | Хөдөө орон нутагт брокерууд идэвхтэй ажиллахгүй байна. Брокерууд УБ хотод байрлах өөрсдийн итгэмжлэгдсэн агуулахад түүхий эдээ байршуулж, арилжаанд оруулж байна. |
| **Үнэ** | Биржээс баталгаажуулсан чанар, эрэлт, нийлүүлэлтээс хамааран үнэ бүрдэнэ. | Биржийн зүгээс хаалттай нөхцлөөр урьдчилж тохирсон үнээр бүртгэл хийж байна. |
| **Хүргэлт** | Гэрээнд тээвэр ложистик, хүргэлтийг тусгаж өгсөн | Брокерууд өөрсдийн тээврээр хүргэлтийг гүйцэтгэж байна. |
| **Итгэлцэл** | Лабораториор баталгаажуулсан стандарт, чанарын шаардлагыг хангасан арилжаа хийхээр зорьж байна | Чанарын баталгааг хангасан анхан шатны тордолт, бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоо бүрдээгүй, төлбөр хураамж өндөр, үйлчилгээ үзүүлэхгүй байгаа учраас биржид итгэх итгэл сул байна. |

Хөдөө аж ахуйн бирж нь форвард арилжаа хийхээр судалгаа хийж, 2017 онд баталсан Биржийн стратеги төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэхээр төлөвлөсөн болович одоогоор форвард арилжаа хийгдээгүй байна.

**Биржээр арилжих бүтээгдэхүүн:**Хөдөө аж ахуйн бирж нь 2013  оны 4 дүгээр сарын 8-ны өдрөөс 2020 оны 12 дугаар сарын 25-ныг хүртэлх хугацаанд нийт 4.3 их наяд төгрөгийн дүнтэй 1339  арилжааг хийсэн . Жилд дундажаар 528 тэрбум төгрөгийн арилжааны бүртгэл хийжээ. Мөн хугацаанд биржээр нийт 14 нэр төрлийн хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эд арилжаа хийхээр туршиж үзсэн бөгөөд ямааны ноолуур, хонины ноос, тэмээний ноос зэрэг нь биржээр арилжаалсан бна. 2013-2020 онд нийт 52.4 мянган тонн ноолуур, 72.2 мянган тонн хонины ноос, 16.5 мянган тонн тэмээний ноосны арилжаа хийгдсэн нь биржийн нийт арилжааны дүнгийн 93.8 хувийг эзэлж байна.

**График 5.**Арилжааны бүртгэлийн дүн, тэрбум.төг




**Ноолуурын арилжаа:** Биржээр арилжих барааны жагсаалтад ноолуур, ямааны завод ноос багтсан. 2013-2020 оны хугацаанд 71.1 мянган төгрөгийн жигнэсэн дундаж үнэтэй 52.4 мян.тн ноолуур, 18.7 мянган төгрөгийн дундаж жигнэсэн үнэтэй 12.7 мян.тн ямааны завод ноосны арилжаа хийжээ. Нийт арилжааны дүнгийн 94.5 хувийг ноолуур, ямааны завод ноос, үүний дотор 89.3 хувийг ноолуур, 5.2 хувийг ямааны завод ноос эзэлжээ. Жилд дундажаар 7.0 мянган тонн буюу 484.2 тэрбум төгрөгийн ноолуур арилжсан дүнтэй байна.

**График 6.** Биржээр арилжаалсан ноолуурын нийт арилжааны дүн, тэрбум.төг




Графикаас үзэхэд биржээр арилжаалсан ноолуурын үнэ болон тоо хэмжээ урвуу хамааралтай байгаа нь харагдаж байна. Өөрөөр хэлбэл ноолуурын үнэ буурснаар биржээр арилжих ноолуурын тоо хэмжээ өсч, буурснаар өсч байна.

**График 7.** Биржээр арилжааны ноолуурын үнэ, тоо хэмжээний уялдаа




Монгол улс 2013 онд 7.0 мянган тонн ноолуур бэлтгэснээс 91 хувь буюу 6.4 мянган тонн ноолуурыг ХААБ-ээр арилжаалсан байна. Жил бүр ноолуурын нөөцийн хэмжээ өсөж байгаа хэдий ч биржээр арилжих ноолуурын хувь хэмжээ буурч байна. 2020 онд ноолуурын дэлхийн зах зээлийн

үнэ буурсан, Ковидын хямрал, мөн төрөөс ноолуурын урамшуулал олгосонтой холбоотойгоор биржээр арилжих ноолуурын хэмжээ өссөн байх хандлагатай байна. Экспортлосон ноолуур 2013 онд биржээр арилжаалсан ноолуурын 64 хувийг эзэлж байснаа 2020 онд 91 хувьд хүртэл өсчээ.

**Хүснэгт 22.** Биржээр арилжаалсан ноолуур, мянган тонн

| | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2017 | 2018 | 2019 | 2020 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Ноолуурын нөөц, мян.тн | 7.0 | 7.7 | 8.9 | 9.4 | 10.2 | 10.9 | 10.9 | 11.8 |
| Биржээр арилжсан нийт ноолуур, мян.тн | 6.4 | 6.3 | 7.0 | 7.2 | 6.9 | 5.9 | 5.9 | 6.9 |
| Биржээр арилжсан ноолуурын нийт нөөцөд эзлэх хувь | 91% | 82% | 79% | 76% | 67% | 54% | 53% | 59% |
| Экспортлосон ноолуурын биржээр арилсан ноолуурт эзлэх хувь | 64 | 64 | 71 | 75 | 79 | 90 | 97 | 91 |

Эх сурвалж: ХААБ

**Ноосны арилжаа:** Биржээр арилжих барааны жагсаалтад хонины ноос, тэмээний ноос, тэмээний завод ноос, хонины завод ноос, сарлагийн завод ноос багтдаг. 2016 онд сарлагийн завод ноос нэг удаа, тэмээний болон хонины завод ноос 2014, 2015, 2018 болон 2019 онд арилжаалсан бүртгэлтэй байна. 2013-2020 оны хугацаанд 2.0 мянган төгрөгийн жигнэсэн дундаж үнэтэй нийт 72.2 мянган тонн буюу 160.5 тэрбум төгрөгийн хонины ноос, 7.7 мянган төгрөгийн дундаж жигнэсэн үнэтэй 16.5 мянган тонн буюу 34.8 тэрбум төгрөгийн тэмээний ноосны арилжаа хийжээ. Нийт арилжааны дүнгийн 4.5 хувийг хонины болон тэмээний ноос эзэлж байна. Жилд дундажаар 9.0 мянган тонн хонины ноос, 2.0 мянган тонн тэмээний ноосны арилжаа хийсэн байна. Нийт үнийн дүнгээр авч үзвэл ноосны арилжаа сүүлийн 2 жилийг үл харгалзвал жил бүр өсөлттэй байсан. 2018 онд килограмм бүр нь 4 мянган төгрөгийн үнэтэй нийт 13.8 мян.тн буюу 56 тэрбум төгрөгийн хонины ноосны арилжижээ.

**График 8.** Биржээр арилжаалсан ноосны дүн, тэрбум.төг




2013-2020 онд биржээр арилжсан хонины ноосны үнэ жилд дундажаар 3.8 хувь, арилжаалсан ноосны хэмжээ 26.2 хувиар өссөн байна. График 5-аас харахад биржээр арилжаалсан ноосны үнэ болон тоо хэмжээ эерэг хамааралтай байна. Энэ нь хонины ноос нь овор ихтэй, тээврийн зардал өндөр учраас хонины ноосны үнэ өсөхөөр үйлдвэрүүдэд нийлүүлэх ноосны хэмжээ өсдөгтэй холбоотой байна. Хонины ноосны жигнэсэн дундаж үнэ нь 2013 онд 1470 төгрөг байснаа 2018 онд 4063 төгрөг хүртэл өссөн хэдий ч сүүлийн 2 жилд 1910-1950 төгрөгөөр арилжаалагдаж байна.

**График 9.** Биржээр арилжааны хонины ноосны үнэ, тоо хэмжээний уялдаа




2013 онд 20.2 мянган тонн хонины ноос бэлтгэснээс 5 хувь буюу 1.0 мян.тн нь ХААБ-ээр арилжаалсан байна. Биржээр арилжаалсан хонины ноосны нийт нөөцөд эзлэх хувь 2013 онд 5 хувь байснаа 2014-2018 онуудад 35-59 хувьд хүрсэн байна. Сүүлийн 2 жилд энэ түвшин 14-22 хувь байна.

**Хүснэгт 23.** Биржээр арилжаалсан хонины ноос, мянган тонн

| | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2017 | 2018 | 2019 | 2020 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Биржээр арилжаалсан ноос, мян.тн | 1.0 | 7.8 | 10.2 | 16.2 | 10.9 | 13.8 | 7.3 | 5.1 |
| Биржээр арилжсан ноосны нийт нөөцөд эзлэх хувь | 5% | 35% | 39% | 59% | 36% | 42% | 22% | 14% |

Эх сурвалж: ХААБ

**Мах, сүү, улаан буудайн арилжаа:** Хөдөө аж ахуйн биржээр арилжих жагсаалтад амьд мал, малын мах арилжаалах боломжтой. 2014 онд 12 толгой амьд хонийг нэгж бүрийг 83.5 мянган төгрөгөөр нийт 1.0 сая төгрөгийн арилжаа хийсэн байна. 2013-2020 онд 1 удаа л амьд мал арилжаалсан бөгөөд бусад үед амьд мал, мах арилжаалаагүй байна. Хөдөө аж ахуйн биржээр сүү, сүүн бүтээгдэхүүн арилжаагүй байна. Хөдөө аж ахуйн бирж нь 2015 онд 1 удаа буудайн арилжаа хийж байжээ. Нэг тонн бүрийг 553.7 мянган төгрөгөөр 1.56 мянган тонн улаан буудай арилжаалжээ. Улаанбуудайн нийт арилжааны дүн 2015 онд 872.6 сая төгрөг байжээ. 2021 онд улаан буудайг биржээр дахин арилжаалахаар бэлтгэл ажил хийгдэж байна.

Цаашид биржээр арилжих бүтээгдэхүүний тоо хэмжээ, нэр төрлийг нэмэгдүүлэх, арилжих барааны чанар баталгаа өгөх тулгамдсан зорилт болж байна.

**Биржээс үзүүлэх үйлчилгээ:**Бирж нь зах зээлийн мэдээ, мэдээллээр оролцогчдыг хангах, биржийн үйл ажиллагаа, дэвшилтэд арга хэмжээний талаар сургалтыг зохион байгуулах, стандартын шаардлага хангасан агуулах, тээвэр, лабораторийг магадлан итгэмжлэх чиг үүргийг гүйцэтгэх зэрэг үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй. Бирж нь сайн үйлчилгээ үзүүлснээр бирж удаан хугацаанд оршин тогтнож, сайн ажиллах боломжтой байдаг. Хөгжиж буй орнуудад оролцогчдыг татах, сайн зохион байгуулалттай худалдааг идэвхжүүлэх сайн үйлчилгээ үзүүлж, үйл ажиллагаа явуулж чадаагүйн улмаас олон тооны биржүүд хаагдсан жишээнүүд их байна. Биржээр арилжих бараа, түүхий эдийн чанарт баталгаа өгөх, бэлтгэн нийлүүлэлтийн үйл ажиллагааг хөнгөвчлөх, биржийн экосистем (агуулах, лаборатори, тээвэр, банк, даатгал, цахим татварын систем, мөшгих зэрэг төрийн үйлчилгээ)-ийг бүрдүүлэх замаар биржийн арилжаанд оролцогчдын тоог нэмэгдүүлж ажилладаг.

Биржийн тухай хуульд зааснаар бирж нь 11 чиглэлээр үйл ажиллагаа явуулна. Эдгээрээс арилжаатай холбоотой 7 үйл ажиллагаа, үүнд биржийн арилжаа зохион байгуулах, биржийн арилжаанд оролцогчдод зөвшөөрөл олгох, биржийн лаборатори, тээвэр болон агуулахад итгэмжлэл олгох, гэрээний арилжааны эрсдлийг бууран, стандарт гэрээний доод хэмжээг тогтоох зэрэг багтаж байна.  Харин биржээс үзүүлэх үйлчилгээтэй холбоотой 4 үйл ажиллагаанд биржээр арилжигдсан бараа экспортлох бол тодорхойлолт гаргах, сургалт явуулах, мэдээ, мэдээллээр хангах, барааны чанар магадлагаа гаргах зэрэг багтаж байна. Хэрэгжилтийн хувьд хөдөө аж ахуйн биржээс арилжааны болон итгэмжлэлийн журам, итгэмжлэл олгох байгууллагуудад тавих шаардлагыг баталж, хэрэгжүүлж байна. Хөдөө аж ахуйн биржийн хуулийн 4.5-д биржээр арилжих жагсаалтад орсон бараа, түүхий эдийг экспортлох бол биржээр арилжаалсан байх гэдэг заалттай.

Энэ заалтын хүрээнд экспортлох бараа, түүхий эдэд биржээр арилжаалсан тодорхойлолтыг өгч байна. Бирж байгуулах бэлтгэлийн хугацаанд олон тооны сургалтууд явуулж, биржийн арилжааны талаар мэдээлэл олон нийтэд хүргэж ажилласан боловч сүүлийн жилүүдэд сургалт болон мэдээллээр хангах үйлчилгээ суларсан, барааны чанарт магадлагаа өгөх үйлчилгээ огт явагдаагүй байна. Олон улсын биржийн туршлагаас харахад биржийн оролцогчдод гадаад худалдан авагчдыг татан оролцуулах, холбох үйлчилгээ үзүүлж, биржийн үйл ажиллагааг идэвхжүүлэх маркетингийн арга хэмжээ авдаг. Хөдөө аж ахуйн биржийн хууль, дүрэм, журамд нь энэ төрлийн үйлчилгээний талаар тусгаагүй байна.

Биржийн хуульд экспортлох бараа, түүхий эдэд биржээр арилжаалсан тодорхойлолтыг өгөх, биржийн оролцогчдод сургалт явуулах, биржийн арилжааны талаар мэдээлэл, сурталчилгаа явуулах зэрэг  ажлууд хийгдэж байгаа ч өргөн цар хүрээтэй ажиллаж, зорилтод хэрэглэгчдэд хүрч чадахгүй байна. Биржээр арилжаалсан бараа, бүтээгдэхүүн экспортлох тохиолдолд экспортлогчид нь биржийн брокероор дамжуулан биржид арилжааны шимтгэл төлж, тодорхойлолт авч байна. Бирж нь нэг талдаа арилжааны шимтгэлийн орлого олж байгаа хэдий ч нөгөө талдаа биржийн арилжаанд оролцогчид болох брокерууд, үйлдвэрүүд, малчдад хүрсэн чанартай үйлчилгээ үзүүлж чадахгүй байгаа нь тэдний бухимдлыг төрүүлж байна.

Олон улсын биржийн туршлагаас суралцаж, гадаад, дотоодод маркетинг, сурталчилгаа явуулах замаар олон улс, орнуудын худалдан авагчдыг үйл ажиллагаандаа татан оролцуулах, хоршоо, брокер, үйлдвэр, малчдыг холбож, биржийн үйл ажиллагааг идэвхжүүлэх маркетингийн арга хэмжээ авах нь зүйтэй байна. Хамгийн гол үйлчилгээ нь арилжаанд оролцогчдын хүсэлтээр бараа, түүхий эдийн чанар, тоо хэмжээг хянан баталгаажуулж, магадлагаа гаргах үүрэгтэй юм. Одоогийн байдлаар зөвхөн Ноос, ноолуурын холбоонд ноолуур, ноосны чанарт магадлагаа өгөх эрх олгосон. Иймд үйлчилгээгээ сайжруулах шаардлагатай байна. Хөдөө аж ахуйн салбарын малчид, тариаланчид, мэргэжлийн холбоод болон бусад биржийн арилжааны оролцогчдод ХААБ-ийн үйл ажиллагаа, арилжааны талаар таниулах, сурталчилах ажил сул байгаагаас ХААБ-ийн талаарх ойлголт бага, дэмжлэг, хамтын ажиллагаа хангалтгүй байна.

**Биржийн  арилжааны дэд бүтэц, платформ:** 2013-2021 онуудад уламжлалт арилжааны системд суурилан арилжаа хийж байсан. Уламжлалт арилжааны системийн сөрөг тал нь халдлагад өртөх магадлал өндөртэй байжээ. Хөдөө аж ахуйн бирж нь 2019 онд блокчейнд суурилсан арилжаа, төлбөр тооцооны платформыг нэвтрүүлэх зорилгоор 2.0 тэрбум төгрөгийн өртөг бүхий нийт 12 модулиас бүрдсэн программ хангамжийг

нэвтрүүлэх ажил хийгджээ.Системийн хэрэглэгчид нь биржийн ажилчид, брокер болон хоршоо, тэдгээрийн итгэмжлэгдсэн агуулахын мэргэжилтэн байна.

Энэхүү программ хангамжийг биржийн арилжааны оролцогчдыг холбох ажлууд хийгдэж байна. Программын давуу тал нь гадаад халдлагад өртөхгүй, аюулгүй байдал талаасаа хамгаалагдсан байна. 2017-2020 оны стратеги төлөвлөгөөний дагуу 2019 онд түлхүүр гардуулах нөхцөлтэй 1.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй "Ложистикийн төвийн оффис, агуулахын барилгыг Эмээлтэд барих ажлыг, “Түшигт арга констракшн” ХХК-аар хийж гүйцэтгэсэн байна.

Энэхүү ложистик төв нь хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийг бэлтгэх, чанарыг тодорхойлох, тээвэрлэх, хадгалах, даатгах цогц үйл ажиллагаа явуулахаар төлөвлөсөн. Мөн ложистик төвийг барьж байгуулахад нэмэлт зардал орохоо байна. Урьдчилсан байдлаар тооцож үзэхэд ложистикийн төв байгуулахад 2,22 тэрбум төгрөг шаардагдахаар байна. Ложистик төвийн дэргэд банк, санхүү, даатгалын үйл ажиллагаа явуулах байгууллагууд ажиллахаар тооцоолжээ. Биржийн дэд бүтэц, эко-систем одоо хүртэл бүрдээгүй, бирж бүтээгдэхүүнээ орон нутгийн агуулахтай малчдын хоршоодод суурилан бэлтгэх, анхан шатны тордолт хийх, арилжаалах нь чухал байна. Одоогоор итгэмжлэгдсэн лаборатори болон тээврийн байгууллага цөөхөн, өөрийн агуулах байхгүй байна. Итгэмжлэгдсэн агуулахтай болсноор биржийн агуулахын удирдлагын системд бараа, түүхий эдээ бүртгэлжүүлж, арилжаанд оролцох боломж бүрдэнэ.

**Биржийн үйл ажиллагааны жилийн зардал, орлого:** Хөдөө аж ахуйн бирж нь жил бүрийн Хөдөө аж ахуйн биржийн зорилтод түвшинг тодорхойлж, үйл ажиллагааны орлогоо төлөвлөн Төрийн өмчийн хороонд хүргэдэг. Төрийн өмчийн хороо Биржийн засаглалыг сайжруулах, ашигт ажиллагааг нэмэгдүүлэх чиглэлээр хяналт тавин ажиллаж байна. Мөн Татварын ерөнхий газар болон Үндэсний аудитын газраас жил бүрийн санхүүгийн тайланд хяналт тавин ажиллаж байна. Төрөөс биржид 5 тэрбум төгрөгийн төсвийн хөрөнгө оруулалт төлөвлөсөн хэдий ч 1.0 тэрбум төгрөгийг олгож, биржийн ямар үйл ажиллагаа үйл ажиллагаанд голлон зарцуулжээ. 2019 онд Хөдөө аж ахуйн бирж нь 2,098.8 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 5,587.8 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, төлөвлөгөөг 166.2 хувиар давуулан биелүүлж, 3.6 тэрбум төгрөгийн ашигтай гарсан байна. 2019 онд ажиллагсдын цалин, нийгмийн даатгалд нийт 830.0 сая төгрөг зарцуулсан нь нийт зардлын 60 орчим хувийг эзэлсэн байна.

Орлогын төлөвлөгөөний биелэлтэд түүхий эдийн зах зээлийн үнэ ханш өссөн нь нөлөөлжээ. Түүхий эдийн үнэ ханш, биржийн арилжааны шимтгэлийн өөрчлөлтөөс хамааран орлогын хэлбэлзэл тодорхойлогдож байна. Хөдөө аж ахуйн биржийн Төлөөлөн удирдах зөвлөл биржийн байнгын болон байнгын бус оролцогчдын гишүүний хураамж, суудлын төлбөр болон арилжааны шимтгэлийн хэмжээг баталж байна. 2013-2018 онд биржийн оролцогчдоос авах хураамж, арилжааны шимтгэл 6-7 удаа шинэчлэл, нэмэлт, өөрчлөлт хийсэн байна. Энэ нь биржийн үйл ажиллагаа тогтвортой ажиллах, биржийн оролцогчдын идэвх, оролцоог нэмэгдүүлэхэд сөрөг нөлөөлөл үүсгэх магадлал өндөртэй байна. Хөдөө аж ахуйн биржийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан биржийн байнгын болон байнгын бус оролцогчдын гишүүний хураамж, суудлын төлбөр болон арилжааны дараах хураамж, шимтгэлийг шинэчлэн баталсан байна.

**Хүснэгт 24.** Хураамж, шимтгэл

| Төрөл | элсэлтийн хураамж | суудлын хураамж | харилцагчийн дансны хураамж |
|---|---|---|---|
| Байнгын гишүүн оролцогч | 4.5 сая төгрөг | 2.0 сая төгрөг | 1000 төгрөг |
| Байнгын бус гишүүн оролцогч | - | 50,000 төгрөг/нэг удаа | - |
| | Авах тал | | Зарах тал |
| Угаасан ноолуур | 0.8% | | 0.2% |
| Самнасан ноолуур | 0.1% | | 0.1% |
| Тэмээний эм ноос/угаасан/ | 10% | | 0.0% |
| Тэмээний эм ноос/самнасан/ | 0.2% | | 0.0% |

Эх сурвалж: ХААБ

Анх нь бүх бараа, түүхий эдийн арилжааны шимтгэл 0.32 хувьтай байсан. Угаасан ноолуурын экспортыг бууруулах зорилгоор шимтгэлийн хэмжээг 1.0 хувь, тэмээний угаасан эм ноос 10.0 хувь, харин самнасан ноолуурын болон тэмээний ноосны хувьд 0.2 хувь байна. 2021 огы эхний хагас жилийн тайлангаар нийт 4.3 тэрбум төгрөгийн орлого олсноос дийлэнх нь арилжааны шимтгэлийн орлого эзэлж байна. Шимтгэлийн орлогоос гадна байнгын гишүүний хураамжийн орлого, агуулахын итгэмжлэхийн хураамжийн орлого болон ажил, үйлчилгээ үзүүлсний орлогоос бүрдэж байна.

**Хүснэгт 25.** 2021 оны эхний хагас жилийн ХААБ-ийн орлого

| **Орлогын төрөл** | **Дүн, сая төгрөг** |
|---|---|
| Арилжааны шимтгэлийн орлого | 4,327.6 |
| Байнгын гишүүний орлого | 9.1 |
| Ажил, үйлчилгээ үзүүлсний орлого | 3.8 |
| Агуулахын итгэмжлэхийн орлого | 3.3 |
| Нийт орлого | **4,343.8** |

Эх сурвалж: ХААБ

## 5.2. Зах зээлийн шинжилгээ

### 1. Ноолуурын нөөц, үйлдвэрлэл, боломж

**Бодлого, хөтөлбөр:**

1. “Алсын Хараа 2050” урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалд Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн түвшинг нэмэгдүүлж, малын гаралтай бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлнэ. 2020-2030 онд буюу I үе шатанд түүхий эдийн экспортоос нэмүү өртөг шингэсэн боловсруулсан бүтээгдэхүүний экспортлогч орон болохоор зорьсон. Энэ хүрээнд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулалтын түвшинг нэмэгдүүлж, мах, ноос болон ноолууран бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэхээр зорилт тавьсан.

2. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 3.3.6-д 3.3.6.Малчдыг дэмжих анхдугаар аян зохион байгуулж, мал сүргийг гэмт халдлагаас хамгаалж, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрийг бүсчилсэн байдлаар байгуулан нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн экспортолж, малчид, иргэдийн орлогыг нэмэгдүүлнэ, мөн төлөвлөгөөний 3.3.10-т Мал, малын гаралтай түүхий эдийг боловсруулах байгальд ээлтэй цогцолбор

байгуулж, хөдөө аж ахуйн гаралтай бараа, бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэхээр төлөвлөсөн байна.
3. Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ын 2.1.3-т Аж үйлдвэрийг хөгжүүлэх I үе шат (2016-2020 он)-нд “Нийт боловсруулах үйлдвэрлэлийн эзлэх хувийн жинг 15 хувьд хүргэж, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний биржийн сүлжээг боловсронгуй болгож, дэвшилтэт технологид суурилсан экспортын чиглэлийн боловсруулах үйлдвэрлэлийн кластерыг хөгжүүлж, бүтээмжийг нэмэгдүүлэн арьс, шир, ноос, ноолуур зэрэг түүхий эдийн бүрэн боловсруулалтыг 60 хувьд хүргэх” гэж төлөвлөсөн.
4 Монгол Улсын Засгийн газраас 2018 онд “Ноолуур” хөтөлбөрийг шинэчлэн баталсан. Уг хөтөлбөрийн 4.2.4-т Түүхий эдийг хөдөө аж ахуйн биржээр арилжаалахад малчид, үйлдвэрлэгчдийн оролцоог нэмэгдүүлэх арга хэмжээ авах гэж, хөтөлбөрийн 2.2.2-т Ямааны үүлдвэр угсаа болон түүхий эдийн бэлтгэл, ноолуурын чанарыг сайжруулах зэрэг арга хэмжээг авахаар төлөвлөсөн байна.

**Нөөц:** Өнгөрсөн 30 жилийн хугацаанд малын нийт тоо толгой жилд дундажаар 3.4 хувийн өсөлттэй байна. Үүний дотор ямааны сүргийн 30 жилийн дундаж өсөлт 5.8 хувь, 20 жилийн өсөлт 5.1 хувь, сүүлийн 10 жилд 7.2 хувийн өсөлттэйгээр тоо толгой өсчээ. Өөрөөр хэлбэл, ямааны тоон толгойн өсөлт нь нийт малын тоон өсөлтөөс бараг 2 дахин, ялангуяа сүүлийн 10 жилд илүү хурдацтай өссөн нь статистикийн тоо баримтаас харагдаж байна. 1990 онд ямааны сүргийн тоо 5.0 саяд хүрч, сүргийн бүтцийн 20 орчим хувийг эзэлж байснаа 2010 онд 13.9 сая толгойд, 2020 онд 27.7 сая толгойд хүрч, нийт мал сүргийн 41.1 хувийг эзэлж, малын сүргийн бүтцэд ихээхэн өөрчлөлт гарсан байна. Ямаан сүргийн тоон өсөлттэй холбоотойгоор ноолуурын хэмжээ нэмэгдсэн байна. 2020 онд 11.8 мянган тонн ноолуур бэлтгэсэн байна.

**График 10.** Ямааны тоо толгой, ноолуурын хэмжээ




**Нөөцийн байршил:** Хүснэгтэд 2010-2015 оныг 2015-2019 онтой харьцуулан аймаг, бүс бүрээр ноолуурын хэмжээ, аймаг бүсийн эзлэх хувийн жинг харуулав. Хүснэгтээс харахад улсын хэмжээнд 2010-2015 онд жилд дундажаар 6.9 мянган тонн ноолуур үйлдвэрлэж байснаа сүүлийн 5 жилд дундажаар 10.1 мянган тонныг үйлдвэрлэж, дундажаар 44.4 хувиар ноолуурын үйлдвэрлэлийн хэмжээ өссөн байна. 2015-2020 оны дундажаар ноолуурын нөөцийн 33.5 хувийг Хангайн, 29.4 хувийг Баруун бүс, 26.0 хувийг Төв, үлдсэн 10.2 хувийг Зүүн бүсэд тус тус байршиж байна. Аймгийн хэмжээнд Хангайн бүсийн Баянхонгор (10.7%), Өвөрхангай (8.7%), Хөвсгөл (6.4%), Баруун бүсийн Говь-Алтай (8.4%), Ховд (6.3%), Төвийн бүсийн Өмнөговь (8.0%), Дундговь (7.2%), Зүүн бүсийн Сүхбаатар (4.2%), Хэнтий (4.2%) аймгууд ноолуурын нөөцийн дийлэнхийг

бүрдүүлж байна. Эдгээр 9 аймагт нийт ноолуурын үйлдвэрлэлийн 64.1 хувийг бэлтгэж байна.

**Хүснэгт 26.** Ноолуурын нөөцийн байршил

| Аймаг | 2010-2015 | 2015-2019 | Өөрлөлт, % | Нөөцөд эзлэх хувь, 2010-2015 | Нөөцөд эзлэх хувь, 2015-2019 |
|---|---|---|---|---|---|
| **Улсын дүн** | **6984.6** | **10088.8** | **44.4%** | **100.0%** | **100.0%** |
| **Баруун бүс** | **2024.6** | **2962.7** | **46.3%** | **29.0%** | **29.4%** |
| Баян-Өлгий | 272.8 | 368.9 | 35.2% | 3.9% | 3.7% |
| Говь-Алтай | 502.1 | 849.0 | 69.1% | 7.2% | 8.4% |
| Завхан | 418.8 | 586.3 | 40.0% | 6.0% | 5.8% |
| Увс | 391.6 | 523.0 | 33.6% | 5.6% | 5.2% |
| Ховд | 439.4 | 635.5 | 44.6% | 6.3% | 6.3% |
| **Хангайн бүс** | **2391.2** | **3380.1** | **41.4%** | **34.2%** | **33.5%** |
| Архангай | 336.9 | 444.4 | 31.9% | 4.8% | 4.4% |
| Баянхонгор | 725.5 | 1077.7 | 48.5% | 10.4% | 10.7% |
| Булган | 273.2 | 324.1 | 18.7% | 3.9% | 3.2% |
| Өвөрхангай | 542.5 | 878.7 | 62.0% | 7.8% | 8.7% |
| Хөвсгөл | 494.6 | 648.0 | 31.0% | 7.1% | 6.4% |
| Орхон | 18.6 | 11.4 | -38.7% | 0.3% | 0.1% |
| **Төвийн бүс** | **1792.7** | **2624.5** | **46.4%** | **25.7%** | **26.0%** |
| Дорноговь | 289.2 | 395.1 | 36.6% | 4.1% | 3.9% |
| Дундговь | 390.9 | 725.4 | 85.6% | 5.6% | 7.2% |
| Өмнөговь | 510.4 | 807.7 | 58.2% | 7.3% | 8.0% |
| Сэлэнгэ | 151.6 | 156.9 | 3.5% | 2.2% | 1.6% |
| Төв | 375.2 | 479.0 | 27.7% | 5.4% | 4.7% |
| Дархан-Уул | 29.6 | 30.1 | 1.6% | 0.4% | 0.3% |
| Говьсүмбэр | 45.6 | 73.8 | 61.9% | 0.7% | 0.7% |
| **Зүүн бүс** | **741.1** | **1033.2** | **39.4%** | **10.6%** | **10.2%** |
| Дорнод | 125.7 | 185.4 | 47.4% | 1.8% | 1.8% |
| Сүхбаатар | 323.3 | 421.2 | 30.3% | 4.6% | 4.2% |
| Хэнтий | 292.0 | 426.6 | 46.1% | 4.2% | 4.2% |

Эх сурвалж: ҮСХороо, 2020

**Ноолуурын бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоо:** Мал аж ахуйн түүхий эдийн бэлтгэл, нийлүүлэлтийн тогтолцооны хувьд дараах нийтлэг онцлог ажиглаж байна. Үүнд:

- Түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлт нь улирлын шинж чанартай байгаа;
- Гадаадын худалдан авагчид малын гаралтай түүхий эд, ялангуяа ноолуурын үнийг тогтоох хандлагатай байгаа;
- Дотоодын зах зээлд худалдан авах үйлдвэрүүдийн байршил хол, гадаадын худалдан авагчидтай өрсөлдөж түүхий эдээ бэлтгэдэг, нөгөө талдаа үйлдвэрүүдийн санхүүгийн нөөц боломж харьцангуй сул, цөөн тоотой байгаа;
- Олон тооны малчид түүхий эд бэлтгэн зах зээлд нийлүүлж байгаа учраас олон тооны худалдан авагч байх шаардлагатай;
- Худалдан авагчдын хувьд мэргэжлийн бус, малчдын хувьд стандартын дагуу түүхий эд бэлтгэхгүй байгаа хүндрэл байгаа зэрэг болно.

**Ноолуурын салбарын нөхцөл байдлын шинжилгээ:** Ямааны ноолуурын нөөцийн 52 хувийг БНХАУ, 40 хувийг МУ үйлдвэрлэж байна. Ноолуурын гарц, өнгөний хувьд Монгол улс давуу талтай байгаа ч чанарын үзүүлэлт муудсан байна. Ноолуурын чанарыг сайжруулж, гуравдагч зах зээлд шууд арилжаалах нөхцлийг бүрдүүлсэнээр Монгол ноолуурын өрсөлдөх чадвар нэмэгдэж боломжтой байна.

**Хүснэгт 27.** Ноолуурын өрсөлдөх чадварын байдал

| Үзүүлэлт | МОНГОЛ | ХЯТАД |
|---|---|---|
| **Ноолуурын нөөц** | 40 хувь | 52 |
| **Нэг ямааны гарц** | 350 грамм | 250 грамм |
| **Чанар, гол ба урт** | Голч: -16.5 микрон<br>Урт: -42 -аас 45 мм | Голч -15.5 микрон<br>Урт: -36 -аас 38 мм |
| **Өнгө** | Байгалийн 4 төрлийн өнгөтэй байгаа нь өнгө оруулахгүй, органик байдлыг харуулна. | 99 хувь нь цагаан. Цагаан ноолуур нь үнэ өндөртэй ч бусад өнгөд хувиргахын тулд будганд оруулдаг. |
| **Эцсийн бүтээгдэхүүн** | Монголын ноолууран бүтээгдэхүүний нэр хүнд гадаад зах зээл дээр өсч байгаа, Өнгө, дизайн сайжирч байгаа. | 100 хувийн ноолуур биш ч 100 хувь гэсэн шошгоор хэрэглэгчдийг төөрөгдүүлдэг. |

Эх сурвалж: Ноос, ноолуурын холбоо

Ноолууран бүтээгдэхүүн нь уул уурхайн бус экспортын орлогын дийлэнх хэсгийг бүрдүүлдэг. Ноолуурын салбарт тулгарч байгаа гол асуудлын нэг нь түүхий эд бэлтгэлийн тогтолцоог боловсронгуй болгох явдал юм.

**Хүснэгт 17.** Ноолуурын салбарт хийсэн СВОТ шинжилгээ

| ДАВУУ ТАЛ | СУЛ ТАЛ |
|---|---|
| - Ноолуурын 4 төрлийн өнгөтэй учраас, органик байдал сайтай.<br>- 4 төрлийн улиралтай, өндөрлөгт оршдог, өвөл хүйтэн болдог тул дулаан, чанартай байдаг.<br>- Ноолуурын гарц өндөр<br>- Ноолуурын салбарын үйлдвэрүүд тогтвортой удаан ажиллаж, техник технологийн шинэчлэлт хийж, тогтвортой ажиллах хүчинтэй болсон.<br>- Гадаад зах зээл дээр бүтээгдэхүүнээ арилжаалж, идэвхтэй хамтын ажиллагааг хөгжүүлж байна. | - Ноолуурын нөөц бүрдүүлэхийн тулд бэлтгэх, тээвэрлэх зардал өндөр<br>- Дэлхийн хэмжээний загвар, дизайны боловсон хүчин байхгүй, бэлтгэгдэхгүй байгаа<br>- Дэлхийн зах зээлийн ноолуурын нөөцийн томоохон өрсөлдөгч хэдий ч их хэмжээгээр үйлдвэрлэж, өрсөлдөж, үнэд нөлөөлж чадахгүй байна.<br>- Гадаад зах зээлд хүрээгээ тэлэхэд мэдээлэл хомс, туршлага бага |
| **БОЛОМЖ** | **АЮУЛ** |
| - Гадаад зах зээл дээрээс хөрөнгө оруулалт болгох боломжтой<br>- Засгийн газрын дэмжлэг сайн байгаа<br>- Европын Холбооны зах зээл болон Японы зах зээлд бүтээгдэхүүнээ татваргүй борлуулах боломжтой болсон<br>- Хөдөө аж ахуйн биржээр чанартай түүхий эдийг тасралтгүй авах тогтолцоо бүрдвэл өртөг зардал буурах, ноолууран бүтээгдэхүүний үйлдвэрлэлд төрөлжин ажиллах боломжтой | - Цаг агаарын өөрчлөлтөөс ямааны тоо буурах<br>- Төрийн бодлогын тогтворгүй байдлаас шалтгаалан салбарын бодлого алдагдах<br>- Ноолуурын экспортын хувьд нэг орноос ихээхэн хамааралтай, экспортын бүтээгдэхүүний дийлэнх нь хагас боловсруулсан хэлбэрээр арилжаалж байна.<br>- Түүхий эдийн чанар муудаж байгаа<br>- Түүхий эдийн бэлтгэхэд өрсөлдөөн ихтэй, мөн ихээхэн хэмжээний санхүүжилт шаардлагатай бөгөөд арилжааны банкны |

- Монгол ноолуурыг брэнд болгож, экспортын тэргүүлэх бүтээгдэхүүн болгох ажлууд хийгдэж байгаа
- Түүхий эдийн нөөц өсөн нэмэгдэж байгаа

өндөр хүүтэй, богино хугацаатай зээлээр шийдвэрлэж байна.

Эх сурвалж: Ноос, ноолуурын холбоо, судлаач

**Ноолуурын бэлтгэн нийлүүлэлтэд сум, хоршооны оролцоо:** Ноолуурын бэлтгэлийн нөөцийн хэмжээг бүс, аймаг, сум болон малчдаар тооцоолон гаргалаа. Аймаг бүр харилцан адилгүй ямаатай байна. Ямааны тоогоор тэргүүлж байгаа аймгуудад Баянхонгор, Өвөрхангай, Өмнөговь, Говь-Алтай, Хөвсгөл, Дундговь, Хэнтий, Сүхбаатар аймаг багтаж байна. Эдгээр аймгуудад бэлтгэж байгаа ноолуурын бэлтгэлийн нийт хэмжээ нь нийт ноолуурын нөөцийн 59 хувийг эзэлж байна. Нэг суманд бэлтгэх боломжтой ноолуурын хэмжээ улсын дундажаар 33.2 тонн, үүний дотор Хангайн бүсийн 1 суманд 36.4 тонн, Баруун бүсэд 34.2 тонн, Төвийн бүсэд 30.1 тонн, Зүүн бүсэд 27.0 тонн байна. Ноолуур их бэлтгэдэг аймаг, сумдын хувьд нэг малчин өрхийн бэлтгэх ноолуурын хэмжээ дундажаар 70-90 кг байна. Ноолуур бэлтгэх хугацаа, ноолуурын нөөцтэй уялдуулан нэг өдөрт бэлтгэх боломжтой ноолуурын дундаж хэмжээг тооцоолж үзлээ. Сумын хэмжээнд ачаалалтай үед өдөрт 1 тонн ноолуур, дундаж ачаалалтай үед 550 кг ноолуур бэлтгэх боломжтой байна.

Нэг малчин өрх дундажаар **37.8** кг ноолуур бэлтгэх боломжтой байна. Бусад бүстэй харьцуулахад Хангайн бүс нь малчин өрхийн тоо ихтэй учраас малчин өрхөд ногдох ноолуурын хэмжээ бага гарч байна. Баруун бүсийн хувьд малчин өрхийн тоо харьцангуй цөөн, нэг малчин өрхөд ноогдох малын тоо ихтэй байгаа нь статистик тооноос ажиглагдсан. Суманд тогтвортой үйл ажиллагаа явуулж байгаа 1-2 хоршоо байдаг судалгаа байна. Суманд байгаа хоршоодыг нэгтгэн 1 хоршоо байдаг гэж үзэж тооцоолол хийлээ. Хоршоо ачаалалтай үед өдөрт бэлтгэлийн стандартын дагуу 1-4 мянган ямаа самнаж, 500 -1000 кг ноолуур бэлтгэн анхан шатны тордолт хийж, ангилан ялгаж багцлах боломжтой байна. Үүний тулд 1 хоршоонд стандартын дагуу бэлтгэж, ангилж, ялгаж байгаад тогтмол хяналт хийж шаардлага тавих түүхий эд бэлтгэгч шаардлагатай байна. Дундажаар 1-2 сар үргэлжлэх бөгөөд өдөрт 20-50 ямаанаас ноолуур самнах хөлсний ажилтан ажиллуулах хэрэгцээ гарч байна.

**Хүснэгт 28.** Ноолуурын бэлтгэлийн хэмжээ, бүс, аймаг, сумдаар

| | | **Ноолуурын дундаж бэлтгэлийн хэмжээ** | **Нэг өдөр бэлтгэх боломжтой хэмжээ** | **Бэлтгэх хугацаа** |
|---|---|---|---|---|
| **Бүс**, тонноор | Баруун | 3,107.8 | 51.8 | 5-6 сар |
| | Хангай | 3,606.0 | 60.1 | 4-5 ар |
| | Төв | 2,856.1 | 47.6 | 4-5 сар |
| | Зүүн | 1,214.3 | 20.2 | 3-4 сар |
| **Аймаг**, тонноор | Баянхонгор | 1,104.3 | 18.4 | 4-5 сар |
| | Өвөрхангай | 928.9 | 15.5 | 4-5 сар |
| | Өмнөговь | 891.3 | 14.9 | 4-5 сар |
| | Говь-Алтай | 918.3 | 15.3 | 5-6 сар |
| | Хөвсгөл | 754.4 | 12.6 | 4-5 сар |
| | Дундговь | 871.9 | 14.5 | 4-5 сар |
| | Хэнтий | 490.4 | 8.2 | 3-4 сар |
| | Сүхбаатар | 475.5 | 7.9 | 3-4 сар |
| | Хувь | 59.1 % | - | - |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **Сум**, дундаж тонн | Баруун | 34.2 | 0.57 | 5-6 сар |
| | Хангай | 36.4 | 0.61 | 4-5 сар |
| | Төв | 30.1 | 0.50 | 4-5 сар |
| | Зүүн | 27.0 | 0.45 | 33-4 сар |
| | **Улсын дундаж** | **33.2** | **0.55** | - |
| **Малчин өрх**, дундаж, килограмм | Баруун | 43.1 | 43.1 | 5-6 сар |
| | Хангай | 25.6 | 25.6 | 4-5 сар |
| | Төв | 49.1 | 49.1 | 4-5 сар |
| | Зүүн | 33.8 | 33.8 | 3-4 сар |
| | **Улсын дундаж** | **37.8** | **37.8** | - |
| **Малчин өрх**, дундаж, килограмм | Баянхонгор | 47.6 | 47.6 | 4-5 сар |
| | Өвөрхангай | 32.8 | 32.8 | 4-5 сар |
| | Өмнөговь | 87.3 | 87.3 | 4-5 сар |
| | Говь-Алтай | 70.0 | 70.0 | 5-6 сар |
| | Хөвсгөл | 24.1 | 24.1 | 4-5 сар |
| | Дундговь | 69.7 | 69.7 | 4-5 сар |
| | Хэнтий | 40.5 | 40.5 | 3-4 сар |
| | Сүхбаатар | 31.7 | 31.7 | 3-4 сар |
| **Малчин өрхийн тоо,** дундаж | Бүс | 73,752 | 1230 | - |
| | Аймаг | 14,048 | 234 | - |
| | Сум | 842 | 14-26 | - |
| | Самнах ямааны тоо, дундаж | 95 | - | - |
| **Хоршоо бэлтгэх ноолуур** | Дундаж хоршоо, тонн | 37.8 | 500 – 1000 кг | - |
| | Хоршооны гишүүний тоо | 820 -1000 | 7-10 | - |
| | Самнах ямааны тоо | 78.0 -120.0 мянган ямаа | 1 – 4 мянган ямаа | - |
| | Самнах ажилчдын тоо | - | 20-50 хүн | - |

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

## 2. Махны нөөц, үйлдвэрлэл, боломж

**Бодлого, хөтөлбөр:**

1. Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, Гурван тулгуур хөгжлийн бодлого, Алсын Хараа 2050 урт хугацаа хөгжлийн үзэл баримтлал зэрэгт Хүнсний үйлдвэрлэлд дэвшилтэд технологи нэвтрүүлж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, гол нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангаж, иргэдийг эрүүл, баталгаат хүнсээр хангах нөхцлийг бүрдүүлэхээр тусгасан.

2. УИХ-аас баталсан Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн салбарт баримтлах бодлогод хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангасан шим тэжээллэг, баталгаатай хүнсээр хүн амыг тогтвортой хангахаар заасан.

3. Засгийн газраас 2016 онд баталсан Мах, сүүний анхдугаар аяны хүрээнд мах, сүү бэлтгэн нийлүүлэх оновчтой тогтолцоог бүрдүүлэх, мах, сүүний боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх, мах, махан бүтээгдэхүүн, сүү, бүүн бүтээгдэхүүний дотоодын хэрэглээ, экспортыг дэмжих зэрэг бодлого баримтлан хэрэгжүүлж байна.

**Нөөц:** Махны салбарт 2020 онд махны нядалгааны жингээр 744.5 мянган тонн мах үйлдвэрлэсэн байна. Нийт бэлтгэсэн махны 28.7 хувь буюу 213.9 мянган тонн нь хонины мах, 21.3 хувь буюу 158.5 мянган тонн нь үхрийн мах, 17.3 хувь буюу 129.2 мянган тонн нь ямааны мах, үлдсэн нь адуу болон тэмээний мах эзэлж байна. 2019 онтой харьцуулахад махны үйлдвэрлэл 36.6 хувиар өссөн байна.

**Хүснэгт 29.** Махны үйлдвэрлэл, нядалгааны жингээр

| | 2016 | 2017 | 2018 | 2019 | 2020 |
|---|---|---|---|---|---|
| **Мах, нядалгааны жингээр, мянган тонн** | **400.0** | **426.1** | **515.2** | **545.0** | **744.5** |
| **Адууны** | 41.7 | 41.8 | 57.2 | 70.8 | 105.9 |
| **Үхрийн** | 92.4 | 97.7 | 126.6 | 114.7 | 158.5 |
| **Тэмээний** | 6.5 | 7.1 | 9.7 | 12.5 | 17.0 |
| **Хонины** | 116.2 | 126.7 | 152.7 | 168.4 | 213.9 |
| **Ямааны** | 76.9 | 80.8 | 83.6 | 89.6 | 129.2 |

Эх сурвалж: ҮСХороо, 2020

**Нөөцийн байршил:** Хүснэгт 20-д 2010-2015 оныг 2015-2019 онтой харьцуулан аймаг, бүс бүрээр махны үйлдвэрлэлийн хэмжээг бүсээр харуулав. Улсын хэмжээнд 2010-2015 онд жилд дундажаар 299.1 мянган тонн мах үйлдвэрлэж байснаа сүүлийн 5 жилд дундажаар 471.6 мянган тонныг үйлдвэрлэж, дундажаар 57.7 хувиар өссөн байна. 2010-2019 онд улсын хэмжээгээр махны үйлдвэрлэл жилд дундажаар 9.5 хувиар өсчээ.
2015-2020 оны дундажаар махны нөөцийн 41.0 хувийг Төвийн бүс, 36.5 хувийг Хангайн, 18.7 хувийг Баруун бүс, 16.1 хувийг Зүүн бүсэд тус тус эзэлж байна. Аймгийн хэмжээнд махны нөөцийг бүрдүүлж байгаа голлох аймгуудад Өвөрхангай, Хөвсгөл, Архангай, Төв, Хэнтий, Дорнод, Сүхбаатар, Дундговь, Баянхонгор, Булган, Завхан зэрэг аймгууд багтаж байна. Эдгээр 11 аймагт нийт бэлтгэсэн махны үйлдвэрлэлийн 71.9 хувийг бэлтгэж байна. Эдгээр аймагт Хангайн бүсийн 5 аймаг, Зүүн бүсийн 3 аймаг багтаж байгаа бөгөөд эдгээр аймгууд нь нийт махны бэлтгэсэн нөөцийн 54.4 хувийг эзэлж байгаа нь махны нөөцийн нийлүүлэлт гол төлөв эдгээр аймгуудаас бэлтгэж байгааг харж болно.

**Хүснэгт 30.** Махны нөөцийн байршил

| | 2010-2015 | 2015-2020 | Өөрчлөлт | Нөөцөд эзлэх хувь, 2010-2015 | Нөөцөд эзлэх хувь, 2015-2019 |
|---|---|---|---|---|---|
| **Улсын дүн** | 299.1 | 471.6 | 57.7% | 100.0% | 100.0% |
| **Баруун бүс** | 55.9 | 99.6 | 78.2% | 18.7% | 21.1% |
| **Хангайн бүс** | 109.3 | 175.1 | 60.2% | 36.5% | 37.1% |
| **Төвийн бүс** | 79.9 | 112.7 | 41.0% | 26.7% | 23.9% |
| **Зүүн бүс** | 48.1 | 73.4 | 52.6% | 16.1% | 15.6% |
| **Улаанбаатар** | 6.0 | 8.2 | 37.2% | 2.0% | 1.7% |

Эх сурвалж: ҮСХороо, 2020

**Махны бэлтгэн нийлүүлэлтийн толтолцоо:** Монгол малын махны онцлог нь бэлчээрийн мал аж ахуйд суурилсан, экологийн цэвэр бүтээгдэхүүн юм. Гэвч мах

бэлтгэлийн дийлэнх хувийг үйлдвэрлэлийн бус буюу уламжлалт гар аргаар нядалж, хэрэглээнд бэлтгэн хүргэж байгаа нь эрүүл мэндийн стандарт, шаардлагыг хангахгүй байна. Нийт бэлтгэсэн махны 10 гаруй хувь нь үйлдвэрлэлийн аргаар нядалсан байна. Мерси Корс байгууллагын судалгаагаар малчдаас зах зээлд нийлүүлж байгаа нийт махны 43.9 хувийг махны ченжүүдэд, 20.6 хувийг орон нутгийн хүнсний захад, 16.1 хувийг орон нутгийн хэрэглэгчдэд нийлүүлсэн гэсэн судалгаа хийсэн байна. Орон нутгийн ченж, хүнсний зах болон хэрэглэгчдэд нийт махны 80.6 хувийг нийлүүлжээ. Орон нутгийн ченжүүд хотын ченжүүд, томоохон захууд, үйлдвэрүүдэд нийлүүлж, 4-5 шат дамжлагаар дамжин эцсийн хэрэглэгчдэд хүрч байна. Шат дамлага бүрд өртөг нэмэгдэж, Улаанбаатар хотын эцсийн хэрэглэгчдэд өндөр үнэтэйгээр худалдаалдаг.

**Диаграмм 12.** Махны бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоо




**Махны нөөц, үйлдвэрлэл, хэрэглээ ба экспорт:** Малын махны нийт нөөц 2019 онд 545.0 мянган тонн, үүнээс жишсэн хүн амын нийт махны хэрэглээ 113.2 мянган тонн байгаа бөгөөд хүн амыг махаар хангах хангамжийн түвшин 381.0 хувь буюу бараг 3 дахин ихээр хангах нөөцэй байна. Мөн 2019 онд 39.0 мянган тонн малын мах экспортолжээ.

**Хүснэгт 31.** Махны нөөц, үйлдвэрлэл, хэрэглээ ба экспорт, мянган тонн

| Үзүүлэлт | 2010 | 2015 | 2018 | 2019 |
|---|---|---|---|---|
| **Нөөц** | 241.1 | 448.1 | 515.2 | 545.0 |
| **Хэрэглээ** | 110.2 | 108.3 | 112.9 | 113.2 |
| **Экспорт** | 13.7 | 4.5 | 40.8 | 39.0 |
| **Махны хангамжийн түвшин** | 119.0 | 314.0 | 356.0 | 381.0 |

Эх сурвалж: ҮСХороо, 2020

**Махны салбарын нөхцөл байдлын шинжилгээ:** Махны салбарын өнөөгийн байдалд нөхцөл байдлын шинжилгээг хийлээ. Махны салбарт тулгарч байгаа гол асуудлын нэг нь түүхий эд бэлтгэлийн тогтолцоог боловсронгуй болгох явдал юм.

**Хүснэгт 32.** Махны салбарт хийсэн СВОТ шинжилгээ

| ДАВУУ ТАЛ | СУЛ ТАЛ |
|---|---|
| - Экологийн цэвэр байгалийн гаралтай<br>- Малын махны экспортлох нөөц ихтэй<br>- Махны салбарын үйлдвэрүүдийн тоо өсөж байгаа бөгөөд техник технологийн шинэчлэлт хийж байгаа.<br>- Гадаад зах зээлтэй харьцуулахад малын махны үнэ харьцангуй хямд.<br>- Малын эрүүл мэнд, аюулгүй байдалд төрөөс ихээхэн анхаарч, сүүлийн жилүүдэд малын шүлхий өвчин гараагүй.<br>- Нэг хүнд ногдох махны нөөц, хэрэглээгээр дэлхийд дээгүүрт орно | - Махны нөөц бүрдүүлэхэд бэлтгэх, тээвэрлэх зардал өндөр<br>- Орон нутагт махны хөргөлттэй, зориулалтын агуулах цөөн<br>- Гадаад зах зээлд хөлдөөсөн малын махыг цөөн орнуудад экспортлож байгаа.<br>- Үйлдвэрлэлийн аргаар махны зөвхөн 10 орчим хувь нь бэлтгэгдэж байгаа<br>- Монгол малын мах гадаад зах зээлд хүргэх нийлүүлэлтийн сүлжээ байхгүй |
| **БОЛОМЖ** | **АЮУЛ** |
| - Гадаад зах зээл дээрээс хөрөнгө оруулалт болгох боломжтой<br>- Засгийн газрын дэмжлэг сайн байгаа<br>- Хөдөө аж ахуйн биржээр арилжаалдаг гол бүтээгдэхүүн<br>- Монгол махыг гадаад зах зээлд сурталчилж, эрэлт хэрэгцээг нэмэгдүүлэх боломжтой<br>- Түүхий эдийн нөөц нь өсөн нэмэгдэж байгаа | - Цаг агаарын өөрчлөлт<br>- Махны экспортын дийлэнх нь хөлдөөсөн мах ээлж байна.<br>- Түүхий эдийн чанар муудаж байгаа<br>- Гадаадын худалдан авагчид махны эрэлт хэрэгцээг нэмэгдүүлж, дотоодын зах зээл дэх үнийг хөөрөгдүүлж байна. |

Эх сурвалж: Судлаач

**Махны бэлтгэн нийлүүлэлтэд сум, хоршооны оролцоо:** Махны бэлтгэлийн нөөцийн хэмжээг бүс, аймаг, сум болон малчдаар тооцоолон гаргалаа.

**Хүснэгт 33.** Махны бэлтгэлийн хэмжээ, мянган тонн, 2020 оноор

| Улс | Бүс | Аймаг | Сумын дундаж |
|---|---|---|---|
| **744.5** | Баруун – 201.8<br>Хангай – 276.2<br>Төв – 177.9<br>Зүүн - 166.1 | Өвөрхангай – 69.3<br>Хөвсгөл – 65.2<br>Архангай – 58.5<br>Төв - 52.1<br>Хэнтий - 51.7<br>Сүхбаатар -46.4<br>Дундговь -41.8<br>Завхан – 36.3 | Баруун – 1.7<br>Хангай – 2.8<br>Төв – 1.6<br>Зүүн - 2.9 |

Жилд бэлтгэсэн махны нөөцийн хэмжээ улсын дундажаар 744.5 мянган тонн, үүний дотор Хангайн бүсэд 276.2 мянган тонн, Баруун бүсэд 201.8 мянган тонн, Төвийн бүсэд 177.9 мянган тонн, Зүүн бүсэд 166.1 мянган тонн байна. Малчин өрхийн хувьд бүс, аймгаас хамаарч жилд бэлтгэх махны хэмжээ өөр өөр байна. Улаанбаатар хотод ойрхон аймгуудын хувьд махны нийлүүлэлт өндөр байна. Сумын хэмжээнд нийлүүлэх махны дундаж нийлүүлэлт Хангайн болон Зүүн бүсийн сумдад 2.8 -2.9 мянган тонн байгаа бол Төв, Баруун бүсийн сумдад дундажаар 1.6-1.7 мянган тонн байна.

**Хүснэгт 34.** Махны бэлтгэлийн хэмжээ, бүс, аймаг, сумдаар

| | | Махны бэлтгэлийн хэмжээ | Бэлтгэх боломжтой хэмжээ |
|---|---|---|---|
| **Малчин өрх,** дундаж, тонн | Баруун | 1.6 | 51 кг |
| | Хангай | 1.7 | 55 кг |
| | Төв | 2.4 | 75 кг |
| | Зүүн | 2.8 | 91 кг |
| **Хоршоо бэлтгэх ноолуур** | Дундаж хоршоо, мян.тонн | 2.4 | 75 кг/өдөрт |
| | Хоршооны гишүүний тоо | 820 -1000 | 7-10 |

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Хангайн бүсийн хувьд малчин өрхийн тоо харьцангуй ихтэй учраас дундаж малчин өрхийн жилд нийлүүлэх махны хэмжээ 1.7 мянга, харин Төвийн болон Зүүн бүсийн малчин өрхийн нийлүүлэх махны хэмжээ жилд 2.4- 2.8 тонн байна. Энэ нь зах зээлд ойрхон, малчин өрхөд ногдох малын тоо зэргээс хамаарч байна. Хоршооны хувьд жилд 2.4 мянган тонн мах дундажаар нийлүүлэх боломжтой байна. Малчин өрх нь жилд дундажаар 51-91 кг мах нийлүүлэх боломжтой байна. Төв болон Зүүн бүсийн малчид зах зээлд ойр учраас илүү ихээр нийлүүлж байна.

## 3. Ноосны нөөц, үйлдвэрлэл, боломж

**Бодлого, хөтөлбөр:**

1. “Алсын Хараа 2050” урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулалтын түвшинг нэмэгдүүлж, мах, ноос болон ноолууран бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэхээр зорилт тавьсан. Уг зорилтын хүрээнд ... ноос, ноолуур, арьс, ширэн бүтээгдэхүүнийг дотооддоо бүрэн боловсруулж, экспортын хэмжээг нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээг авахаар тусгасан байна.

2. Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д ... ноос, ноолуур зэрэг түүхий эдийн бүрэн боловсруулалтыг 60 хувьд хүргэх” гэж төлөвлөсөн.
3. Монгол Улсын Засгийн газраас “Ноос” хөтөлбөрийг баталж хэрэгжүүлж байна.

**Нөөц:** Өнгөрсөн 10 жилийн хугацаанд хонин сүргийн тоо жилд дундажаар 7.6 хувиар өсөж иржээ. Нийт малын 45 хувийг хонин сүрэг эзэлж байна. Хонины тоо толгой өсөхийн хирээр хонины ноосны хэмжээ нэмэгдэж байна. 2010 онд 14.5 сая толгой хонь улсад бүртгэгдэж, 17.1 мянган тонн хонины ноос үйлдвэрлэж байжээ. 2020 он гэхэд хонины тоо толгой болон ноосны хэмжээ бараг 2 дахин өсчээ.

**График 11.** Хонины тоо болон ноосны хэмжээ




**Нөөцийн байршил:** Хүснэгтэд 2010-2015 оныг 2015-2019 онтой харьцуулан хонины ноосны нөөцийн хэмжээг бүсээр харуулав. Улсын хэмжээнд 2010-2015 онуудад жилд дундажаар 19.9 мянган тонн ноос бэлтгэж байсан бол өнгөрсөн 5 жилийн дундажаар жилд 30.1 мянган тонн болж 51.6 хувиар өссөн байна. Хонины ноосны нөөцийн 35.0 хувийг Хангайн, 26.6 хувийг Баруун бүс, 23.3 хувийг Төв, 13.9 хувийг Зүүн бүсэд эзэлж байна. Аймгийн хэмжээнд хонины ноос бэлтгэж буй голлох аймгуудад Хөвсгөл, Архангай, Дундговь, Өвөрхангай, Хэнтий, Сүхбаатар, Булган, Завхан, Увс зэрэг аймгууд багтаж байна. Эдгээр 11 аймагт нийт бэлтгэсэн махны үйлдвэрлэлийн 68.5 хувийг бэлтгэж байна.

Баруун болон Хангайн бүсийн аймгууд нийт ноосны 60.4 хувийг бэлтгэж байна. Хонины ноос овор ихтэй, тээврийн зардал өндөртэйгээс гадна ноосны бэлтгэлийн дийлэнх нь зах зээлээс алслагдсан байгаа нь харагдаж байна.

**Хүснэгт 35.** Ноосны нөөцийн байршил

| | 2010-2015 | 2015-2020 | Өөрчлөлт | Нөөцөд эзлэх хувь, 2010-2015 | Нөөцөд эзлэх хувь, 2015-2019 |
|---|---|---|---|---|---|
| **Улсын дүн** | 19.9 | 30.1 | 51.6% | 100.0% | 100.0% |
| **Баруун бүс** | 5.2 | 8.0 | 54.5% | 26.1% | 26.6% |
| **Хангайн бүс** | 7.0 | 10.5 | 51.1% | 35.1% | 35.0% |
| **Төвийн бүс** | 4.8 | 7.0 | 45.8% | 24.2% | 23.3% |
| **Зүүн бүс** | 2.7 | 4.2 | 52.1% | 13.8% | 13.9% |
| **Улаанбаатар** | 0.1 | 0.2 | 30.5% | 0.7% | 0.6% |

**Ноосны нөөц, үйлдвэрлэл, хэрэглээ ба экспорт:** Малын ноосны нийт нөөц 2019 онд 36.7 мянган тонн, үйлдвэрт бэлтгэсэн ноосны хэмжээ 13.3 мянган тонн, экспортод гарсан ноосны хэмжээ 20.4 тонн байна. Сүүлийн жилүүдэд ноосны урамшуулал өгсөнтэй холбоотойгоор үйлдвэрт тушаагдсан ноосны хэмжээ өссөн байна.

**Хүснэгт 36.** Хонины ноосны нөөц, үйлдвэрлэл ба экспорт

| Үзүүлэлт | 2011 | 2015 | 2018 | 2019 |
|---|---|---|---|---|
| Малчдын бэлтгэсэн ноосны нөөц, мян.тн | 16.9 | 27.9 | 36.1 | 36.7 |
| Үйлдвэрт бэлтгэсэн ноос, мян.тн | 4.7 | 18.1 | 16.7 | 13.3 |
| Экспортлосон самнаагүй ноос, тонн | 7.9 | 13.9 | 20.1 | 20.4 |

**Ноосны салбарын нөхцөл байдлын шинжилгээ**

**Хүснэгт 37.** Ноосны салбарт хийсэн СВОТ шинжилгээ

| ДАВУУ ТАЛ | СУЛ ТАЛ |
|---|---|
| - Ноосоор барилгын дулаалгын материал хийж байна.<br>- Ноосны үйлдвэрүүд техник технологийн шинэчлэлт хийж байгаа. | - Ноос нь овор ихтэй, зах зээлээс алслагдсан учир тээвэрлэх зардал өндөр<br>- Ноосны дийлэнх нь хаягддаг, ноос нь хог хаягдал ихтэй байна |
| **БОЛОМЖ** | **АЮУЛ** |
| - Засгийн газрын дэмжлэг сайн, татаас олгож байгаа<br>- Хөдөө аж ахуйн биржээр арилжих боломжтой бөгөөд одоогоор биржээр арилжаалдаг гол бүтээгдэхүүний нэг<br>- Түүхий эдийн нөөц нь өсөн нэмэгдэж байгаа | - Цаг агаарын өөрчлөлт<br>- Түүхий эдийн чанар муудаж байгаа |

Эх сурвалж: Судлаач

**Ноосны бэлтгэн нийлүүлэлтэд сум, хоршооны оролцоо:** Ноосны бэлтгэлийн нөөцийн хэмжээг бүс, аймаг, сум болон малчдаар тооцоолон гаргалаа.

**Хүснэгт 38.** Хонины ноосны бэлтгэлийн хэмжээ, мянган тонн, 2020 оноор

| Улс | Бүс | Аймаг | Сумын дундаж |
|---|---|---|---|
| **35.5** | Баруун – 9.5<br>Хангай – 12.4<br>Төв – 8.3<br>Зүүн - 4.9 | Хөвсгөл – 3.2<br>Архангай – 3.0<br>Төв - 6.7<br>Өвөрхангай – 6.2<br>Хэнтий - 6.0<br>Сүхбаатар -5.2<br>Булган – 5.9<br>Дундговь -6.5<br>Завхан – 7.4<br>Увс - 6.1 | Баруун – 94 тн<br>Хангай – 118.5 тн<br>Төв – 80.5 тн<br>Зүүн - 113.2 тн<br><br>Улсын дундаж -102 тн |

Эх сурвалж: ҮСХ

Жилд бэлтгэсэн хонины ноосны хэмжээ 2020 онд 35.5 мянган тонн, үүний дотор Хангайн бүсэд 12.4 мянган тонн, Баруун бүсэд 9.5 мянган тонн, Төвийн бүсэд 8.3 мянган

тонн, Зүүн бүсэд 4.9 мянган тонн байна. Малчин өрхийн хувьд бүс, аймгаас хамаарч жилд бэлтгэх махны хэмжээ өөр өөр байна. Хонины ноосны нөөцийн дийлэнх нь баруун аймгуудад байршиж байна. Сумын хэмжээнд нийлүүлэх хонины ноосны дундаж нийлүүлэлт 102 тонн байна. Хоршооны хувьд жилд 2.4 мянган тонн мах дундажаар нийлүүлэх боломжтой байна.

**Хүснэгт 39.** Хонины ноосны бэлтгэлийн хэмжээ, бүс, аймаг, сумдаар

| | | Ноосны бэлтгэлийн хэмжээ | Агуулахын хүчин чадал, хоногт |
|---|---|---|---|
| **Малчин өрх**, дундаж, кг | Баруун | 114.7 | - |
| | Хангай | 89.8 | - |
| | Төв | 137.1 | - |
| | Зүүн | 146.5 | - |
| | улсын дундаж | 94.1 | - |
| **Хоршоо бэлтгэх ноолуур** | Дундаж хоршоо, тонн | 90.0 | 1.5 |
| | Хоршооны гишүүний тоо | 820 -1000 | 15-20 гишүүн |

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол, ҮСХ

## 4. Арьс, ширний нөөц, үйлдвэрлэл, боломж

**Бодлого, хөтөлбөр:** Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, Гурван тулгуур хөгжлийн бодлого, Алсын Хараа 2050 урт хугацаа хөгжлийн үзэл баримтлал, Ногоон хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн салбарт баримтлах бодлого зэрэгт арьс ширний үйлдвэрлэлийн салбарыг хөгжүүлэхээр тусгагдсан. Засгийн газрын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол экспорт хөтөлбөрүүдэд арьс ширний үйлдвэрлэлийг хөгжүүлэх талаар бодлогууд тусгагдсан .

**Нөөц:** 2020 онд 24.4 сая ширхэг арьс, шир бэлтгэсэн байна. Нийт бэлтгэсэн арьс, ширний 45.6 хувь буюу 11.8 сая ширхэг нь хонины арьс, 37.7 хувь буюу 9.2 сая ширхэг нь ямааны арьс, 5.2 хувь буюу 5.2 сая ширхэг нь үхрийн шир, үлдсэн нь адуу болон тэмээний шир эзэлж байна. 2019 онтой харьцуулахад бэлтгэсэн арьс, ширний хэмжээ 38.7 хувиар өссөн байна.

Хүснэгт 40. Арьс ширний нөөц

| | 2016 | 2017 | 2018 | 2019 | 2020 |
|---|---|---|---|---|---|
| **Арьс, шир, мянган ширхэг** | **14 001.2** | **14 523.4** | **17 361.5** | **17 600.2** | **24 407.1** |
| **Тэмээний** | 30.9 | 33.9 | 42.2 | 53.9 | 74.9 |
| **Адууны** | 352.7 | 333.0 | 626.4 | 601.3 | 917.7 |
| **Үхрийн** | 791.0 | 797.8 | 1 038.8 | 893.4 | 1 271.8 |
| **Хонины** | 6 566.6 | 7 011.9 | 8 422.8 | 8 973.6 | 11 853.4 |
| **Ямааны** | 5 763.8 | 5 850.6 | 6 220.7 | 6 270.6 | 9 202.7 |

Эх сурвалж: ҮСХ

**Нөөцийн байршил:** Хүснэгтэд 2010-2015 оныг 2015-2019 онтой харьцуулан бэлтгэсэн арьс, ширний хэмжээг бүсээр харуулав. 2010-2015 оны хугацаанд дундажаар 11.8 сая арьс шир бэлтгэж байсан бол сүүлийн 5 жилийн дундажаар 16.5 сая ширхэгт хүрч, 40.3 хувиар өссөн байна. 2010-2019 оны хугацаанд жилд дундажаар 1.7 хувиар арьс, ширний бэлтгэлийн хэмжээ өссөн байна. Ялангуяа Зүүн болон Баруун бүсийн аймгуудын хувьд 8.7 хувиар нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ. Төвийн болон Хангайн бүсэд дорвитой өсөлт

энэ хугацаанд гараагүй байна. Тухайлбал Хангайн бүсэд 0.7 хувиар, Төвийн бүсэд 0.5 хувиар бэлтгэсэн арьс ширний тоо хэмжээ нэмэгджээ. 2015-2020 онд бэлтгэсэн арьс, ширний тоо хэмжээний 35.3 хувийг Хангайн бүс, 25.1 хувийг Баруун бүс, 23.3 хувийг Төвийн бүс, 15.5 хувийг Зүүн бүс эзэлсэн.

**Хүснэгт 41.** Арьс, ширний нөөцийн байршил, сая ширхэг

| | 2010-2015 | 2015-2020 | Нөөцөд эзлэх хувь, 2010-2015 | Нөөцөд эзлэх хувь, 2015-2019 | Өөрчлөлт |
|---|---|---|---|---|---|
| **Улсын дүн** | 11.8 | 16.5 | 100.0% | 100.0% | 40.3% |
| **Баруун бүс** | 2.8 | 4.1 | 23.8% | 25.1% | 48.1% |
| **Хангайн бүс** | 4.3 | 5.8 | 36.5% | 35.3% | 35.5% |
| **Төвийн бүс** | 2.8 | 3.8 | 23.7% | 23.3% | 37.8% |
| **Зүүн бүс** | 1.8 | 2.6 | 15.0% | 15.5% | 45.4% |
| **Улаанбаатар** | 0.1 | 0.1 | 1.0% | 0.9% | 17.2% |

Эх сурвалж: ҮСХ

Аймгийн хэмжээнд арьс шир бэлтгэн нийлүүлж байгаа голлох аймгуудад Өвөрхангай, Хөвсгөл, Архангай, Булган, Төв, Дундговь, Хэнтий, Сүхбаатар, Завхан, Говь-Алтай болон Увс зэрэг аймгууд багтаж байна. Эдгээр 11 аймагт нийт бэлтгэсэн арьс, ширний 73.2 хувийг бэлтгэж байна. Сүүлийн жилүүдэд Сүхбаатар, Хэнтий, Дорноговь, Говь-Алтай, Баян-Өлгий аймгуудад бэлтгэсэн арьс, ширний тоо хэмжээ өсч, харин Өмнөговь, Сэлэнгэ зэрэг аймгуудад буурч байгаа нь статистик тоо баримтаас харагдаж байна.

Тэмээний ширний хувьд Төвийн бүсийн Өмнөговь, Дундговь, Дорноговь аймгуудаас голлон бэлтгэж байгаа бөгөөд нийт бэлтгэсэн тэмээний ширний 49.5 хувийг Төвийн бүс эзэлж байна. Үхрийн ширний хувьд Хангай бүсийн Хөвсгөл, Архангай, Өвөрхангай, Булган зэрэг аймгуудад үхрийн шир голлон бэлтгэсэн. Хангай, Төв болон Зүүн бүсийн аймгууд адууны шир голлон бэлтгэж байна.

**Хүснэгт 42.** Бүс нутгууд дахь арьс ширэн түүхий эдийн бэлтгэл /түүхий эд тус бүрээр/

| Бүсүүд | Хонины нэхий | Ямааны арьс | Адууны шир | Үхрийн шир | Тэмээний шир |
|---|---|---|---|---|---|
| Баруун | 24.5 | 26.5 | 19.2 | 18.1 | 24.8 |
| Хангай | 38.1 | 36.7 | 35.9 | 45.4 | 18.1 |
| Төв | 23.5 | 25.5 | 24.3 | 19.2 | 49.5 |
| Зүүн | 13.1 | 10.5 | 19.5 | 16.1 | 7.5 |
| Улаанбаатар | 0.8 | 0.8 | 1.1 | 1.2 | 0.1 |

Эх сурвалж: ҮСХ

**Арьс, ширний бэлтгэн нийлүүлэлтийн толтолцоо**

Малын нядалгааны цикл нь 8-12 дугаар саруудад ихээхэн идэвхтэй явагдаж, ялангуяа 11-12 дугаар саруудад өрх гэрүүд өвлийн махны бэлтгэл хийдэг учраас арьс ширний бэлтгэлийн хэмжээ энэ үед эрс өсдөг. Нийт бэлтгэсэн арьс, ширний бараг 80 орчим хувь нь 9-12 дугаар сард бэлтгэдэг гэсэн судалгааны үр дүн гарчээ. "Мэрси Кор Монгол" олон улсын байгууллагаас хийсэн судалгаагаар нийт бэлтгэсэн арьс ширний 54 орчим хувь нь орон нутгийн ченжүүдэд, 37 хувь нь аймгийн ченжүүд, 6 орчим хувь нь Улаанбаатарын ченжүүдэд, үлдсэн 3 хувь нь орон нутгийн хоршоо, үндэсний үйлдвэрийн төлөөлөгч нарт нийлүүлдэг гэсэн судалгаа 2010 онд хийжээ. ХХААХҮЯ-наас 2014 оноос эхлэн арьс ширний урамшуулал олгож эхэлснээр үйлдвэрүүдэд

нийлүүлэх арьс ширний тоо хэмжээ өссөн байна. 2019 онд нийт бэлтгэсэн арьс ширний 11.4 хувь буюу 2.2 мянган ширхэг арьс ширийг 39.3 мянган малчин бэлтгэн үйлдвэрт тушаажээ.

**Хүснэгт 43.**Үйлдвэрт тушаасан арьс ширний тоо хэмжээ, мян.ширхэг

| | 2014 | 2015 | 2016 | 2017 | 2018 | 2019 |
|---|---|---|---|---|---|---|
| Үйлдвэрт тушаасан арьс, шир, мян.ширхэг | 0.8 | 2.0 | 2.7 | 3.1 | 3.5 | 2.2 |
| Малчдын тоо | 32896 | 54535 | 45061 | 64255 | 77900 | 39263 |

Эх сурвалж: ХХААХҮЯ

**Арьс, ширний бэлтгэсэн нөөц, үйлдвэрлэл, хэрэглээ ба экспорт:** Арьс, ширний нийт нөөц 2019 онд 19.5 сая ширхэг байна. 2010 онтой харьцуулахад бэлтгэсэн арьс, ширний хэмжээ 2 дахин өссөн байна. Үйлдвэрт тушаасан арьс ширний хэмжээ 2014 онд 0.8 сая ширхэг байснаа 2020 онд 2.2 сая болж өссөн байна. Үүнд арьс, ширний татаасын бодлого нөлөөлсөн байна. Мөн үйлдвэрт боловсруулсан арьс ширний үйлдвэрлэл 2014 онд 5.8 сая байсан бол 2020 онд 7.5 саяд хүрч өссөн байна. 2020 онд 540.5 мянган ширхэг арьс, шир экспортложээ. Арьс ширний экспорт өссөн хэдий ч хагас боловсруулсан арьс, шир дийлэнх хувийг эзэлж, мөн экспортын хэмжээ үлэмж бага хэвээр байна.

**Хүснэгт 44.** Арьс ширний нөөц, үйлдвэрлэл, хэрэглээ ба экспорт, сая ширхэг

| Үзүүлэлт | 2014 | 2015 | 2018 | 2019 |
|---|---|---|---|---|
| Бэлтгэсэн арьс шир, сая ширхэг | 10.2 | 15.2 | 19.3 | 19.5 |
| Боловсруулсан арьс, сая ширхэг | 5.8 | 6.5 | 5.2 | 7.5 |
| Үйлдвэрт тушаасан, сая шир | 0.8 | 2.0 | 3.5 | 2.2 |
| Экспорт, мянган шир | 0.3 | 117.9 | 0.3 | 540.5 |

Эх сурвалж: ХХААХҮЯ

**Арьс,ширний салбарын нөхцөл байдлын шинжилгээ**

Арьс, ширний салбарын өнөөгийн байдалд нөхцөл байдлын шинжилгээг хийлээ.

**Хүснэгт 45.** Арьс, ширний салбарт хийсэн СВОТ шинжилгээ

| ДАВУУ ТАЛ | СУЛ ТАЛ |
|---|---|
| - Арьс ширээр, савхин гутал, дээл, бээлий, нэхий дээл зэргийг үйлдвэрлэж байгаа бөгөөд энэ төрлийн бүтээгдэхүүний эрэлт нэмэгдэж байна.<br>- Арьс ширний үйлдвэрүүд техник технологийн шинэчлэлт хийсэн.<br>- | - Нийт бэлтгэсэн арьс, ширний 10 орчим хувь нь арьс, ширний үйлдвэрт, өчүүхэн хувь нь экспортод гарч байна. Өөрөөр хэлбэл арьс ширээ ашиглаж чадахгүй байна.<br>- Арьс ширний үйлдвэрлэлийн аж үйлдвэрийн бүтээгдэхүүний 0.3 хувийг эзэлж байна. |
| **БОЛОМЖ** | **АЮУЛ** |
| - Засгийн газрын дэмжлэг сайн, ХХААХҮЯ-наас арьс ширний урамшуулал олгож байна.<br>- Хөдөө аж ахуйн биржээр дамжуулан бэлтгэж, махны үйлдвэрт бэлтгэгдсэн арьс нийлүүлснээр арьсны гэмтэл 20-30 хувиар буурах боломжтой<br>- Түүхий эдийн нөөц нь өсөн нэмэгдэж байгаа<br>- Дархан, Ховд аймаг, Эмээлтэд арьс ширний үйлдвэрийн парк байгуулагдаж байна. | - Цаг агаарын өөрчлөлт<br>- Нядалгааны өмнөх, нядалгааны үеийн болон дараах гэмтэл их, ялангуяа нядалгааны өмнөх гэмтэл буурахгүй байна. Энэ нь ноос, ноолуур самнах бэлтгэлийн ажилтай холбоотой байна.<br>- Түүхий эдийн чанар муудаж байгаагаас үйлдвэрүүд чанартай түүхий эдээр хангагдаж чадахгүй байна.<br>- Боловсон хүчин бага бэлтгэгдэж байна. |

Эх сурвалж: Судлаач

**Арьс ширний бэлтгэн нийлүүлэлтэд сум, хоршооны оролцоо:** Арьс ширний бэлтгэлийн нөөцийн хэмжээг бүс, аймаг, сум болон малчдаар тооцоолон гаргалаа.

**Хүснэгт 46.** Бэлтгэсэн арьс, ширний тоо хэмжээ, сая ширхэг, 2019 оноор

| Улс | Бүс | Аймаг | Сумын дундаж |
|---|---|---|---|
| **24.4** | Баруун – 6.0<br>Хангай – 8.6<br>Төв – 5.3<br>Зүүн - 4.3 | Өвөрхангай – 1.9<br>Хөвсгөл – 1.6<br>Хэнтий - 1.6<br>Архангай - 1.3<br>Төв - 1.5<br>Сүхбаатар - 1.3<br>Дундговь - 1.2<br>Завхан - 1.1<br>Говь-Алтай - 1.0<br>Увс - 1.0<br>Булган - 1.0 | Баруун – 52.9 мян<br>Хангай – 69.7 мян<br>Төв – 44.5 мян<br>Зүүн - 77.3 мян<br>Улс - 59.3 мян |

Бэлтгэсэн арьс, ширний тоо хэмжээ 2020 онд 24.4 сая ширхэгт хүрсэн. Үүнээс Хангайн бүс 8.6 сая, Баруун бүс 6.0 сая, Төвийн бүс 5.3 сая, Зүүн бүс 4.3 сая ширхэг нийлүүлсэн байна. Хангайн бүсийн хувьд малчин өрхийн тоо харьцангуй ихтэй учраас дундаж малчин өрхийн жилд нийлүүлэх махны хэмжээ 1.7 мянга, харин Төвийн болон Зүүн бүсийн малчин өрхийн нийлүүлэх махны хэмжээ жилд 2.4- 2.8 мянган тонн байна. Зах зээлд ойрхон, малчин өрхөд ногдох малын тоо зэргээс хамаарч байна. Хоршооны хувьд жилд 2.4 мянган тонн мах дундажаар нийлүүлэх боломжтой байна. Малчин өрх жилд дундажаар 72 ширхэг арьс, шир бэлтгэх боломжтой байна. Зүүн болон Төвийн бүсэд орших малчид илүү их арьс, шир буюу 72-97 ширхэг арьс, шир нийлүүлдэг байна. Сумын хоршооны хувьд жилдээ 79-97 мянган ширхэг арьс шир нийлүүлэх боломжтой бөгөөд үүний 80 орчим хувийг 9-12 сард нийлүүлж байна.

**Хүснэгт 47.** Арьс ширний бэлтгэлийн хэмжээ, бүс, аймаг, сумдаар

| | | **Бэлтгэлийн хэмжээ** | **Хоногт бэлтгэх боломжтой хэмжээ** |
|---|---|---|---|
| **Малчин өрх,** дундаж, ширхэг | Баруун | 66 | - |
| | Хангай | 52 | - |
| | Төв | 72 | - |
| | Зүүн | 97 | - |
| | Улс дундаж | 72 | - |
| **Хоршоо бэлтгэх арьс, шир, мянган шир** | Дундаж хоршоо | 79-97 | 500-600 ширхэг |
| | Хоршооны гишүүний тоо | 820 -1000 | 7-10 |

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол, ҮСХ

## 5. Сүүний нөөц, үйлдвэрлэл, боломж

**Бодлого, хөтөлбөр:**

1. УИХ-аас баталсан Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн салбарт баримтлах бодлогод хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангасан шим тэжээллэг, баталгаатай хүнсээр хүн амыг тогтвортой хангахаар заасан.
2. Засгийн газраас 2016 онд баталсан Мах, сүүний анхдугаар аяны хүрээнд мах, сүү бэлтгэн нийлүүлэх оновчтой тогтолцоог бүрдүүлэх, мах, сүүний боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх, мах, махан бүтээгдэхүүн, сүү, бүүн бүтээгдэхүүний дотоодын хэрэглээ, экспортыг дэмжих зэрэг бодлого баримтлан хэрэгжүүлж байна.

**Нөөц:** 2020 онд малчид 1,082.4 сая литр сүү бэлтгэсэн байна. Нийт бэлтгэсэн сүүний 60.2 хувь буюу 651.2 сая нь үхрийн, 18.2 хувь буюу 196.6 сая литр нь ямааны, 9.7 хувь буюу 104.6 сая литр нь гүүний сүү эзэлж байна. 2015-2020 онуудад жилд дундажаар 5.0 хувиар сүүний нийлүүлэлт өсч байна. Нийт сүүний нийлүүлэлтийн 80 орчим хувь нь үхрийн болон ямааны сүү эзэлж байна.

**Хүснэгт 48.** Бэлтгэсэн сүүний үйлдвэрлэл, сая литр

| | 2016 | 2017 | 2018 | 2019 | 2020 |
|---|---|---|---|---|---|
| **Сүү, сая литр** | **891.5** | **919.5** | **902.4** | **1 074.2** | **1 082.4** |
| **Гүүний** | **86.2** | **94.3** | **83.9** | **112.0** | **104.6** |
| **Үнээний** | **522.4** | **539.9** | **553.3** | **627.9** | **651.2** |
| **Ингэний** | **10.2** | **10.4** | **11.5** | **11.3** | **13.5** |
| **Хонины** | **99.1** | **99.7** | **103.8** | **120.8** | **116.5** |
| **Ямааны** | **173.6** | **175.2** | **149.8** | **202.3** | **196.6** |

Эх сурвалж: ҮСХ

**Нөөцийн байршил:** Хүснэгтэд 2010-2015 оныг 2015-2019 онтой харьцуулан аймаг, бүс бүрээр сүүний нийлүүлэлтийн тоо хэмжээг бүсээр харуулав. 2010-2015 онд жилд дундажаар 631.7 сая литр байснаа 2015-2020 онд дундажаар 932.4 сая литрийг нийлүүлж, 47.6 хувиар өссөн байна. 2010-2019 онд улсын хэмжээгээр сүүний нийлүүлэлт жилд дундажаар 12.7 хувиар өсчээ. 2015-2020 оны дундажаар сүүний нийлүүлэлтийн нөөцийн 34.4 хувийг Хангайн бүс, 24.5 хувийг Төвийн бүс, 22.5 хувийг Баруун бүс, 16.3 хувийг Зүүн бүсэд тус тус эзэлж байна. Сүүний нөөцийг бүрдүүлж байгаа голлох аймгуудад Өвөрхангай, Архангай, Төв, Хөвсгөл, Хэнтий, Баянхонгор, Завхан зэрэг аймгууд багтаж байна. Эдгээр 7 аймаг нь нийт бэлтгэсэн сүүний 52.3 хувийг бэлтгэж байна.

**Хүснэгт 49.** Сүүний нийлүүлэлтийн нөөцийн байршил

| | 2010-2015 | 2015-2020 | Өөрчлөлт | Нөөцөд эзлэх хувь, 2010-2015 | Нөөцөд эзлэх хувь, 2015-2019 |
|---|---|---|---|---|---|
| **Улсын дүн** | 631.7 | 932.4 | 47.6% | 100.0% | 100.0% |
| **Баруун бүс** | 142.1 | 215.9 | 51.9% | 22.5% | 23.2% |
| **Хангайн бүс** | 218.6 | 320.6 | 46.6% | 34.6% | 34.4% |
| **Төвийн бүс** | 154.7 | 210.0 | 35.7% | 24.5% | 22.5% |
| **Зүүн бүс** | 102.8 | 158.9 | 54.6% | 16.3% | 17.0% |
| **Улаанбаатар** | 13.5 | 18.1 | 34.0% | 2.1% | 1.9% |

Эх сурвалжҮСХ

**Сүүний бэлтгэн нийлүүлэлтийн толтолцоо:** 2020 онд 67.1 сая толгой мал бүртгэгдснээс 45 хувь нь хээлтэгч мал байна. 2020 онд мал аж ахуйн салбарт нийт 1,082.0 сая литр сүү бэлтгэсэн. Нийт нийлүүлсэн сүүний 65 хувийг дулааны улиралд, 35 хувийг сэрүүний улиралд нийлүүлдэг судалгаа байна. Нийт бэлтгэсэн сүүний нөөцийн 15 хувь нь сүү боловсруулах үйлдвэээр боловсруулалт хийж байна. Зах зээлд нийлүүлж байгаа нийт сүүний 25 гаруй хувийг орон нутгийн хэрэглэгчид, 22 гаруй хувийг орон нутгийн хүнсний дэлгүүр, 17 хувийг орон нутгийн ченжүүдэд, үлдсэн хувь нь Улаанбаатарын үйлдвэр, захуудад нийлүүлсэн байна.

**Сүүний нөөц, үйлдвэрлэл, хэрэглээ ба экспорт:** Сүүний нөөц 2019 онд 1074.2, үүнээс жишсэн хүн амын нийт сүүний хэрэглээ 164.7 сая литр байна. ХХААХҮЯ-на мэдээгээр сүүний арвин нөөцтэй хэдий ч Монгол Улсын хүн амын сүү, сүүн бүтээгдэхүүний хангамжийн хэрэгцээ 53 хувьтай байна гэж үзсэн.

**Хүснэгт 50.** Махны нөөц, үйлдвэрлэл, хэрэглээ ба экспорт, сая литр

| **Үзүүлэлт** | **2010** | **2015** | **2018** | **2019** |
|---|---|---|---|---|
| Нөөц | 365.8 | 874.4 | 902.4 | 1074.2 |
| Үйлдвэрт боловсруулсан сүүн бүтээгдэхүүн | 42.0 | 69.6 | 135.0 | 164.7 |
| Хэрэглээ | 176.2 | 144.6 | 150.5 | 150.9 |

Эх сурвалж: ХХААХҮЯ

**Сүүний салбарын нөхцөл байдлын шинжилгээ:** Сүү, сүүн бүтээгдэхүүний салбарын өнөөгийн байдалд нөхцөл байдлын шинжилгээг хийлээ.

**Хүснэгт 51. СВОТ шинжилгээ**

| ДАВУУ ТАЛ | СУЛ ТАЛ |
|---|---|
| - Экологийн цэвэр байгалийн гаралтай<br>- Сүүний нөөц ихтэй | - Сүү боловсруулах шаардлага хангасан үйлдвэрийн тоо цөөн<br>- Сүүний нөөц нь зах зээлээс алслагдсан учраас хотын орчмын сүүний фермерүүдээс үйлдвэрт хэрэгцээтэй сүүг нийлүүлж байна.<br>- Орон нутагт сүүний хөргөлттэй, зориулалтын агуулах цөөн |
| **БОЛОМЖ** | **АЮУЛ** |
| - Засгийн газраас сүүний урамшуулал олгож эхэлсэн.<br>- Сүү, сүүн бүтээгдэхүүний эрэлт, хэрэгцээ нэмэгдэж байна.<br>- Сургуулийн сурагчдын үдийн хоол хөтөлбөрт сүү, сүүн бүтээгдэхүүнээр хангахаар зорьж байна | - Цаг агаарын өөрчлөлт, улирлын нөлөөлөлтэй |

Эх сурвалж: Судлаач

**Сүү, сүүн бүтээгдэхүүний нийлүүлэлтэд сум, хоршооны оролцоо:** Сүү, сүүн бүтээгдэхүүний нөөцийн хэмжээг бүс, аймаг, сум болон малчдаар тооцоолон гаргалаа.

**Хүснэгт 52.** Сүүний нийлүүлэлтийн хэмжээ, сая литр, бүс, тэргүүлэх аймгаар 2020 он

| **Улс** | **Бүс** | **Аймаг** | **Сумын дундаж** |
|---|---|---|---|
| **1082.4** | Баруун – 237.1<br>Хангай – 374.8<br>Төв – 233.8<br>Зүүн - 191.5 | Архангай – 103.0<br>Төв - 90.0<br>Хэнтий - 89.0<br>Өвөрхангай – 80.0<br>Хөвсгөл – 70.0<br>Баянхонгор-68.0<br>Завхан – 61.0 | Баруун – 2.6<br>Хангай – 3.8<br>Төв – 2.4<br>Зүүн - 4.2 |

Эх сурвалж: ҮСХ

Сүүний нийлүүлэлтийн хэмжээ 2020 онд 1082.4 сая литр, үүнээс Хангай бүсэд 374.8 сая, Баруун бүсэд 237.1 сая, Төв бүсэд 233.8 сая, Зүүн бүсэд 191.5 сая литр байна. Хангай

болон Баруун бүсийн сүүний нөөц нь нийт нөөцийн 56.5 хувийг эзэлж байгаа ч Улаанбаатар, Дархан, Эрдэнэт зэрэг төвлөрсөн зах зээлээс алслагдсан байна. Сүүний нийлүүлэлт хийж байгаа гол аймгууд болох Архангай, Төв, Хэнтий, Өвөрхангай, Хөвсгөл, Баянхонгор болон Завхан аймгууд нийт 561.0 сая литр нийлүүлсэн нь нийт сүүний нөөцийн 51.8 хувьтай байна.

Үхрийн болон адууны тоогоор тэргүүлж байгаа, мөн Улаанбаатар хотод ойрхон аймгуудын хувьд сүү, сүүн бүтээгдэхүүний нийлүүлэлт өндөр байна. Сумын хэмжээнд жилд нийлүүлэх сүүний дундаж хэмжээ 3.2 сая литр, малчин өрхийн сүүний дундаж нийлүүлэлт 4134 литр байх боломжтой байна. Бэлтгэсэн сүүний 40-50 хувийг ахуйн хэрэгцээнд, үлдсэн хувийг хоршоонд нийлүүлнэ гэж тооцоолоход жилд хоршоонд 1.3 - 1.7 сая литр сүү нийлүүлэх боломжтой байна. Үүгээр хоршоо нь сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, орон нутгийн сургууль, эмнэлэг болон хэрэглэгчдийг хангах боломжтой юм. Зах зээлд ойрхон, малчин өрхөд ногдох малын тоо зэргээс хамаарч байна.

**Хүснэгт 53.** Сүүний бэлтгэлийн хэмжээ, бүс, аймаг, сумдаар

| | | **Сүүний нийлүүлэлтийн хэмжээ** | **Агуулахын хүчин чадал, хоногт** |
|---|---|---|---|
| **Малчин өрх**, дундаж, литр | Баруун | 3175 | Дулааны болон сэрүүний улиралд нийлүүлэх хэмжээнээс хамаарна. Жилд 200 өдөр нийлүүлнэ гэж тооцоолбол өдөрт хоршоонд 6.6-8.2 тонн сүү нийлүүлэх боломжтой. |
| | Хангай | 3241 | |
| | Төв | 4460 | |
| | Зүүн | 5658 | |
| **Хоршоонд нийлүүлэх боломжтой сүүний нөөц** | Дундаж хоршоо, сая литр | 1.3 – 1.7 | |
| | Хоршооны гишүүний тоо | 820 -1000 | 7-10 |

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

## 5.3. TOWS шинжилгээ

Хөдөө аж ахуйн биржийн үйл ажиллагаанд TOWS шинжилгээ хийлээ.

**Хүснэгт 54.** Биржийн үйл ажиллагааны дотоод болон гадаад орчинд хийсэн СВОТ шинжилгээ

| БОЛОМЖ | АЮУЛ |
|---|---|
| - Цахим хөдөө аж ахуй хөтөлбөр<br>- Хөдаө аж ахуйн татаасын бодлого<br>- Форвард арилжаа хийснээр банк, санхүү, даатгалын байгууллагын оролцоог нэмэгдүүлэх замаар арилжаанд оролцогчдын оролцоо, итгэлцлийг бий болгох боломжтой.<br>- Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн нөөц жил бүр өсөн нэмэгдсэн.<br>- Дархан, Ховд аймаг, Эмээлтэд баригдах арьс ширний аж үйлдвэрийн парк<br>- Техник технологи хөгжиж, цахим агуулах, лаборатори, орчин үеийн дэвшилтэд бэлтгэлийн багаж хэрэгсэл, цахим чанарын баталгаажуулалтын системийг бүрдүүлэх замаар алслагдсан бүс, хөдөө орон нутгийн хоршоодтой холбогдож, бараа, түүхий эдийн чанарыг баталгаажуулах боломжтой. | - Дэлхийн дулаарал, цаг агаарын гэнэтийн өөрчлөлт.<br>- Түүхий эд бэлтгэлийн тогтолцоонд ченж, гадаадын худалдан авагчдын оролцоо хүчтэй хэвээр байна.<br>- Спот арилжаа хийж байгаа нөхцөлд ченжүүд идэвхтэй хэвээр байдаг. Ингэхийн тулд ирэх жилүүдийн бараа, түүхий эдээ биржийн тогтолцоогоор баталгаажуулж, зээл авах боломжийг бүрдүүлэх хэрэгтэй юм.<br>- Түүхий эдийн чанар муудаж байна.<br>- Зам харилцаа, итгэмжлэгдсэн агуулах, лаборатор, хоршоодыш цахимжуулах, хоршооны засаглалыг сайжруулахад ихээхэн хугацаа, хөрөнгө шаардлагатай. |

| | |
|---|---|
| | - Аймаг, сумдын ЗДТГ-тай хамтран ажиллахад хүн хүч, цаг хугацаа ихээхэн орно. |
| ДАВУУ ТАЛ | СУЛ ТАЛ |
| - Олон тооны оролцогчид оролцох боломжтой<br>- Арилжаа зохион байгуулахад туршлага хуримтлуулсан<br>- Блокчейнд суурилсан арилжааны иж бүрэн программ хангамжтай болсон<br>- Биржийн эрх зүйн орчин бүрдсэн.<br>- Эмээлтэд Ложистикийн төв байгуулсан.<br>- Гадаад болон дотоод зах зээлд эрэлт хэрэгцээ нэмэгдэж байна<br>- Санхүүгийн бие даасан боломж, орлогын тогтвортой эх үүсвэр бүрдэж байна.<br>- Орон нутагт түүхий эд ангилах, ялгах бэлтгэлийн хөдөлмөрийн зах зээл бүрдэж эхэлсэн. | - Биржийн дийлэнх арилжаа нь крос захиалгын нөхцөлтэй спот арилжаа хийгдэж байна. Форвард арилжаа хийх тогтолцоо бүрдээгүй байна.<br>- Бирж байгуулахад төр, хувийн хэвшлийн томоохон хөрөнгө оруулалт одоог хүртэл хийгдээгүй.<br>- Биржээр арилжих бараа, түүхий эдэд анхан шатны тордолт хийж, ангилан бэлтгэж, чанарын баталгаа өгөх ажил хангалтгүй.<br>- Орон нутагт түүхий эд бэлтгэх ажилд биржийн оролцоо сул хэвээр байна.<br>- Биржийн удирдах зөвлөл ажиллах<br>- Олон улсын байгууллагуудтай хамтран ажиллаж, биржийн үйл ажиллагаа, чадавхийг бэхжүүлэх ажил удааширалтай байна.<br>- Биржээс зөвшөөрөл олгосон итгэмжлэгдсэн агуулах, лаборатори, тээврийн байгууллагууд цөөхөн, үр дүнтэй ажиллахгүй байна. |

Эх сурвалж: Судлаач

## 5.4. PESTLE шинжилгээ

Хөдөө аж ахуйн биржийн үйл ажиллагаанд PESTLE шинжилгээ хийлээ.

**Хүснэгт 55.** Биржийн гадаад орчны өөрчлөлтөд хийсэн PESTLE шинжилгээ

| | | | |
|---|---|---|---|
| Шинжилгээ | P | Улс төр, төрийн бодлогын өөрчлөлт | - Цахим хөдөө аж ахуй, үүний дотор мөшгих тогтолцоо<br>- Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний урамшуулал, татаас<br>- Цахим татварын систем<br>- Дархан, Ховд аймагт АҮП . |
| | E | Эдийн засгийн өөрчлөлт | - Хөдөө аж ахуйн бараа, түүхий эдийн нөөц нэмэгдэж байгаа<br>- Түүхий эдийн тооноос илүү чанарт анхаарах шаардлагатай<br>- Бараа, түүхий эдийг дотооддоо боловсруулж, нэмүү өртөг шингээсэн үйлдвэрлэл эрхлэх аж ахуйн нэгжийн тоо өсч, тоног төхөөрөмжийн шинэчлэл нэмэгдэж байгаа |
| | S | Нийгмийн өөрчлөлт | - Үндэсний брэнд бүтээгдэхүүн, тухайлбал Хаан ноолуур<br>- Цахим арилжааны платформ хөгжиж, биржийн арилжааны талаарх мэдлэг нэмэгдэж байна.<br>- Дэлхийн хэмжээнд экологийн хүнсний бүтээгдэхүүн хэрэглэх хандлага өсч байна. |
| | T | Технологийн өөрчлөлт | - Бүх сумдад интернет, харилцаа холбооны сүлжээтэй холбогдсон.<br>- Төр засгаас цахим орчинд төрийн үйлчилгээг хүргэх, нийтэд ид тод, нээлттэй байхад ихээхэн анхаарч ажиллаж байна. |
| | L | Хууль эрх зүйн орчны өөрчлөлт | - Хөдөө аж ахуйн салбарыг дэмжихэд чиглэсэн бодлого, хөтөлбөр, төсөл арга хэмжээ хэрэгжүүлж байна.<br>- Хоршооны хууль шинэчлэн батлагдсан.<br>- Ноолуурын хөтөлбөр шинэчлэн батлагдсан.<br>- Цахим Монгол хөтөлбөр хэрэгжиж байгаа.<br>- Хөдөө аж ахуйн биржийн гол журмууд шинэчлэн боловсруулж байна.<br>- Алсын хараа хөгжлийн бодлого батлагдсан |
| | E | Байгаль орчны өөрчлөлт | - Дэлхийн дулаарал<br>- Хүнсний аюулгүй байдлын бодлогын хүрээнд экологийн цэвэр бүтээгдэхүүн хэрэглэх сонирхол өссөн<br>- Малын үүлдэр, ашиг шим, чанарт анхаарах хэрэгтэй |

Эх сурвалж: Судлаач

## 5.5. GAP шинжилгээ

Монгол Улсын хөдөө аж ахуйн салбарын нөөц, боломж, потенциал, олон улсын биржийн хөгжлийн түвшинтэй уялдуулан Хөдөө аж ахуйн биржийн өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж, цаашдын зорилгыг тодорхойлж, цаашдын зорилго, зорилтод хүрэхийн тулд ямар асуудлууд байгаа, түүний учир шалтгаан юу болох талаар шинжилгээ (gap analysis) хийлээ.

Хүснэгт 56. GAP шинжилгээ

| Үзүүлэлт | Өнөөгийн байдал | Ирээдүйн зорилт | Зөрүү | Шалтгаан |
|---|---|---|---|---|
| **Нэг. Ажил, үйлчилгээ** | | | | |
| Зорилго, зорилт | Малчид, тариаланчид болон үйлдвэрүүдийг шууд холбосон бараа, түүхий эд бэлтгэн нийлүүлэлт, борлуулалтын тогтолцоог бүрдүүлж чадаагүй байна. | Орчин үеийн дэвшилтэд техник технологи, мөшгих тогтолцоог нэвтрүүлэх замаар ил тод, нээлттэй, зохион байгуулалт сайтай арилжааны болон агуулахын үйлчилгээг үзүүлэх | Мөшгих тогтолцоог нэвтрүүлж чадаагүй, агуулахын аж ахуй орон нутагт байхгүй, орчин үеийн техник, технологид хөрөнгө оруулалт хийгээгүй. | ХХААХҮЯ-ны бодлогын хэрэгжилттэй биржийн зорилго, зорилтоо уялдуулаагүй, орон нутагт буюу түүхий эдийн нөөцийн дэргэд биржийн салбар байхгүй |
| Зарчим | Олон улсын биржүүдийн адилаар нээлттэй, ил тод, бие даасан, хараат бус байхаар ХААБ-ийн хуульд тусгасан. Гэвч биржийн арилжаа нь арилжаанд оролцогчдод ил тод бус, хаалттай арилжаа /кросс арилжаа/ хийгдэж байна | Нээлттэй, ил тод, шударга, найдвартай, дундыг баримтласан (нейтрал) зарчимд суурилан дуудлага худалдаа болон цахим платформод суурилсан биржийн арилжаа явуулах | Биржийн зарчмыг хэрэгжүүлэхийн тулд арилжааны рекорд хийх, арилжааны цахим платформыг сайжруулах шаардлагатай байна. | Кросс арилжаа хийж байгаа нь нээлттэй бус байх гол шалтгаан болж байна. Шинээр нэвтрүүлэх блокчейнд суурилсан арилжааны платформын ажиллагааг эхлүүлэх, олон нийтэд сурталчилах ажил удаашралтай байна. |
| Бүтээгдэхүүн | Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн 10.0 орчим хувийг биржээр арилжаалж байна. Ноолуур, ноос голлон арилжаалж байна. Нийт арилжаалсан бүтээгдэхүүний 95 хувийг ноос, ноолуур эзэлж байна.. | Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн биржээр арилжаалах хувь хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлэх замаар биржээр арилжаалах бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлэх, чанарыг сайжруулж, үйлдвэрүүдийг түүхий эдээр тасралтгүй хангах | Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн биржээр арилжаалах хувь хэмжээг 10-аас 100 хувь хүртэл нэмэгдүүлэх шаардлагатай байна. Биржээр арилжаалах бүтээгдэхүүний тоо хэмжээ цөөн байгаа нь орон нутагт биржийн салбар байхгүй, чанар сул, тээврийн зардал өндөр байгаатай холбоотой байна. | Биржээр арилжаалсан бүтээгдэхүүний дийлэнх нь экспортын угаасан болон самнасан ноолуур байна. Биржээр арилжаалах жагсаалтад орсон бараа, түүхий эдийг экспортлох бол биржээр арилжаалагдсан байх шаардлагатай. Сайн тал нь экспортын бүтээгдэхүүний бүртгэл, хяналт сайжирсан. |
| Үйлчилгээ | Бирж сайн үйлчилгээ үзүүлээгүйгээс болж хаагдах тохиолдол олон байдаг. ХААБ нь биржийн хууль заасан сургалт явуулах, мэдээ, мэдээллээр хангах, бараа, түүхий эдийн чанарт хяналт тавих, баталгаажуулах, брокерийн үйлчилгээ үзүүлэх зэрэг ажлууд хангалтгүй хэрэгжүүлжээ. | Биржийн зах зээл болон арилжаанд оролцогчдод зориулсан мэргэшүүлэх сургалт зохион байгуулах, зах зээлийн мэдээ, мэдээллээр тогтмол хангах, агуулахын үйлчилгээ үзүүлэх, бараа, түүхий эдийн чанарт хяналт тавих, баталгаажуулах үйлчилгээ үзүүлэх | Хоршоонд суурилсан агуулахын үйлчилгээг нэвтрүүлэх, олон тооны оролцогчдыг татахад чиглэсэн маркетингийн бодлогыг хэрэгжүүлэх, шаардлагатай мэдээ, мэдээллээр тогтмол хангах | ХААБ нь орон нутагт өөрийн агуулах, лаборатори, түүхий эдэд хяналт тавих мэргэжилтэн байхгүй, өргөн цар хүрээтэй маркетингийн бодлого, зар сурталчилгаа сургалт, судалгаа, мэдээ мэдээллийн үйлчилгээ сул, эдгээр үйлчилгээнд төсөв бага төсөвлөж байна. Брокерууд |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | цогц бодлого байхгүй байна. | хэрэглэгчдийг татах, мэргэжлийн үйл ажиллагаа, үйлчилгээ үзүүлэх ажлыг хийхгүй байна. |
| Арилжааны төрөл | Танхимийн болон цахим арилжаа хийж байна. Брокерууд орон нутгаас түүхий эд худалдан авсаны дараагаар экспортын тодорхойлолт авахын тулд нөхөж арилжаа хийж байна. ХААБ-ийн арилжааны дийлэнх нь спот арилжаа ээзлж байна. Биржээр арилжааны гэрээнд үнэ, чанар, тоо хэмжээ, хүргэлтийн байршил зэрэг үзүүлэлтүүд тусгагдаж байгаа ч чанарын баталгаажуулалт хийгдэхгүй байна. | Эхний ээлжинд нээлттэй, ил тод, шударга байдлаар хоршоонд суурилсан агуулахын үйлчилгээ үзүүлэх замаар спот арилжааны худалдаа явуулж, олон тооны оролцогчдыг татах замаар биржид итгэх итгэлийг бий болгосны дараагаар форвард арилжаа явуулах, мөн агуулахын батламжид суурилсан даатгалын үйлчилгээ, санхүү-зээлийн үйлчилгээ авах нөхцлийг бүрдүүлэх | Нөхөж арилжаа хийхгүй байх, агуулахтай хоршоодыг арилжаанд түлхүү оролцуулах, форвард арилжааг нэвтрүүлэх, агуулахад байгаа бараанд суурилсан зээл, санхүүгийн үйлчилгээ авах боломж бүрдүүлэх шаардлагатай байна. | Чанарын баталгаа байхгүй, орон нутагт салбар, сүлжээ байхгүй, спот арилжаа голлон хийж байгаа тохиолдолд тогтолцооны зардал буурахгүй, тогтолцооны дийлэнх маржин буюу ашгийн завсрын худалдаачид хүртэх боломжтой байдаг. |
| Оролцогчдын сэтгэл ханамж | Ярилцлага болон уулзалт хийсэн оролцогчид нь ХААБ-д сэтгэл хангалуун биш, биржид итгэх итгэл сул байна. | Биржид итгэх итгэлийг сэргээх, биржийн талаарх зөв, нэгдсэн ойлголтыг олон нийтэд хүргэх ажлуудыг хийх | Бодит арилжаа хийх, үйлчилгээний чанар болон хүртээмжийг нэмэгдүүлэх, барааны чанарт баталгаа өгөх хэрэгтэй байна. | Биржийн талаар цэгцтэй, нэгдсэн ойлголтыг өгөхгүй, мөн чанарт суурилсан ялгавартай үнэ бүрддэг, бодит арилжаа, үйлчилгээ үзүүлдэг биржийн тогтолцоо байхгүй байна. |
| **Хоёр. Соёл** | | | | |
| Биржийн хууль | Биржийн хуульд 5 удаа өөрчлөлт орсон. Биржийн хуулийн хэрэгжилт хангалтгүй байна. | Биржийн хуулийг үр дүнтэй хэрэгжүүлэх, хэрэгжилтийг эрчимжүүлэх, биржийн хуульд зарим нэмэлт, өөрчлөлт оруулж сайжруулах | БУЗөвлөл, лаборатори, хоршоодын оролцоог хангах ажлууд хангалтгүй байна. | Биржийн зохицуулах зөвлөл ажиллахгүй байгаа, хоршооны оролцоо, барааны чанарын баталгаажуулалт байхгүй, оролцогчдын үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх, агуулахын аж ахуйг хөгжүүлэх шаардлагатай. |
| Төрийн бодлогын уялдаа | Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого, хөтөлбөр, төсөл арга хэмжээ, Цахим хөдөө аж ахуйн хөтөлбөр болон нэмэгдсэн өртгийн албан татвар болон хоршооны хуультай уялдуулан хөдөө аж ахуйн биржийн үйл ажиллагаар | Төрийн бодлоготой уялдуулан хөдөө аж ахуйн биржийн үйл ажиллагаар эрчимжүүлэх, сайжруулах, хөгжүүлэх | Алсын хараа 2050 урт хугацааны хөгжлийн бодлого, Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого, Цахим хөдөө аж ахуй хөтөлбөр, холбогдох хуулиудтай | Олон улсад төрөөс аж үйлдвэр, худалдааны талаар баримтлах бодлоготой уялдан хөдөө аж ахуйн биржийн бодлого, стратегийг хэрэгжүүлж байна. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | сайжруулах ажил удааширалтай байна. | | уялдуулан биржийн хууль эрх зүйн орчин, стратеги төлөвлөгөө зэргийг сайжруулах шаардлагатай байна. | |
| ХААБиржийн журам | Хугацаа хоцрогдолтой ч гэсэн 20 орчим журам батлагдан хэрэгжиж байна. | Нээлттэй, бодит арилжаа хийх, барааны чанарт тавих хяналтыг сайжруулах, агуулахын аж ахуйг хөгжүүлэх, хоршоодын оролцоог нэмэгдүүлэх, оролцогчод тавих шаардлага, эрх, үүргийг сайжруулах | Мөшгих тоготолцоо, цахим татвар, хөдөө аж ахуйн урамшууллын бодлого болон Алсын хараа 2050 хөгжлийн бодлоготой уялдуулах шаардлагатай байна. | 2016-2021 онд хөдөө аж ахуйн салбарын бүтээгдэхүүн, үйлчилгээг цахимжуулах, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг биржээр арилжаалах тухай төрийн бодлогууд батлагдан хэрэгжиж байна. |
| Стандарт | Монгол Улсын үндэсний стандартын дагуу хөдөө аж ахуйн бараа, түүхий эдийг бэлтгэх стандартууд хэрэгжиж байна. Эдгээр стандартын дагуу бэлтгэн нийлүүлэх ажлууд хийгдэхгүй байна. Журамд хөдөө аж ахуйн түүхий эдийг үндэсний стандартын дагуу бэлтгэн холбогдох баталгаажуулалт, хяналтыг хийсний үндсэн дээр арилжаанд оруулахаар тусгасан хэдий ч бэлтгэлийн стандарт хэрэгжихгүй байгаагаас түүхий эдийн чанар муудсан. Биржээр арилжих бараанд чанарын хяналт хийгдэхгүй байна. | Монгол Улсын үндэсний стандартын дагуу хөдөө аж ахуйн бараа, түүхий эдийг бэлтгэх стандартуудыг ХААБ-ийн өөрийн онцлог, хэрэглэгчийн стандартад нийцүүлэн шинэчлэх боловсруулах, заавал даган мөрдүүлэх, хоршоонд суурилсан агуулахын аж ахуйн үйлчилгээгээр дамжуулан биржээр арилжаалах бараанд чанарын  хяналт хийх | Монгол Улсын үндэсний стандартын дагуу хөдөө аж ахуйн бараа, түүхий эдийг бэлтгэх стандартад тавих төрийн хяналт сул байна. | Малчид үйлдвэрийн төлөөлөгч болон ченжүүд түүхий эдээ ангилан бэлтгэхгүйгээр шууд худалдан авч арилжаанд оруулж байна. |
| Чанарын баталгаа | Орон нутагт сумдын хөдөө аж ахуйн газар, мал эмнэлэг, үржлийн нэгжээс тодорхойлолт авсаны үндсэн дээр арилжаанд оруулж байна. Энэ тодорхойлолт нь малын эрүүл мэнд талаас тодорхойлж байгаа болохоос түүхий эдийн чанарыг баталгаажуулах тодорхойлолт болж чадахгүй байна. Мөн орон нутагт | Орон нутагт хоршоонд суурилсан агуулахын аж ахуйг хөгжүүлж, агуулахын аж ахуйд түүхий эд бэлтгэлийн ажилд хянагч ажиллуулах, агуулахыг тоногжуулж, бараа түүхий эдийг хүлээн авах, ангилах, бэлтгэх, лабораториор хянан баталгаажуулсны дараагаар арилжаанд оруулах | Хөдөө аж ахуйн бараа, түүхий эдийг ангилан бэлтгэх, чанарт шинжилгээ хийх лобатори болон мэргэжилтэн орон нутагт байхгүй, хоршоодын оролцоо сул зэрэг асуудлууд байна. | Орон нутагт агуулахтай хоршоо хичнээн байгаа талаар судалгаа байхгүй, мөн хоршоодыг арилжаанд оролцуулдаггүй, цөөн тооны брокерууд арилжаанд оролцдог. Итгэмжлэгдсэн агуулахууд Улаанбаатар байрлаж байна. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | лаборатори байхгүй байна. | | | |
| **Гурав. Бүтэц, зохион байгуулалт** | | | | |
| Биржийн бүтэц, зохион байгуулалт | Хувьцаа эзэмшигчдийн оролцоо багатай бүтэц, зохион байгуулалттай байна | Олон тооны хувьцаа эзэмшигчидтэй, тэдгээр хувьцаа эзэмшигчдыг өсөн дэвших мерит зарчимд суурилан Биржийн Удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлага, Зохицуулах зөвлөлд оролцуулах, идэвх оролцоог нэмэгдүүлэх | Төрийн өмчид аж ахуйн нэгж хэлбэрээр үйл ажиллагаа явуулж байна. | Хувьцаат компани хэлбэрээр байгуулаагүйгээс хувьцаа эзэмшигчдийн тоо цөөн, оролцоо бага байна. |
| Биржийн Зохицуулах зөвлөл | Биржийн Зохицуулах зөвлөл 2013-2017 оны хугацаанд ажилласан боловч өнөөг хүртэл ажиллагаагүй хэвээр байна. Биржийн Зохицуулах зөвлөлийн үүргийг төрийн өмчийн Биржийн Удирдах зөвлөл гүйцэтгэж байгаа ч оролцоо нь бага байна. | Биржийн зохицуулах зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх | Биржийн өмнө шийдвэрлэх шаардлагатай олон асуудлууд шийдлээ хүлээсээр байна. | Биржийн хуульд өөрчлөлт оруулж, биржийн ажлын хэсгийг татан буулгаснаар Биржийн зохицуулах зөвлөл ажиллаагүй байна. Биржийн зохицуулах зөвлөл ажиллах эрх, үүрэг нь хуульд хэвээр байна. |
| Биржийн оролцогчид | Цөөн тооны брокерууд арилжаанд оролцож байна. Хоршоодын оролцоо байхгүй. | Олон тооны оролцогчдыг татан оролцуулах, хоршоодын оролцоог идэвхжүүлэх | Биржийн брокеруудад тавих СЗХ-оос санхүүгийн шаардлага өндөр байна. Цөөн тооны брокерууд арилжаанд оролцож үнэ тогтоох хандлагатай байна. | Хоршоодын менежмент болон оролцоо сул, санхүүжилт бага байна. Брокеруудын хувьд СЗХ-оос тавьсан шаардлагыг ханган оролцож байна. |
| Биржийн дэд бүтэц, хөрөнгө оруулалт | Бирж байгуулахад төрөөс 5 тэрбум төгрөг төлөвлөсөн боловч 1 тэрбум төгрөгийг олгосон. Төрийн бодлоготой уялдуулан биржийн дэд бүтцийг сайжруулах шаардлагатай хэвээр байна. | Төрийн бодлоготой уялдуулан биржийн агуулахын аж ахуйг хөгжүүлэх, цахим татвар, даатгал, санхүүгийн үйлчилгээг сайжруулах, хөрөнгө оруулах | | Биржийг хөгжүүлэхэд томоохон хөрөнгө оруулалтууд бага хийгджээ. |
| Биржийн арилжааны платформ | Уламжлалт технологид суурилсан арилжааны платформтой байна. Энэ платформыг шинэчлэх ажлууд хийгдэж байна. ХААБ нь блокчейн технологид суурилсан арилжааны платформыг хөгжүүлсэн хэдий ч одоогоор турших, арилжааны системд | Блокчейн технологид суурилсан арилжааны платформыг хөгжүүлсэн, хараахан турших, нэвтрүүлэх, цахим арилжааг хөгжүүлэх | Оролцогчдод нээлттэй бус, цахим арилжаанд оролцох боломж сул байна. Сүүлийн жилүүдэд олон улсад үйл ажиллагаа явуулж байгаа ихэнх барааны биржүүд баталгаатай, аюулгүй | Бирж байгуулагдаж эхэлсэн цагаас хойш орчин үеийн арилжааны платформыг байгуулах ажлууд хийсээр ирсэн. Тухайлбал NASDAQ арилжааны системийг нэвтрүүлэхээр талаар багагүй ажилласан боловч бүтээгүй. Уламжлалт |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | нэвтрүүлэх ажил хараахан хийгдээгүй байна. | | системтэй платформыг ашиглан цахим арилжаа хийхэд голлон анхаарч ажиллаж байна. | арилжааны платформ нь найдвартай, аюулгүй ажиллах боломж сул юм. |
| Биржийн эко-систем | Агуулахын аж ахуй, лаборатори, банк, даатгал, түүхий эдийн мэргэжилтэн орон нутагт байхгүй байна. | Хоршоонд суурилсан агуулахын аж ахуйг хөгжүүлэх, хоршооны үйл ажиллагаатай уялдуулан банк, даатгал, явуулын лабораторийг бий болгох, түүхий эдийн мэргэжилтэн бэлтгэж, ажлуулах | Төв аймгийн Аргалант суманд ложистикийн төв байгуулсан боловч үйл ажиллагаа эхлээгүй, орон нутагт биржийн салбар, сүлжээ, агуулах байхгүй байна. | Төрийн мэргэжлийн хяналтын байгууллага болон хоршоодын оролцоо, хамтын ажиллагаа сул байгаатай холбоотой байна. |
| **Дөрөв. Санхүү, хүн хүч** | | | | |
| Ажиллах хүч | ХААБ нь 5 нэгжийн нийт 43 ажилтантайгаар ажиллаж байна. | Биржийн ажиллагсдыг мэргэшүүлэх, биржийн оролцогчдыг татах, сургах, судалгаа хийхэд анхаарах | Оролцогчдод үзүүлэх үйлчилгээ, биржийн арилжаа болон арилжааны зах зээлд оролцогчдын хоорондох хамтын ажиллагаа болон ажлын байрын уялдаа холбоог сайжруулах шаардлагатай. | Биржээс үзүүлэх үйлчилгээ сул үзүүлж байна. Мөн гадаадын биржүүд, дотоодын төрийн байгууллагууд, мэргэжлийн холбоод, арилжааны зах зээлд оролцогидтой хамтран ажиллах ажлууд сул байна. |
| Санхүү | Бирж жилд дундажаар 3-5 тэрбум төгрөгийн шимтгэлийн болон бусад орлого олж байна. | Бирж орлогыг нэмэгдүүлж, биржийн эко-системийг хөгжүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалтад зарцуулах | Төлөвлөсөн хэмжээнд орлого нэмэгдэж байгаа ч тогтвортой биш байна. | Биржийн оролцогчид биржид шимтгэл төлж байгаад сэтгэл дундуур байна. |
| Шимтгэл, хураамж | Шимтгэл 0.22-1.0 хувьтай байна. Шимтгэлийг бууруулах талаар оролцогч талууд гомдол гаргаж байна. | Биржээр арилжаалах бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлэх замаар биржийн шимтгэлийн бууруулах | | |

## 5.6. Дэд дүгнэлт

Хэрэв олон улсын жишгээр хөдөө аж ахуйн биржийн үйл ажиллагаа явагддаг бол дараах үйл ажиллагаа явагдах боломжтой юм.

Товчоор хэлэхэд малын эрүүл мэнд, үүлдэр угсаа, ашигт шимийн талаар сумын мэдээллийн санд бүртгэгдсэн, даатгалд хамрагдсан, хоршооны гишүүн нь өөрийн түүхий эдийг стандартын дагуу анхан шатны тордолт хийснээр биет арилжаанд оролцох боломжтой болно. Хэрэв малчин ирэх жилийн түүхий эдээ барьцаалан өнөөдөр арилжаанд оролцохыг хүсвэл дээрх нөхцлийг хангасан байхад форвард арилжаанд мөн оролцох боломжтой бөгөөд бусад улсын туршлагаар ирээдүйн барааны 30 хүртэлх хувьд зээл авах боломжтой байдаг.

Форвардын арилжаа хийж байгаа үед гэрээнд заасан тоо хэмжээ, чанар стандартыг хангасан бараа, бүтээгдэхүүнийг гэрээгээр тохирсон хугацаанд багтаан биржийн итгэмжлэгдсэн агуулахад нийлүүлнэ. Биржийн агуулах барааг шалгаж хүлээж авсаны дараагаар барааны чанарын болон агуулахын гэрчилгээг худалдагчид олгоно. Агуулахын гэрчилгээг хоршоод эсвэл брокеруудын агуулахын мэргэжилтэн шалгаж, тодорхойлсны үндсэн дээр олгоно. Харин чанарын гэрчилгээг орон нутгийн мал эмнэлэг, үржлийн тасаг болон түүхий эд бэлтгэгч, хянагч нь олгоно. Шаардлагатай бол түүхий эдийг лабораториор дээшлэн баталгаажуулна. Дараагаар нь малчин нь уг баталгааг өөрийн брокерийн пүүс эсвэл хоршоонд хугацаанд өгч арилжаанд оруулдаг.

Биржийн арилжаанд оролцож форвардын арилжаа хийх үед худалдагч, худалдан авагч талууд төлбөрийн бүрэн чадвартай байх, гэрээгээр хүлээсэн үүргээ харилцан биелүүлэх баталгаа болгож тодорхой хэмжээний урьдчилгаа төлбөр буюу дэнчин тавьдаг. Хэрэв форвардын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй буюу хагас дутуу биелүүлсэн тохиолдолд эрсдлийг үүрэх чадвартай байх шаардлагатай. Агуулахад бараа бүтээгдэхүүнээ байршуулж байгаа бол урьдчилгаа бага байх бөгөөд агуулахад бараа бүтээгдэхүүн байршаагүй, харин өмнөх саруудын худалдан авалтын хэмжээ, гэрээг үндсэн арилжаа хийж байгаа бол урьдчилгааны хэмжээ өндөр байна.

Даатгалын байгууллагаар даатгуулсан чанарын болон агуулахын гэрчилгээнд суурилсан гэрээ нь санхүүгийн хэрэгсэл болохыг төр, банк санхүүгийн байгууллагууд баталгаажуулах шаардлагатай. Баталгаажуулж чадвал малчин урьдчилж зээл авах боломж бүрдэнэ. Нөгөө талдаа даатгалын байгууллага, малчдын хариуцлага, баталгаажуулалт өгч байгаа лаборатори, төрийн хяналтын байгууллагуудын хариуцлага өндөрсөнө. Бараа нь агуулахад байгаа тохиололд зээлийн урьдчилгаа өндөр дүнтэй, байхгүй бол бага дүнтэй байх шаардлагатай.  Ийм олон төрлийн шаардлагууд, урьдчилсан нөхцлүүдийг хангаж байж биржийн үйл ажиллагаа амжилттай явагддаг.

Ерөнхийдөө дүгнэхэд биржийн хуулийн хэрэгжилт хангалтгүй байна. Биржийн тулгамдаж байгаа асуудал бүрээр дүн шинжилгээ хийж, шалтгааны талаар тодорхойлох гэж оролдлоо.  Нөхцөл байдлын шинжилгээ нь биржийн стратегийн зорилтыг тодорхойлох гол үндэслэл нь учраас энэхүү судалгаанд ихээхэн ач холбогдол өгч олон талаас нь судлахыг хичээлээ.

# ЗУРГАДУГААР БҮЛЭГ. БИРЖИЙГ ХӨГЖҮҮЛЭХ СТРАТЕГИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ТӨЛӨВЛӨЛТ

## 6.1. Стратегийн зорилго, зорилтууд, стратегийн үе шат

Стратегийн төлөвлөгөө боловсруулах хүрээнд нөхцөл байдлын шинжилгээ хийж, түүний нэгдсэн үр дүнгийн талаар хүснэгт 1 -д харуулав.

Хүснэгт 57. Стратегийн төлөвлөгөө боловсруулах хүрээнд хийгдсэн нөхцөл байдлын шинжилгээний дүгнэлт

| Шинжилгээ | Нөлөөлөх хүчин зүйлс |
|---|---|
| **Зах зээлийн шинжилгээ** | **Зах зээлийн боломж:**<br>- Монгол Улсын хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдийн нөөц нь 2.0 тэрбум ам.доллар буюу ДНБ-ний 10 гаруй хувьтай тэнцэх хэмжээний үнэлгээтэй байна.<br>- Жилд дундажаар 6.1 хувиар мал аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн нөөц нэмэгдэж байна. Энэ нь дэлхийд тэргүүлэх үзүүлэлт юм.<br>- ХААБ-ээр арилжаалж байгаа бараа, түүхий эдийн нийт дүн нь зах зээлийн нийт нөөцийн 10 орчим хувийг эзэлж байна. Энэ нь биржийн хувьд том нөөц, боломж байгааг харуулж байна. |
| **SWOT шинжилгээ** | **Дотоод байдал:**<br>- Биржийн арилжаа ил тод биш, мөн цөөн нэр төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлж байна.<br>- Спот арилжаа голлон хийж, цөөн тооны брокерууд арилжаанд оролцож байна. Харин хоршоодын хувьд оролцож чадахгүй байна.<br>- Биржийн дэд бүтэц, эко-систем бүрдээгүй, биржээр арилжаалах бүтээгдэхүүнд анхан шатны тордолт хийж, чанарыг баталгаажуулах систем хөгжөөгүй байна.<br>- Биржийн арилжааны платформ, ложистик төв, эрх зүйн орчин бүрдсэн гэхдээ эдгээрийг үр дүнтэй, оновчтой менежмент хийх, сайжруулах шаардлага тулгарч байна.<br>- Бие даасан санхүүгийн боломж бүрдсэн, гэхдээ хөрөнгө оруулалт хийх хэмжээний санхүүжилт хангалтгүй хэвээр байна.<br>- Биржээр арилжаалсан бүтээгдэхүүний арилжааны шимтгэл өндөр байна.<br>- Биржийн талаарх нэгдсэн ойлголтод биржийн бүх оролцогчид, иргэд хүрч чадаагүй байна. Олон оролцогчид биржийн үйл ажиллагаанд сэтгэл хангалуун биш байгаа нь ажиглагдсан.<br>- Брокер нь олгосон эрхийн хүрээнд оролцогчдыг татах үйлчилгээ үзүүлэхгүй, харин өмнө хэвшсэн ченжийн зарчмаар ажиллаж байна.<br>- Биржийн бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэх шаардлагатай байна.<br>- Биржийн үйл ажиллагаанд хяналт тавих төрийн хяналт болон биржийн гадаад, дотоод хамтын ажиллагаа сайжруулах шаардлагатай байна<br>**Гадаад байдал:**<br>- Алсын хараа 2050 хөгжлийн бодлого, Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн салбарт баримтлах бодлого, “Цахим хөдөө аж ахуй” хөтөлбөр, “Мөшгих тогтолцоо” мэдээллийн сүлжээ, хөдөө аж ахуйн урамшууллын бодлоготой уялдуулан Хөдөө аж ахуйн биржийн эрх зүйн орчин, үйл ажиллагааг эрчимжүүлэх арга хэмжээ авч байна. |

| | | |
|---|---|---|
| | | - Дархан-Уул, Ховд, Улаанбааатарын Эмээлтэд арьс шир боловсруулах цогцолт аж үйлдвэрийн парк байгуулж байна.<br>- Орон нутагт түүхий эдийг бэлтгэх бичил зах зээл үүссэн бөгөөд үүнийг биржийн үйл ажиллагаатай уялдуулах шаардлагатай байна.<br>- Гадаад, дотоод зах зээлд чанартай түүхий эд худалдан авах эрэлт, хэрэгцээ нэмэгдэж байна. |
| **PESTLE шинжилгээ** | **Гадаад байдал:**<br>- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын бодлогууд өөрчлөгдөж, эдгээр өөрчлөлттэй уялдуулан биржийн тогтолцоог сайжруулах хүрээнд цахим хөдөө аж ахуйд суурилсан цогц мэдээллийн платформыг хөдөө аж ахуйн биржийн арилжааны цахим платформтой холбож, нэгдсэн мэдээллийн урсгалыг бий болгох шаардлага тулгарч байна.<br>- Дархан-Уул, Ховд, Улаанбааатарын Эмээлтэд арьс шир боловсруулах цогцолт аж үйлдвэрийн паркийн үйл ажиллагааг дэмжиж, чанартай түүхий эдээр тогтвортой хангах биржийн сүлжээг бүрдүүлэх хэрэгцээ үүссэн.<br>- Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл нэмэгдэж байгаа хэдий ч малын үүлдвэр угсаа, ашиг шимийг сайжруулах, түүхий эдийн чанарт дэвшил гаргах, үйлдвэрүүд болон хоршоодыг шууд холбосон биржийн сүлжээг бүрдүүлсэн арилжааны орчинг боловсронгуй болгох нь зүйтэй байна.<br>- Хөдөө орон нутагт интернет, харилцаа холбооны сүлжээ бүрэн нэвтэрч, цахим арилжаа хийх таатай нөхцөл бүрдсэн байна.<br>- Үндэсний үйлдвэрүүд техник, технологийн шинэчлэл хийж, брэнд бүтээгдэхүүний бий болгож, өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэх, гадаад зах зээлд үндэсний брэнд бүтээгдэхүүнээ таниулах, экспортлох арга хэмжээ авч байна.<br>- Хэрэглэгчид үндэсний бүтээгдэхүүн, экологийн бүтээгдэхүүн хэрэглэх хандлагатай болж байна. | |
| **GAP шинжилгээ** | **Тулгамдсан суудал:**<br>- Малчид, тариаланчид болон үйлдвэрүүдийг шууд холбосон биржийн сүлжээ байгуулж чадаагүй байна.<br>- Кросс арилжаа хийж байгаа нь биржийн хуульд заасан нээлттэй, ил тод, шударга байх зарчимд нийцэхгүй байна.<br>- Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн 10 орчим хувийг биржээр арилжаалж байгаа бөгөөд цаашид 100 хувьд хүргэж боломжтой юм. Гол асуудал нь түүхий эдийн чанарыг сайжруулах явдал юм.<br>- Биржээс чанартай, сайн үйлчилгээ үзүүлж чадахгүй, брокерууд мөн брокерийн үйлчилгээгээр хангаж чадахгүй байна.<br>- Биржийн арилжааны дийлэнх нь ноос, ноолуурын спот арилжаа эзэлж байна. Түүхий эдийн чанарт хяналт тавих, чанартай түүхий эдээр үйлдвэрүүдийг хангах ажил хангалтгүй байна.<br>- Биржид хандах оролцогчдын хандлага болон итгэл сул байна.<br>- Биржийн хуулийн хэрэгжилт хангалтгүй, биржийн дүрэм, журмын дийлэнх нь цаг хугацаа ихээхэн алдаж батлагдсан байна.<br>- Биржийн хууль, төрийн бодлоготой уялдуулан биржийн дүрэм, журмыг сайжруулах шаардлагатай байна.<br>- Үндэсний стандартын дагуу түүхий эдийн стардартыг биржийн нөхцөлд шинэчлэн батлах ажил хийгдээгүй, мөн түүхий эдэд анхан шатны тордолт хийж, бэлтгэн нийлүүлэх ажил орон нутагт хийгдэхгүй байна. | |

| | |
|---|---|
| | - Орон нутагт лаборатори байхгүй, хоршооны бирж дэх оролцоо сул байна.<br>- Орон нутгийн банк, даатгалын байгууллагын хамтын ажиллагааг биржийн үйл ажиллагаатай уялдуулан ажиллах хэрэгтэй байна.<br>- Олон улсын бирждтэй харьцуулахад ХААБ-ийн бүтэц, зохион байгуулалт сул, хувь оролцогчдын бүрэлдэхүүн цөөн байна.<br>- Биржийн зохицуулах зөвлөл 2017 оноос хойш үйл ажиллагаа явуулаагүй байна.<br>- Өмнөх ченжийн тогтолцооны сууринд бий болсон цөөн тооны брокерууд биржийн арилжаанд идэвхтэй оролцож байна.<br>- Бирж байгуулахад төрөөс хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэг сул үзүүлжээ.<br>- Биржийн дэд бүтэц, эко-систем бүрдээгүй байна.<br>- Биржийн арилжааны шимтгэл өндөр байна.<br><br>**Эрсдэл:**<br>- Биржийн оролцогчдын биржийн талаарх мэдлэг, мэдээлэл, ойлголт ихээхэн зөрүүтэй байна. Нэг ойлголтод хүргэх нь зүйтэй байна.<br>- Биржийн дэд бүтэц, эко-системийг бүрдүүлэхэд ихээхэн хэмжээний санхүүжилт, хөрөнгө оруулалт шаардлагатай байна. Төрөөс хөрөнгө оруулалт гаргахад хүндрэлтэй байдаг. Төрийн бодлоготой оновчтой уялдуулан төр, хувийн хэвшлийн хамтын хөрөнгө оруулалтаар шийдэх хэрэгтэй болов уу.<br>- Хоршоодын санхүү, хөрөнгө оруулалт, менежментийн чадвар сул, агуулахтай хоршоодын тоо цөөн байх талтай байна. Агуулахтай малдчын жинхэнэ хоршоо, түүний чадавхийн талаар бодит, үр дүнтэй бүртгэл хийж, хамтран ажиллах, төр, хувийн хэвшил, олон улсын байгууллагын хамтын ажиллагаагаар тэдгээрийн үйл ажиллагааг бэхжүүлэхэд ихээхэн хүч, цаг хугацаа шаардах эрсдэл байна.<br>- Хувийн хэвшилд суурилсан албарын мэргэжлийн чанарын баталгаажуулалтын нэгжийг байгуулах, тэдгээрийг мэргэшүүлэх, эрх зүйн орчинг бүрдүүлэхэд ихээхээн хугацаа орно.<br>- Банк, даатгал, агуулахын аж ахуй болон биржийн үйл ажиллагааг уялдуулан  биржийн оролцогчид бараагаа барьцаалан урьдчилан зээл авдаг байх тогтолцоог бүрдүүлэхэд мөн ихээхэн хүчин чармайлт, цаг хугацаа шаардана. |
| **Дүгнэлт** | - Хөдөө аж ахуйн биржийг байгуулах бэлтгэл ажил хангалтгүй хэрэгжүүлсэн байна. Бусад улсын туршлагаас харахад дор хаяж 2-5 жилийн хугацаанд биржийн эрх зүйн орчин, бизнес төлөвлөгөө болон санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэж, бэлтгэл ажил бүрэн хангагдсны дараагаар биржийн үйл ажиллагааг эхлүүлдэг байна.<br>- Биржийн хуулийн хэрэгжилт хангалтгүй, биржийн үйл ажиллагаа зарим талаар доголдолтой байна.<br>- Биржийн одоогийн үйл ажиллагааг үндэсний онцлогт нийцүүлэн олон улсын биржийн түвшинд хүргэж ажиллахад ихээхэн цаг хугацаа, хүчин чармайлт, тогтвортой менежментийн үйл ажиллагаа шаардаж байна.<br>- Эхний ээлжинд хоршоонд суурилсан агуулахын аж ахуйг хөгжүүлэх, биржийн зохицуулах зөвлөлийг ажиллуулах, төрийн бодлоготой уялдуулан биржийн үйл ажиллагааг бүхэлд нь сайжруулах зэрэг ажлуудыг хийх нь зүйтэй байна. |

Хөдөө аж ахуйн биржийн стратеги төлөвлөгөө нь биржийн зорилго, зорилтод чиглсэн үйл ажиллагааны стратеги байх шаардлагатай юм. Сайтар боловсруулагдсан стратеги төлөвлөгөө нь биржийн үйл ажиллагааг тогтвортой хэрэгжүүлэх, урт хугацаанд ажиллах боломжийг бүрдүүлдэг. Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд хүний нөөц, албадуудын хоорондох хамтын ажиллагаа ихээхэн чухал юм. Стратегийн зорилгыг хэрэгжүүлэхэд байгууллага, алба болон ажиллагсад нэг зүгтээ анхаарлаа төвлөрүүлж, хөрвөх чадвартай, уян хатан байдлаар хамтын ажиллагаагаа өрнүүлж, ажлын уялдаагаа хангаж ажилласнаар биржийн үйл ажиллагааны стратегийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэх явцад тулгарах аливаа эрсдлүүдийг даван туулах, бууруулах боломжтой байдаг. Мөн түүнчилэн төрийн бодлого, орчин үеийн технологийг судалж, үйл ажиллагаандаа нэвтрүүлэх зарчим баримтлах ажиллах нь зүйтэй байдаг. Техник, технологийн дэвшлийн эерэг үр нөлөөгөөр төрөл бүрийн үр ашиггүй байдлыг шийдвэрлэх боломжтой төдийгүй бизнесийн үр ашгийг нэмэгдүүлэх, зардлыг бууруулах, бүтээмжийг өсгөх, бие даасан байдлыг бий болгоход ихээхэн нөлөөтэй байдаг. Дараагийн асуудал нь биржийн арилжаанд оролцогчдын үйл ажиллагаанд анхаарлаа төвлөрүүлж, тэдгээрийг шүүмжийг соргогоор мэдэрч, шүүмжийг боломж болгон ашиглахад анхаарч ажиллах шаардлагатай байдаг. Бирж нь байгууллагын ашиг, ажиллагсдын бүтээмжид хэт их анхаарал хандуулснаар биржийн хамтын ажиллагаа, биржийн оролцогчдод үзүүлэх үйлчилгээтэй холбоотой ажлууд хаягддаг. Үүнээс болж хэрэглэгч болон байгууллагын хооронд үл ойлголцол үүсдэг. Ажиллагсдын чадварт цаг үргэлж анхаарч, сайжруулах, мэргэжүүлэх арга хэмжээ авч ажиллах нь чухал юм. Ажиллах хүчин бол байгууллагын стратегийн зорилтыг хэрэгжүүлэх цөм юм.

Иймд байгууллагын хувьд дараах зарчмыг санал болгож байна. Үүнд:

| | |
|---|---|
| **Судалгаанд суурилдаг байх** | Судалгаанд суурилан стратеги төлөвлөгөөний зорилтыг дэвшүүлэх, стратегийн зорилтод бодит үнэлгээ хийж, үйл ажиллагаагаа эрчимжүүлэх |
| **Ажлын уялдаа холбоог хангах** | Байгууллага, алба, хувь хүмүүсийн хамтын ажиллагаа, ажлын уялдааг сайжруулах, ажиллагсдыг уян хатан, хөрвөх чадвартай ажиллуулах; |
| **Гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх** | Биржээр үзүүлэх үйлчилгээ, гадаад хамтын ажиллагааг сайжруулахад анхаарлаа төвлөрүүлэх; |
| **Ажиллагсдын чадварыг сайжруулах** | Ажиллагсад биржийн стратегийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх гол хүчин зүйл. Ажиллагсдын уян хатан, хөрвөх чадвартай ажиллах нөхцлийг бүрдүүлэх. |
| **Техник, технологийн дэвшлийг нэвтрүүлдэг байх** | Техник, технологийн үр дүнд биржийн арилжааны үйл ажиллагаа сайжирч, аливаа зардлуудыг бууруулах, биржийн оролцогчдыг татах, шинэ бизнесийн төрлүүдийг хөгжүүлэх, төрийн бодлогын уялдааг хангахад ач холбогдолтой. |
| **Хэрэглэгчдэд үзүүлэх үйлчилгээгээ сайжруулах** | Хөдөө аж ахуйн бирж нь төрийн өмчид компани бөгөөд гол хэрэглэгчид нь малчид, тариаланчид, үйлдвэрүүд, хоршоод, брокерууд байдаг. Тэдгээрийг татах, оролцоог нэмэгдүүлэх, биржид итгэл итгэлцлийг нэмэгдүүлэхэд бүх анхаарлаа хандуулж ажиллах нь стратегийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх хамгийн чухал алхам юм. |

Стратегийн төлөвлөгөөний зорилгын хувилбар

| | | |
|---|---|---|
| | Давуу тал (S):<br>- Хоршоо, брокероор дамжуулан олон тооны оролцогчид оролцох боломжтой<br>- ХААБ багагүй туршлага хуримтлуулсан<br>- Биржээр арилжаалсан бараа, түүхийг экспортлох боломжтой<br>- Биржийн эрх зүйн орчин, арилжааны платформ, ложистикийн төв бүрдсэн | Сул тал (W):<br>- Спот арилжаа зонхилж байгаа<br>- Шимтгэл, хураамжийн зардал өндөр байгаа<br>- Түүхий эдэд анхан шатны тордолт хийж, чанарын баталгаажуулалт хийх нөхцөл бүрдээгүй<br>- Биржийн Зохицуулах зөвлөл ажиллахгүй байна<br>- Гадаад хамтын ажиллагаа сул байна. |
| Боломж (O).<br>- Төрийн бодлогын дэмжлэг, ажлын уялдаа холбоо сайжирч байгаа<br>- ХАА-н түүхий эдийн нөөц нэмэгдэж байгаа<br>- Техник, технологийн хурдацтай хөгжиж байна. Үүнийг биржийн үйл ажиллагаанд ашиглах нь зүйтэй.<br>- Орон нутагт АҮП байгуулагдаж, биржээр арилжаалах бүтээгдэхүүний эрэлт өссөн төлөвтэй байна<br>- Үйлдвэрүүд техник, технологийн шинэчлэлт хийж, эрэлт хэрэгцээ өссөн | 1. **SO стратеги:** Давуу талдаа тулгаарлан боломжийг ашиглах стратеги<br><br>Төрийн бодлогын хүрээнд агуулахтай хоршоонд суурилсан цахим арилжааг хөгжүүлж, хоршоод болон үйлдвэрүүдийн шууд арилжаа хийх, экспортлох боломжийг бүрдүүлэх стратеги | 2. **WO стратеги:** Боломжийг давуу тал болгож, сул тулыг бууруулах стратеги<br><br>Хөдөө аж ахуйн биржийн хяналтын системийг сайжруулж, дэвшилтэд техник технологи, форвард, фьючерсийн арилжааг нэвтрүүлэх замаар түүхий эдийн чанарыг сайжруулах, шимтгэлийн хэмжээг бууруулах стратеги |
| Аюул (T):<br>- Цаг агаарын өөрчлөлт<br>- Улирлын нөхцөл байдал<br>- Гадаадын худалдан авагчдын хүчтэй оролцоотой хэвээр байна.<br>- Биржийн дэд бүтэц, эко-систем сул хөгжсөн<br>- Орон нутагт биржийн сүлжээ байхгүй<br>- Хөрөнгө оруулалт, санхүүгийн эх үүсвэр хангалтгүй | 3. **ST стратеги:** Аюулыг бууруулж, давуу талаа ашиглах стратеги<br><br>Орон нутагт хоршоодод суурилсан агуулахын аж ахуй, эко-системийг хөгжүүлэх замаар хөрөнгө оруулалтыг татах, оролцогчдын зээл авах боломжийг бүрдүүлэх стратеги | 4. **WT стратеги:** Аюулаас зайлсхийж, сул талыг багасгах стратеги<br><br>Хөдөө аж ахуйн биржийн хяналтын системийг сайжруулах, түүхий эдийн чанарыг сайжруулах, хоршоодын оролцоог нэмэгдүүлэх стратеги |

Хүснэгт 58. Стратеги төлөвлөгөөний зорилго, зорилтууд

| WT стратеги | ST стратеги | WO стратеги | SO стратеги |
|---|---|---|---|
| Хөдөө аж ахуйн биржийн хяналтын системийг сайжруулах, түүхий эдийн чанарыг сайжруулах, хоршоодын оролцоог нэмэгдүүлэх стратеги | Орон нутагт хоршоодод суурилсан агуулахын аж ахуй, эко-системийг хөгжүүлэх замаар хөрөнгө оруулалтыг татах, оролцогчдын зээл авах боломжийг бүрдүүлэх стратеги | Хөдөө аж ахуйн биржийн хяналтын системийг сайжруулж, дэвшилтэд техник технологи, форвард, фьючесрийн арилжааг нэвтрүүлэх замаар түүхий эдийн чанарыг сайжруулах, шимтгэлийн хэмжээг бууруулах стратеги | Төрийн бодлогын хүрээнд агуулахтай хоршоонд суурилсан цахим арилжааг хөгжүүлж, хоршоод болон үйлдвэрүүдийн шууд арилжаа хийх, экспортлох боломжийг бүрдүүлэх стратеги |
| Дунд хугацаанд хэрэгжүүлэх стратегийн зорилтууд | | | |
| - Биржийн зохицуулах зөвлөлийн үйл ажиллагааг хэвийн явуулах<br>- Ил тод, нээлттэй арилжаа хийх, арилжаанд оролцогчдын тоог нэмэгдүүлэх<br>- Хоршоодын агуулахын хүчин чадал, чадавхад үнэлгээ хийх<br>- Гадаадын биржийн байгууллага, олон улсын төслүүдтэй хамтран ажиллах<br>- Түүхий эдийн бэлтгэгчдийг бэлтгэх<br>- Агуулахын аж ахуйг хөгжүүлэх<br>- Агуулахад байгаа түүхий эдэд чанарын баталгаажуулалт хийх хувийн хэвшлийн нэгжийг байгуулах | - Биржийн бүтцийг өөрчлөх, биржийн хувьцааг олон нийтэд арилжаалах, хөрөнгө босгох, нээлттэй хувьцаат компани болох<br>- Биржээр арилжаалах бүтээгдэхүүний чанарын баталгааг сайжруулах,<br>- Биржээс үзүүлэх үйлчилгээ, барааны нэр төрлийг нэмэгдүүлэх<br>- Эрх зүйн орчинг сайжруулах<br>- Агуулахын аж ахуйд суурилсан санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх | - Форвард, фьючерсийн арилжаа хийх нөхцлийг бүрдүүлэх<br>- Биржээр арилжаалах бүтээгдэхүүний арилжааны шимтгэл, хураамжийг бууруулах<br>- Банк, даатгал, тээврийн нэгдсэн үйлчилгээ үзүүлэх тогтолцоог бий болгох<br>- Орчин үеийн дэвшилтэд түүхий эд бэлтгэх, хөргөлттэй агуулахын тоног төхөөрөмжийг нэвтрүүлэх | - Мөшгих тогтолцоо, цахим татвар, цахим даатгал, цахим төрийн худалдан авалтын сүлжээг биржийн арилжааны системтэй холбож, чанарын үнэлэмжид суурилсан үнийн тогтолцоог бий болгох<br>- Экспортын барааны чанарт баталгаа олгох,<br>- Нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүнийг биржээр арилжаалах<br>- Бүх төрлийн хөдөө аж ахуйн бараа, түүхий эдийг биржээр арилжаалах<br>- Гадаадын хөрөнгө оруулалт татах |

Хөдөө аж ахуйн биржийн стратеги төлөвлөгөөг 2021-2025 оны хугацаанд 2 үе шаттайгаар дараах биржийг хөгжүүлэх стратегийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Үүнд:

- Ил тод, нээлттэй, шударга арилжаа хийх, арилжаанд оролцогчдын тоог нэмэгдүүлэх
- Биржийн үйл ажиллагаанд хяналт тавих тогтолцоог сайжруулах
- Хөдөө аж ахуйн биржийн агуулахын аж ахуй, дэд бүтэц, эко-системийг хөгжүүлэх
- Биржээр арилжаалах бүтээгдэхүүний тоо хэмжээ, нэр төрөл, чанарыг нэмэгдүүлэх, үйлчилгээг сайжруулах
- Биржийн бүтэц зохион байгуулалтыг сайжруулах, хамтын ажиллагааг хөгжүүлэх
- Биржийн бодлого, эрх зүйн орчинг сайжруулах
- Форвард болон фьючесрийн арилжаа хийх, санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх нөхцлийг бүрдүүлэх

Сул стратегиас хамгийн сайн стратеги руу үе шаттайгаар хүрэхээр тооцооллоо. Үе шат бүрд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийж, дараагийн шат руу орох нь зүйтэй байна. Биржийн стратеги төлөвлөгөө нь 2 үе шаттай байх бөгөөд эхний шатанд бодит арилжаа хийх нөхцөл бүрдэж, биржээс үзүүлэх бүтээгдэхүүний нэр төрөл, үйлчилгээний төрөл, чанар сайжирч, биржийн арилжаанд оролцогчдын биржид итгэх итгэл сэргэсэн байна гэсэн хүлээлттэй байна. Хоёр дахь шатанд форвард болон фьючесрийн арилжаа хийх нөхцлийг бүрдүүлж, санхүүгий зах зээл хөгжиж, биржийн оролцогчид урьдчилсан зээл авах боломж бүрдэнэ гэж хүлээж байна. Хамгийн гол хүлээлт нь биржийн оролцогчид нэмэгдэж, биржийн арилжаагаар бараа, түүхий чанарын үнэлэмжид нийцсэн зах зээлийн бодит үнэ тогтож, биржээр арилжаалах хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний тоо хэмжээ, эргэлтийн хэмжээ нэлээдгүй нэмэгдэнэ гэсэн урьдчилсан хүлээлттэйгээр энэхүү стратегийн төлөвлөгөөний зорилтыг дэвшүүлэв.

Диаграмм 13: Стратегийн зорилтын үе шат, хэрэгжүүлэх хугацаа



## 6.2. Бизнесийн үйл ажиллагааг сайжруулах боломж ба эрсдлүүд

**Хөдөө аж ахуйн биржийн эрхэм зорилгыг шинээр тодорхойллоо.** Олон улсын барааны биржүүдийн нийтлэг сайн жишигт нийцүүлэн “Биржийн эрхэм зорилго нь орчин үеийн дэвшилтэд техник технологи, мөшгих тогтолцоог нэвтрүүлэх замаар ил тод, нээлттэй, зохион байгуулалт сайтай арилжааны болон агуулахын үйлчилгээг үзүүлэхэд чиглэнэ” гэж тодорхойлж байна.

**Биржийн үйл ажиллагандаа баримтах зарчимыг мөн шинэчлэх гэж оролдлоо.** Мөн олон улсын биржүүдийн туршлагад тулгуурсан нээлттэй, ил тод, шударга, бие даасан найдвартай, дундыг баримтласан (нейтрал) зарчимд суурилан дуудлага худалдаа болон цахим платформод суурилсан биржийн арилжаа явуулна гэж шинэчлэв. Үүнд:

- Ил тод байх гэдэгт биржийн оролцогчдыг нэгэн ижил мэдээ, мэдээллээр тогтвортой хангаж ажиллана гэсэн утгатай бөгөөд зах зээлийн, санхүүгийн, арилжааны, хариуцлагын талаарх бүхий л мэдээ, мэдээллийн урсгалыг бүрдүүлэхэд чиглэн ажиллана. Мэдээллийн бүхий л арга хэрэгслэл, ялангуяа олон нийтийн мэдээллийн сувгаар дамжуулан мэдээлэл түгээх боломжоор хангахад анхаарч ажиллах хэрэгтэй юм.
- Хуулийн хүрээнд арилжаанд оролцох эрх бүхий брокер, хоршоодыг арилжаанд оролцуулах боломжоор хангах замаар нээлттэй байдлыг хангаж ажиллана. Нээлттэй байдлыг хангаж ажиллахад дүрэм, журмын шинэчлэл, хамтын ажиллагаа, техник технологийн тусламжтайгаар гүйцэтгэнэ.
- Бие даасан байх зарчимд биржийн санхүү болон хөрөнгө оруулалтыг орчинг бүрдүүлэх, бие даан ажиллах, улс төрөөс хамааралгүй байх боломжоор хангаан ажиллах зэрэг ажлууд багтах бөгөөд бие даасан арилжааны платформ, байр, ажиллах хүчин, төсөвтэй байх зэрэг хамаарах болно. Бирж нь өөрөө өөрийгөө зохицуулах үүрэгтэй статустай байгууллага бөгөөд үүний тулд биржитэй холбоотой мэргэжлийн холбоод, хувийн хэвшлийн болон төрийн мэргэжлийн байгууллагуудын оролцоог биржийн зохицуулах зөвлөлд түлхүү оролцуулж, тэдний үг, санал бодлыг сонсож, үйл ажиллагаагаа сайжруулан ажиллахад чиглэнэ.
- Шударга байх зарчимд аль нэгэн оролцогчдод давуу тал олгохгүй байх, биржийн дүрэм, журам зөрчсөн этгээдүүдэд хуулийн хүрээнд зохих хариуцлагыг хатуу оноох, хяналтын үйл ажиллагааг хатуу чанд мөрдүүлэх зэрэг арга хэмжээнүүд багтаж байна.
- Орчин үеийн дэвшилтэд техник, технологийг үйл ажиллагаандаа тасралтгүй нэвтрүүлдэг байх, үүний тулд ажиллагсдыг инноваци, техник, технологийн чиглэлд удирдан манлайлах зарчим баримтлах нь зүйтэй байна. Тухайлбал, автомат төхөөрөмжөөр хонио ноослох, хөргөлтийн агуулахаар мах, сүүг арилжаалах зэрэг болно.
- Төрийн бодлогын уялдаа холбоог хангах, ялангуяа хөгжиж буй орнуудын барааны биржийн үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн мөшгих тогтолцоонд суурилсан агуулахын аж ахуйг хөгжүүлэх, агуулахын аж ахуйн үйл ажиллагааг банк, даатгал, чанар баталгаажуулалтын нэгж болон тээврийн байгууллагуудтай холбож өгөхөд бүхий л анхаарлаа хандуулан ажиллах нь зүйтэй байна.

Хүснэгт 59. Биржийн үйл ажиллагааны зарчим

| БИРЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРЧИМ | | | |
|---|---|---|---|
| **Ил тод** | **Нээлттэй** | **Бие даасан** | **Шударга** |
| Бүх оролцогчдыг нэгэн ижил мэдээ, мэдээллээр тогтвортой хангах | Арилжааны эрхтэй брокер болон хоршоод арилжаанд оролцох эрхээр хангагдах | Санхүү, хөрөнгө, удирдлагын түвшинд бие даан үйл ажиллагаа явуулах боломж | Оролцогчдын тэнцвэрт байдлыг хангах буюу нэг талд давуу эрх олгохгүй нейтрал хандлагатай байх |
| **Зарчмыг хэрэгжүүлэх хүрээнд хийгдэх арга хэмжээ** | | | |
| - мэдээллийн урсгал<br>- санхүүгийн ил тод<br>- арилжааны мэдээ<br>- хариуцлага<br>- бүх оролцогчид мэдээллийн бүх сувгаар мэдээлэл авах боломжтой | - Малчид, тариаланчид<br>- Брокер, хоршоо<br>- Хамтын ажиллагаа<br>- Техник, технологи<br>- Хууль, дүрэм, журам | - Бие даасан санхүү, төсөвтэй байх<br>- Өөрийн байр, программ хангамж, IT -ын бие даасан байдал<br>- Боловсон хүчин<br>- Улс төрөөс хамааралгүй байх | **1.** Зах зээлийн эрэлт, нийлүүлэлтэд тулгуурлах<br>**2.** Эрсдлийн менежментийг хэрэгжүүлэх<br>**3.** Бүх оролцогчдын эрх ашгийг тусгаж байх |

**Биржийн үүргийн тодорхой болгох үүднээс олон улсын барааны биржийн жишигт нийцүүлэн биржийн үүргийг дараах байдлаар багцалж байна. Үүнд:**

1. Биржийн дүрэм, журам, зарчмыг чанд баримлан биржээр арилжих барааны үнийг нээх, хаах арилжааны үйл ажиллагаа явуулах;
2. Биржийн арилжааны зах зээлийн ил тод байдлыг хангах;
3. Биржийн санхүү, хөрөнгө оруулалтын орчинг сайжруулах, биржийн оролцогчдын бараа, түүхий эдээ барьцаалан зээл авах боломжоор хангах;
4. Биржийн арилжаанд олон тооны оролцогчдыг татаж, тэдний эрх ашгийг хамгаалах.
5. Хөдөө аж ахуйн түүхий эд бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцооны зардлыг бууруулахад анхаарч ажиллах, ;
6. Форвард, фьючерсийн гэрээний арилжааг нэвтрүүлэх замаар бараа, түүний эдийн ирээдүйн үнийг тогтоох, учирч болох үнийн эрсдлийг удирдах;

Хөдөө аж ахуйн биржийг хөгжүүлэх стратеги зорилтыг тодорхойлж, тус зорилтыг хэрэгжүүлэх боломж, тулгарч болох эрсдлүүд болон цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар харуулахыг зорьлоо.

***А/. Ил тод, нээлттэй, шударга арилжаа хийх, арилжаанд оролцогчдын тоог нэмэгдүүлэх хүрээнд:***

**Хөгжүүлэх боломж:** Танхимийн болон цахим хэлбэрээр нээлттэй дуудлага худалдааны арилжаа явуулах нь зохистой байна. Одоогийн кросс нөхцөлтэй спот арилжааг стратегийн бүтээгдэхүүний арилжаанд ашиглах нь зүйтэй юм. Тухайлбал, стратегийн бүтээгдэхүүн болох улаан буудайнд кросс нөхцөлтэй арилжааг ашиглаж болно. Бирж нь хязгаарлагдмал тооны гишүүдээс бүрдсэн гишүүнчлэл бүхий байгууллага юм. Биржийн арилжаанд цөөн брокерууд оролцож байна. Хоршоодын оролцоог нэмэгдүүлэх нь зүйтэй юм. Бороoны дараах мөөг шиг олон тооны хоршоод байгуулагдаж, аль хоршоо нь малчдын жинхэнэ хоршоо байгааг мэдэхэд хүндрэлтэй байна. Орон нутагт дэлгүүрийн эзний хоршоо, брокеруудын байгуулсан хоршоо байгуулсан нь малчдын жинхэнэ хоршоог хөгжүүлэх, хамтран ажиллахад бэрхшээлтэй байна. 2018 онд малчдын жинхэнэ хоршоо байгаа эсэх талаарх үнэлгээ ХХААХҮЯ-наас зохион байгуулсан байна. Энэхүү

үнэлгээг дахин хийж агуулах, үйл ажиллагаа нь тогтворжсон хичнээн хоршоо Монгол Улсад байгааг үнэлж, байрлыг тогтоож, хамтрах хэрэгтэй юм. Зах зээл ба биржийн үйл ажиллагаа амжилттай явагдаж байгаа эсэх нь брокер, хоршоодын менежмент, санхүүгийн чадавх болон бизнесийн ёс зүйгээс ихээхэн хамаардаг байна. Хөгжиж буй орнуудын барааны биржийн оролцогчид ёс зүй муутай, хууран мэхлэх, залилах зэрэг үзэгдэл байдаг. Үүнийг биржийн дүрэм, журам, зохицуулалтын хүрээнд хатуу хянан шалгаж, зөрчлийг тухай бүр арилгаж байх шаардлагатай болно. Биржид итгэх итгэл, шударга байдлыг хангахын тулд биржийн дүрэм, журмыг ягштал биелүүлэх чадвартай, ёс зүйтэй гишүүдтэй байх хэрэгтэй байна.

**Тулгарч болох эрсдлүүд:** Ил тод, нээлттэй, шударга арилжаа хийх, арилжаанд оролцогчдын тоог нэмэгдүүлэхэд дараах хүндрэл, эрсдлүүд тулгарч болзошгүй юм.

- Биржийн талаар олон нийтэд зөв ойлголт өгөхгүй бол биржийн үйл ажиллагааг шүүмжлэгчид олон байгаа. Иймд биржийн талар үнэн, зөв, бодит мэдээ, мэдээллээр хангах;
- Биржийн брокер, хоршоод нь биржийн үйл ажиллагааны талаар мэдлэг, мэдээлэл болон менежментийн чадвар сул учраас Хоршоодын нэгдсэн холбоотой хамтран брокер, хоршоодыг мэдлэгжүүлэх, мэргэшүүлэх сургалтуудыг явуулах:
- Малчдын жинхэнэ хоршоо, түүний агуулах, байршил, санхүү, менежментийн чадавхийг бодитоор үнэлэхэд хугацаа, санхүү, хүн хүч шаарддаг. Иймд ХХААХАҮ, Хоршоологчдын нэгдсэн холбоо, Хөдөө аж ахуйн хоршоологчдын холбоо, Үндэсний статистикийн хороо, Улсын бүртгэлийн ерөнхий газартай хамтран хоршоодын үйл ажиллагаанд бодит үнэлгээ хийх;
- Танхимийн болон цахим арилжааг явуулахын тулд агуулахтай хоршоод, брокеруудыг арилжааны платформтой холбохын тулд техник, тоног төхөөрөмж суурилуулж, түүний зааварчилгаа өгөх шаардлагатай болно. Тодорхой хэмжээний зардлууд төсөвлөх;

***В/. Биржийн үйл ажиллагаанд хяналт тавих тогтолцоог сайжруулах хүрээнд:***

**Хөгжүүлэх боломж:** Биржийн зохицуулах зөвлөл 2017 оноос хойш ажиллаагүй байна. Бусад улс орнуудад биржийн зохицуулах зөвлөлтэй адилхан байгууллагууд биржийн үйл ажиллагаанд хяналт тавьдаг. Бодлогын хувьд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас бодлогын болон эрх зүйн орчинг бүрдүүлж өгөхөд дэмжлэг үзүүлж байна. Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн биржийн өмчлөгч бөгөөд биржийн менежментийн удирдлага (Зохицуулах зөвлөл, Гүйцэтгэх Захирал) -ыг мөн томилдог. Бусад орны туршлагаас харахад биржийн гишүүд мөн Зохицуулах зөвлөлийн хуралдаанд оролцох, удирдлагаа томилох буюу саналаа өгөх эрхтэй байдаг. Биржийн гишүүд нь мэрит зарчимд тулгуурлан зохицуулах зөвлөлд нэр дэвшигдэх, биржийг удирдах хүртэл эрхтэй байдаг. Манай нөхцөлд энэ хэлбэрийг нэвтрүүлэх нь зүйтэй. Этиоп улсад Удирдах зөвлөлийн дэргэд биржийн оролцогчдын нэгдсэн холбоо биржийн гишүүд (биржид суудал худалдан авч, улмаар биржээс орлого олдог арилжааны байгууллагууд) удирдах зөвлөлийг сонгох ба удирдах зөвлөл менежмент (гүйцэтгэх удирдлага)-н багийг томилдог. Удирдах зөвлөлд төрийн байгууллагууд (улсын) болон хувийн хэвшилд хамаарах гишүүд бараг тэнцүү тоогоор сонгогддог. Үндэсний биржийн оролцогчдын холбоог шударга байдал, мэргэжлийн ур чадвар, биржид оролцдог бүх тоглогчдын туршлага дадлын стандартыг хангуулах зорилгоор биржийн гишүүд байгуулдаг.

**Биржийн зохицуулах зөвлөл:** Биржийн Зохицуулах Зөвлөл 2013-2016 оны хугацаанд ажиллаж, 2016 онд үйл ажиллагаа нь зогссон байна. Зөвлөлийн чиг үүрэгт төрийн бодлого болон хуулийн хэрэгжилтийг хангах, цаг үеийн тулгамдсан асуудлыг шуурхай шийдвэрлэх, биржийн үйл ажиллагаанд оролцогч төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод, арилжаанд оролцогчдын үйл ажиллаагаар уялдуулах, үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх, биржийн төсөв, хөрөнгө оруулалттай холбоотой үйл ажиллагаар зохицуулах, биржийн бодлогыг тодорхойлох, дүрэм, журам, стандартыг батлах зэрэг багтдаг. Биржийн хуулийн хэрэгжилтийг хангаж, Биржийн Зохицуулах зөвлөлийн үйл ажиллагаар эхлүүлэх хэрэгтэй байна.

**Биржийн оролцогчдын Үндэсний холбоо:** Биржийн Зохицуулах зөвлөлийн дэргэд Биржийн оролцогчдын үндэсний холбоо буюу дээвэр холбоог байгуулах нь зөв болов уу. Биржийн оролцогчдын Үндэсний холбоонд Монгол үндэсний хоршоодын нэгдсэн холбоо, Хөдөө аж ахуйн хоршоо, Ноос, ноолуур, арьс шир, мах, сүү, буудайн мэргэжлийн холбоод, Брокерийн холбоо, банк, даатгал, тээвэр, агуулах, ложистиктой холбоотой мэргэжлийн холбоодыг оролцуулах нь зөв юм. Холбоод нь өөрсдийн хариуцсан ажлын чиглэл бүрээр үүргээ хуваарилж, ажлаа уялдуулах, хяналт тавих, тайлангаа Биржийн зохицуулах зөвлөлд тайлагнах, хариуцлага хүлээн ажиллана.

**Диаграмм 14**. Биржийн бүтэц, зохион байгуулалтын шинэчлэх санал



Биржийн арилжааны үйл ажиллагаа идэвхжиж, спот арилжаанаас форвард, форвард арилжаанаас фьючерсийн арилжаа руу үе шаттайгаар нэвтрэх замаар биржээр арилжих гэрээний нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлэхийн хирээр зарим албыг бие даасан бүтэц рүү шилжүүлэх шаардлага тулгарна. Тухайлбал, Клиринг төлбөр тооцооны төв, Мэдээллийн нэгдсэн төв, Агуулах, ложистикийн төв гэх бие даасан байгууллагууд хөгжих боломжтой юм. Хяналтын албаны дэргэд арбитрын хороо байх бөгөөд шаардлагатай тохиолдолд ажиллана. Хөдөө аж ахуйн бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэн боловсруулав. Бүтэц, зохион байгуулалт өөрчлөгдсөнтэй холбоотойгоор биржийн албадын чиг үүргийг мөн шинэчлэв.

**Тулгарч болох эрсдлүүд:** Биржийн үйл ажиллагаанд хяналт тавих тогтолцоог сайжруулахад дараах хүндрэл, эрсдлүүд тулгарч болзошгүй юм.

- Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуульд заасны дагуу биржийн Зохицуулах зөвлөлийн үйл ажиллагааг эхлүүлэх шаардлагатай. Биржийн зохицуулах зөвлөлийн үйл ажиллагааг яаралтай эхлүүлэхгүй бол биржийн бодлого төлөвлөлт, биржийн хууль эрх зүйн орчныг сайжруулах асуудал удаашрах, стратеги төлөвлөгөөний хэрэгжилттэй холбоотой зарим ажлууд хэрэгжихгүй байх эрсдэлтэй;
- Биржийн зохицуулах зөвлөлийн дэргэд Оролцогчдын үндэсний холбоог байгуулах шаардлагатай. Энэ байгууллагын талаар биржийн оролцогчдод танилцуулах, уг байгууллагын зорилго, үйл ажиллагааны чиглэл, хамтын ажиллагааны талаар илүү нарийвчлан танилцуулга бэлтгэх хэрэгтэй байна.
- Биржийн хяналтын алба, мэдээлэл, технологийн албыг шинээр байгуулах, тэдгээрийн ажлын чиг үүргийг тодорхой болгох хэрэгтэй. Эдгээр албадуудад чадварлаг мэргэшсэн мэргэжилтэнгүүдийг авч ажиллуулах нь зүйтэй юм.

### *С/. Хөдөө аж ахуйн биржийн агуулахын аж ахуй, дэд бүтэц, эко-системийг хөгжүүлэх хүрээнд:*

**Хөгжүүлэх боломж:** Биржийн дэд бүтэц, эко-систем гэдэгт арилжааны систем, агуулахын аж ахуйн бүртгэлийн систем, мөшгих тогтолцооны мэдээллийн систем, зах зээлийн мэдээлийн нэгдсэн систем, банк, даатгал, тээвэр, лаборатори болон цахим татварын системийг холбосон мэдээллийн цогц систем, эдгээртэй холбогдох барилга, дэд бүтцийг хамруулсан ойлголт болно.

Хүснэгт 60. Биржийн эко-системийн бүрэлдэхүүн

| Бүрдэл нэгж | Үйл ажиллагаа |
|---|---|
| **Төвлөрсөн худалдааны систем** | Хөдөө аж ахуйн бараа, түүхий эдийг төвлөрсөн нэг цэгт нэгдсэн зохион байгуулалттайгаар арилжаалах биржийн үйл ажиллагаа багтана. |
| **Агуулахын аж ахуй** | Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг хүлээн авах, бүртгэх, дээжлэх, ангилах, чанарыг баталгаажуулах үйл ажиллагаа зэрэг орно. |
| **Клирингийн банк** | Банкны зээлийн барьцаанд байгаа биржээр арилжаалах гэрээг төвлөрүүлэх, арилжаалагдсан бүтээгдэхүүний гүйлгээг баталгаажуулж, шилжүүлдэг санхүүгийн үйл ажиллагаа зайлшгүй шаардлагатай болно. |
| **Зах зээл мэдээллийн нэгдсэн сүлжээ** | Хөдөө орон нутаг дахь төвүүдтэй цахим сүлжээгээр холбогдсон мэдээллийн сүлжээний үйл ажиллагаа юм. Үүнийг мөшгих тогтолцоо, цахим татвар, цахим урамшууллын системийг биржийн арилжааны платформтой холбох ажиллагаа юм. |
| **Цахим худалдааны төв** | Гадаадын болон хөдөө орон нутгийн оролцогчдыг цахим худалдааны төв системтэй холбосон тоног төхөөрөмж, арилжааны үйл ажиллагаа зэрэг багтана. |

| | |
|---|---|
| **Мэдээллийн аюулгүй байдлын төв** | Биржийн гишүүнчлэл болон зах зээлийн мэдээллийг удирдах нэгдсэн системийн үйл ажиллагаа бөгөөд мэдээллийн аюулгүй байдлыг хангаж ажиллана. |
| **Арбитарын шүүхийн хороо** | Гишүүд эсвэл гишүүдийн хоорондын маргааны шийдвэрлэх үүрэгтэй хороо бөгөөд хөгжиж буй орнуудын ихэнх биржүүд арбитрын хороотой байдаг. Хөгжиж буй орнуудын иргэдийн сэтгэлгээ, залилах, хуурам, ёс зүйгүй байх үйлдлүүд элбэг байдаг учраас энэ хороо зайлшгүй ажилладаг. Энэ хороо нь биржийн хууль, дүрэм, журамд нийцүүлэн брокер, хоршоо, бусад оролцогчдын үйл ажиллагааг хянан ажилладаг болно. |

Олон улсын барааны биржийн туршлагаас харахад агуулахын аж ахуйг хөгжүүлэх замаар бараа, түүхий эдэд анхан шатны тордолт хийж, ангилж, зэрэглэж, багцалсны дараагаар биржийн арилжаанд оруулдаг. Агуулахын аж ахуй нь хоршоо болон брокерийн өөрийн эзэмшлийн эсвэл түрээсийн байж болно. Агуулахад бирж итгэмжлэл олгоно. Агуулах нь биржээс тавьсан шаардлагын дагуу биржээс хүлээн зөвшөөрөгдсөн тоног төхөөрөмжөөр тоногдогдсон, түүхий эдийг бэлтгэх чадварлаг мэргэжилтэнтэй байна. Түүхий эдийн дээжид лабораторийн шинжилгээ хийж, хянан баталгаажуулдаг салбарын мэргэшсэн чанарын баталгаажуулалтын нэгж ажилладаг. Энэ нэгж нь хувийн хэвшлийн байх бөгөөд олон улсын мэргэшсэн компанийн салбар мөн ажиллаж болдог. Биржээс олгосон эрх мэдлийн хүрээнд үйл ажиллагаа явуулж, төлбөр хураамжийн орлого олно. Хэрэв биржээр арилжаалсан бараанд чанарын маргааны асуудал үүссэн тохиолдолд (биржийн арбитрын хороо ажиллана) тухайн чанарын гэрчилгээ олгосон мэргэжлийн баталгаажуулалтын нэгж хариуцлагыг өөрөө хариуцах бөгөөд энэ талаар журмуудад тодорхой тусгагдсан байх шаардлагатай юм. Чанарын гэрчилгээ нь улсын тэмдэгттэй байх бөгөөд төрийн мэргэжлийн байгууллагын хяналт, шалгалтын хүрээнд чанарын гэрчилгээ олгогдож болох юм.

Диаграмм 15. Биржийн дэд, бүтэц, эко-системийн ерөнхий бүдүүвч




Хоршооны дэргэд банк, даатгал, мэргэжлийн баталгаажуулалтын нэгж үйл ажиллагаа явуулж, биржээс зөвшөөрөгдсөн шаардлагын дагуу үйлчилгээ үзүүлж, төлбөр, хураамжаа авдаг. Мэдээж хэрэг эдгээр итгэмжлэгдсэн байгууллагууд нь тодорхой

хэмжээний итгэмжлэлийн төлбөрийг биржид төлнө. Амжилттай ажиллаж байгаа тохиолдолд жил бүр итгэмжлэлийн хугацаа автоматаар сунгагддаг. Эдгээр байгууллагуудтай бирж нь гэрээ байгуулж, биржээс баталсан дүрэм, журмын хүрээнд шударга, ил тод, нээлттэй, хариуцлагатай ажиллахаар шаардлага тавина. Агуулахын аж ахуйн менежментийг малчдын жинхэнэ хоршоо гүйцэтгэх нь Монгол Улсын нөхцөлд үр ашигтай болов уу. Аймаг, сумдад үйл ажиллагаа явуулж байгаа хоршоодын үйл ажиллагаанд үнэлгээ дахин хийж, үйл ажиллагаа явуулж буй жинхэнэ хоршоо буюу малчдын хоршоо байгаа эсэхийг тодруулах хэрэгтэй юм. Суманд малчдын хоршоо байгаа бол хамтран ажиллах, хэрэв байхгүй бол шинээр хоршоо байгуулж, хоршооны агуулахад үнэлгээ хийж, итгэмжлэх, агуулахтай хоршоодын үйл ажиллагааг бирж, лаборатори, банк, даатгалын байгууллагуудтай холбох хэрэгтэй юм. Энэ нь биржийн спот арилжаанд оролцогчдын тоог нэмэгдүүлэх, форвард болон фьючерсийн арилжаа явуулах бэлтгэл ажлыг хангахад ихээхэн чухал үүрэгтэй юм. Эхний ээлжинд ноос, ноолуур, арьс шир, амьд мал агуулдаг ердийн агуулахтай байх бөгөөд цаашид мах, сүү арилжаалах бол хөргөлттэй агуулахтай байх шаардлагатай болно. Эдгээр агуулахад бүртгэсэн бараа, түүхий эд бүрийн гарал үүслийн талаарх мэдээллийг баталгаажуулж, мөшгих тогтолцооны системд бүртгэгдэх боломжтой болно. Агуулахын аж ахуйтай хоршоо нь мэргэжлийн түүхий эд бэлтгэх мэргэжилтэн ажиллах бөгөөд эдгээр мэргэжилтэнгүүд нь бараа, түүхий эдэд анхан шатны тордолт хийж, өнгө, чанараар нь ангилж, бөөнөөр нь нэг бүхэл багц болгож, арилжаанд бэлтгэх учраас түүхий эдийн чанараас хамаарч янз бүрийн үнэ бүрдэх боломжтой болно. Бодит нөхцөл байдалд агуулахтай малчдын жинхэнэ цөөхөн байгаа учраас эдгээр агуулахын хүрээнд, аажимдаа байршлын тоог нэмэгдүүлэх замаар биржийн агуулахын аж ахуйг хөгжүүлэх боломжтой байна. Малчдын хувьд дараах сонголтыг хийх шаардлага тулгарна.

1. Малын гаралтай түүхий эдээ анхан шатны тордолт хийхгүйгээр өөрийн тээврийн хэрэгслээр аймгийн төвд хүргэж худалдаалах;
2. Малын гаралтай түүхий эдэд өөрсдөө анхан шатны тордолт хийж, өөрийн тээврийн хэрэгслээр аймгийн төвд хүргэж худалдаалах;
3. Хоршооны гишүүн малчин нь малын гаралтай түүхий эдээ сумын төвийн агуулахтай хоршоонд хүргэж, хоршоогоор түүхий эдээ бэлтгэн биржийн арилжаанд оруулах.

Одоогийн нөхцөлд эхний сонголтыг ихэнх малчид хийж байна. Зарим малчид хоёрдахь хувилбарыг тэр бүр сонгохгүй байна. Учир нь хавар мал төллөдөг, ам бүл цөөтэй зэрэг шалтгаанаар зарим малчид түүхий эдээ бэлтгэж, анхан шатны тордолт хийх боломж хязгаарлагдмал байдаг. Хоршооны борлуулсан ноолуурын чанар хэр өндөр байна, малчид хоршооноос тэр чинээний өндөр ашиг хүртэнэ. Хэрэв агуулахын аж ахуй хөгжиж, чанарын ялгаатай байдлаар үнэ бүрддэг болсноор тодорхой хугацааны дараагаар ангилж, зэрэглэж бэлтгэсэн чанартай ноолуур өндөр үнэд хүрэх үед агуулахын хоршоог түшиглэн түүхий эдээ бэлтгэх эрэлт хэрэгцээ нэмэгдэнэ. Одоогоор ямаа самнах, хонь ноослох зэрэг зардал зах зээл дээр өндөр зардалтай байна. Хоршоогоор бэлтгэснээр энэхүү зардал буурах боломжтой. Хоршооноос түүхий эдийг хүлээн авч, жинлэж, чанараар нь ангилж бэлтгэсний дараагаар агуулахад бүртгэнэ. Бүртгэлийн баримтыг малчинд шууд өгнө. Биржээр арилжаанд орсны дараагаар хоршооны агуулахаас худалдан авч өөрийн агуулах руу тээвэрлэх ажлыг зохион байгуулдаг. Худалдан авагчийн агуулахад хүргэгдэж, төлбөр тооцоо хийгдэнэ. Агуулахтай хоршооны дэргэдэх мэргэжлийн баталгаажуулалтын нэгж баталгаа өгч, чанарын гэрчилгээ олгодог болсноор малчид тэжээл бэлтгэх, цагаан сар, бусад хэрэгцээ шаардлагаар биржээс итгэмжилсэн арилжааны банкнаас урьдчилан зээл авах боломжтой болно. Банкнаас зээл авахын өмнө

хоршоотой хэзээ, хэдий хэмжээний түүхий эдээ биржээр борлуулах талаар гэрээ байгуулж, малаа даатгалд хамруулж, түүхий эдийн дээжид сорьц авч, чанарын гэрчилгээ авах хэрэгтэй болно. Хоршоо нь мэдээллүүдийг нэгтгэн хэзээ хичнээн хэмжээний түүхий эдийг борлуулах боломжтой талаар урьдчилсан мэдээллийг биржид хүргүүлж, арилжааны өдөр товлогдоно. Арилжаанд орсноор хоршооны гишүүн малчин нь хууль, журамд заасан хөдөө аж ахуйн урамшууллыг чанарын үнэлэмжтэй уялдуулан авах нөхцөл бүрдэнэ. Этиоп нь кофе өндөр хөгжилтэй орнууд руу экспортлодог. Гэтэл янз бүрийн чанартай кофе импортлож байсан учраас нэгдсэн стандарттай болгохын тулд мөшгих тогтолцоог ашиглах шаардлагыг тавьснаар Этиопийн бирж нь экспортод гаргах кофенд мөшгих тогтолцоог ашиглаж байна. Ингэснээр тус биржид итгэх итгэл сэргэж, мөн биржийн кофены чанар сайжирсан.

**Тулгарч болох эрсдлүүд:** Биржийн дэд бүтэц, эко-системийг бий болгоход цаг хугацаа, хүн хүч, хөрөнгө оруулалт шаардсан томоохон ажил юм. Үүнийг хэрэгжүүлэхэд дараах хүндрэл эрсдлүүд тулгарч болно.

- Биржийн бүтэц, зохион байгуулалтыг өөрчилж, хяналтын алба, мэдээлэл, технологийн албыг шинээр байгуулах.
- Мөшгих тогтолцоонд суурилсан агуулахын аж ахуй хөгжүүлэхэд мөшгих тогтолцоо, сумдын хөдөө аж ахуйн мэдээллийн сүлжээ, цахим татварын сүлжээ, А данстай холбосон хоршоодын бүртгэл, мэдээллийн сүлжээ, арилжааны платформ зэргийг холбосон мэдээллийн нэгдсэн сүлжээг бүрдүүлэх шаардлагатай болно.
- Агуулахын аж ахуй, чанарын баталгаажуулалтын нэгжийг хуулийн хүрээнд байгуулах нөхцлийг бүрдүүлэх;
- Биржийн арбитрын хороо, хяналтын албаны ажил үүрэг, хариуцлагыг сайжруулах;
- Малчдын жинхэнэ хоршооны талаар үнэлгээ хийх;

***D/. Биржээр арилжаалах бүтээгдэхүүний тоо хэмжээ, нэр төрөл, чанарыг нэмэгдүүлэх, үйлчилгээг сайжруулах хүрээнд:***

**Хөгжүүлэх боломж:** Үнэ бүрдэлт, бүтээгдэхүүн, чанарын баталгаажуулалт, үйлчилгээ зэргийг сайжруулахтай холбоотой саналуудыг тусгав.

**Үнэ бүрдэлт:** Бирж нь нээлттэй дуудлага худалдааг зохион байгуулснаар зах зээлийн бодит бүрддэг. Биржийн үнэ бүрдэлт нь олон нийтийн оролцоо, хяналтад дор үнэ бүрддэг.

**Бүтээгдэхүүн:** Анхан шатны тордолт хийсэн хөдөө аж ахуйн бараа, түүхий эдийг биржээр арилжаалах, улмаар биржээр арилжаалсан самнасан ноос, ноолуур зэрэг нэмүү өртөг шингээсэн барааг зөвхөн экспортлох талаар бодлого тусгах нь зүйтэй. Биржээр арилжаалах бараа нь гарал үүсэл, чанарын зэрэглэл, баталгаажуулалтын дугаар, барааны тоо хэмжээ зэргийг тодорхой тусган баталгаажуулж биржийн мэдээллийн сүлжээнд бүртгэсэн байна. Биржээр арилжаалах гэрээг худалдагч, худалдан авагч талын брокер, хоршоод гүйцэтгэх бөгөөд гэрээнд барааны чанар, тоо хэмжээ, үнэ болон хүргэлт, гэрээний үүргээ биелүүлээгүй бол хариуцлага, үр дагавар зэрэг нь тодорхой тусгагдсан байх шаардлагатай.

**Үйлчилгээ:** Хөгжиж буй орнуудын биржүүдтэй харьцуулахад биржийн бүтээгдэхүүний тоо хэмжээ, үйлчилгээний нөр төрөл нь цөөхөн байна. Гэрээний хэрэгжилтийг хангах нь чухал асуудал юм. Бирж нь олон төрлийн үйлчилгээ үзүүлж

байж, үйлчилгээний төлбөр авдаг. Хамгийн чухал үйчилгээний нэг төрөл нь мэдээллийн үйлчилгээ юм. *Нэгдүгээрт,* биржийн арилжаанд оролцогчид ижил мэдээ, мэдээлэлтай байж, арилжааны гэрээ, хэлэлцээрт оролцсноор бодит үнэ бүрдэх нөхцөл бүрддэг. Иймд ижил мэдээ, мэдээллээр хангах шаардлагатай болно. *Хоёрдугаарт*, биржээр арилжих барааны жагсаалтад багтсан бараа, түүхий эдийн зах зээлийн болон үнийн мэдээллийг олон нийтэд мэдээлснээр энэхүү үнэ нь ижил төрлийн бүтээгдэхүүн арилжаалж байгаа аливаа бизнес эрхлэгчдэд жишиг үнэ болдог бөгөөд форвард, фьючесрийн үнэ тогтсноор бизнес эрхлэгчдийн хувьд ирэх жилийн бизнесийн төлөвлөгөөгөө боловсруулахад ач холбогдолтой байдаг. Зах зээлийн мэдээллээр хангах явдал биржийн гол чиг үүрэгт тооцогддог. Ирэх жилийн зах зээлийн үнэ тодорхой болсноор малчид, тариаланчид, үйлдвэрүүд ирэх жилийн үйлдвэрлэлийн хэмжээ, борлуулах боломжоо тооцоолж, мөн эргэлтийн зээл авах зэргийг төлөвлөхөд үнийн мэдээллийг ашигладаг. Иймд биржээр арилжаалах бараа, түүхий эдийн үнийг тогтмол сурталчлах компанит ажил нь бирж болон ХХААХҮЯ-ны өдөр тутам хийгдэх ёстой томоохон үйлчилгээний ажил юм. Зах зээлийн тэгш бус мэдээлэл нь дундын зуучлагчдад давуу талтай олгодог. Тариаланчид, малчид бараа бүтээгдэхүүний зах зээлийн үнийн талаар боломжийн ойлголттой, мэдээлэл хангалттай авдаг бол борлуулалт болоод үнэ хэлэлцэх, зөвшилцөх чадвар нь хамаагүй өндөр байх үндэслэлтэй юм.

**Чанарын баталгаажуулалт:** Агуулахын аж ахуйн бүртгэлийн систем нь баталгаат агуулахад бараа, түүхий эдээ бүртгүүлж, чанарын зэрэглэл тогтоосноор малчид, тариаланчдад урьдчилан зээл авах боломжийг олгодог. Улирлаас хамаарсан үнийн хэлбэлзэл ихтэй бүтээгдэхүүн тохиолдолд эсвэл тухайн нөхцөлд мөнгөний шаардлага гарсан бол үнэ хүргэж борлуулах хүртэлээ бараа бүтээгдэхүүнээ хадгалуулж, улмаар зээл авах боломжтой юм. Агуулахын аж ахуйн нь барааны чанарын болон агуулахын гэрчилгээ олгосноор арилжааны банкнаас зээлийн барьцаанд ашиглах нөхцөл болдог. Агуулахын аж ахуйн амжилттай ажиллах эсэх нь агуулахын үйл ажиллагааг шударгаaар удирдах, оролцогчдын итгэлийг олох чадвараас ихээхэн хамаардаг. Агуулахын аж ахуйн дэргэд чанарын баталгаажуулалтын нэгж ажиллаж, барааны чанарт хяналт тавьж, баталгаажуулна. Түүхий эдийг бэлтгэх мэргэжлийн бэлтгэгчид мөн ажиллана. Агуулахын аж ахуй, чанарын баталгаажуулалтын нэгж болон түүхий эд бэлтгэгч, хоршооны үйл ажиллагаанд дүрэм, журмын хүрээнд бирж гэнэтийн шалгалт хийдэг.

**Тулгарч болох эрсдлүүд:** Биржээр арилжаалах бүтээгдэхүүний тоо хэмжээ, нэр төрөл, чанар болон үйлчилгээний чанарыг сайжруулахад дараах ажлуудыг гүйцэтгэх шаардлагатай юм. Хэрэв гүйцэтгэж чадахгүй бол биржийг хөгжүүлж чадахгүй юм. Үүнд:

- Биржийн хуулийн дагуу нээлттэй дуудлага худалдааг зохион байгуулах;
- Анхан шатны тордолт хийж, чанарын зэрэглэл тогтоосон, нэмүү өртөг шингэсэн бараа, түүхий эдийг экспортлох;
- Мэдээлэл, сургалт, судалгаа хийж, бодит мэдээ, мэдээллээр тогтвортой хангах үйлчилгээний чанарыг сайжруулах;
- Олон улсын биржийн туршлагаас харахад гадаад, дотоодод маркетинг, сурталчилгаа явуулах замаар оролцогчдыг татдаг учраас Хятадаас гадна Хонконг, Япон, Солонгос, Итали, Герман, Франц зэрэг орнуудын худалдан авагчдыг үйл ажиллагаандаа татан оролцуулах, хоршоо, брокер, үйлдвэр, малчдыг холбож, биржийн үйл ажиллагааг идэвхжүүлэх маркетингийн арга хэмжээ авах;

- Хамгийн гол үйлчилгээ нь арилжаанд оролцогчдын хүсэлтээр бараа, түүхий эдийн чанар, тоо хэмжээг хянан баталгаажуулж, магадлагаа гаргах үүрэгтэй юм. Одоогийн байдлаар зөвхөн Ноос, ноолуурын холбоонд ноолуур, ноосны чанарт магадлагаа өгөх эрх олгосон. Биржээр арилжих бүтээгдэхүүний чанарт магадлагаа өгөх эрх бүхий хувийн хэвшлийн чанарын баталгаажуулалтын нэгжийг бий болгох, дээж, сорьц авдаг лабораторийн үйл ажиллагааг ноос, ноолуурын холбооны лабораторитой холбох;
- Хөдөө аж ахуйн салбарын малчид, тариаланчид, мэргэжлийн холбоод болон бусад биржийн арилжааны оролцогчдод ХААБ-ийн үйл ажиллагаа, арилжааны талаар таниулах, сурталчилах замаар ХААБ-ийн талаарх нэгдсэн ойлголтод хүрэх.

***E/. Биржийн бүтэц зохион байгуулалтыг сайжруулах, хамтын ажиллагааг хөгжүүлэх хүрээнд:***

**Хөгжүүлэх боломж:** Бирж нь хувьцаагаа 49 хувь хүртэл зарж, нээлттэй хувьцаат компани хэлбэрээр зохион байгуулагдах нь зүйтэй байна. Энэ тохиолдолд ашгийн төлөө үйл ажиллагаа явуулж, биржийн хувьцаа эзэмшигчдийн хувьцааны үнэ цэнийг нэмэгдүүлэх, биржийн оролцогчдын эрх үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх боломжууд бүрддэг. Биржийн хувьцаа эзэмшигчдэд Мэргэжлийн хяналт, Татвар, Гааль, Санхүүгийн зохицуулах хороо зэрэг төрийн байгууллагуудын төлөөлөл, мөн төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоо, хоршоод, брокерууд, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, иргэдийг оролцуулдаг. Ингэснээр нээлттэй, ил тод, бие даасан байдлаар үйл ажиллагаа явуулах, нийгмийн хариуцлаг нэмэгдэх боломж болно. Нээлттэй хувьцаат компани хэлбэрээр зохион байгуулж байгаа тохиолдолд биржийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, биржийн зохицуулах зөвлөлийг хасч, биржийн хувьцаа эзэмшигчдийн хурал гэж оруулах шаардлагатай болно.

**Тулгарч болох эрсдлүүд:** Хөдөө аж ахуйн биржийн хувьцааны тодорхой хувийг зах зээлд нийлүүлж, хувьцаат компани хэлбэрээр ажиллах нөхцлийг бүрдүүлэх. Эхний ээлжинд биржийн нэр хүндийг нэмэгдүүлж, биржийн хувьцааны ханшийг өсгөх, үүний дараагаар биржийн 49 хувь хүртэл хувийг биржийн оролцогчид болон хэрэглэгчдэд санал болгох зэрэг ажлуудыг хийх. Ингэснээр биржийн зохицуулах зөвлөл, биржийн хувьцаа эзэмшигчдын хурал гэсэн удирдлагын бүтэц бий болно. Биржийн зохицуулах зөвлөл нь биржийн бодлогыг тодорхойлох, төрийн хяналтыг хийхэд чиглэнэ. Хувьцаа эзэмшигчдийн нийтийн хурал нь биржийн оролцогчдын ажлын уялдаа, менежмент, өмчлөл, санхүү, эдийн засгийн үр ашгийг сайжруулахад чиглэнэ.

***F/. Биржийн бодлого, эрх зүйн орчинг сайжруулах хүрээнд:***

**Хөгжүүлэх боломж:** Төр, хувийн хэвшил, олон улсын байгууллагын түншлэлээр биржийн үйл ажиллагааг амжилттай явуулахад биржийн зах зээлийн оролцогчид болох Засгийн газар, үйлдвэрлэгчид, хоршоод, брокерууд, малчид, тариаланчид, мэргэжлийн холбоод, экспортлогчдын итгэлийг олох, тэдгээрт итгэл төрүүлэх, тэдний санаачилгыг бодитоор дэмжих хэрэгтэй байдаг. Хөгжиж буй орнуудын барааны бирж, ялангуяа Этиопын биржийг байгуулах техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах, биржийн бэлтгэл ажлыг хангахад 3-5 жилийн хугацааг өнгөрөөсөн бөгөөд энэхүү ТЭЗҮ-д суурилан төсөл боловсруулж, олон удаагийн идэвхтэй уулзалт, хурал, семинарыг зохион байгуулсны эцэст санхүүжилтийг босгож чадсан. Санхүүжилт босгоно гэдэг нь ихээхэн хугацаа, шаргуу хүчин чармайлтын үр дүнд бий болдог байна. Ихэнх оронд

биржийн бодлого нь аж үйлдвэрийн болон гадаад худалдааны бодлоготой уялдан хөгждөг. Төрийн бодлогын нэгдсэн уялдаа, холбоог эргэн харж, дүн шинжилгээ хийж, биржийг хөгжүүлэх төрийн бодлогын үндэслэлийг боловсруулах шаардлагатай байна. Биржийг хөгжүүлэх төрийн бодлогын үндэслэл тодорхой бол биржийг хөгжүүлэхэд шаардлагатай төр, хувийн хэвшил, олон улсын байгууллагын хамтын ажиллагаа мөн тодорхой болдог. Энэ нь төр, хувийн хэвшлийн түншлэлээр хөрөнгө оруулалт босгох, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын татах, хувьцааны тодорхой хэсгийг эдийн засгийн эргэлтэд оруулах, хувьцаа эзэмшигчдийн тоог нэмэгдүүлэх зэрэг нөхцлийг хангаж өгдөг. Төрийн нэгдсэн тогтвортой бодлого болон биржийн шинэ тогтолцоотой уялдуулан биржийн хууль, дүрэм, журмыг шинэчлэх, нэмэлт, өөрчлөлт оруулах нь зүй ёсны асуудал юм. Хөдөө аж ахуйн биржийн тухай хуультай нийцүүлэн дүрэм, журмуудад нэмэлт, өөрчлөлт оруулах, эдгээр журмуудад хоршоодын оролцоог нэмэгдүүлэх, чанарын баталгааны тогтолцоог бий болгох, оролцогчдын үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх  заалтуудыг тусгах нь зүйтэй байна.

**Тулгарч болох эрсдлүүд:** Биржийн хуульд биржийн агуулахын аж ахуй, чанарын баталгаажуулалтын нэгж, гэрээний төрөл, хариуцлагатай холбоотой заалтуудыг шинээр оруулах нь зүйтэй байна. Харин биржийн хуулийг бүрэн ашиглаж, биржийн хуультай нийцүүлэн дүрэм, журмыг шинэчлэх нь зөв юм. Биржийн үйл ажиллагааг сайжруулах, санхүүжилт босгохтой холбоотой бизнес төсөл боловсруулах шаардлагатай байна. Энэ төслийг үндэслэн олон улсын байгууллага, төр, хувийн хэвшлээс санхүүжилт болгох нь зөв болов уу. Бизнес төслөө хөрөнгө оруулагчид, бизнес эрхлэгчид, хандивлагч орнуудын төслүүдэд танилцуулах олон төрлийн арга хэмжээ авах шаардлагатай болно.

### *G/. Форвард болон фьючесрийн арилжаа хийх, санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх нөхцлийг бүрдүүлэх хүрээнд:*

**Хөгжүүлэх боломж:** Биржийн дүрэм, журмын хүрээнд ил тод, нээлттэй форвард болон фьючерсийн арилжаа явуулж, стандартчилсан бараа, түүхий эд (ханарын баталгаа хангасан ангилж, бэлтгэсэн бараа, түүхий эд)-ийг арилжаалдаг болсноор оролцогчдын тоо нэмэгдэж, биржид итгэх итгэлцэл бий болгож чаддаг бөгөөд энэ нь биржийг амжилттай ажиллах нөхцөл болдог гэж үздэг. Фьючерс эсвэл форвард зах зээлийг нэвтрүүлснээр стандартчилагдсан, чанарын зэрэглэл/ангилал хийгдсэн бараа арилжаалах, улмаар биржээс баталсан дүрэм, журмыг хатуу мөрдөх шаардлагатай болдог. Форвард болон фьючерс гэрээнд тусгасан гэрээний асуудлыг заавал хэрэгжүүлэх ёстой бөгөөд стандарт гэрээний хүрээнд эрх, үүрэг хариуцлага, тэдгээрийг хэрэгжүүлэх механизмыг нэн тодорхой тогтоож өгснөөр сая хэрэгждэг. Биржийн зохицуулах зөвлөл, биржийн арбитрын хороо нь биржийн гэрээний хэрэгжилттэй холбоотой хяналтыг хэрэгжүүлдэг. Гэрээг хэрэгжилтэд хяналт тавих тогтолцоог бүрдүүлж чадахгүй бол фьючерс эсвэл форвард арилжаа явуулах боломж байхгүй юм.

Диаграмм 16. Хөдөө аж ахуйг биржийн тогтолцоо




Форвард, фьючерсийн арилжааг нэвтрүүлэхэд агуулахын аж ахуй чухал үүрэгтэй юм. Биржтэй болсноор арилжаанд оролцогчдод тулгарах аливаа эрсдэл, үр ашиггүй зардлууд буурдаг. Хөдөө аж ахуйн нөөц ихтэй бүс нутгуудад байршсан агуулахын баталгаажсан аж ахуйг хоршоонд суурилан бий болгоно. Монгол улсын хувьд агуулахын системийг хөгжүүлэх хэрэгтэй байна. Агуулах нь хүнсний болон хүнсний бус гэсэн хоёр төрлийн агуулахтай. Хүнсний агуулахууд мах, махан бүтээгдэхүүнийг хадгалдаг. Арванхоёрдугаар сард аж үйлдвэрүүд түүхий эд худалдаж авах хүсэлтээр биржид гаргаж, энэхүү хүсэлтийг бирж нь хоршоодод хүргүүлнэ. Хоршоо нь 1-2 сардаа багтаан малчид банктай байгуулсан гэрээ эсвэл нийлүүлэх боломжоо биржид хүргүүлснээр арилжаа хийгдэх урьдчилсан тов тодорхой болж, олон нийтэд зарлана.

Агуулах нь хувийн хэвшилийнх байх бөгөөд хоршооны өмч байна. Биржээс бэлтгэгдсэн түүхий эдийн шинжээч түүхий эдээс дээж авч жинлэх, ангилах ажлыг гүйцэтгэдэг. Харин чанарын баталгаажуулалтын нэгж нь түүхий эдийн чанарт баталгаа гаргана. Агуулахаас чанарын болон агуулахын баталгааны гэрчилгээ олгож, мөн даатгалын үйлчилгээнд хамрагдснаар арилжааны банкнаас зээл авах боломжтой. Арилжааны банк нь зээлийн гэрээг хоршоо, брокероор дамжуулан биржийн арилжаанд оруулна. Зээлийн гэрээ нь клиринг, төлбөр тооцооны төвд цугларч арилжаанд бэлтгэгддэг. Худалдан авагчаас төлбөр удаан орж ирдэг учраас энэхүү эрсдэлийг бирж өөрөө зохицуулах замаар хурдан хугацаанд, ялангуяа нэг хоногийн дотор төлбөрийг барагдуулдаг систем бүрддэг.

Хоёр талын брокерууд нь худалдагч болон худалдан авах талуудад гэрээг үзүүлж, тэд нараар албан ёсоор үзэглэж, баталгаажуулснаар гэрээ хүчин төгөлдөр болно. Гэрээг баталгаажуулахын өмнө Клиринг тооцооны төвөөр төлбөр тооцооны асуудалгүй эсэхийг шалгуулж, баталгаажуулна. Гэрээний хэрэгжилт дутуу эсвэл огт хангагдаагүй, гэрээтэй холбоотой асуудал гарсан бол Арбитрийн хороо ажиллана.

Бирж нь арбитрын хороонд талуудын маргааныг хүргүүлэхээс өмнө өөр төрлийн арга хэрэгслэлүүдийг ашиглаж, гэрээний хэрэгжилтийг хангуулах оролдлого хийж болно. Тухайлбал;

- Биржээс гэрээний хэрэгжилтийг хангах талаар албан мэдэгдэл талуудад өгөх;

- Хохирол гаргасан газар хамгийн бага хохирол гаргах хэмжээний төлбөрийг брокер хариуцах;
- Сануулга өгөх;
- Бирж дээр арилжаа хийх эрхийг түтгэлзүүлэх, зогсоох;
- Хариуцлагагүй талуудад дээрх арга хэмжээ авахаас гадна компанийн нэр хүндэд халдах, биржийн арилжааны зах зээлд цаашид мөсөн оруулахгүй байх;

**Тулгарч болох эрсдлүүд:** Арилжааны банк, даатгалын байгууллага, чанарын баталгаажуулалтын нэгж, агуулахтай хоршоо зэргийг биржээс баталгаажуулах, заримыг нь шинээр байгуулах шаардлага тулгарч байна. Эхний ээлжинд үндэсний стандартын дагуу түүхий эдийг бэлтгэх, түүхий эд, барааны чанарт баталгаа олгох тогтолцоог бүрдүүлэх, хоршоодын оролцоог хангах замаар биржийн арилжааг нээлтэй, ил тод, тэгш, шударга зарчимд нийцүүлэн бодит арилжаа хийх, биржийг хувьцаат компани хэлбэрээр зохион байгуулж, олон нийтийн оролцоог хангах шаардлагатай юм. Дараагийн ээлжинд форвард, фьючесрийн арилжаа хийх, олон улсын стандартад нийцсэн бараа, түүхий эд бэлтгэлийн тогтолцоог бүрдүүлэх замаар биржийн үйл ажиллагааг боловсронгуй болгох нь зүйтэй юм. Эдгээр дэд бүтэц, эко-системийг бүрдүүлэх, агуулахтай хоршоог байгуулж чадахгүй бол форвард, фьючесрийн арилжааг нэвтрүүлэх боломжгүй юм. Энэ бол хамгийн том эрсдэл болж байна.

## 6.3. Биржийн стратеги төлөвлөгөө

**Үндэслэл:** Алсын хараа 2050 урт хугацааны хөгжлийн бодлогын зорилтод 2030 онд түүхий эдийн чанарыг тооноос чанарт шилжих, үйлдвэрүүдийг чанартай түүхий эдээр тогтвортой хангах зорилт, мөн дунд хугацаанд Хүнс, хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн яамнаас хэрэгжүүлж байгаа Дархан-Уул, Ховд аймагт байгуулах аж үйлдвэрийн парк, мөшгиг тогтолцоо, цахим татвар, урамшууллын бодлого, олон улсын барааны биржийн сайн туршлага, хөдөө аж ахуйн биржийн өнөөгийн байдал, тулгамдсан асуудал зэрэгтэй уялдуулан энэхүү стратеги төлөвлөгөөг боловсруулсан болно.



## 2.1. Биржийн стратеги төлөвлөгөө

Хүснэгт 61. Алсын хараа, Эрхэм зорилго, зарчим

| Алсын хараа | Орчин үеийн Чанарын үнэлэмжид суурилсан үнийн тогтолцоог бүрдүүлж, үндэсний үйлдвэрүүдийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх нөхцлийг бүрдүүлнэ. |
|---|---|
| **Эрхэм зорилго** | Орчин үеийн дэвшилтэд техник технологи, мөшгих тогтолцоог нэвтрүүлэх замаар ил тод, нээлттэй, зохион байгуулалт сайтай арилжааны болон агуулахын үйлчилгээг үзүүлэх замаар малчид, хоршоодын оролцоог нэмэгдүүлэх, үндэсний үйлдвэрүүдийг чанартай түүхий эдээр тогтвортой хангах, экспортын орлогыг нэмэгдүүлэх нөхцлийг бүрдүүлнэ. |
| **Зарчим** | Биржийн арилжаа, төлбөр тооцоотой холбоотой бүхий л үйл ажиллагаанд ил тод, нээлттэй, шударга зарчмыг баримтлана.<br><br>Стратегийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхийн тулд төрийн бодлого, зах зээлийн судалгаанд суурилсан байх, ажлын уялдаа холбоог хангах, гадаад, дотоод хамтын ажиллагааг хөгжүүлэх, ажилчдын болон биржийн оролцогчдын ур чадварыг тогтмол хөгжүүлэх, дэвшилтэд техник технологийг нэвтрүүлэх, төрөл бүрийг чанартай үйлчилгээг тогтмол үзүүлнэ. |

### Хүснэгт 62. Хэрэгжүүлэх үе шат, хүрэх үр дүн

| Үе шат | Хугацаа | Үе шатын зорилт | Стратегийн зорилт | Хүрэх үр дүн |
|---|---|---|---|---|
| **I шат** | 2022-2024 | Бодит арилжаа хийж, оролцогчдын итгэлийг сэргээх үе шат | - Ил тод, нээлттэй, шударга арилжаа хийх, арилжаанд оролцогчдын тоог нэмэгдүүлэх<br>- Биржийн бүтэц зохион байгуулалт сайжруулах, хамтын ажиллагааг хөгжүүлэх<br>- Биржийн үйл ажиллагаанд тавих төрийн хяналтыг сайжруулах эрх зүйн орчинг боловсронгуй болгох | - Ил тод, нээлттэй, шударга арилжаа хийнэ.<br>- Биржийн бүтэц, зохион байгуулалт сайжирна.<br>- Төрөөс биржийн үйл ажиллагаанд тавих хяналт болон ажлын уялдаа холбоо сайжирна. |
| **II шат** | 2025-2027 | Ирээдүйн гэрээний арилжаа хийх нөхцлийг бүрдүүлэх үе шат | - Форвард, фьючесрийн арилжаа хийх, санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх нөхцлийг бүрдүүлэх | - Форвард, фьючесрийн арилжаа хийнэ.<br>- Малчид, тариаланчдад бараа, түүхий эдээ барьцаалан зээл авах нөхцөл бүрдэнэ. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **I-II үе шат** | 2021-2027 | Агуулахын аж ахуй, эко-систем, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөл, чанарыг тасралтгүй нэмэгдүүлэх, сайжруулах | - Агуулахын аж ахуйд суурилсан хоршоо болон эко-системийг хөгжүүлэх<br>- Биржээр арилжаалах бүтээгдэхүүний тоо хэмжээ, нэр төрөл, чанарыг нэмэгдүүлэх, үйлчилгээг сайжруулах | - Хоршоодын оролцоо нэмэгдэнэ.<br>- Агуулахын аж ахуй, эко-систем бүрдэнэ.<br>- Бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөл, тоо хэмжээ, чанарт ахиц гарна. |

## Хүснэгт 63. Хэрэгжүүлэх стратегийн зорилго, зорилтууд, түүний хүрэх үр дүн

| Үе шат | Стратегийн зорилго | Стратегийн зорилтууд, хүрэх үр дүн |
|---|---|---|
| **I шат** | - Ил тод, нээлттэй, шударга арилжаа хийх, арилжаанд оролцогчдын тоог нэмэгдүүлэх | - Биржийн хууль, дүрэм, журамд нэмэлт, өөрчлөлт оруулж, эрх зүйн орчин сайжирна.<br>- Цахим болон танхимын арилжаагаар нээлттэй дуудлага худалдаа зохион байгуулна.<br>- Биржээр арилжих бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлж, оролцогчдыг татаж, идэвхтэй арилжаа бий болно.<br>- Малчдын жинхэнэ хоршоог олж ирлүүлэн, үйл ажиллагаар өргөтгөх эсвэл шинээр байгуулж хамтран ажиллана.<br>- Урьдчилсан захиалга үйлдвэрүүдээс хүлээн авч, эртнээс хоршоодоор дамжуулан түүхий эдээ бэлтгэх хугацааг тодорхой болгох ажлыг зохион байгуулж, биржийн арилжааны календартчилсан төлөвлөгөөний дагуу арилжаа хийнэ. |
| | - Биржийн бүтэц зохион байгуулалт сайжруулах, хамтын ажиллагааг хөгжүүлэх | - Биржийн бүтэц, зохион байгуулалт өөрчлөгдөж, ажлын дотоод уялдаа холбоо сайжирна.<br>- Тогтвортой менежментээр үйл ажиллагаа явуулна.<br>- Биржийн засаглал, дотоод зохион байгуулалтыг оновчтой тодорхойлж, бүтцийн шинэчлэлт хийж, ажлын үр дүн сайжирна.<br>- Гадаад, дотоод хамтын ажиллагааг өргөжүүлнэ.<br>- Биржийн маркетингийн үйл ажиллагаа сайжирч, биржийн талаарх зөв, нэгдсэн, системтэй ойлголтыг олон нийтэд хүргэж, үйл ажиллаагаа сурталчилна.<br>- Боловсон хүчний бодлого, төлөвлөлт, ажлын чадвар сайжирч, үр дүнд суурилсан цалингийн урамшууллын системийг бий болгох, уян хатан хөрвөх чадвартай ажиллах боломж бүрдэнэ. |
| | - Биржийн үйл ажиллагаанд тавих төрийн хяналтыг сайжруулах эрх зүйн орчинг боловсронгуй болгох | - Биржийн зохицуулах зөвлөл, биржийн үндэсний холбоо байгуулагдана. |

| | | |
|---|---|---|
| | | - Төрийн бодлого, биржийн агуулахын аж ахуй, эко-систем, хариуцлагын системийг боловсронгуй болгохтой холбоотойгоор биржийн хууль, дүрэм, журамд нэмэлт, өөрчлөлт оруулж, биржийн хуулийн хэрэгжилтийг хангана.<br>- Биржээр арилжаалах бүтээгдэхүүний бэлтгэл, ангилалт, бүртгэлт, чанарын баталгаажуулалттай холбоотой стандартыг шинэчлэн батлана. |
| | - Агуулахын аж ахуйд суурилсан хоршоо болон эко-системийг хөгжүүлэх | - Малчдын жинхэнэ хоршоотой хамтран ажиллаж, агуулахын аж ахуйг хөгжүүлнэ.<br>- Мэдээлэл технологийн цахим шилжилт хийх бэлтгэл ажил хийгдсэн байна.<br>- Чанарын баталгаажуулалтын хувийн нэгж байгуулж, үйл ажиллагааг эхлүүлнэ.<br>- Цахим татвар, мөшгих систем, агуулахын аж ахуйн бүртгэлийн систем, цахим лабораторийн систем, цахим урамшууллын системтэй биржийн арилжааны платформыг уялуулах бэлтгэл ажил хангагдана.<br>- Арилжааны банк, даатгалын байгууллагын үйлчилгээтэй клиринг төлбөр тооцооны системийг холбох бэлтгэл ажлыг хийнэ. |
| | - Биржээр арилжаалах бүтээгдэхүүний тоо хэмжээ, нэр төрөл, чанарыг нэмэгдүүлэх, үйлчилгээг сайжруулах | - Эхний ээлжинд ноос, ноолуур, арьс шир, амьд мал, улаан буудайн спот арилжаа явуулна.<br>- Зах зээлийн мэдээ, мэдээллээр биржийн оролцогчдыг тогтмол хангана.<br>- Биржийн оролцогчдыг мэргэшүүлэх сургалт тогтмол хийнэ.<br>- Брокерийн болон хоршооны оролцогчдод үзүүлэх үйлчилгээний талаар сургалт, мэдээллээр хангаж ажиллана. |
| **II шат** | - Агуулахын аж ахуйд суурилсан хоршоо болон эко-системийг хөгжүүлэх | - Мэдээлэл технологийн цахим шилжилтэд бүрэн шилжсэн байна.<br>- Цахим татвар, мөшгих систем, агуулахын аж ахуйн бүртгэлийн систем, цахим лабораторийн систем, цахим урамшууллын системтэй биржийн арилжааны платформыг уялуулаж, үйл ажиллагаа хэвшинэ.<br>- Арилжааны банк, даатгалын байгууллагын үйлчилгээтэй клиринг төлбөр тооцооны системийг холбоно. |
| | - Биржээр арилжаалах бүтээгдэхүүний тоо хэмжээ, нэр төрөл, чанарыг нэмэгдүүлэх, үйлчилгээг сайжруулах | - Эхний ээлжинд ноос, ноолуур, арьс шир, амьд мал, улаан буудайн спот арилжаа явуулж, дараагийн шатанд хөргөлттэй агуулахын систем шинээр байгуулж, сүү, мах арилжаална. |

| | |
|---|---|
| | - Форвард, фьючесрийн арилжааны бэлтгэл ажлыг хангана.<br>- Биржээр арилжаалах бүтээгдэхүүний шаардлагыг бий болгоно.<br>- Биржийн арилжаанд оролцох брокер, хоршоо, чанарын баталгаажуулалтын нэгж, банк, даатгал,<br>- Зах зээлийн мэдээ, мэдээллээр биржийн оролцогчдыг тогтмол хангана.<br>- Биржийн оролцогчдыг мэргэшүүлэх сургалт тогтмол хийнэ.<br>- Брокерийн болон хоршооны оролцогчдод үзүүлэх үйлчилгээний талаар сургалт, мэдээллээр хангаж ажиллана.<br>- Сонгодог утгаар нь биржийн брокерийн компаниуд болон хоршоод нь биржийн брокерийн үйлчилгээ үзүүлнэ. |
| - Форвард, фьючесрийн арилжаа хийх, санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх нөхцлийг бүрдүүлэх | - Форвард болон фьючерсийн арилжаа хийх эко-орчин бүрдсэн байна.<br>- Биржийн шаардлага, стандартын дагуу түүхий эдийн бэлтгэн стандартчилсан гэрээний арилжаанд оролцуулна.<br>- Агуулахын аж ахуй, банк, даатгал, чанарын баталгаажуулалтын нэгжийн цахим мэдээлэл (нууцлалын зэрэглэлтэй, зөвшөөрөгдсөн мэргэжилтэн)-ийг холбож, малчид, тариаланчид агуулахад байгаа эсвэл 2 сарын дотор агуулахад хүргэх боломжтой бараа, түүхий эдийг барьцаалан зээл авах боломж бүрдэнэ. |

## Хяналтын механизм

Биржийн стратеги төлөвлөгөөний хэрэгжилтэд жил бүр үнэлгээ хийж, тайлан боловсруулах ажлыг Захиргаа, удирдлагын алба гүйцэтгэнэ. Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг Биржийн зохицуулах зөвлөлд жил бүр танилцуулж, биржийн дотоод үйл ажиллагаатай ажлуудыг эрчимжүүлэх чиглэл өгөх, гадаад үйл ажиллагаатай холбоотой ажлуудад анхаарал хандуулж, холбогдох байгууллагуудтай хамтын санамж бичиг байгуулж, тэдгээр байгууллагуудын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлнэ.

## Хүснэгт 64. Стратегийн үйл ажиллагааны төлөвлөгөө

| Зорилт | Арга хэмжээ | | I үе шат | II үе шат | Хариуцан эзэн | Төсөв, сая төг |
|---|---|---|---|---|---|---|
| | Стратегийн зорилт 1: Ил тод, нээлттэй, шударга арилжаа хийх, арилжаанд оролцогчдын тоог нэмэгдүүлэх | | | | | |
| Биржийн хууль, дүрэм, журамд нэмэлт, өөрчлөлт оруулж, эрх зүйн орчин сайжирна. | А/. Судалгаа, дүн шинжилгээ хийх хүрээнд: | | | | | |
| | 1.1. | Биржийн одоогийн мөрдөж буй дүрэм, журмын хэрэгжилтийн үнэлгээг гаргаж, хэрэгжүүлэх боломжгүй болон хэрэгжилт хангахгүй зүйл, заалтанд дүгнэлт хийх; | 2022 | | ЗХЭА | 9.3 |
| | 1.2. | Төрийн байгууллагуудын холбогдох журамтай биржийн эрх зүйн орчинг уялдуулан судлах | 2022 | | ЗХЭА | 4.7 |
| | 1.3. | Хөдөө аж ахуйн салбарт хэрэгжих богино, дунд, урт хугацааны бодлого төлөвлөлт, хөтөлбөрийн уялдаа холбоог судлах; | 2022 | | СИХА | 13.9 |
| | 1.4. | Олон улсын биржүүдийн арилжааны дүрэм, журмыг нарийвчлан судлах | 2022 | | СИХА | 5.0 |
| | 1.5. | Хоршоодын талаар судалгаа хийх, биржийн хуулийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, дүгнэх | 2022 | | СИХА | 5.0 |
| | В/. Хууль, дүрэм, журам, стандартыг шинэчлэн боловсруулах хийх хүрээнд: | | | | | |
| | 1.6. | ХААБ-ийн хуульд агуулах, чанарын баталгаажуулалтын нэгж, оролцогчид байгууллагуудад тавих шаардлага, үүрэг, хариуцлагатай холбоотой нэмэлт, өөрчлөлт оруулах | 2022-2024 | | АЛДБА | 7.8 |
| | 1.7. | Төрийн бодлого, биржийн хуультай уялдуулан биржийн дүрэм, журмыг шннэчлэх | 2022-2024 | | ЗХЭЗА | 9.3 |
| | 1.8. | Холбогдох төрийн байгууллагын зохицуулах журамд нэмэлт, өөрчлөлтийн санал боловсруулах, танилцуулах; | 2022-2024 | | ЗХЭЗА | 6.0 |
| | 1.9. | Биржийн дотоод үйл ажиллагаанд мөрдөж буй дүрэм, журам, холбогдох гэрээг шинэчлэн боловсруулах; | 2022-2024 | | ЗХЭЗА | 5.0 |
| | 1.10. | Мэдээллийн ил тод байдал, харилцагчид, олон нийтэд мэдээллийг хүргэх, мэдээллийг үнэлэх, түүнтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулах мэдээллийн журам боловсруулах; | 2022-2024 | | МТА | 9.3 |
| | 1.11. | Биржийн “Спот гэрээ”-ний арилжаанд мөрдөж буй журам, холбогдох гэрээний шаардлагатай зүйл, заалтыг шинэчлэн боловсруулах; | 2022-2024 | | АА | 10.0 |
| | 1.12. | Биржээр арилжигдах “Фьючерс гэрээ”-ний арилжаа, клиринг, төлбөр тооцоо болон дагалдах | | 2025-2027 | АА | 10.0 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | журам, холбогдох гэрээг боловсруулах; | | | | |
| | 1.13. | Биржийн үйл ажиллагаанд хамаарах хөдөө аж ахуйн салбарт хэрэгжих богино, дунд, урт хугацааны бодлого төлөвлөлт, хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах үе шат бүхий төлөвлөгөө гаргасан байх; | 2022-2024 | | ЗХЭЗА | 6.0 |
| | 1.14. | Биржийн хуулийн хэрэгжилтийг холбогдох байгууллагуудтай хамтарч сайжруулах арга хэмжээ авах | жил бүр | | ЗХЭЗА | 3.0 |
| | | С/. Хэрэгжилтийн хангах хүрээнд: | | | | |
| | 1.15. | Биржийн “Спот гэрээ”-ний арилжаанд мөрдөх журмын хэрэгжилтийг хангах; | 2022-2024 | | АА | 40.0 |
| | 1.16. | Биржээр арилжигдах “Фьючерс гэрээ”-ний арилжаа, клиринг, төлбөр тооцоо болон дагалдах журам, холбогдох гэрээг арилжаанд оролцогчдод танилцуулах; | | 2025-2027 | АА | 6.0 |
| | 1.17. | Биржээр арилжигдах “Форвард гэрээ”-ний арилжаа, клиринг, төлбөр тооцоо болон дагалдах журам, холбогдох гэрээг боловсруулах, арилжаанд оролцогчдод танилцуулах; | | 2025-2027 | АА | 6.0 |
| | 1.18. | Биржийн дотоод үйл ажиллагаанд мөрдөх дүрэм, журмын хэрэгжилтийг хангах; | 2022-2024 | | ЗХЭЗА | 8.0 |
| | 1.19. | Биржээр арилжигдах “Опцион гэрээ”-ний арилжаа, клиринг, төлбөр тооцоо болон дагалдах журам, холбогдох гэрээг арилжаанд оролцогчдод танилцуулах; | | 2025-2027 | АА | 10.0 |
| Цахим болон танхимын арилжаагаар нээлттэй дуудлага худалдаа зохион байгуулна | | А/. Судалгаа, дүн шинжилгээ хийх хүрээнд: | | | | |
| | 2.1. | Мах, сүүний агуулахын аж ахуйг хөгжүүлэх талаар судлах | 2022 | | АА | 5.0 |
| | 2.2. | Малын дайвар бүтээгдэхүүн биржээр арилжаалах боломжийн талаар судлах | 2022 | | СИХА | 5.0 |
| | 2.3. | Цахим арилжааны техник, технологийн шийдэл, боломж, инновацийн талаар судлах | жил бүр | | СИХА | |
| | 2.4. | “Спот гэрээ”-ний арилжааны төлбөр тооцоог хялбаршуулах, хурдан шуурхай гүйцэтгэх боломжийг судлах; | 2023 | | КТТА | 5.0 |
| | 2.5. | “Фьючерс гэрээ”-ний арилжааны төлбөр тооцоо гүйцэтгэх арга, аргачлалыг судлан боловсруулах | 2023 | | ТТА | 5.0 |
| | 2.6. | Олон улсын жишгийн дагуу дэнчин тооцоолох аргыг судлах (спот, форвард, фьючерс, опционы гэрээ бүрээр); | 2023 | | ТТА | 5.0 |
| | 2.7. | Олон улсын жишгийн дагуу арилжааны төлбөр тооцоо гүйцэтгэх аргыг судлах (спот, форвард, фьючерс, опционы гэрээ бүрээр); | 2023 | | ТТА | 5.0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 2.8. | Олон улсын биржийн дотоод болон гадаад эрсдлийг тооцоолох аргачлалыг судлах | 2023 | ТТА | 5.0 |
| | | В/. Хууль, дүрэм, журам, стандартыг шинэчлэн боловсруулах хийх хүрээнд: | | | |
| | 2.9. | Биржээр арилжиж бүтээгдэхүүний “Спот гэрээний нийтлэг стандарт”-ыг шинэчлэн боловсруулах шаардлагыг тодорхойлох, шинэчлэх; | 2022-2024 | АА | 9.3 |
| | 2.10. | Биржээр арилжих жагсаалтад шинээр орсон бүтээгдэхүүн бүрийн “Спот гэрээний стандарт”-ыг боловсруулах; | 2022-2024 | АА | 9.3 |
| | 2.11. | “Форварт, Фьючерс болон Опционы гэрээ”-ээр арилжих боломжтой бараа, түүхий эдийг тодорхойлж, “Гэрээний стандарт” загварыг боловсруулах; | 2022-2024 | АА | 7.5 |
| | | С/. Хэрэгжилтийн хангах хүрээнд: | | | |
| | 2.12. | “Ямааны ноолуур”-ын арилжааг идэвхжүүлэх; | 2022-2024 | АА | 5.0 |
| | 2.13. | “Ноос” (хонь, тэмээ, завод)-ны арилжааг идэвхжүүлэх; | 2022-2024 | АА | 5.0 |
| | 2.14. | “Хүнсний буудай”-н арилжааг идэвхжүүлэх; | 2022-2024 | АА | 5.0 |
| | 2.15. | “Адууны дэл, сүүл” биржээр арилжих боломжийг судлах; | 2022-2024 | АА | 5.0 |
| | 2.16. | “Арьс, шир”-ний арилжааг идэвхжүүлэх; | 2022-2024 | АА | 5.0 |
| | 2.17. | “Тосны ургамал”-ын арилжааг идэвхжүүлэх; | 2022-2024 | АА | 5.0 |
| | 2.18. | “Амьд мал”-ын арилжааг идэвхжүүлэх; | 2022-2024 | АА | 5.0 |
| | 2.19. | “Адууны дэл, сүүл”-ний биржийн арилжааг зохион байгуулах; | 2022-2024 | АА | 5.0 |
| | 2.20. | “Мах”-ны биржээр арилжих боломжийг судлах; | 2022-2024 | АА | 5.0 |
| | 2.21. | “Малын дайвар”-ны биржийн арилжааг зохион байгуулах; | 2022-2024 | АА | 5.0 |
| | 2.22. | Нээлттэй хэлбэрээр олон оролцогчдыг оролцуулан танхимийн болон цахим дуудлага худалдаа зохион байгуулах; | жил бүр | АА | 5.0 |
| | 2.23. | Ашиг шим сайтай амьд малын болон мах, сүүн бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдааг жил бүр тогтмол зохион байгуулах | жил бүр | БХА | 5.0 |
| | 2.24. | Арилжаанд идэвхтэй оролцсон, дэвшилтэд техник нэвтрүүлсэн, менежмент сайтай байдлаар нь номинаци дэвшүүлж, шилдэг хоршоодыг шалгаруулж, олон нийтэд таниулах | жил бүр | СИХА | 5.0 |
| Биржээр арилжих бүтээгдэхүүний нэр төрлийг | | А/. Судалгаа, дүн шинжилгээ хийх хүрээнд: | | | |
| | 3.1. | Биржээр арилжаалах бүтээгдэхүүний зах зээлийн судалгаа тогтмол хийж, оролцогчдыг мэдээллээр хангах | жил бүр | СИХА | 10.0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| нэмэгдүүлж, оролцогчдыг татаж, идэвхтэй арилжаа бий болно. | 3.2. | Шинэ төрлийн үйлчилгээний талаар судлах | жил бүр | СИХА | 8.0 |
| | 3.3. | Гадаадын худалдан авагчид, бүтээгдэхүүний зах зээлийн талаар тогтмол судлах | жил бүр | СИХА | 6.0 |
| | | В/. Хууль, дүрэм, журам, стандартыг шинэчлэн боловсруулах хийх хүрээнд: | | | |
| | 3.4. | Түүхий эд бэлтгэх стандартыг шинээр боловсруулж, батлуулах | 2022-2024 | АЛДБА | 7.5 |
| | 3.5. | Биржийн оролцогчдод үйлчилгээ үзүүлэх төлөвлөгөө боловсруулж, батлуулах | 2022-2024 | АЛДБА | 7.8 |
| | | С/. Хэрэгжилтийн хангах хүрээнд: | | | |
| | 3.6. | Малчин, тариалан эрхлэгчдэд биржийн үйл ажиллагааг сурталчлан таниулах; | жил бүр | МТА | 9.3 |
| | 3.7. | Малчин, тариалан эрхлэгчдийг биржээр бараа, түүхий эдээ хэрхэн арилжаалах талаар мэдээ, мэдээллээр тогтмол хангах; | жил бүр | МТА | 20.0 |
| | 3.8. | Биржийн арилжаанд оролцуулах нөхцөл боломжийг бүрдүүлэх; | 2022-2024 | бүх алба | - |
| | 3.9. | Малчин, тариалан эрхлэгчдэд биржийн арилжааны мэдээ, мэдээллийг ил тод, тэгш түгээх; | 2022-2024 | МТА | 80.0 |
| | 3.10. | Малчин, тариалан эрхлэгчдэд биржийн арилжаанд оролцуулах идэвхийг нэмэгдүүлэх, сургах; | 2022-2024 | бүх алба | -60.0 |
| Малчдын жинхэнэ хоршоог олж ирлүүлэн, үйл ажиллагааг өргөтгөх эсвэл шинээр байгуулж хамтран ажиллана. | | А/. Судалгаа, дүн шинжилгээ хийх хүрээнд: | | | |
| | 4.1. | Хоршоодын өнөөгийн чадавх, чадварт үнэлгээ хийж, дүгнэлт гаргах | 2022 | ХААБ | 15.0 |
| | | В/. Хууль, дүрэм, журам, стандартыг шинэчлэн боловсруулах хийх хүрээнд: | | | |
| | 4.3. | Хоршооны байршил, хүчин чадлын талаар судалж, жишиг хоршоог хөгжүүлэх ТЭЗҮ болон мастер төлөвлөгөө боловсруулах, батлах | 2022 | СИХА | 15.0 |
| | 4.4. | Хоршоогоор түүхий эд бэлтгэх, ангилах, хүлээн авах, арилжаанд оруулах талаарх нэгдсэн үлгэрчилсэн зааварчилгаа, журмыг боловсруулах, батлах | 2022 | АЛДБА | 15.0 |
| | | С/. Хэрэгжилтийн хангах хүрээнд: | | | |
| | 4.5. | ХХААХҮЯ, Хоршоодын нэгдсэн холбоо, Хөдөө аж ахуйн хоршоологдчын холбоотой хамтран малчдын хоршооны байршил, хүчин чадал, чадварын талаар нарийвчлан судалж, үнэлгээ хийх нэгдсэн зохион байгуулалттай ажлыг зохион байгуулах | 2022 | ЗХЭЗА | 10.0 |
| | 4.6. | Үлгэрчилсэн зааварчилгаа, журмын дагуу сургалт зохион байгуулах | 2022 | бүх алба | 10.0 |
| | 4.7. | Түүхий эд бэлтгэгчдийг бэлтгэх, сургах арга хэмжээ авах. | 2022 | бүх алба | 15.0 |
| Урьдчилсан захиалга үйлдвэрүүдээс хүлээн авч, эртнээс хоршоодоор дамжуулан | | А/. Судалгаа, дүн шинжилгээ хийх хүрээнд: | | | |
| | 5.1. | Жилд бэлтгэх боломжтой түүхий эдийн судалгаа хийх, өнгөрсөн жилээс нэмэгдүүлэх боломжийн талаар судлах | жил бүр | СИХА | 8.0 |
| | 5.2. | Биржтэй хамтран ажиллах хоршоодуудын түүхий эд бэлтгэх боломжтой нөөцийн судалгаа хийх | жил бүр | СИХА | 6.0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| түүхий эдээ бэлтгэх хугацааг тодорхой болгох ажлыг зохион байгуулж, биржийн арилжааны календартчилсан төлөвлөгөөний дагуу арилжаа хийнэ. | 5.3. | Үйлдвэрүүдийн хүчин чадал, шаардлагатай түүхий эдийг хэрэгцээг тодорхойлох | жил бүр | СИХА | 8.0 |
| | | B/. Хууль, дүрэм, журам, стандартыг шинэчлэн боловсруулах хийх хүрээнд: | | | |
| | 5.4. | Зарах болон худалдан авах урьдчилсан захиалга хүлээн авах маягт боловсруулах, батлах | жил бүр | бүх алба | - |
| | 5.5. | Календартчилсан төлөвлөгөө гаргах журам боловсруулах, батлах | жил бүр | бүх алба | - |
| | | C/. Хэрэгжилтийн хангах хүрээнд: | | | |
| | 5.6 | Үйлдвэрүүдээс урьдчилсан захиалга хүлээн авах (хэмжээ, хугацаа, чанар) | 2023 | бүх алба | |
| | 5.7. | Малчин хоршоооноос нийлүүлэх боломжтой урьдчилсан захиалга авах (хэмжээ, хугацаа, чанар, байршил, тээвэрлэх боломж) | | бүх алба | |
| | 5.8. | Арилжаа хийх календарчилсан төлөвлөгөө гаргах, оролцогчдод мэдэгдэх, цахим орчноор дамжуулан мэдээлэх, хэрэгжүүлэх | | бүх алба | |
| | | Стратегийн зорилт 2: Биржийн бүтэц зохион байгуулалт сайжруулах, хамтын ажиллагааг хөгжүүлэх | | | |
| Биржийн засаглал, дотоод зохион байгуулалтыг оновчтой тодорхойлж, бүтцийн шинэчлэлт хийж, ажлын үр дүн сайжирна. Тогтвортой менежментээр үйл ажиллагаа явуулна. | | A/. Судалгаа, дүн шинжилгээ хийх хүрээнд: | | | |
| | 6.1. | Бусад орны биржүүдийн бүтэц, зохион байгуулалт, зохицуулалтын орчны тогтолцоог судлах; | 2022 | СИХА | 6.0 |
| | 6.2 | Биржийн одоогийн бүтэц, зохион байгуулалт, зохицуулалтын орчны тогтолцоонд үнэлгээг гаргаж, дүгнэлт хийх; | 2022 | СИХА | 6.0 |
| | 6.3 | Биржийн дунд хугацааны төлөвлөгөөтэй уялдуулан дотоод зохион байгуулалтыг оновчтой тодорхойлох, хүний нөөцийн хэрэгцээ шаардлагыг нарийвчлан гаргах; | 2022 | ЗХЭЗА | 4.5 |
| | 6.4 | Биржийг өөрийгөө зохицуулах байгууллага болох боломжийг судлах; | 2022 | СИХА | 4.5 |
| | | B/. Хууль, дүрэм, журам, стандартыг шинэчлэн боловсруулах хийх хүрээнд: | | | |
| | 6.5. | Биржийн одоогийн “Хүний нөөцийн бодлогын баримт бичиг”-ийн хэрэгжилтийг дүгнэх; | 2022-2023 | ЗХЭЗА | 5.0 |
| | 6.6. | Биржийн ажилтны нийгмийн оролцоо, хувь хүний хөгжлийн талаар авч хэрэгжүүлэх бодлогыг тодорхойлох; | 2022-2023 | ЗХЭЗА | 5.0 |
| | 6.7. | Ажилтны ажлын үр дүн, гүйцэтгэлд үндэслэн цалин, урамшууллын системийг боловсронгуй болгох; | 2022 | ЗХЭЗА | 5.0 |
| | 6.8. | “Ажлын төлөвлөлт, гүйцэтгэл, ажлын үр дүнг үнэлж, дүгнэх журам” боловсруулах; | 2022-2023 | ЗХЭЗА | 5.0 |
| | 6.9. | “Хүний нөөцийн бодлогын баримт бичиг”-ийг шинэчлэн боловсруулах; | 2022-2023 | ЗХЭЗА | 5.0 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | 6.10 | Боловсон хүчний ур чадварыг сайжруулах, чадавхжуулах, “Сургалтын төлөвлөгөө” боловсруулах; | 2022-20233 | | ЗХЭЗА | |
| | 6.11 | Биржийн ажилтны нийгмийн оролцоо, хувь хүний хөгжлийн талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулах; | жил бүр | | ЗХЭЗА | 5.0 |
| | | С/. Хэрэгжилтийн хангах хүрээнд: | | | | |
| | 6.12 | Биржийн дунд хугацааны төлөвлөгөөтэй уялдуулан дотоод зохион байгуулалтын бүтцийн шинэчлэлт хийж, ажлын үр дүнг нэмэгдүүлэх; | 2023 | жил бүр | ЗХЭЗА | 5.0 |
| | 6.13 | Биржийн дотоод үйл ажиллагаанд мөрдөх дүрэм, журмын хэрэгжилтийг хангах; | 2023 | жил бүр | ЗХЭЗА | 5.0 |
| | 6.14 | “Сургалтын төлөвлөгөө”-ний дагуу холбогдох эдтгээдийг сургалтанд хамруулж, чадавхжуулах; | жил бүр | | бүх алба | 10.0 |
| | 6.15 | “Ажлын төлөвлөлт, гүйцэтгэл, ажлын үр дүнг үнэлж, дүгнэх журам” –ыг хэрэгжүүлэх; | жил бүр | | ЗХЭЗА | - |
| | 6.16 | “Хүний нөөцийн бодлогын баримт бичиг”-ийн хэрэгжилтийг хангах; | жил бүр | | ЗХЭЗА | - |
| | 6.17 | Ажлын гүйцэтгэлийн “KPI" үнэлгээ”-г хэрэгжүүлэх; | жил бүр | | ЗХЭЗА | - |
| | 6.18 | Ажлын байрны таатай орчин нөхцлийг бүрдүүлэх; | жил бүр | | ЗХЭЗА | - |
| | 6.19 | Биржийн дотоодын нэгдсэн системтэй болох /“ERP” хэрэгжүүлэх/; | 2024 | | ЗХЭЗА | 5.0 |
| Гадаад, дотоод хамтын ажиллагаа өргөжинө. | | А/. Судалгаа, дүн шинжилгээ хийх хүрээнд: | | | | |
| | 7.1. | Төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэх талаар нөхцөл байдлын судалгаа хийх; | 2023 | | ЗХЭЗА | 5.0 |
| | 7.2 | Монгол Улсад хэрэгжиж буй хөдөө аж ахуйн салбарын хөрөнгө оруулалт, үүсмэл санхүүгийн хэрэгсэл болон зохицуулалттай зах зээлийн хөгжилд чиглэсэн гадаад болон дотоод төсөл, хөтөлбөртэй хамтран ажиллах боломжийн талаар судлах; | 2023 | | ЗХЭЗА | 5.0 |
| | 7.3 | Олон улсад хэрэгжиж буй төсөл, хөтөлбөртэй хамтран ажиллах боломжийг судлан хэрэгжүүлэх; | жил бүр | | ЗХЭЗА | 5.0 |
| | 7.4. | Олон улсын биржийн холбоонд нэгдэн орох боломжийг судлах; | 2022-2023 | | ЗХЭЗА | 20.0 |
| | | В/. Хууль, дүрэм, журам, стандартыг шинэчлэн боловсруулах хийх хүрээнд: | | | | |
| | 7.5 | Гадаад, дотоод хамтын ажиллагаа байгуулах санамж бичиг, чиглэлээ тодорхой болгох бодлогын бичиг баримт боловсруулах, батлах | 2023 | | ЗХЭЗА | 12.0 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | 7.6 | Бусад орны ижил төстэй үйл ажиллагаа эрхлэн явуулдаг байгууллагад туршлага солилцох журмаар ажилтныг дадлагажуулах ажлыг хэрэгжүүлэх боломж нөхцлийг бүрдүүлэх; | 2023 | | ЗХЭЗА | 30.0 |
| | | C/. Хэрэгжилтийн хангах хүрээнд: | | | | |
| | 7.7. | Бусад орны ижил төстэй үйл ажиллагаа эрхлэн явуулдаг байгууллага хоорондын хамтран ажиллах санамж бичиг үйлдэх, хэрэгжүүлэх; | 2023 | 2024-2027 | бүх алба | 20.0 |
| | 7.8 | Монгол Улсад хэрэгжиж буй хөдөө аж ахуйн салбарт чиглэсэн гадаад болон дотоод төсөл, хөтөлбөртэй хийх хамтын ажиллагааг өргөжүүлэх ажлыг хэрэгжүүлэх; | жил бүр | | бүх алба | - |
| Биржийн дотоод үйл ажиллагааны уялдаа холбоо сайжирч, санхүү, урамшуулал, маркетингийн үйл ажиллагаа эрчимжинэ. | | A/. Судалгаа, дүн шинжилгээ хийх хүрээнд: | | | | |
| | 8.1 | Биржийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн удирдлагыг боловсронгуй болгох; | 2022 | | КТТА | 6.0 |
| | 8.2 | MNS IAS IAS 8 : 2010 нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг нэвтрүүлэх боломж нөхцөлийг судлах; | 2022 | | КТТА | 6.0 |
| | | B/. Хууль, дүрэм, журам, стандартыг шинэчлэн боловсруулах хийх хүрээнд: | | | | |
| | 8.3 | Төсөв, санхүүгийн төлөвлөгөөг 5 жилээр боловсруулах | 2023 | | КТТА | 6.0 |
| | 8.4 | Биржийн ажлын уялдаа холбоог хангах талаар чиглэл боловсруулах | 2022 | | СИХА | 6.0 |
| | | C/. Хэрэгжилтийн хангах хүрээнд: | | | | |
| | 8.5 | Биржийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн удирдлагыг хэрэгжүүлэх | I шат | | КТТА | 6.0 |
| | 8.6 | Арилжааны шимтгэлийн тооцоолол, гишүүнчлэлийн хураамж, элсэлтийн хураамж, сунгалтын хураамж, суудлын хураамж, итгэмжлэгдсэн этгээдийн хураамжийн хэмжээг нарийвчлан тооцоолох, холбогдох этгээдэд танилцуулах; | I шат | | КТТА | 6.0 |
| | 8.7 | Суудлын хураамж, арилжааны төлбөр, хураамж, шимтгэлийг бууруулах | I шат | | КТТА | 6.0 |
| | 8.8 | Төлбөр тооцоог шуурхай олгох системийг бий болгох | I шат | | КТТА | 6.0 |
| | 8.9 | Урт хугацааны хөрөнгө оруулалт хийхэд хөрөнгийн удирдлагыг хангах | | II шат | КТТА | 6.0 |
| | 8.10 | Төлбөр тооцоо, клиринг, гэрээний арилжаа уялдааг хангах цахим системийг хөгжүүлэх | | II шат | КТТА | 6.0 |
| Биржийн маркетингийн үйл ажиллагаа сайжирч, биржийн талаарх зөв, нэгдсэн, | | A/. Судалгаа, дүн шинжилгээ хийх хүрээнд: | | | | |
| | 8.11 | Маркетинг бодлогын талаар судлах | 2022 | | бүх алба | - |
| | 8.12 | Биржийн ойлголтын тухай товхимол гаргах | 2022 | | бүх алба | - |
| | 8.13 | Биржийн дүрэм, журмын эмхэтгэх гаргах | 2023 | | бүх алба | 15.0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| системтэй ойлголтыг олон нийтэд хүргэж, үйл ажиллагаагаа сурталчилна | В/. Хууль, дүрэм, журам, стандартыг шинэчлэн боловсруулах хийх хүрээнд: | | | | |
| | 8.14 | Биржийн үйл ажиллагааг сурталчиллах, таниулах, зах зээлд оролцогчдод зориулсан “Маркетингийн төлөвлөгөө” боловсруулах; | жил бүр | бүх алба | - |
| | С/. Хэрэгжилтийн хангах хүрээнд: | | | | |
| | 8.15 | Биржийн цахим мэдээллийн хэрэгсэл /www.mce.mn/ болон бусад платформ дахь цахим хуудсуудыг хөгжүүлэх, олон нийтийн сүлжээнд маркетингийн үйл ажиллагаа хэрэгжүүлэх; | 2022 | бүх алба | 6.0 |
| | 8.16 | Биржийн сургалт зохион байгуулах, танилцуулга видео, гарын авлага боловсруулах, контент хөгжүүлэх, түгээх; | жил бүр | бүх алба | 50.0 |
| | 8.17 | Биржийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулах, брендинг хийх, мэдээллийг тэгш хүртээмжтэй түгээх; | жил бүр | бүх алба | 20.0 |
| | 8.18 | Мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангасан нэгдсэн санг хөгжүүлэх; | II шат | МТА | 9.5 |
| | 8.19 | Маркетингийн зардалд санхүүжилт төлөвлөх, хэрэгжүүлэх | жил бүр | КТТА | 3.0 |
| | 8.20 | Биржийн зах зээлд оролцогчдод зориулсан “Маркетингийн төлөвлөгөө”-г хэрэгжүүлэх; | II шат | бүр алба | 25.0 |
| Стратегийн зорилт 3: Хөдөө аж ахуйн биржийн үйл ажиллагаанд хяналт тавих тогтолцоог сайжруулах | | | | | |
| Биржийн зохицуулах зөвлөл, биржийн оролцогчдын нэгдсэн холбоог байгуулах, үйл ажиллагааг эхлүүлэх | А/. Судалгаа, дүн шинжилгээ хийх хүрээнд | | | | |
| | 9.1 | Биржийн зохицуулах зөвлөл, Биржийн оролцогчдын нэгдсэн холбоотой ижил төстэй байгууллагын зорилт, чиг үүргийн талаар судалж, монголын нөхцөлд турших боломжийн талаар санал болгох | 2022 | СИХА | 6.0 |
| | 9.2 | Биржийн хувьцааг арилжаалах боломжийн талаар судалж, хувьцааны зах зээлийн үнэлгээг гаргах | 2022 | СИХА | 6.0 |
| | В/. Хууль, дүрэм, журам, стандартыг шинэчлэн боловсруулах хийх хүрээнд: | | | | |
| | 9.3 | Биржийн зохицуулах зөвлөлийн эрх зүйн орчинг боловсронгуй болгох | 2022-2023 | ЗХЭЗА | 8.0 |
| | 9.4 | Биржийн оролцогчдын нэгдсэн холбооны эрх зүйн орчинг бий болгох | 2022-2023 | ЗХЭЗА | 12.0 |
| | С/. Хэрэгжилтийн хангах хүрээнд: | | | | |
| | 9.5 | Биржийн зохицуулах зөвлөлийн болон биржийн оролцогчдын нэгдсэн холбооны үйл ажиллагааг эхлүүлэх | 2023-2024 | ЗХЭЗА | 8.0 |
| | 9.6 | Биржийн хувьцааны тодорхой хувийг зах зээлд арилжаалах | 2023-2024 | ЗХЭЗА | 8.0 |
| Стратегийн зорилт 4: Хөдөө аж ахуйн биржийн агуулахын аж ахуй, дэд бүтэц, эко-системийг хөгжүүлэх | | | | | |
| Арилжаа, төлбөр тооцоо, клирингийн үйл | А/. Судалгаа, дүн шинжилгээ хийх хүрээнд: | | | | |
| | 10.1 | Цахим татвар, цахим урамшуулал, мөшгих тогтолцоо зэргийг холбосон | 2022-2023 | МТА | 12.0 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
